

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ
АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛ,
ТҮҮНД ХОЛБОГДОХ МАТЕРИАЛ**

/Албан хэрэгцээнд/



Улаанбаатар хот
2021

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ АНХДАГЧ
ХУУЛИЙН ТӨСӨЛ, ТҮҮНД ХОЛБОГДОХ МАТЕРИАЛ**

Ерөнхий редактор: Л.Өлзийсайхан

Редакцийн зөвлөл: Э.Түвшинжаргал
Ц.Батбаатар

Эмхэтгэн боловсруулсан: Ж.Бямбадулам
Ц.Болормаа
Ц.Норовдондог

**Судалгаа, мэдээлэл
гаргасан:** Хууль, эрх зүйн газар
Хяналт шинжилгээ, үнэлгээний газар
Парламентын судалгааны хүрээлэн
О.Мөнхсайхан

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ: 4

I: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ, ХОЛБОГДОХ МАТЕРИАЛ

- 1.1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл..... 5-33
- 1.2.Хамт өргөн мэдүүлэх хуулийн төслийн жагсаалт 34
- 1.3.Төслийн үзэл баримтлал..... 35-40
- 1.4.Төслийн танилцуулга..... 41-43

II: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ СУДАЛГАА

- 2.1.Парламентын хяналтын үр ашигтай зохицуулалтын механизмыг бүрдүүлэх талаар Олон Улсын Парламентын Холбоо (IPU)-ны зөвлөмж /Парламентын судалгааны хүрээлэн/ 44-56
- 2.2.Парламентын хяналтыг бие даасан хуулиар зохицуулж буй зарим орны холбогдох хуулийн албан бус орчуулга:.....57
 - 2.2.1. Парламентын хяналтын тухай Босни-Херцеговин Улсын хууль 58-75
 - 2.2.2. Парламентын хяналтын тухай Оросын Холбооны Улсын хууль 76-82
- 2.3.Парламентын хяналтыг бусад хуулиар зохицуулж буй зарим орны туршлага:..... 83-95
 - 2.3.1.Америкийн Нэгдсэн Улс;
 - 2.3.2.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс;
 - 2.3.3.Бүгд Найрамдах Итали Улс;
 - 2.3.4.Канад Улс;
 - 2.3.5.Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс;
 - 2.3.6.Бүгд Найрамдах Польш Улс;
 - 2.3.7.Шведийн Вант Улс;
 - 2.3.8.Бүгд Найрамдах Энэтхэг Улс;
 - 2.3.9.Япон Улс.
- 2.4.ХБНГУ-ын Бундестагийн хянан шалгах түр хороодын эрх зүйн байдлын тухай хуулийн албан бус орчуулга96-105
- 2.5.Үндсэн хуулийн үзэл баримтлал ба сайн туршлага: Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо106-132

III: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛ

- 3.1.Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн санал...133-139
- 3.2.Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал хариуцсан хэлтсээс ирүүлсэн санал..... 140-147

3.3.Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний газраас ирүүлсэн санал.....148- 186

3.4.Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн шинжилгээний хэлтсийн санал.....186-190

IV: МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

4.1.Хуулийн төслийн зурагт танилцуулга..... 191-203

ТЭМДЭГЛЭЛ ХЭСЭГ:..... 204-208

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу эрх мэдэл хоорондын хяналт-тэнцлийг хангах, Засгийн газрын хууль тогтоомжийн биелэлтийг хангах үйл ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын хянан шалгах арга хэрэгсэл, хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүнээс гарах үр дагавар болон Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хянан шалгах түр хороо байгуулах, түүний үйл ажиллагааг журамлахтай холбоотой харилцааг бие даасан хуулиар нарийвчлан зохицуулах шаардлага үүссэн.

Түүнчлэн Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн улсын төсөв, төсвийн гүйцэтгэлийг батлахдаа Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д нийцэж байгаа эсэхийг хянах, мөн эдгээр баримт бичгийн хэрэгжилтийг хэлэлцэхдээ тухайн баримт бичгийн зорилго, зорилт нь өөрийн болон урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрч биелсэн, бодлогын зорилго, зорилт хоорондын уялдаа холбоо хэрхэн хангагдаж байгаа зэргийг нэгтгэн хянах механизм бүрдүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн.

Мөн парламентын хяналт шалгалтад хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага, хөндлөнгийн шинжээч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, парламентын хяналт шалгалт нь бодит мэдээлэлд тулгуурлан үр нөлөөтэй хяналт шалгалт явуулах замаар хүнд суртлаас ангид, хариуцлагатай гүйцэтгэх засаглалыг бэхжүүлэх, төрийн албаны бүх шатанд сахилга, хариуцлагыг бэхжүүлэх хэрэгцээ, шаардлага бий болсон.

Үүний дагуу Улсын Их Хурлын дарга 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 44 дүгээр захирамжаараа Хянан шалгах түр хорооны анхдагч хуулийн төслийг боловсруулах, мөн оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 62 дугаар захирамжаараа Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай анхдагч хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг тус тус байгуулсан.

Ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт ахалж, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, С.Ганбаатар, Ц.Даваасүрэн, Ж.Сүхбаатар, Л.Мөнхбаатар, Ц.Мөнхцэцэг, С.Одонтуяа нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Улмаар ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт Улсын Их Хурлын гишүүдийн ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын дэд хэсэг байгуулж, энэ хугацаанд хийж гүйцэтгэсэн олон улсын парламентын холбооны зөвлөмж, зарим улсын холбогдох хуулийн албан бус орчуулга, бусад орны туршлагын талаарх судалгааны материал, холбогдох байгууллагуудаас хуулийн төсөлд ирүүлсэн санал болон хуулийн төсөл, түүний үзэл баримтлал, танилцуулгыг эмхэтгэн Та бүхний ажлын хэрэгцээнд хүргүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг биелүүлэх үйл ажиллагаанд тавих Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль тогтоомж

2.1.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹ /цаашид “Үндсэн хууль” гэх/, Монгол Улсын Их Хурлын тухай², Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай³, Нийтийн сонсголын тухай⁴, энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоос бүрдэнэ.

3 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын зорилго

3.1.Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/-ын хяналт шалгалтыг дараах зорилгоор хэрэгжүүлнэ:

3.1.1.хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хангуулах;

3.1.2.хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, баталгааг хангах;

3.1.3.нийтийн эрх ашгийг хөндсөн тодорхой асуудлаар иргэний мэдэх эрхийг хангах;

3.1.4.иргэд шууд болон өөрсдийн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөллийн байгууллагаараа уламжлан төрийн үйл хэрэгт оролцох эрхийг хангах;

3.1.5.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн улсын төсөв, төсвийн гүйцэтгэлийг батлахдаа Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д нийцэж байгаа эсэхийг хянах;

3.1.6.төсөв, төрийн санхүүгийн удирдлагын хяналтын байнгын тогтолцоо

¹Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

²Монгол Улсын Их Хурлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

³Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

⁴Нийтийн сонсголын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

бүрдүүлэх, тэдгээрийн үр нөлөөг сайжруулах;

3.1.7.хууль хэрэгжүүлэх явцад төрийн байгууллагын үйл ажиллагаанд гарч буй тулгамдсан асуудлыг тогтоох, Улсын Их Хурлын хяналтын явцад төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах замаар төрийн удирдлагын тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх;

3.1.8.хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх, судлан шинжлэх байнгын тогтолцоо бүрдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөг сайжруулах, боловсронгуй болгох.

4 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зарчим

4.1.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын зэрэгцээ дараах тусгай зарчмыг баримтална:

- 4.1.1.үндсэн хуульт ёсыг дээдлэн сахих;
- 4.1.2.хүний эрх, эрх чөлөөг хангах;
- 4.1.3.төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрийг хангах;
- 4.1.4.хараат бус, иж бүрэн мэдээлэлд тулгуурлах;
- 4.1.5.ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх;
- 4.1.6.хууль бусаар нөлөөлөхийг хориглох;
- 4.1.7.ил тод байх.

4.2.Энэ хуулийн 4.1-д заасан Улсын Их Хурлын хяналт шалгалтын зарчмыг доор дурдсан агуулгаар ойлгоно:

4.2.1.“үндсэн хуульт ёсыг дээдлэн сахих зарчим” гэж Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, үндсэн зарчмын хүрээнд ажиллахыг;

4.2.2.“хүний эрх, эрх чөлөөг хангах зарчим” гэж Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулиар тогтоосон хүний эрх, эрх чөлөөнд хууль бусаар халдахгүй байх, үндсэн эрхийг нь баталгаатай эдлүүлэх, олон нийтийн оролцоог хангахыг;

4.2.3.“төрийн эрх мэдэл хоорондын тэнцвэрийг баримтлах зарчим” гэж Улсын Их Хурал хяналт шалгалтаа хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулиар тогтоосон төрийн эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцлийг алдагдуулахгүй байх, гүйцэтгэх болон шүүх эрх мэдлийг орлон гүйцэтгэхгүй байхыг;

4.2.4.“хараат бус, иж бүрэн мэдээлэлд тулгуурлах зарчим” гэж Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газраас хараат бус мэдээллийн эх үүсвэрт тулгуурлаж, нягтлан үзсэний үндсэн дээр бодитой, иж бүрэн тооцоо, судалгаа, мэдээлэл, дүгнэлтийг үндэслэж ажиллахыг;

4.2.5.“ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх зарчим” гэж энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд хувийн болон тодорхой бүлгийн ашиг сонирхлоос ангид байж, зөвхөн ард түмний төлөөлөл болохын хувьд Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэхийг;

4.2.6.“хууль бусаар нөлөөлөхийг хориглох зарчим” гэж Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хараат бус, бие даасан байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс нөлөөлөхгүй байхыг;

4.2.7.“ил тод байх зарчим” гэж хуулиар хязгаарласнаас бусад тохиолдолд Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл явц, холбогдох мэдээлэл, үр дүнг олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй мэдээлэхийг.

5 дугаар зүйл.Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан

5.1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр нөлөөг дүгнэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг агуулсан хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан /цаашид “мэдээллийн нэгдсэн сан” гэх/ Улсын Их Хуралд байна.

5.2.Мэдээллийн нэгдсэн сан нь Улсын Их Хурлаас явуулсан хяналт шалгалтын баримт мэдээлэл, тайлан, дүгнэлт, хяналт шалгалтын бусад байгууллагаас гаргуулж авсан мэдээлэл, хууль тогтоомжид заасан бусад тогтмол мэдээллээс бүрдэх бөгөөд хуульд өөрөөр заагаагүй бол мэдээллийн нэгдсэн сан олон нийтэд нээлттэй байна.

5.3.Энэ хуулийн 5.2-д заасан мэдээллийг Улсын Их Хурлын Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/ болон холбогдох байгууллагын хамтарсан шийдвэрийн дагуу мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлнэ.

5.4.Тамгын газар нь холбогдох төрийн байгууллагын цахим систем болон цахим хэлбэрээр бүрдүүлсэн мэдээллийн сангаас шаардлагатай мэдээллийг гаргуулан авах эрхтэй.

5.5.Улсын Их Хурлаас хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан мэдээлэл, тооцоо судалгаа, баримт бичгийг нуун дарагдуулахыг хориглоно.

5.6.Тамгын газар мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, эрхлэн хөтөлнө. Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журмыг Улсын Их Хурлын даргын захирамжаар батална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АРГА ХЭРЭГСЭЛ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

6 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын арга хэрэгсэл

6.1.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараах арга хэрэгслээр хэрэгжүүлнэ:

6.1.1.асуулт тавих;

6.1.2.асуулга тавих;

6.1.3.хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;

6.1.4.тайлан, мэдээлэл, илтгэл сонсох, хэлэлцэх;

- 6.1.5.төсвийн хяналт;
- 6.1.6.хяналтын сонсгол хийх;
- 6.1.7.хянан шалгах /мөрдөн шалгах/ түр хороо байгуулах.

6.2.Засгийн газрын гишүүний үүргийг хавсран гүйцэтгэж байгаа Улсын Их Хурлын гишүүн хянан шалгах чиг үүрэг бүхий ажлын хэсэг, хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд орж ажиллахыг хориглоно.

7 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоо

7.1.Байнгын, дэд, түр болон хянан шалгах түр хороо нь Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

7.2.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл Төрийн аудитын байгууллага, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл болон холбогдох бусад хараат бус хянан шалгах чиг үүрэгтэй байгууллагад түшиглэн явуулна. Улсын Их Хурал тэдгээр байгууллагыг хууль тогтоомжид заасан чиг үүргийнх нь хүрээнд Улсын Их Хурлын хяналт шалгалтад оролцуулахдаа тухайн байгууллагын хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлж үл болно.

7.3.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай бол тухайн асуудлаар мэргэшсэн судлаач, мэргэжлийн холбоо болон төрийн бус байгууллагыг оролцуулна.

7.4.Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Тамгын газар мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

8 дугаар зүйл.Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих

8.1.Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлынхаа хүрээнд тодорхой асуудлаар шалган судлах, эсхүл хууль тогтоомжийн биелэлтэд хяналт шалгалт хийж, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дангаар болон хамтран байгуулна.

8.2.Байнгын хороо энэ хуулийн 8.1-д заасан ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор холбогдох хяналт шалгалтын байгууллага, эрх бүхий албан тушаалтан, шаардлагатай гэж үзвэл тусгай мэдлэг, мэргэшил шаардагдах асуудлаар туслалцаа үзүүлэх шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн дэд ажлын хэсэг байгуулж болно.

8.3.Байнгын хороо энэ хуулийн 8.1-д заасан ажлын хэсгийн хяналт шалгалт хийх үйл ажиллагааны удирдамжийг тогтоолоороо батлах бөгөөд ажлын хэсэг уг тогтоолд заасан хугацаанд санал, дүгнэлт гаргаж Байнгын хороонд танилцуулна. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч танилцуулна.

8.4.Ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 8.3-т заасан санал, дүгнэлтийн хамт тогтоолын төслийг боловсруулж холбогдох Байнгын хороонд танилцуулж болно.

8.5.Хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын хороо Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэх хүрээнд дараах тогтоол гаргана:

8.5.1.хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой зохион байгуулалтын асуудлаар;

8.5.2.хуулийн хэрэгжилтийг хангаж зөрчлийг арилгах, шаардлагатай гэж үзвэл Төрийн аудитын байгууллагын аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх.

8.6.Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд Засгийн газар, холбогдох бусад байгууллагад зөвхөн тогтоолоор чиглэл өгнө.

8.7.Байнгын хороо Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Шаардлагатай гэж үзвэл холбогдох тогтоолын төслийг боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.

8.8.Байнгын хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд тодорхой асуудлаар хяналт шалгалт хийгээд шаардлагатай гэж үзвэл холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх санал, шийдвэрийн төслийг нэгдсэн хуралдаанд оруулна.

8.9.Дэд хороо тухайн эрхэлсэн асуудлаараа хяналт шалгалт, судалгаа хийх, шаардлагатай мэдээлэл авах, холбогдох албан тушаалтан, иргэн, байгууллагаас тайлбар авч, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж харьяалах Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх эрхтэй.

8.10.Дэд хороо зөвхөн энэ хуулийн 8.5.1-д заасан асуудлаар тогтоол гаргаж болно.

9 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хэлбэр

9.1.Улсын Их Хурлын хяналт шалгалт нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэртэй байна. Энэ хуулийн 6.1.3, 6.1.4, 6.1.5-д заасан хяналт шалгалт нь төлөвлөгөөт хяналт шалгалт байх бөгөөд 6.1.1, 6.1.2, 6.1.6, 6.1.7-д заасан хяналт шалгалтыг шаардлага гарсан тухай бүр нь зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын төлөвлөгөөт хяналт шалгалт

10.1.Улсын Их Хурлын хяналт шалгалтын төлөвлөгөөг Байнгын хороодын болон цөөнхийн бүлгийн саналыг үндэслэн, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 14.3-т заасан Зөвлөлийн хуралдаанаар зөвшилцөн Улсын Их Хурлын даргын захирамжаар батална.

10.2.Байнгын хороод болон цөөнхийн бүлэг дараагийн ээлжит чуулганы хяналт шалгалтын төлөвлөгөөнд өгөх саналаа тухайн ээлжит чуулган дуусахаас ажлын 15 өдрийн өмнө Тамгын газарт ирүүлсэн байна.

10.3.Байнгын хороод энэ хуулийн 10.2-т заасан хугацаанд санал ирүүлээгүй бол хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.

11 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ

11.1.Улсын Их Хурал хяналт шалгалтынхаа үр дүнд үндэслэн шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авна.

11.2.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, эрчимжүүлэх, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлаар тогтоол гаргана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Нэгдүгээр дэд бүлэг Асуулт, асуулга

12 дугаар зүйл.Асуулт тавих

12.1.Улсын Их Хурлын гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнд тодорхой бодлогын асуудал, түүний санхүүжилт, төрийн санхүү, төрийн нийтийн өмч, хүний эрх, эрх чөлөө хангагдаж байгаа эсэх асуудал болон Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлж байгаатай холбоотой мэдээлэл авахаар бичгээр хандсаныг “асуулт” гэнэ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.16, 8.1.17-д заасан албан бичгээр авах мэдээлэл нь асуултад хамаарахгүй.

12.2.Асуултыг хүргүүлснээс хойш холбогдох албан тушаалтан 14 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр хүргүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр асуултын хариуг хугацаа хэтрүүлж өгсөн бол тухайн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд⁵ заасан хариуцлага хүлээлгэнэ.

12.3.Гишүүн асуултын хариуд ирүүлсэн холбогдох байгууллага, албан тушаалтны мэдээлэл шаардлага хангаагүй гэж үзвэл нэмэлт мэдээлэл, тооцоо, судалгааг авахаар хугацаатай албан бичиг явуулна. Холбогдох албан тушаалтан албан бичигт заасан хугацаанд нэмэлт мэдээллийг ирүүлэх үүрэгтэй.

12.4.Гишүүн шаардлагатай гэж үзвэл асуултын хариуг Байнгын хорооны хуралдаанд танилцуулж, тодорхой арга хэмжээ авах хүсэлтийг шийдвэрийн төслийн хамт Байнгын хорооны даргад уламжилж болно.

12.5.Байнгын хороо энэ хуулийн 12.4-т зааснаар гишүүнээс гаргасан хүсэлт, шийдвэрийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

13 дугаар зүйл.Асуулга тавих

⁵Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

13.1.Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар тодруулах, тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж Улсын Их Хурлын гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурал бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад бичгээр хандсаныг “асуулга” гэнэ.

13.2.Асуулгыг хүргүүлснээс хойш холбогдох албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр хүргүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр асуулгын хариуг хугацаа хэтрүүлж өгсөн бол тухайн албан тушаалтанд Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.3.Гишүүн асуулгын хариуд ирүүлсэн холбогдох байгууллага, албан тушаалтны мэдээлэл шаардлага хангаагүй гэж үзвэл нэмэлт мэдээлэл, тооцоо, судалгаа авахаар хугацаатай албан бичгийг явуулна. Холбогдох албан тушаалтан албан бичигт заасан хугацаанд нэмэлт мэдээллийг ирүүлэх үүрэгтэй.

13.4.Асуулга тавьсан гишүүн асуулгын хариутай холбогдуулж тодорхой шийдвэр гаргах шаардлагатай гэж үзвэл холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

13.5.Нэгдсэн хуралдаан гишүүний саналын талаар хэлэлцээд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргахыг дэмжсэн тохиолдолд асуудал хариуцсан Байнгын хороонд энэ талаар чиглэл өгч болно.

13.6.Асуудал хариуцсан Байнгын хороо энэ хуулийн 13.5-д зааснаар нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон төрийн бодлоготой холбоотой санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж тодорхой шийдвэр гаргуулна.

Хоёрдугаар дэд бүлэг **Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх**

14 дугаар зүйл.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх

14.1.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ гэж хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад хуримтлагдсан өгөгдлүүдийг задлан шинжилж, гарч байгаа хүндрэл бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох, хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээг тодорхойлоход чиглэсэн цогц үйл ажиллагааг ойлгоно.

14.2.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийх үнэлгээ нь доор дурдсан хүрээг хамарна:

14.2.1.хууль тогтоомжид бүхэлд нь;

14.2.2.хууль тогтоомжийн зарим зүйл, хэсэг, заалт;

14.2.3.тодорхой харилцааг зохицуулж буй хууль тогтоомжийн зохицуулалт.

14.3.Холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзсэн бол хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын баталсан дүрэм, журам тухайн хуульд нийцэж байгаа эсэхэд үнэлгээ хийнэ.

14.4.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үйл ажиллагаанд Тамгын газар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

14.5.Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхтэй холбогдон гарах зайлшгүй зардлыг улсын төсвөөс санхүүжилнэ.

14.6.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг хууль тогтоох үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх зорилгогүйгээр ашгийн бус байгууллага санхүүжүүлж болно.

14.7.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийн хэрэгжилтэд хөндлөнгийн, хараат бус байгууллага, судлаачаар үнэлгээ хийлгэх буюу хамтарч болно.

14.8.Улсын Их Хурал Засгийн газар, төрийн байгууллага болон хөндлөнгийн судалгааны байгууллага, судлаачдын хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хийсэн хяналт-шинжилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан цахим санд байршуулна.

14.9.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний үр дүнг холбогдох Байнгын хороо Улсын Их Хуралд танилцуулна.

14.10.Улсын Их Хурлаас тухайн жилд хийсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний үр дүнгийн талаарх Хууль зүйн байнгын хорооны танилцуулгыг жил бүрийн 12 дугаар сарын эхний долоо хоногт нэгдсэн хуралдаанд танилцуулна.

14.11.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх журам, аргачлалыг Улсын Их Хурлын даргын захирамжаар батална.

Гуравдугаар дэд бүлэг Мэдээлэл, тайлан, илтгэл

15 дугаар зүйл.Мэдээлэл сонсох

15.1.Нэгдсэн хуралдаан дараах мэдээллийг хуульд заасан хугацаанд нээлттэй болон хаалттай сонсоно:

15.1.1.Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилт, үндэсний аюулгүй байдлын тухайн жилийн нөхцөл байдлын талаарх Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний жил бүрийн хаалттай мэдээлэл;

15.1.2.Ерөнхий сайдын 14 хоног тутмын мэдээлэл;

15.1.3.Шаардлагатай бол цаг үеийн тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн тухай бүр хийх мэдээлэл.

15.2.Улсын Их Хурал энэ хуулийн 15.1.1-д заасан мэдээллийг жил бүрийн 1 дүгээр сарын 3 дахь долоо хоногт багтаан нэгдсэн хуралдаанаараа сонсоно. Нэгдсэн хуралдааны үеэр гишүүд танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

15.3.Энэ хуулийн 15.1.3-т заасан асуудлаарх мэдээллийг нэгдсэн хуралдаанд сонсох үеэр гишүүд Ерөнхий сайд болон Засгийн газрын холбогдох гишүүнээс асуулт асууж, үг хэлж болно.

15.4.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 15.1.2, 15.1.3-т заасан мэдээллийг хэлэлцээд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах болон хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахаар Засгийн газарт чиглэл өгөх шаардлагатай гэж үзвэл асуудал хариуцсан Байнгын хороонд энэ талаар чиглэл өгч болно.

15.5.Асуудал хариуцсан Байнгын хороо энэ хуулийн 15.4-т заасан чиглэлийн дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

15.6.Хэрэв Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийг хангах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсан бол Засгийн газар уг тогтоолын хэрэгжилтийг тогтоосон хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.

16 дугаар зүйл.Тайлан, илтгэл, мэдээлэл хэлэлцэх

16.1.Улсын Их Хурал дараах тайлан, илтгэл, мэдээллийг хуульд заасан хугацаанд нээлттэй болон хаалттай хэлэлцэнэ:

16.1.1.төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг тухай бүр;

16.1.2.авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдлын талаарх Авлигатай тэмцэх газрын мэдээллийг жил бүр;

16.1.3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн үндэсний комиссын илтгэлийг жил бүр;

16.1.4.Монголбанкны санхүүгийн тайлан, түүнд холбогдох аудитын санал, дүгнэлт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг жил бүр, төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө, зээлийн байдлын талаарх Монголбанкны мэдээллийг шаардлагатай тохиолдолд;

16.1.5.хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайлан жил бүр;

16.1.6.эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Хүний эрхийн үндэсний комиссын гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг жил бүрийн эхний улиралд;

16.1.7.эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх Улсын ерөнхий прокурорын мэдээллийг жилд нэгээс доошгүй удаа;

16.1.8.жөндөрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын болон Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг 2 жил тутам;

16.1.9.банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны тайланг жил бүр;

16.1.10.статистикийн хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Үндэсний статистикийн хорооны тайланг жил бүр;

16.1.11.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр;

16.1.12.Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жил бүр;

16.1.13.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг жил бүр.

16.2.Энэ хуулийн 16.1-д заасан тайланг Улсын Их Хурал хүлээн авсанаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст нийтлэх бөгөөд ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар дүн шинжилгээ хийж, холбогдох Байнгын хороо, гишүүдэд тараасан байна.

16.3.Байнгын хороо энэ хуулийн 16.1-д заасан тайлан, илтгэл, мэдээллийг хэлэлцсэн талаарх санал, дүгнэлт болон шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын бусад шийдвэр /цаашид “тогтоол” гэх/-ийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд Засгийн газрын тайлан, илтгэлийг Ерөнхий сайд, холбогдох байгууллагын тайлан, илтгэлийг тухайн байгууллагын дарга Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд танилцуулна.

16.4.Энэ хуулийн 16.1.8-д заасан илтгэлийг Нийгмийн бодлогын, Хууль зүйн байнгын хороо хамтран хэлэлцэнэ.

16.5.Байнгын хороо энэ хуулийн 16.1-д заасан тайлан, илтгэл, мэдээллийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэгжилтийг хангуулах, холбогдох албан тушаалтанд хариуцлага хүлээлгэхтэй холбоотой санал боловсруулж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, шаардлагатай тогтоолыг баталж болно.

16.6.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж байгаа тайлан, илтгэл, мэдээлэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн асуулт асууж, үг хэлж болно.

16.7.Хэрэв Улсын Их Хурал хууль тогтоомжийн биелэлтийг хангах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоол баталсан бол тухайн тогтоолд заасан хугацаанд Засгийн газар тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.

16.8.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 16.1-д заасан тайланд дүн шинжилгээ хийх шаардлагатай гэж үзвэл Тамгын газар мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

17 дугаар зүйл.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх

17.1.Улсын Их Хурал жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний дотор Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хэлэлцэхдээ дараах асуудлыг хянан хэлэлцэнэ:

17.1.1.улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт нь тухайн жилийнхээ зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг төсөл, арга хэмжээ тус бүрээр болон нэгдсэн дүнгээр;

17.1.2.тухайн жилийн биелэлт нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлт хангасан эсэхийг төсөл, арга хэмжээ тус бүрийн хувиар харьцуулан;

17.1.3.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй бол түүний шалтгаан, нөхцөлд хийсэн дүн шинжилгээний үр дүн, цаашид авах арга хэмжээний тодорхой санал.

17.2.Засгийн газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

17.3.Төрийн аудитын дээд байгууллага улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд аудит хийж, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд ирүүлсэн байна.

17.4.Улсын Их Хурал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл дараа жилийн улсын хөгжлийн төлөвлөгөөний төсөл боловсруулах болон холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлаар Засгийн газарт тогтоолоор чиглэл өгч болно.

18 дугаар зүйл.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх

18.1.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн явцыг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн жил бүрийн 04 дүгээр сарын 01-ний дотор Улсын Их Хурал хянан хэлэлцэнэ.

18.2.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг тухайн баримт бичиг дуусгавар болох жилийн 04 дүгээр сарын 01-ний дотор Улсын Их Хурал хянан хэлэлцэнэ.

18.3.Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэхдээ дараах асуудлыг хянан хэлэлцэнэ:

18.3.1.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг зорилт тус бүрээр;

18.3.2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг нэгдсэн дүнгээр;

18.3.3.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.2, 6.5-д заасан урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг зорилт тус бүрээр;

18.3.4.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг нэгдсэн дүнгээр.

18.4.Төрийн аудитын байгууллага Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, гүйцэтгэлийн тайлан хэлэлцэх жилийн 3 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хуралд ирүүлсэн байна.

18.5.Засгийн газар Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

18.6.Төрийн аудитын дээд байгууллага Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй гэж дүгнэсэн бол түүний шалтгаан, нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаарх санал зөвлөмжийг аудитын тайланд тусгасан байна.

18.7.Улсын Их Хурал энэ хуулийн 18.6-д заасан асуудлыг хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнг тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд эргэн танилцуулах үүрэгтэй.

19 дүгээр зүйл.Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх

19.1.Улсын Их Хурал Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.5-д заасан Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцын тайланг таван жил тутам Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хэлэлцэнэ.

19.2.Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайланг тухайн баримт бичиг дуусгавар болохоос нэг жилийн өмнө Улсын Их Хурал хянан хэлэлцэнэ.

19.3.Улсын Их Хурал Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайланг хэлэлцэхдээ дараах асуудлыг хянан хэлэлцэнэ:

19.3.1.Хөгжлийн зорилтот хөтөлбөр нь урт хугацааны хөгжлийн бодлогын холбогдох зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг хөтөлбөр тус бүрээр;

19.3.2.Хөгжлийн зорилтот хөтөлбөр нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг зорилго, зорилт тус бүрийн нэгдсэн дүнгээр.

19.4.Төрийн аудитын дээд байгууллага Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийг хэлэлцэх тухайн жилд гүйцэтгэлийн тайланд аудит хийж, Улсын Их Хуралд ирүүлсэн байна.

19.5.Засгийн газар Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 6 сарын өмнө Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

19.6.Төрийн аудитын дээд байгууллага Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүд нь бүрэн хэрэгжээгүй гэж дүгнэсэн бол түүний шалтгаан, нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаарх санал зөвлөмжийг аудитын тайланд тусгасан байна.

20 дугаар зүйл.Урт хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх

20.1.Улсын Их Хурал урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа” /цаашид “урт хугацааны хөгжлийн бодлого” гэх/-ны хэрэгжилтийн явцын тайланг 10 жил тутам Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хянан хэлэлцэнэ.

20.2.Урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг тухайн баримт бичиг дуусгавар болох хугацаанаас хоёр жилийн өмнө Улсын Их Хурал хянан хэлэлцэнэ.

20.3.Улсын Их Хурал урт хугацааны хөгжлийн бодлого нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг зорилго, зорилт тус бүрээр хянан хэлэлцэнэ.

20.4.Засгийн газар урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 6 сарын өмнө Төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлнэ.

20.5.Төрийн аудитын дээд байгууллага урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланд аудит хийж, Улсын Их Хурлаар гүйцэтгэлийн тайланг хэлэлцэхээс 3 сарын өмнө Улсын Их Хуралд ирүүлсэн байна.

20.6.Төрийн аудитын дээд байгууллага урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилт нь бүрэн хэрэгжээгүй гэж дүгнэсэн бол түүний шалтгаан, нөхцөл, цаашид авах арга хэмжээний талаарх санал зөвлөмжийг аудитын тайланд тусгасан байна.

20.7.Төрийн аудитын дээд байгууллага урт хугацааны хөгжлийн бодлого нь бүрэн хэрэгжээгүй гэж дүгнэсэн бол түүний шалтгаан, нөхцөл, цаашид авах арга хэмжээний тодорхой саналыг дүгнэлтдээ тусгана.

20.8.Байнгын хороод урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг хэлэлцээд Төрийн байгуулалтын байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлнэ. Хуралдаанд холбогдох Засгийн газрын гишүүд заавал оролцож, Улсын Их Хурлын гишүүдийн асуултад хариулна.

20.9.Улсын Их Хурал урт хугацааны хөгжлийн бодлогын гүйцэтгэлийн тайланг хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт холбогдох чиглэл өгөх тогтоол батална. Засгийн газар Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнгийн талаар тухайн тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд эргэн танилцуулах үүрэгтэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ТӨСВИЙН ХЯНАЛТ

21 дүгээр зүйл.Төсвийн хяналтын зарчим, төрөл

21.1.Улсын Их Хурлын төсөвт хяналт тавих үйл ажиллагаанд энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчмын зэрэгцээ дараах зарчмыг баримтална:

- 21.1.1.тасралтгүй, байнгын байх;
- 21.1.2.ил тод, нээлттэй байх;
- 21.1.3.үр нөлөөтэй байх;
- 21.1.4.зохистой байх;
- 21.1.5.олон нийтийн оролцоог хангасан байх.

21.2.Улсын Их Хурал төсвийн хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ:

21.2.1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн тухайн жилийн төсвийн төслийн хэлэлцүүлгийн үе шатанд тавих хяналт;

21.2.2.Төсвийн хэрэгжилтэд тавих хяналт.

21.3.Төсвийн төслийн хэлэлцүүлгийн үе шатанд тавих хяналт нь дараах төрөлтэй байна:

- 21.3.1.хэлэлцүүлэгт бэлтгэх шатны хяналт;
- 21.3.2.хэлэлцүүлгийн шатны хяналт.

21.4.Хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын төсвийн хяналт шалгалтын мэдээлэл олон нийтэд ил тод, нээлттэй байна.

22 дугаар зүйл.Төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үе шатны хяналт

22.1.Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг эхлэхээс өмнөх үе шатанд төсвийн төсөл дараах шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавина:

22.1.1.Төсвийн төсөл нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д заасны дагуу улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх;

22.1.2.Төсвийн⁶ болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд⁷ заасан шалгуурыг хангасан эсэх;

22.1.3.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх.

22.2.Төсвийн төсөл нь энэ хуулийн 22.1-д заасан шаардлага хангасан эсэхэд Тамгын газрын төсвийн хяналт шинжилгээний асуудал хариуцсан нэгж /цаашид “Төсвийн хяналт шинжилгээний нэгж” гэх/ дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргана.

22.3.Энэ хуулийн 22.1.3-т заасан асуудлаарх Төсвийн тухай хуулийн 8.4.7-д заасан аудитын дүгнэлт, зөвлөмж, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн зөвлөмжийг Улсын Их Хуралд ирүүлсэн даруйд гишүүдэд тараана.

22.4.Энэ хуулийн 22.2-т заасан дүн шинжилгээ, 22.3-т заасан дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурал төсвийн төслийг Үндсэн хууль, холбогдох хуульд нийцүүлэх чиглэл өгч Засгийн газарт төсвийн төслийг буцаана.

22.5.Засгийн газар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хугацаанд төсвийг төслийг хуульд нийцүүлэн дахин боловсруулж, Улсын Их Хуралд ирүүлнэ.

22.6.Улсын Их Хурал төсвийн төслийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг хийж болно.

23 дугаар зүйл.Төсвийн төслийн хэлэлцүүлгийн үе шатны хяналт

23.1.Төсвийн төслийн хэлэлцүүлэгийн үе шатанд төсөлд тусгуулахаар гаргасан санал нь энэ хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд түүнд тавих хяналтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 70 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.

23.2.Энэ хуулийн 23.1-д заасан хяналтыг хэрэгжүүлэхэд Тамгын газрын төсвийн хяналт шинжилгээний асуудал хариуцсан нэгж /цаашид “Төсвийн хяналт шинжилгээний нэгж” гэх/ дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж, төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн шатанд уг дүгнэлтийг гишүүдэд тараасан байна.

23.3.Энэ хуулийн 23.2-д заасан дүн шинжилгээ хийх аргачлалыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын захирамжаар батална.

23.4.Төсвийн төслийн хэлэлцүүлгийн шатанд Төсвийн хяналт шинжилгээний нэгж нь Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Төсвийн байнгын хороог шаардлагатай тооцоо, мэдээллээр хангаж ажиллана.

24 дүгээр зүйл.Төсвийн хэрэгжилтэд тавих хяналт

⁶Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

⁷Төсвийн тогтвортой байдлын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2010 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

24.1.Улсын Их Хурал төсвийн хэрэгжилтэд тавих хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

24.1.1.Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний илтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

24.1.2.шаардлагатай гэж үзвэл энэ хууль болон Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу тухайн жилийн төсвийн хуулийн хэрэгжилтийн талаар Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах;

24.1.3.шаардлагатай гэж үзвэл төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах ажлын хэсэг байгуулан ажиллуулах, дүнг сонсох, хэлэлцэх;

24.1.4.хуульд заасан бусад хэлбэр.

24.2.Тухайн жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь төсвийн хууль тогтоомжид нийцсэн эсэх, түүнчлэн тухайн жилийн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд заасан зорилго, зорилт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэхэд Улсын Их Хурал хяналт тавина.

24.3.Сар, улирал, хагас жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан Улсын Их Хуралд тухай бүр ирүүлэх бөгөөд түүнд Төсвийн хяналт шинжилгээний нэгж дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн, Улсын Их Хурлын гишүүд, холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

24.4.Улсын Их Хурал энэ хуулийн 24.3-т заасан жилийн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт төсвийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой чиглэл өгч болно.

24.5.Засгийн газар энэ хуулийн 24.4-т Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнгийн талаар уг тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд эргэн танилцуулах үүрэгтэй.

ТАВДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТЫН СОНСГОЛ

Нэгдүгээр дэд бүлэг Хяналтын сонсголын төрөл

25 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналтын сонсголын төрөл

25.1.Улсын Их Хурлын хяналтын сонсгол дараах төрөлтэй байна:

- 25.1.1.хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол;
- 25.1.2.төсвийн хяналтын сонсгол;
- 25.1.3.ерөнхий хяналтын сонсгол;
- 25.1.4.нэр дэвшигчийн сонсгол.

25.2.Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.

25.3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байгаа асуудлаар хяналтын сонсгол явуулахыг хориглоно.

25.4.Улсын Их Хурлын хяналтын сонсголыг Нийтийн сонсголын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу холбогдох Байнгын, дэд, түр хороо зохион байгуулна.

25.5.Холбогдох Байнгын, дэд, түр хороо хяналтын сонсголын тэмдэглэл, хяналтын сонсгол явуулсан талаарх санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд нэгдсэн хуралдаанд гишүүд асуулт асууж, үг хэлнэ.

25.6.Энэ хуулийн 25.5-д заасан санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаан хэлэлцээд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах шаардлагатай гэж үзвэл асуудал хариуцсан Байнгын хороонд энэ талаар чиглэл өгч болно.

25.7.Асуудал хариуцсан Байнгын хороо энэ хуулийн 25.6-д заасан нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулж санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд танилцуулна.

26 дугаар зүйл.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол

26.1.Хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, үр нөлөөг сайжруулах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, мэдээлэл авах, үнэлэх зорилгоор хяналтын сонсгол явуулна.

26.2.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг хийх хүсэлтээ иргэн, хуулийн этгээд тухайн асуудал эрхэлсэн Байнгын болон дэд хороонд, эсхүл цөөнхийн бүлэгт хандан гаргана.

26.3.Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг тухайн асуудал эрхэлсэн Байнгын хороо хэлэлцэн хүлээн авсан, цөөнхийн бүлэг хүсэлт гаргасан эсхүл Улсын Их Хурлын таваас доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг зохион байгуулна.

26.4.Улсын Их Хурлын таваас доошгүй гишүүний санаачилснаар хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол явуулах бөгөөд Хүний эрхийн Үндэсний Комиссоор дүгнэлт гаргуулж болно.

27 дугаар зүйл.Төсвийн хяналтын сонсгол

27.1.Улсын Их Хурал төсвийн болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах болон төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэл, жилийн төлөвлөгөө,

төсвийн хүрээний мэдэгдлээр төрийн байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн холбоо, судлаач, олон нийтийг оролцуулан төсвийн хяналтын сонсгол явуулна.

27.2.Төсвийн хяналтын сонсголыг Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо санаачилна. Хэрэв Улсын Их Хурлын таваас доошгүй гишүүн төсвийн хяналтын сонсгол явуулах хүсэлт гаргасан бол төсвийн хяналтын сонсгол явуулна.

27.3.Төсвийн хяналтын сонсгол явуулахдаа тухайн асуудлаарх аудитын тайлан, санал, дүгнэлт, зөвлөмж, түүний хэрэгжилтийг заавал сонсоно.

27.4.Төсвийн хяналтын сонсгол явуулах санал гаргах, зохион байгуулахтай холбоотой харилцаанд Нийтийн сонсголын тухай хуулийг баримтална.

28 дугаар зүйл.Ерөнхий хяналтын сонсгол

28.1.Улсын Их Хурал энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагавартай танилцах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, түүний удирдах албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэх зорилгоор ерөнхий хяналтын сонсголыг явуулна.

28.2.Улсын Их Хурал нь дараах тохиолдолд ерөнхий хяналтын сонсголыг заавал явуулна:

28.2.1.Монгол Улсын Ерөнхийлөгчөөс хүсэлт гаргасан;

28.2.2.Улсын Их Хурлын таваас доошгүй гишүүн хүсэлт гаргасан;

28.2.3.Байнгын, дэд, түр хорооны нийт гишүүний олонх, эсхүл цөөнхийн бүлэг хүсэлт гаргасан;

28.2.4.эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа иргэн, хуулийн этгээдийн гаргасан хүсэлтийг тухайн асуудал эрхэлсэн Байнгын, дэд, түр хороо хэлэлцэн хүлээн авсан;

28.2.5.хуульд тусгайлан сонсгол явуулах хугацаа тогтоосон.

29 дүгээр зүйл.Хяналтын сонсголыг хүчингүйд тооцох

29.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Байнгын, дэд, түр хорооны гишүүдийн олонх оролцоогүй бол тухайн сонсголыг хүчингүйд тооцно.

Хоёрдугаар дэд бүлэг Нэр дэвшигчийн сонсгол

30 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсгол

30.1.Эрх бүхий этгээдээс хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлаас зохион байгуулах сонсголыг нэр дэвшигчийн сонсгол гэх бөгөөд энэхүү сонсгол нь дараах хэлбэртэй байна:

30.1.1.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн, Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн

гишүүн, Авлигатай тэмцэх газрын дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүн, Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Улсын Ерөнхий аудитор, Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга, дэд дарга, гишүүний албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаар томилгооны сонсгол;

30.1.2.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийн албан тушаалд нэр дэвшигчийг зөвшилцөхөөр Улсын Их Хуралд санал болгосон тохиолдолд зөвшилцөх сонсгол;

30.1.3.Улсын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд ирүүлсэн тохиолдолд нэр дэвшигчийн талаар танилцах сонсгол.

30.2.Энэ хуулийн 30.1.1, 30.1.2, 30.1.3-т заасан албан тушаалд нэр дэвшигчийн сонголыг заавал зохион байгуулна. Улсын Их Хурлаас албан тушаалтныг томилох, зөвшилцөх, танилцахтай холбогдуулан Улсын Их Хурлын таваас доошгүй гишүүн хүсэлт гаргасан, эсхүл сонсгол хийхээр хуульд тусгайлан заасан бол нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулна.

30.3.Нэр дэвшигчийн сонсгол нь олон талын тэнцвэртэй оролцоо, баримт, судалгаанд үндэслэн дараах зорилгыг хангана:

30.3.1.нэр дэвшигч нь тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан эсэх, зохих мэдлэг, чадвар, туршлага, мэргэшилтэй эсэхийг олон нийтэд танилцуулах;

30.3.2.нэр дэвшигч хараат бусаар ажиллах, ёс зүйн шаардлага хангасан эсэхийг нээлттэй, ил тодоор хэлэлцэх;

30.3.3.нэр дэвшигчийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хангах.

30.4.Нэр дэвшигчийн сонголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ зохион байгуулна.

30.5.Байнгын хорооны гишүүдийн гуравны нэг хүрэлцэн ирснээр сонголыг хүчинтэйд тооцно.

30.6.Нэр дэвшигч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонсголд оролцоогүй бол Улсын Их Хурал тухайн албан тушаалд томилохоос татгалзах үндэслэл болно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар сонсголд оролцоогүй бол сонголыг энэ хуульд заасны дагуу дахин зарлаж зохион байгуулна.

30.7.Нэр дэвшигчийн сонголыг зохион байгуулахад энэ хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах журам, эдгээрт нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийг удирдлага болгох бөгөөд Байнгын хороо эдгээрт нийцүүлэн сонсголын дэгээ өөрөө тогтооно.

30.8.Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах журмыг Улсын Их Хурал батлах бөгөөд уул журмыг баталснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст хавсралтуудын хамт байршуулна.

30.9.Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах танхимын болон техникийн бэлтгэл хангах, сонсголын тэмдэглэл хөтлөх, сонсгол даргалагчийн даалгаснаар сонсголын журам зөрчигчийг сонсголоос гаргах, сонсголыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулах, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг урьж оролцуулах, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх ажлыг Байнгын хорооны Ажлын алба хариуцна.

30.10.Энэ хуульд заасны дагуу холбогдох баримт бичиг, зар, бусад мэдээллийг цахим хуудаст байршуулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээх, нийтэд мэдээлэхэд Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс техник, зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

31 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсгол даргалагч, түүний эрх, үүрэг

31.1.Нэр дэвшигчийн сонсголын даргалагчийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно. Сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална.

31.2.Сонсгол даргалагч нь Нийтийн сонсголын тухай хуулийн 17 дугаар зүйлд зааснаас гадна дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

31.2.1.сонсголын бэлтгэлийг хангах;

31.2.2.сонсголыг товлосон цагт эхлүүлж, дэгийн дагуу явуулах;

31.2.3.гишүүдэд болон оролцогчид асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх;

31.2.4.сонсголд уригдан ирсэн хүмүүст гишүүдийн асуултад хариулах, тайлбар хийх зөвшөөрөл өгөх;

31.2.5.сонсголын тайланг хэлбэржүүлэх, ёсчлох ажлыг зохион байгуулах;

31.2.6.хүндэтгэн үзэх шалтгаантай гишүүнд чөлөө өгөх;

31.2.7.сонсголын дэгийн биелэлтэд хяналт тавьж, сонсголд оролцогчдоос түүнийг биелүүлэхийг шаардах;

31.2.8.сонсголын дэг зөрчигчид энэ хуульд заасан арга хэмжээ авах;

31.2.9.оролцогчийн асуулт, санал, мэдээлэл нь сонсголын сэдэвт хамааралгүй, эсхүл ялгаварлан гадуурхсан, доромжилсон, хувийн шинжтэй, эсхүл зохисгүй үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох;

31.2.10.сонсголын дэгийг зөрчсөн, эсхүл энэ хуулийн 32.8-д заасан үйлдэл гаргасан оролцогчийн үг хэлэх эрхийг сануулахгүйгээр хасах;

31.2.11.сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх;

31.2.12.сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах.

32 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсголд оролцогчийн болон бусад этгээдийн эрх, үүрэг

32.1.Нэр дэвшигчээс асуулт асуух, нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан эсхүл хангаагүй тухай санал хэлэх, мэдээлэл өгөх тухай хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд, шинжээчийг сонсголд оролцогч гэнэ.

32.2.Нэр дэвшигчийн сонсголд оролцогч нь Нийтийн сонсголын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

32.3.Сонсголд оролцогч нь нэр дэвшигч тухайн албан тушаал тавигдах шаардлага хангасан эсхүл хангаагүй тухай санал хэлэх, нэр дэвшигчээс асуулт асуух бөгөөд Байнгын хорооны гишүүний асуултад хариулна.

32.4.Сонсголд оролцогчийн асуулт, санал болон холбогдох мэдээлэл нь нэр дэвшигчийн мэдлэг, чадвар, туршлага, мэргэшил, ёс зүй, хараат бус, бие даасан байдал, тухайн албан тушаалд томилогдвол хийх ажлын төлөвлөгөөний талаар байна.

32.5.Сонсголыг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулагдаж байгаа эсэхэд хяналт тавих талаар хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг ажиглагч гэнэ. Ажиглагч нь сонсголын үед нэр дэвшигчээс болон бусад оролцогчдоос асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.

32.6.Сонсголд холбогдох асуудлаар мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, нэр дэвшигчийн талаар саналтай иргэн, хэвлэл, мэдээллийн төлөөллийн оролцоог заавал хангана.

32.7.Эрхэлж байгаа албан тушаалын хувьд сонсголд оролцох үүрэг хүлээсэн төрийн албан хаагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонсголд оролцох, тайлбар өгөхөөс татгалзсан бол Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.17-д заасан нийтийн сонсголыг зохион байгуулах, сонсголд оролцох журам, хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзнэ.

32.8.Сонсголд оролцогч, ажиглагч, бусад хүн нь сонсголын явцад бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, басамжлах, яриаг нь таслах, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.

32.9.Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор сонсголыг дохионы хэлмэрчтэй явуулна.

32.10.Сонсголд эмзэг бүлгийн эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцох, ажиглах боломжийг хангасан байхаар зохион байгуулна.

32.11.Байнгын хорооны гишүүн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.5-д заасны дагуу нэр дэвшигчтэй хамаарал бүхий этгээд бол энэ тухайгаа сонсгол эхлэхээс өмнө нийтэд мэдэгдэх үүрэгтэй.

33 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах үе шат

33.1.Нэр дэвшигчийн сонсголыг дараах үе шатаар зохион байгуулна:

- 33.1.1.нэр дэвшигчийг санал болгох;
- 33.1.2.нэр дэвшигчийг судлах;
- 33.1.3.сонсголыг товлон зарлах;
- 33.1.4.сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх;
- 33.1.5.сонсголыг явуулах;
- 33.1.6.сонсголын тайлан гаргах.

34 дүгээр зүйл.Нэр дэвшигчийг санал болгох

34.1.Хуульд заасны дагуу эрх бүхий этгээд нэр дэвшигчийг томилуулах, зөвшилцөх, эсхүл танилцуулахаар Улсын Их Хуралд санал болгох бөгөөд нэр дэвшигч нь тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангаж байгаа талаарх мэдээлэл болон нэр дэвшүүлэх саналаа холбогдох Байнгын хороонд ирүүлнэ.

34.2.Байнгын хороо нэр дэвшүүлэх саналыг хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор нэр дэвших тухай хүсэлтийг нэр дэвшигчээс гаргуулан авна.

34.3.Энэ хуулийн 34.2-т заасан нэр дэвших тухай хүсэлтийн загварыг Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах журмын хавсралтаар батлах бөгөөд уул хүсэлт нь нэр дэвшигчийн танилцуулга, тухайн албан тушаалд тавих нийтлэг болон тусгай шаардлага, томилогдвол хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл зэрэг агуулга бүхий дэлгэрэнгүй мэдээллийг нэр дэвшигчээс гаргуулан авахад чиглэнэ.

34.4.Нэр дэвшигч нь нэр дэвших тухай хүсэлтийг Байнгын хороонд хүлээлгэн өгснөөр сонсголд оролцох болон танилцуулга, нэр дэвших тухай хүсэлтийг олон нийтэд мэдээлж хэвлэн нийтэлнэ гэдгийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

34.5.Нэр дэвшигчийг Монгол Улсын Их Хуралд санал болгосон этгээд нь энэ хууль, Нийтийн сонсголын тухай хууль, Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах журам болон нэр дэвшигчийн сонсголын талаарх мэдээллийг нэр дэвшигчид урьдчилан танилцуулах үүрэгтэй.

34.6.Нэр дэвшүүлэх тухай эрх бүхий этгээдийн санал болон энэ хуулийн 34.2-т заасан нэр дэвших тухай хүсэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, холбогдох бусад баримт бичгийг Байнгын хороо хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй. Нэр дэвших тухай хүсэлтийг цахим хуудаст заавал нийтэлнэ.

35 дугаар зүйл.Нэр дэвшигчийг судлах

35.1.Байнгын хорооны гишүүд нэр дэвшигчийн талаар судалсны үндсэн дээр сонсголын үеэр асуух асуулт, саналаа бэлтгэнэ.

35.2.Байнгын хороо нь нэр дэвшигчийн мэдлэг, чадвар, ёс зүй, мэргэшил, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий нэг эсхүл хэд

хэдэн шинжээч /цаашид “хараат бус шинжээч” гэх/-ийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүний гуравны хоёрын саналаар томилно.

35.3.Энэ хуулийн 35.2-т заасан дүгнэлт гаргах үүргийг тухайн чиглэлийн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагад хариуцуулах шийдвэрийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүний гуравны хоёрын саналаар гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд хараат бус шинжээчийг томилохгүй.

35.4.Энэ хуулийн 35.3-т заасны дагуу томилогдсон мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага нь хараат бус шинжээчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

35.5.Энэ хуулийн 35.2, 35.3-т заасны дагуу томилогдсон хараат бус шинжээч, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

35.5.1.нэр дэвшигчийн баримт бичиг, олон нийтээс ирүүлсэн саналыг судлах;

35.5.2.нэр дэвшигчтэй болон бусад этгээдтэй ярилцлага хийх зэргээр мэдээлэл цуглуулах;

35.5.3.нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дэлгэрэнгүй тайлан бичих;

35.5.4.нэр дэвшигчийн талаарх дэлгэрэнгүй тайланг нэр дэвшигчийн сонсгол болон Байнгын хорооны хуралдаанд танилцуулах.

35.6.Энэ хуулийн 34.1, 34.2-т заасан болон холбогдох бусад баримт бичгийг Байнгын хорооны гишүүдэд болон хараат бус шинжээчид цаасан болон цахим хэлбэрээр хүргүүлэх ажлыг Байнгын хороо хариуцан зохион байгуулна.

35.7.Нэр дэвшигчийг санал болгосон этгээд болон бусад байгууллага, албан тушаалтан нэр дэвшигчийн талаарх баримт, мэдээллийг Байнгын хорооны гишүүн, эсхүл хараат бус шинжээчийн хүсэлтийн дагуу гаргаж өгөх үүрэгтэй.

36 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсголыг товлон зарлах

36.1.Энэ хуулийн 34.6-д заасан хүсэлт, мэдээллийг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулснаас хойш ажлын таван өдрийн дотор Байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигчийн сонсголыг товлон зарлана.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасны дагуу сонсголыг товлон зарлахдаа сонсгол явуулах огноо, цаг, оролцох хүний тоо, оролцогч, ажиглагчийг хэрхэн бүртгэх, бүртгэл эхлэх, дуусах хугацаа, нэр дэвшигчийн ажлын туршлага, боловсролын талаарх танилцуулга, нэр дэвших тухай хүсэлтийг байршуулсан цахим хуудас, нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг бичгээр хүлээн авах цахим болон шуудангийн хаяг, бусад холбогдох мэдээллийг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол давтамж, хүртээмжтэй байдлаар нийтэд мэдээлнэ.

36.3.Нэр дэвшүүлэх тухай эрх бүхий этгээдийн санал, нэр дэвших тухай хүсэлт, нэр дэвшигчийн ажлын туршлага, боловсролын талаарх танилцуулгыг

байршуулснаас хойш 14-өөс доошгүй хоногийн хугацаанд сонирхогч этгээдээс нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг цахимаар эсхүл шуудангаар хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй.

36.4.Энэ хуулийн 36.3-т заасны дагуу асуулт, санал хүлээн авах хугацааг Байнгын хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

36.5.Энэ хуулийн 36.4-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 14 хоногийн дотор сонсгол явуулна.

37 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсголд оролцогч болон бусад этгээдийг бүртгэх, мэдэгдэх

37.1.Сонсголд оролцогч, ажиглагчийн тоог Байнгын хороо тогтоох бөгөөд нэр дэвшигч тухайн албан тушаал тавигдах шаардлага хангасан эсхүл хангаагүй тухай саналтай оролцогчийг сонсголд тэнцвэртэй оролцуулна.

37.2.Сонсголд оролцох иргэн, хуулийн этгээд нь сонсгол явуулах өдрөөс ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах журмын хавсралтаар баталсан загварын дагуу холбогдох хүсэлтийг гарган Байнгын хороонд бүртгүүлнэ. Байнгын хорооноос оролцогчид хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл, сонсголд оролцох асуудлаар зааварчилга өгнө.

37.3.Сонсголд оролцогч нь нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан эсхүл хангаагүй тухай санал, мэдээлэл, асуултаа бичгээр гаргаж өгөх эрхтэй бөгөөд энэ нь сонсголд оролцож үг хэлэхэд саад болохгүй.

37.4.Энэ хуулийн 37.2-т заасны дагуу бүртгүүлэх хүсэлтийг цахимаар эсхүл шуудангаар илгээж болох бөгөөд Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар эрэмбэлэн бүртгэж, баталгаажуулна.

37.5.Хэвлэл, мэдээллийн байгууллага сонсголд оролцох хүсэлтээ сонсгол явуулахаас ажлын нэгээс доошгүй өдрийн өмнө цахимаар, эсхүл шуудангаар Байнгын хороонд ирүүлнэ.

37.6.Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, тухайн чиглэлийн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг сонсгол даргалагчийн болон Байнгын хорооны гишүүний урилгаар сонсголд оролцуулж болно.

37.7.Байнгын хороо энэ хуулийн 37.2, 37.5, 37.6-д заасны дагуу бүртгэсэн нэрсийг сонсгол даргалагчид танилцуулж, оролцогч, ажиглагч, шинжээч, хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөллийн нэрсийг бүртгүүлсэн дарааллын дагуу сонсгол эхлэхээс 24-өөс доошгүй цагийн өмнө Улсын Их Хурлын цахим хуудсанд байршуулна.

37.8.Сонсголд оролцож, тодорхой асуудлаар тайлбар, мэдээлэл хийх төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, шинжээч нарт сонсгол болохоос ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө мэдэгдэх бөгөөд тэдний нэрсийг энэ хуулийн 37.7-д заасны дагуу нийтэд мэдээлнэ.

38 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсгол явуулах

38.1.Сонсгол даргалагч сонсголоор хэлэлцэх асуудал болон сонсгол зарласан огноо, оролцогч, ажиглагч, дуудагдсан албан тушаалтан, шинжээч, хараат бус шинжээч, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, тайлбар хийх бусад байгууллага, хүний нэр, сонсголын дэгийг 10 минутад багтаан танилцуулна.

38.2.Сонсгол даргалагч эсхүл Байнгын хорооны гишүүн нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг 10 минутад багтаан хийнэ.

38.3.Нэр дэвшигч нь 20 минутад багтаан тухайн албан тушаалд томилогдвол хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, эзэмшсэн боловсрол, ажлын туршлагаа танилцуулна.

38.4.Энэ хуулийн 35.2, 35.3-т заасны дагуу томилсон хараат бус шинжээч эсхүл мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын дүгнэлтийг 20 минутад багтаан сонсоно. Сонсгол даргалагч болон Байнгын хорооны гишүүн дүгнэлттэй нь холбогдуулан асуулт асууж болно.

38.5.Нэр дэвшигчээс асуулт асуух саналтай Байнгын хорооны гишүүдийн дарааллыг сонсгол даргалагч тогтооно. Дарааллыг тогтоохдоо Байнгын хорооны бүрэлдэхүүн дэх олонх болон цөөнхийн төлөөлөл тэнцвэртэй асуух зарчим баримтална.

38.6.Байнгын хорооны гишүүн нэр дэвшигчээс асуух асуулт нь 4 минут байх бөгөөд 4 хүртэл удаа асуулт асуух эрхтэй. Хариулт хангалтгүй гэж үзвэл нэмэлт хугацаа олгох эсэхийг сонсгол даргалагч шийдвэрлэнэ.

38.7.Энэ хуулийн 38.6-д заасны дагуу Байнгын хорооны гишүүд нэр дэвшигчээс асуулт асуусны дараа сонсголд оролцогчдын зүгээс нэр дэвшигчээс асуулт асууна. Оролцогчийн нэр дэвшигчээс асуух асуулт нь 4 минут байх бөгөөд 1 удаа нэмэлт асуулт асуух эрхтэй.

38.8.Энэ хуулийн 36.3-т заасны дагуу ирүүлсэн асуулт, саналыг сонсгол даргалагч эсхүл Байнгын хорооны гишүүн танилцуулж нэр дэвшигчээс хариулт авна.

38.9.Байнгын хорооны гишүүд болон оролцогчид нэр дэвшигчээс асуулт асууж хариулт авч дууссаны дараа нэр дэвшигчтэй холбогдуулан үг хэлнэ. Дарааллыг тогтоохдоо Байнгын хорооны бүрэлдэхүүн дэх олонх болон цөөнхийн төлөөллийг тэнцвэртэй хангах, нэр дэвшигч тухайн албан тушаал тавигдах шаардлага хангасан болон хангаагүй тухай саналтай оролцогчийг тэнцвэртэй сонсох зарчим баримтална.

38.10.Энэ хуулийн 38.9-д заасны дагуу Байнгын хорооны гишүүний үг хэлэх хугацаа 10 минут, сонсголд оролцогчийн үг хэлэх хугацаа 5 минут байна. Шаардлагатай тохиолдолд нэмэлт цаг сунгах асуудлыг хуралдаан даргалагч шийдвэрлэнэ.

38.11.Үг хэлэх, асуулт асуухдаа энэ хуулийн 32.8-д заасан хориглолтыг зөрчсөн эсхүл сонсгол даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан бол сонсгол даргалагч сонсголын дэгийг сахихыг шаардах, шаардлагыг

үл биелүүлбэл оролцогчийг сонсголоос гаргах зэрэг зайлшгүй шаардлагатай хязгаарлах арга хэмжээ авна.

38.12.Сонсгол даргалагч сонсголыг хааж үг хэлнэ.

38.13.Сонсголыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон нийгмийн сүлжээгээр шууд дамжуулан олон нийтэд ил тод явуулна.

39 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсголыг нээлттэй, хаалттай явуулах

39.1.Нэр дэвшигчийн сонсголыг нээлттэй явуулна.

39.2.Нэр дэвшигчийн сонсголын үед хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай асуудал гарсан бол сонсголыг хаалттай хэлбэрээр үргэлжлүүлж болно.

39.3.Энэ хуулийн 39.2-т заасны дагуу сонсголыг хаалттай хэлбэрээр үргэлжлүүлэх шийдвэрийг сонсголд оролцож байгаа Байнгын хорооны гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

39.4.Сонсголыг хаалттай хэлбэрээр үргэлжлүүлэн явуулахад энэ хуулийн 38.1, 38.2, 38.3, 38.4, 38.5, 38.6, 38.7, 38.8, 38.9, 38.10, 38.11, 38.12, 38.13-т заасныг баримтална.

40 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсголыг цахимаар явуулах

40.1.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу өндөржүүлсэн эсхүл бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед сонсголыг цахимаар зохион байгуулах эсэхийг Байнгын хороо шийдвэрлэж болно.

40.2.Сонсголд оролцож байгаа Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар сонсголыг танхимын болон цахим хэлбэрийг хослуулан явуулж болно.

40.3.Цахим сонсголын программ нь Байнгын хорооны гишүүд болон сонсголын оролцогч, ажиглагчид байршлаасаа үл хамааран дүрсээ харан нэгэн зэрэг сонсох болон ярих боломжтой байна.

40.4.Сонсголд оролцогч, ажиглагч холбогдох хууль тогтоомж, сонсголын дэг, эрх, үүрэгтэй танилцсан тухай мэдэгдлийг ирүүлсний дараа цахим холбоосыг илгээнэ.

40.5.Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах журмын хавсралтаар баталсан оролцогч, ажиглагчийн бүртгэлд бичсэн цахим хаягаар цахимаар оролцох холбоосыг хүргүүлнэ.

40.6.Сонсголыг цахимаар эсхүл танхимтай хослуулан явуулахад энэ хуулийн 38 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

41 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсголын тайлан гаргах

41.1.Нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулснаас хойш ажлын хоёр өдрийн дотор сонсголд оролцсон Байнгын хорооны гишүүд хаалттай хуралдаж, нэр

дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан эсхүл хангаагүй талаарх дүгнэлтийг цуглуулсан баримт, мэдээлэл, сонсголын дүнд үндэслэн олонхын саналаар гаргаж сонсголын тайланд тусгана.

41.2.Сонсголд оролцсон гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр энэ хуулийн 41.1-д заасан хуралдааныг хүчинтэйд тооцох бөгөөд зөвхөн сонсголд оролцсон Байнгын хорооны гишүүд тайланг хэлэлцэж санал хураалгана.

41.3.Энэ хуулийн 41.1, 41.2-т заасны дагуу сонсголын тайлан гаргах хуралдаанд сонсголд оролцоогүй Байнгын хорооны гишүүн оролцож болох бөгөөд саналын эрхгүй байна.

41.3.Сонсголын тайланг ажлын таван өдрийн дотор Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ.

41.5.Сонсголын тайланг Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулах журмын хавсралтаар баталсан загварын дагуу бичнэ. Тайлан нь нэр дэвшигч шаардлага хангасан эсэх тухай дүгнэлт, түүний үндэслэлийг агуулсан байх бөгөөд тайланд нэр дэвшүүлэх санал, нэр дэвших тухай хүсэлт, холбогдох бусад баримтыг хавсаргана.

41.6.Сонсголын явцад ил болсон асуудал, түүнийг шийдвэрлэх зөвлөмж, эсхүл бусад асуудлын талаар сонсголын тайланд тусгаж болно.

41.7.Сонсголын тайланг нийтлэхээс ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө нэр дэвшигч болон түүнийг санал болгосон этгээдэд хүргүүлнэ.

41.8.Энэ хуулийн 41.1-д заасан хугацаа өнгөрснөөс хойш ажлын таван өдрийн дотор сонсголын тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст нийтлэх бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй.

41.9.Сонсголын тайланг Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлэх бөгөөд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулна.

41.10.Сонсголын тайланд нэр дэвшигчийг тухайн албан тушаалд тавигдах шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гарсан эсэхээс үл хамааран Байнгын хорооны хуралдаанаар нэр дэвшигчийн асуудлыг хэлэлцэн санал, дүгнэлт гаргах бөгөөд эрх бүхий этгээд томилгооны шийдвэр гаргахдаа тухайн тайланд дурдсан дүгнэлт, түүний үндэслэл, баримт, мэдээллийг харгалзан үзнэ.

42 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсголын тэмдэглэл

42.1.Улсын Их Хурлын Тамгын газар нэр дэвшигчийн сонсголын тэмдэглэлийг аудио хэлбэрээр ажлын хоёр өдрийн дотор, бичгэн хэлбэрээр ажлын таван өдрийн дотор хийж, сонсгол даргалагч гарын үсэг зурж ёсчилсон тэмдэглэлийг байгууллагын албан ёсны цахим хуудсанд ажлын гурван өдрийн дотор байршуулна.

42.2.Сонсголын тэмдэглэлд сонсголыг зохион байгуулсан огноо, байрлал, эхэлсэн дууссан цаг, сонсгол даргалагч, оролцогч, ажиглагчийн овог, эцгийн нэр, өөрийн нэр, хаяг, сонсголын ирц болон оролцогч, ажиглагчид эрх, үүргийг тайлбарласан байдал, оролцогчийн тайлбар, баримтыг шинжилсэн талаар бичнэ.

42.3.Сонсгол дууссаны дараа сонсголын үйл ажиллагаа болон сонсголын үед хэлэлцэгдсэн асуудал, асуулт, хариулт, мэдээлэл, дүгнэлт зэрэгтэй холбогдуулан маргаан үүсгэхгүй.

43 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсголын зардал

43.1.Нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулахтай холбогдон гарах аливаа зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

43.2.Хараат бус шинжээчийн зардал, төлбөрийн хэмжээг хуульд заасны дагуу тогтооно.

43.3.Хараат бус шинжээчийн ажлын хөлс болон сонсгол зохион байгуулахтай холбоотой зардал, нөхөн төлбөр, ажлын хөлсний хэмжээг холбогдох Байнгын хороо тогтооно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО

Нэгдүгээр дэд бүлэг Хянан шалгах /мөрдөн шалгах/ түр хорооны эрх зүйн байдал

44 дүгээр зүйл.Хянан шалгах түр хороог байгуулах

44.1.Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор уг хороог заавал байгуулна.

44.2.Энэ хуулийн 44.1-д заасан хянан шалгах түр хороо нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг мөрдөн шалгах арга хэрэгслээр хянан шалгаж, дүнг тогтоосон хугацаанд Улсын Их Хуралд тайлагнах үүрэгтэй.

44.3.Энэ хуулийн 44.1-д асуудлаар Улсын Их Хуралд тогтоолын төсөл өргөн мэдүүлэх бөгөөд тогтоолын төсөлд хянан шалгах түр хорооны мөрдөн шалгалтын сэдэв, хүрээ хязгаар, тухайн асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тодорхой тусгана.

44.4.Энэ хуулийн 44.3-т заасан тогтоолын төслийг өргөн мэдүүлэхээр Улсын Их Хурлын даргад хүргүүлэх бөгөөд ийнхүү хүргүүлснээс хойш ажлын гурван өдөрт багтаан хүлээн авна.

44.5.Тогтоолын төслийг энэ хуулийн 44.4-т заасны дагуу өргөн мэдүүлсэн бол Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасан дэгийн дагуу чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлын дарааллыг харгалзахгүйгээр нэн даруй хэлэлцэж, хянан шалгах түр хороо байгуулах тогтоол батална.

44.6.Тогтоолын төслийг холбогдох Байнгын хороо хэлэлцэж хянан шалгах түр хорооны мөрдөн шалгалтын сэдэв, хүрээ хязгаар Үндсэн хуульд харшилсан эсэх

талаар санал, дүгнэлт, түр хорооны гишүүнийг томилох санал гаргаж, нэгдсэн хуралдаанд оруулна.

44.7.Улсын Их Хурал тогтоолын төсөлд тусгасан хянан шалгах түр хорооны мөрдөн шалгалтын сэдэв, хүрээ хязгаар нь Үндсэн хуульд харшилсан гэж холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт гаргасан, эсхүл санаачлагч гишүүд санал нэгдэн зөвшөөрснөөс бусад үндэслэлээр тэдгээрийг өөрчлөхгүй.

44.8.Хянан шалгах түр хорооны мөрдөн шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг өөрчлөхөөр бол энэ хуулийн 44.6, 44.7-д заасны дагуу Улсын Их Хурлын тогтоолоор өөрчилнө.

44.9.Хянан шалгах түр хороог зургаан сар хүртэл хугацаагаар байгуулах бөгөөд шаардлагатай бол мөн хугацаагаар хоёр удаа сунгаж болно. Хянан шалгах түр хороо тайлан, санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулснаар уг хороо татан буугдсанд тооцно.

44.10.Хянан шалгах түр хороо /цаашид “Түр хороо” гэх/-ны үйл ажиллагаа нь хуулийн тогтоомжийн биелэлтийг хянан шалгах Улсын Их Хурлын эрх хэмжээний хүрээнд байна. Хянан шалгах түр хорооноос шүүх болон эрх бүхий бусад байгууллагын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс оролцох, заавар өгөхийг хориглоно.

44.11.Энэ хуулийн 44.7-д заасны дагуу мөрдөн шалгалтын сэдэв, хүрээ хязгаарыг Үндсэн хуульд харшилсан гэж өөрчилсөн нь үндэслэлгүй гэж үзвэл түр хороо байгуулах санал гаргасан гишүүд Улсын Их Хурлын тухайн тогтоол Үндсэн хууль зөрчсөн хэмээн Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаж болно.

45 дугаар зүйл.Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн

45.1.Түр хороо 19 хүртэл гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

45.2.Түр хорооны бүрэлдэхүүнийг тогтоохдоо Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн төлөөллийг хувь тэнцүүлэх боловч түр хорооны бүрэлдэхүүний гуравны нэгээс доошгүй нь цөөнхийн төлөөлөл байх, Улсын Их Хурал дахь нам, эвсэл бүрийн төлөөллийг оролцуулах зарчмыг баримтална.

45.3.Нам, эвслийн бүлэг энэ хуулийн 45.2-т заасан зарчмын дагуу түр хорооны бүрэлдэхүүнд оруулах гишүүдийн нэрийг өөрөө тогтоож холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. Нам, эвслийн бүлэгт харьяалалгүй Улсын Их Хурлын гишүүн түр хорооны бүрэлдэхүүнд орох хүсэлтээ холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ. Байнгын хороо ирүүлсэн нэрийг өөрчлөхгүй.

45.4.Улсын Их Хурлын гишүүний өмнөх эсхүл одоогийн үйл ажиллагаа нь мөрдөн шалгах тухайн асуудалтай холбоотой бол уг гишүүнийг түр хорооны бүрэлдэхүүнд оруулахыг хориглоно.

45.5.Түр хорооны дарга нь түр хорооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, түр хорооны хуралдааныг даргална.

45.6.Хянан шалгах түр хорооны даргыг түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно. Түр хорооны хяналт шалгалтын сэдвээс

хамааран шаардлагатай гэж үзвэл түр хорооны даргыг түр хорооны бүрэлдэхүүнд орсон цөөнхийн төлөөллөөс сонгоно.

46 дугаар зүйл.Хянан шалгах түр хорооны бүрэн эрх

46.1.Хянан шалгах түр хороо нь Байнгын хорооны нийтлэг бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 46.1.1.нотлох баримт цуглуулах;
- 46.1.2.нотлох баримтыг нийтийн сонсголоор шинжлэн судалж, үнэлэх;
- 46.1.3.төрийн байгууллагаас нотлох баримт гаргуулж авах;
- 46.1.4.нотлох баримт гаргаж өгөх тухай хүсэлт гаргах;
- 46.1.5.нотлох баримт гаргаж өгөхийг хүн, хуулийн этгээдээс шаардах;
- 46.1.6.гэрчээр дуудах, гэрчээс мэдүүлэг авах, асуулт тавих;
- 46.1.7.шинжээч томилох, тайлбар, мэдүүлэг авах;
- 46.1.8.хянан шалгагч томилох;
- 46.1.9.газар дээр нь очиж үзэх, тэмдэглэл үйлдэх;
- 46.1.10.бичиг баримтад дүн шинжилгээ хийх;
- 46.1.11.тайлан, шаардлагатай бол тогтоолын төсөл боловсруулж Улсын

Их Хуралд танилцуулах;

46.1.12.энэ хуулийн 69 дүгээр зүйлд заасан шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйн талаарх мэдээлэл эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах;

46.1.13.хуульд заасан бусад.

47 дугаар зүйл.Түр хорооны үйл ажиллагааны зохион байгуулалт

47.1.Түр хороо асуудлыг хуралдаанаараа шийдвэрлэх бөгөөд түр хорооны даргын санаачилгаар, эсхүл түүний нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь шаардсанаар түр хорооны хуралдааныг хуралдуулна.

47.2.Түр хорооны хуралдааныг гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзнэ.

47.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

47.4.Түр хорооны шийдвэр тогтоол хэлбэртэй байна. Түр хороо зөвхөн өөрийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой асуудлаар тогтоол батална.

47.5.Түр хорооны хуралдааныг хуралдуулахаас гурваас доошгүй хоногийн өмнө түүний хэлэлцэх асуудал, хуралдааны товыг гишүүдэд урьдчилан мэдэгдэнэ.

47.6.Түр хороо зохион байгуулалтынхаа асуудлыг хуралдаанаараа шийдвэрлэж, нотлох баримтыг сонсголоор шинжлэн судална.

47.7.Хуульд өөрөөр заагаагүй бол түр хорооны хуралдааныг нээлттэй явуулна.

47.8.Түр хорооны дарга эсхүл гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь энэ хуулийн 46.1.12-т заасан мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж болно.

Хоёрдугаар дэд бүлэг Нотлох баримт

48 дугаар зүйл.Нотлох баримт цуглуулах шийдвэр

48.1.Түр хорооны хуралдаанаар мөрдөн шалгалтын сэдвийн хүрээнд шаардагдах нотлох баримтыг цуглуулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд энэ тухай түр хороо тогтоол гаргана.

48.2.Түр хорооны нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь гэрчээр дуудах, шинжээч томилох, нотлох баримт гаргуулах, хянан шалгагч томилох, газар дээр нь очиж үзэх, бичиг баримтад дүн шинжилгээ хийх зэргээр нотлох баримтыг цуглуулах тухай тогтоолын төсөл санаачилбал түр хороо энэ тухай тогтоол гаргах үүрэгтэй.

48.3.Энэ хуулийн 48.2-т заасан төсөл санаачилснаас хойш 14 хоногийн дотор түр хороо тогтоол гаргаагүй бол тухайн тогтоолыг батлагдсанд тооцож, нотлох баримт цуглуулна.

48.4.Энэ хуулийн 48.3-т заасны дагуу гарсан тогтоол нь нотлох баримт цуглуулах тухай түр хорооны тогтоолтой адил хүчин чадалтай.

49 дүгээр зүйл.Нотлох баримт

49.1.Улсын Их Хурлын тогтоолд заасан хяналт шалгалтыг явуулахад ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.

49.2.“Баримтат мэдээлэл” нь гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, тайлбар, мэдүүлэг, хянан шалгагчийн тайлан, дүгнэлт, тайлбар, мэдүүлэг, холбогдох байгууллага, албан тушаалтан, хүн, хуулийн этгээдээс ирүүлсэн баримт мэдээлэл, баримт бичиг, бичгийн хэлбэртэй бусад баримт, хуульд заасны дагуу бэхжүүлсэн кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, хэрэв тухайн асуудлаар өмнө нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажил явуулсан бол хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл болон энэ хуульд заасны дагуу цуглуулсан бусад баримтаар тогтоогдоно.

50 дугаар зүйл.Гэрчээр дуудах

50.1.Гэрч гэж мөрдөн шалгах асуудал, үйл баримтыг нягтлан тодруулахад ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг хэлнэ.

50.2.Түр хороо гэрчийг дуудан ирүүлж, сонсголд биечлэн оролцуулж мэдүүлэг авна. Гэрч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаанд биечлэн оролцох боломжгүй бол түүний мэдүүлгийг бичгээр авахаар түр хороо шийдвэрлэж болно.

50.3.Гэрч түр хорооны дуудсанаар хүрэлцэн ирэх, үнэн зөв мэдүүлэх үүрэгтэй бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаантай бол энэ талаар сонсгол товлогдохоос өмнө түр хороонд заавал мэдэгдэнэ.

50.4.Түр хороо гэрчээр дуудах тухай мэдэгдлийг гэрчид сонсгол эхлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө хүргүүлэх үүрэгтэй. Гэрчээр дуудах тухай

мэдэгдэлд мөрдөн шалгалтын сэдэв, мэдүүлэг авах асуудал, сонсгол болох он, сар, өдөр, цаг, минут, газар, хууль зүйн мэргэжлийн туслалцаа авах болон бусад эрх, үүрэг, мэдүүлэг өгөөгүй буюу зайлсхийсний үр дагаврын талаар тусгана.

50.5.Гэрч дараах тохиолдолд мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй:

50.5.1.гэрчээс асуусан асуултад хариулах нь тухайн гэрчийг эсхүл түүний гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийг гэмт хэрэгт буруутгаж болзошгүй нөхцөл үүссэн;

50.5.2.хуульд өөрөөр заагаагүй бол хуульч, өмгөөлөгч болон бусад этгээд нь мэргэжлийн үүргээ гүйцэтгэх явцад мэдэж нууцлалыг хадгалах үүрэг хүлээсэн үйл баримтын талаар.

50.6.Гэрч энэ хуулийн 50.5-д заасны дагуу мэдүүлэг өгөхөөс татгалзах үндэслэлээ тайлбарлах бөгөөд татгалзлыг хүлээн авах эсэхийг түр хороо шийдвэрлэнэ.

50.7.Гэрч мэдүүлэг өгөхтэй холбоотой гарсан зардлаа нотолсны үндсэн дээр улсын төсвөөс нөхөн төлүүлэх эрхтэй.

50.8.Хянан шалгалтын явцад гэрчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэдгээрийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх ажиллагааг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу явуулна.

51 дүгээр зүйл.Шинжээч томилох

51.1.Түр хороо нь мөрдөн шалгалтын явцад тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлаар дүгнэлт гаргуулахаар шинжээч томилох бөгөөд дүгнэлт гаргах хугацааг тухайн шинжээчтэй тохиролцон тогтооно.

51.2.Шинжээч тогтоосон хугацааны дотор тухайн асуудлыг тал бүрээс нь бүрэн, бодитой, хараат бусаар шинжилж, үнэн зөв дүгнэлтийг бичгээр гаргах бөгөөд түр хороо хүсэлт тавибал сонсголд биечлэн оролцож амаар мэдүүлэг өгнө.

51.3.Шинжээч нь энэ хуулийн 50.5-д заасан үндэслэлээр дүгнэлт гаргахаас татгалзаж болно.

51.4.Энэ зүйлд өөрөөр заагаагүй бол шинжээчийг дуудан ирүүлэх болон холбогдох бусад харилцаанд энэ хуулийн 50 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

52 дугаар зүйл.Бичмэл нотлох баримт

52.1.Түр хороо мөрдөн шалгалт явуулахад ач холбогдол бүхий бичгийн хэлбэртэй баримтыг бичмэл нотлох баримт гэнэ. Цахим нотлох баримтыг бичмэл нотлох баримтад тооцно.

52.2.Бичмэл нотлох баримтыг түр хороонд эх хувиар нь, хэрэв тухайн баримтын эх хувийг өгөх боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өгнө. Түр хороо шаардлагатай гэж үзвэл тухайн баримтын эх хувийг шаардан авах эрхтэй.

52.3.Төрийн байгууллага, хуулийн этгээд нь бичмэл нотлох баримтыг өөрийн байгууллагын архивын “хуулбар үнэн” гэсэн тэмдэг дарж баталгаажуулна.

52.4.Өмнө нь хуульд заасны дагуу цугларсан нотлох баримтын шаардлага хангасан материалыг хуулбарласан тохиолдолд бичмэл нотлох баримтыг нотлох баримтын шаардлага хангасан гэж үзнэ.

52.5.Түр хорооноос тайлан гаргасны дараа бичмэл баримтын эх хувийг түүнийг гаргаж өгсөн этгээд хүсвэл буцаан өгч болно. Харин уг баримтын нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг мөрдөн шалгалтын материалд үлдээнэ.

53 дугаар зүйл.Төрийн байгууллага, албан тушаалтнаас нотлох баримт гаргаж өгөх

53.1.Монгол Улсын Засгийн газар, яам, агентлаг болон түүний харьяа байгууллага, төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газар нь түр хорооноос эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан хүсэлтийн дагуу түүний тогтоосон хугацааны дотор нотлох баримтыг бүрэн гүйцэд гаргаж өгөх үүрэгтэй.

53.2.Энэ хуулийн 53.1-д заасны дагуу ирүүлсэн нотлох баримт нь шаардлага хангаагүй гэж үзвэл түр хороо шаардлагад нийцүүлэн ирүүлэх хугацаатай үүрэг өгөх бөгөөд холбогдох байгууллага, албан тушаалтан албан бичигт заасан хугацааны дотор нэмэлт нотлох баримт гаргаж өгөх үүрэгтэй.

53.3.Ерөнхийлөгч, Ерөнхий сайд эсхүл Засгийн газрын гишүүн энэ хуулийн 53.1, 53.2-д заасан үүргээ биелүүлээгүй бол энэ нь Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар Улсын Их Хурлын наймаас доошгүй гишүүн Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаж болно.

54 дүгээр зүйл.Хүн, хуулийн этгээдээс нотлох баримт гаргаж өгөх

54.1.Хуульд өөрөөр заагаагүй бол түр хороо нь мөрдөн шалгалтад ач холбогдол бүхий нотлох баримтыг гаргаж өгөхийг хүн, хуулийн этгээдээс шаардах эрхтэй бөгөөд холбогдох этгээд түр хорооны тогтоосон хугацаанд, хуульд заасан хүрээнд тус шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

54.2.Түр хороо, түүний гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад байгууллага, хувь хүний нууцтай танилцсан бол тухайн байгууллага хувь хүний зөвшөөрөлгүйгээр, эсхүл хуульд зааснаас бусад тохиолдолд задруулж болохгүй.

55 дугаар зүйл.Хянан шалгагч томилох

55.1.Түр хорооны гишүүн хянан шалгагч томилох санал гаргасан бол түр хорооны хуралдаанд оролцсон гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар томилно. Хянан шалгагч томилох тухай түр хорооны тогтоолд хянан шалгагчийн ажлын даалгавар, шаардлагатай бол ажиллах хугацааг тогтооно.

55.2.Хянан шалгагч нь сүүлийн таван жил улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухайн асуудлаар мэргэжлийн дүгнэлт гаргах чадвартай, гурваас

доошгүй жил тухайн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулсан туршлагатай Монгол Улсын иргэн, хуулийн этгээд байна.

55.3.Хянан шалгагч нь түр хорооны мөрдөн шалгалтын бэлтгэл хангах зорилгоор энэ хуулийн 55.1-д заасан даалгаврын хүрээнд доор дурдсан ажиллагааг хараат бусаар явуулна:

55.3.1.шаардлагатай нотлох баримтыг бүрдүүлэх;

55.3.2.энэ хуулийн 53.1, 54.1-д заасны дагуу нотлох баримт гаргаж өгөхийг шаардах;

55.3.3.мэдээлэл авах зорилгоор хүнээс тайлбар авах;

55.3.4.газар дээр нь очиж үзэх, тэмдэглэл үйлдэх;

55.3.5.бичиг баримтад дүн шинжилгээ хийх.

55.4.Энэ хуулийн 55.3.2-т заасны дагуу нотлох баримтыг гаргаж өгөөгүй бол хянан шалгагч энэ хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу нотлох баримтыг цуглуулах тухай тогтоол гаргуулах саналаа түр хороонд гаргана.

55.5.Хянан шалгагч нь түр хорооны өмнө ажлаа хариуцах бөгөөд олон нийтэд зориулсан мэдээлэл хийхгүй.

55.6.Хянан шалгагч нь мөрдөн шалгалтын дүнд үндэслэн тайлан бичгээр гаргаж, сонсголд амаар танилцуулах бөгөөд уг тайлантай танилцах боломжийг түр хорооны гишүүн бүрт олгоно. Түр хорооноос авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх зөвлөмжийг тайланд тусгаж болно.

55.7.Хянан шалгагч энэ хуулиар хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн бол түр хорооны нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар түүнийг огцруулна.

Гуравдугаар дэд бүлэг

Хянан шалгах түр хорооны сонсгол

56 дугаар зүйл.Нотлох баримтыг сонсох

56.1.Нотлох баримтыг энэ дэд бүлэгт заасны дагуу сонсголоор шинжлэн судална.

56.2.Нотлох баримтыг сонсгох ажиллагаанд энэ хуульд өөрөөр заагаагүй бол Нийтийн сонсголын тухай хуульд заасан нийтлэг журмыг баримтална.

56.3.Доор дурдсанаас бусад тохиолдолд сонсголыг нээлттэй явуулж, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулна:

56.3.1.төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой асуудал;

56.3.2.гэрч эсхүл гуравдагч этгээдийн хувийн амьдралтай холбоотой бөгөөд олон нийтэд мэдээлбэл түүний хууль ёсны ашиг сонирхлыг хохироох үйл баримт;

56.3.3.олон нийтэд мэдээлбэл Монгол Улсын язгуур ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах асуудал.

56.4.Энэ хуулийн 56.3-т заасан үндэслэлээр түр хорооны гишүүн нийтийн сонсголыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг хаалттай явуулах горимын санал гаргавал гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх бөгөөд шийдвэрийн үндэслэлээ нийтэд танилцуулна.

57 дугаар зүйл. Сонсголыг товлон зарлах

57.1.Нотлох баримтыг шинжлэн судлах сонсгол /цаашид “сонсгол” гэх/ болохоос долоогоос доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

57.2.Нээлттэй сонсголд хэвлэл мэдээллийг тэнцвэртэй оролцуулах бөгөөд танхимын багтаамжид тохируулан иргэд, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.

57.3.Хянан шалгах түр хорооны сонсголд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар зөвшөөрснөөс бусад тохиолдолд хуралдааны явцад дуу эсхүл дүрсний бичлэг хийх, зураг авахыг хориглоно.

58 дугаар зүйл. Сонсголыг нээх

58.1.Түр хорооны дарга, эсхүл түүний томилсон түр хорооны гишүүн сонсголыг даргалах бөгөөд сонсголыг нээж, сонсох асуудлын сэдэв, дараалал, дэгийг танилцуулна.

58.2.Сонсголын ирцийг Тамгын газар бүртгэж, ирээгүй гэрч, шинжээч, хянан шалгагч, ажиглагч болон холбогдох бусад этгээдэд сонсголын товыг мэдэгдсэн эсэх, ямар шалтгаанаар ирээгүй болохыг сонсгол даргалагчид илтгэн танилцуулна.

58.3.Сонсгол даргалагч түр хорооны бүрэлдэхүүн, гэрч, шинжээч, хянан шалгагч, орчуулагч, хэлмэрч, ажиглагч болон бусад оролцогчдыг танилцуулна.

59 дүгээр зүйл. Сонсголд оролцогчийн эрх, үүргийг тайлбарлах, дэг сахиулах

59.1.Сонсгол даргалагч гэрч, шинжээч, хянан шалгагч, бусад оролцогчид хууль сануулж, эрх, үүргийг нь танилцуулна.

59.2.Сонсголын танхимд орсон хэн бүхэн парламентыг хүндэтгэх үүрэгтэй бөгөөд сонсголын дэгийг сахих, сонсгол даргалагчийн хууль ёсны шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

59.3.Сонсгол даргалагч сонсголын дэг сахиулах бөгөөд дэг зөрчигчдөд сануулах, танхимаас хөөж гаргана.

60 дугаар зүйл. Нотлох баримтыг шинжлэн судлах дараалал

60.1.Сонсголыг үр дүнтэй явуулах, ялгаатай байр сууриудыг шударгаар илэрхийлэх боломж олгох үүднээс нам, эвслийн бүлэг тус бүрт асуулт тавих эрхийг нь тэнцвэртэй эдлүүлэх, гэрч, шинжээч, хянан шалгагчаас мэдүүлэг, тайлбар авах, шинжээчийн дүгнэлт болон хянан шалгагчийн тайланг сонсох, бичмэл болон бусад нотлох баримтыг уншиж сонсох, шинжлэн судлах дарааллыг тогтооно.

60.2.Энэ хуулийн 60.1-д заасан дарааллыг түр хороо хуралдаанаараа шийдвэрлэнэ.

60.3.Нотлох баримтыг шинжлэн судлах зорилгоор гэрч, шинжээч, хянан шалгагч болон бусад оролцогчдоос сонсгол даргалагч болон түр хорооны гишүүд асуулт асууж болно.

61 дүгээр зүйл.Гэрчийн мэдүүлэг сонсох

61.1.Сонсгол даргалагч гэрчийг танхимд оруулна. Хэрэв мөрдөн шалгах тухайн асуудлаар хоёр ба түүнээс дээш гэрч байгаа бол гэрчийг тус тусад нь асууна. Сонсголд дуудагдсан гэрчийн мэдүүлгийг сонсох хүртэл түүнийг танхимаас түр гаргана. Гэрчүүдийг хооронд нь харилцуулахгүй байлгах талаар сонсгол даргалагч шаардлагатай арга хэмжээ авна.

61.2.Сонсгол даргалагч гэрчээс мэдүүлэг авахын өмнө түүний биеийн байцаалт, эрх, үүргийг танилцуулж, мөрдөн шалгах асуудлын талаар мэдэх зүйлээ үнэн зөв мэдүүлэх үүрэгтэйг сануулж, мэдүүлэг өгөхөөс зайлсхийх, санаатайгаар худал мэдүүлбэл хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулж, тэмдэглэлд гарын үсэг зуруулна.

61.3.Гэрчийн мэдүүлэг сонссоны дараа хуралдаан даргалагч, улмаар түр хорооны гишүүд асуулт тавина.

61.4.Мөрдөн шалгалтын сэдэвтэй холбоогүй, тодорхойгүй, салаа утгатай, хөтөлсөн, гэмт хэрэгт буруутгасан, доромжилсон шинжтэй асуулт тавихыг хориглоно.

61.5.Гэрчид тавьсан асуулт нь энэ хуулийн 61.4-т заасан агуулгатай байвал сонсгол даргалагч тухайн асуултыг алгасаж хариулт авахгүйгээр дараагийн асуултыг асууна. Асуултыг алгасах саналыг гэрч хуралдаан даргалагчид гаргаж болно. Асуултыг алгасах тухай гишүүд санал зөрөлдвөл тухайн асуултыг алгасах эсэхийг сонсголд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэнэ.

61.6.Гэрчүүдийн мэдүүлэгт ноцтой зөрүү байвал тэдгээрийг нүүрэлдүүлэн мэдүүлэг авч болно. Түр хорооны гишүүн нь мэдүүлгийн зөрүүтэй байдлыг гаргаж тавих, үүнтэй холбогдуулан нэмэлт асуулт асуух, эсхүл давтан асуух эрхтэй.

61.7.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гэрчээс мэдүүлэг авахтай холбоотой бусад харилцаанд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд⁸ заасан журмыг жишиг болгоно.

62 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлт сонсгох

62.1.Шинжээчийн дүгнэлтийг сонсголд уншиж сонсгоно.

⁸Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 9 дугаарт нийтлэгдсэн.

62.2.Шинжээч сонсголд оролцож байгаа бол өөрийн дүгнэлтийг тайлбарласны дараа нь сонсгол даргалагч болон түр хорооны гишүүдийн асуултад хариулна.

62.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол шинжээчээс мэдүүлэг авах, асуулт тавихад энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

62.4.Түр хороо шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй, тодорхой бус болон үндэслэлгүй, эсхүл шинжээч зөрүүтэй дүгнэлт гаргасан гэж үзвэл нэмэлт эсхүл дахин шинжилгээ хийлгэж болно.

63 дугаар зүйл.Хянан шалгагчийн тайланг сонсгох

63.1.Хянан шалгагчийн тайланг уншиж сонсгоно.

63.2.Хянан шалгагч сонсголд биечлэн оролцож байгаа бол өөрийн тайланг тайлбарласны дараа сонсгол даргалагч болон түр хорооны гишүүдийн асуултад хариулна.

63.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хянан шалгагчаас тайлбар авах, асуулт тавихад энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

63.4.Түр хороо хянан шалгагчийн тайлан эргэлзээтэй, тодорхой бус болон үндэслэлгүй, эсхүл хянан шалгагч зөрүүтэй тайлан гаргасан гэж үзвэл нэмэлт эсхүл дахин хянан шалгалт хийлгэж болно.

64 дүгээр зүйл.Бичмэл нотлох баримтыг уншиж сонсгох

64.1.Түр хорооны гишүүн бүрт бичмэл нотлох баримттай танилцах боломж олгох бөгөөд түр хороо шаардлагатай гэж үзсэн бол бичмэл нотлох баримтыг сонсголын үеэр уншиж сонсгоно.

64.2.Нээлттэй сонсголын үед бичмэл нотлох баримтад энэ хуулийн 56.3-т заасан нөхцөл илэрвэл тухайн бичмэл нотлох баримтын холбогдох хэсгийг эсхүл бүхэлд нь уншиж танилцуулахгүй. Хувийн болон байгууллагын нууцыг хамгаалахын тулд хувийн захидал, бичгийг тухайн этгээд зөвшөөрсөн бол нээлттэй сонсголд уншиж сонсгоно. Хэрэв зөвшөөрөөгүй бол хувийн захидал, бичгийг уншиж сонсгох болон шинжлэх ажиллагааг хаалттай сонсголоор гүйцэтгэнэ.

64.3.Хянан шалгаж байгаа бичмэл нотлох баримт хуурамч болохыг мэдсэн этгээд уг баримтыг нотлох баримтаас хасуулах хүсэлтийг түр хороонд гаргана. Бичмэл нотлох баримт хуурамч гэж мэдэгдсэн этгээд энэ тухайгаа нотлох үүрэгтэй. Бичмэл нотлох баримт хуурамч эсэхийг шалгахын тулд шинжилгээ хийлгэх болон бусад нотлох баримт шаардан авч болно.

64.5.Бичмэл нотлох баримт хуурамч байсан нь тогтоогдвол түр хороо түүнийг нотлох баримтаас хасах бөгөөд шаардлагатай гэж үзвэл хуурамч баримт бичгийн талаар эрх бүхий байгууллагад гомдол, мэдээлэл гаргаж болно.

65 дугаар зүйл.Сонсголыг хаах

65.1.Гэрч, шинжээч, хянан шалгагчаас мэдүүлэг, тайлбар авах, шинжээчийн дүгнэлт болон хянан шалгагчийн тайланг уншиж сонсгох, бичмэл болон бусад

нотлох баримтыг уншиж сонсгон шаардлагатай асуултад хариулт авч дууссан гэж үзвэл сонсгол даргалагч сонсголыг хаана.

65.2.Сонсголын тэмдэглэлийг Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу хөтөлж, баримтжуулах бөгөөд тэмдэглэлийг бэлэн болсноос хойш ажлын таван өдрийн дотор Улсын Их Хурлын цахим хуудаст байрлуулна.

Дөрөвдүгээр дэд бүлэг
Хянан шалгах түр хорооны хуралдаан, тайлан,
санал, дүгнэлт, зардал

66 дугаар зүйл.Түр хорооны хуралдаан

66.1.Түр хороо хаалттай хуралдаанаар сонсголоор цуглуулж шинжлэн судалсан нотлох баримтад үндэслэн тайлан, болон санал, дүгнэлт гаргана.

66.2.Түр хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан нийтлэг дэгийг баримтална.

67 дугаар зүйл.Хянан шалгах түр хорооны тайлан

67.1.Түр хороо нь сонсголоор цуглуулж шинжлэн судалсан нотлох баримтад үндэслэн гаргасан тайланг холбогдох санал, дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд танилцуулна.

67.2.Тайлан нь мөрдөн шалгах ажиллагааны агуулга, цуглуулсан нотлох баримт, тогтоогдсон үйл баримт, мөрдөн шалгалтын дүгнэлт, шаардлагатай гэж үзвэл холбогдох саналыг багтаана.

67.3.Түр хорооны тайлан, санал, дүгнэлт нь шүүхэд үүрэг хүлээлгэхгүй бөгөөд түр хорооны цуглуулсан нотлох баримтыг шүүн таслах ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд үнэлэх эсэхийг шүүх шийднэ.

67.4.Түр хорооны тайлан гаргахад цөөнх болсон гишүүн тусгай саналаа бичгээр гаргаж тайланд хавсаргах эрхтэй бөгөөд энэ тухайгаа түр хорооны санал, дүгнэлтэд тусгуулна.

67.5.Түр хороо шаардлагатай гэж үзвэл мөрдөн шалгах ажиллагааны явцыг нэгдсэн хуралдаанд танилцуулна.

67.6.Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө мөрдөн шалгалтын даалгаврыг гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүсвэл түр хороо нь тухайн үед хийгдсэн мөрдөн шалгалтын явцын тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулж, архивын нэгж үүсгэн хадгалуулна.

67.7.Түр хорооны тайланг эцэслэснээс хойш 14 хоногийн дотор тусгай санал, гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, тайлбар, бичмэл нотлох баримтын хамт Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна.

67.8.Түр хороо тайлан, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулснаар уг хороог татан буугдсанд тооцно.

68 дугаар зүйл.Хянан шалгах түр хорооны зардал

68.1.Түр хорооны мөрдөн шалгах үйл ажиллагаатай холбогдон гарах аливаа зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

68.2.Гэрч, шинжээчийн зардал, төлбөрийн хэмжээг хуульд заасны дагуу тогтооно.

68.3.Хянан шалгагчийн ажлын хөлс болон мөрдөн шалгалттай холбоотой зардал, нөхөн төлбөр, ажлын хөлсний хэмжээг Түр хороо тогтооно.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

69 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

69.1.Энэ хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтаар албан тушаалтанд оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй нь Улсын Их Хурлын хяналт шалгалтыг тасалдуулсан бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37.9-д заасан парламентыг үл хүндэтгэх үйлдэл гэж үзэн Төрийн албаны тухай, эсхүл Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

69.2.Холбогдох албан тушаалтан энэ хуульд заасан нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр түр хороонд ирүүлээгүй, гаргаж өгөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай, Зөрчлийн тухай эсхүл бусад хуульд заасан хариуцлага оногдуулна.

69.3.Гэрч түр хорооны дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, эсхүл мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.

69.4.Гэрч зориуд худал мэдүүлэг өгсөн бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага оногдуулна.

69.5.Түр хорооноос томилсон шинжээч нь тогтоосон хугацаанд дүгнэлт гаргаж өгөөгүй, эсхүл дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, эсхүл мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан бол Зөрчлийн тухай хуулиар хариуцлага оногдуулна.

69.6.Шинжээч зориуд худал дүгнэлт гаргасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага оногдуулна.

69.7.Гэрч, шинжээч, сонсголд оролцогч, ажиглагч, бусад хүн сонсголын дэг зөрчсөн бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

69.8.Түр хорооноос шаардсан нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй, гаргаж өгөөгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.

70 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

70.1.Энэ хуулийг 2021 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

A blue ink handwritten signature, consisting of a series of loops and curves, positioned below the text "Гарын үсэг".

1.2.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛЭХ ХУУЛИЙН ТӨСӨЛ

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2.Улсын Их Хурлын наймаас доошгүй гишүүн энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Улсын Их Хурлын хүсэлтийг гаргана.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэр дэвшигчийн сонсгол хийж” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 16 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 16.3 дахь хэсэг нэмсүгэй:

1/16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг:

“3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 53.3-т заасан асуудлаар Улсын Их Хурлын наймаас доошгүй гишүүн хүсэлт гаргаж болно.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэр дэвшигчийн сонсгол хийж” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийн “хороогоор хэлэлцүүлнэ” гэснийг “хороо нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна” гэж, 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн “15 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулна. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад тэнцэж, хамгийн өндөр оноо авсан иргэнийг нэр дэвшүүлж, Хууль зүйн байнгын хороо томилгооны сонсгол зохион байгуулна” гэснийг “60 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулна. Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад тэнцэж, хамгийн өндөр оноо авсан иргэнийг нэр дэвшүүлж, Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлнэ” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 65.10 дахь хэсэг нэмсүгэй:

1/65 дугаар зүйлийн 65.10 дахь хэсэг:

“65.10.Зөвлөл бүрэн эрхэд хамаарах асуудлаар Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.”

2 дугаар зүйл. Төрийн албаны тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.3 дахь хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэр дэвшигчийн сонсгол хийсний үндсэн дээр” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн доор дурдсан агуулгатай 6.8 дахь хэсэг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.8 дахь хэсэг:

“6.8. Төрийн аудитын байгууллага өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.”

2 дугаар зүйл. Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэр дэвшигчийн сонсгол хийж” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨВ БАНК /МОНГОЛБАНК/-НЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 30 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмсүгэй:

1/30 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5. Монголбанк өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. ”

2 дугаар зүйл. Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэр дэвшигчийн сонсгол хийж” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэр дэвшигчийн сонсгол хийж” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Төв Банк /Монголбанк/-ны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “улирал тутам” гэснийг “шаардлагатай тохиолдолд” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.3 дахь хэсэг нэмсүгэй:

1/9 дугаар зүйлийн 9.3 дахь хэсэг:

“9.3. Хороо өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. ”

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “Улсын Их Хурлаас” гэсний дараа “нэр дэвшигчийн сонсгол хийж” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Статистикийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Улсын Их Хурлаас” гэсний дараа “нэр дэвшигчийн сонголт хийж” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэр дэвшигчийн сонсгол хийж” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14¹ дүгээр зүйлийн 14^{1.3} дахь хэсгийн “Улсын Их Хурал” гэсний дараа “нэр дэвшигчийн сонсгол хийж” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**НИЙТИЙН СОНСГОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Нийтийн сонсголын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.2.8, 6.2.9 дэх заалт:

“6.2.8.зөвшилцөх сонсгол;

6.2.9.хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол.”

2/18 дугаар зүйлийн 18.9 дэх хэсэг:

“18.9.Энэ хуулийн 6.2.4, 6.2.7, 6.2.8-д заасан сонсголыг нэр дэвшигчийн сонсгол гэж нэрлэх бөгөөд тэдгээрийг зохион байгуулж, явуулахдаа Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтын “олонх” гэсний дараа “, эсхүл цөөнхийн бүлэг” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх заалтын “Төсвийн зарлагын хяналтын дэд хороо” гэсний дараа “, цөөнхийн бүлэг” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нийтийн сонсголын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийн “Хууль тогтоомжийн төслийн сонсгол явуулахаар бол тухайн Байнгын хорооны нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар шийдвэрлэнэ” гэснийг “Байнгын хорооны гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хууль тогтоомжийн төслийн сонсгол явуулах санал тавибал уг сонсголыг заавал явуулна” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалтын “нийт гишүүний дөрөвний нэгээс” гэснийг “таваас” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалтын “нийт гишүүний дөрөвний нэгээс” гэснийг “таваас” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “нийт гишүүний дөрөвний нэгээс” гэснийг “таваас” гэж, 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн “томилгооны” гэдгийг “нэр дэвшигчийн, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой” гэж, 20 дугаар зүйлийн 20.3.2 дахь заалтын “томилгооны” гэдгийг “нэр дэвшигчийн, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “, томилгооны” гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Нийтийн сонсголын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Арван тавдугаар бүлэгт доор дурдсан агуулгатай зүйл нэмсүгэй:

“15.33 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны мөрдөн шалгалтад саад учруулах

1.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны сонсголын дэг, журмыг зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, эсхүл гэрч, шинжээч мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан эсхүл мөрдөн шалгалтад саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Шинжээч Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос тогтоосон хугацаанд дүгнэлтийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гаргаж өгөөгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос шаардсан нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй, гаргаж өгөөгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос цуглуулсан нотлох баримтыг устгасан, өөрчилсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “15.12” гэсний дараа “, 15.33” гэж, 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг,” гэсний дараа “15.33 дугаар зүйл,” гэж, 9.1 дүгээр зүйлийн 14 дэх хэсгийн “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “15.33 дугаар зүйл,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг “Зөрчлийн тухай хуулийн 15.33 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шүүгчийн торгох шийтгэлийн биелэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, энэ хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бусад зөрчил үйлдсэн хүнд оногдуулсан шүүгчийн торгох шийтгэлийн биелэлтийг тухайн зөрчилд хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулсан эрх бүхий байгууллага тус тус хариуцна.” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “шүүхэд” гэсний дараа “эсхүл Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 21.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “шүүхэд” гэсний дараа “эсхүл Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хороонд” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 21.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “шүүхэд” гэсний дараа “эсхүл Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороонд” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4.1.1-т “хохирогчийг” гэж заасны дараа “Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрчийг” гэж нэмсүгэй:

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хууль,” гэсний дараа “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй:

1/27 дугаар зүйлийн 27.1.8, 27.1.9 дэх заалт:

“27.1.8.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх;”
27.1.9.төрийн мөнгөний бодлогын зорилтод нийцсэн байх.”

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “Төсвийг төлөвлөх, батлах,” гэснийг “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах,” гэж, 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалтын “улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл” гэснийг “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж” тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дүгээр
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Прокурорын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг нэмсүгэй:

1/16 дугаар зүйлийн 46.8 дахь хэсэг:

“46.8.Энэ хуулийн 46.1, 46.2-т заасны дагуу санал болгосон нэр дэвшигчийн сонсголыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо зохион байгуулна.”

2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**



1.3.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл: Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлээр Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг тогтоохдоо тус зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтад “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах;” эрхтэй гэж заасан.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог...” байгуулах замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангах эрх зүйн үндсийг тогтоосон.

Мөн Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийн 1.3.4-т “Хянан шалгах түр хороог хуулиар тусгайлан тогтоосон эрх хэмжээний хүрээнд мэргэжлийн хараат бус шинжээч томилох, гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах зэрэг арга хэрэгсэл ашиглан Засгийн газар, түүний байгууллага, албан тушаалтан хууль зөрчсөн эсэх, эрх мэдлээ урвуулан ашигласан эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан эсэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэх зорилгоор байгуулах, түр хорооноос гаргасан дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй байх зарчмыг хуульчлах;” гэсний хүрээнд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлах хууль зүйн шаардлага үүссэн.

Практик хэрэгцээ, шаардлага: Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 581 хууль хүчин төгөлдөр үйлчилж байгаа ч тэдгээрийн нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөлөл, тухайн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор гарч байгаа хүндрэл бэрхшээл ямар түвшинд байгаа, цаашид тухайн хууль тогтоомжийг зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох болон тэдгээрийг хэрэгжүүлэхээр Засгийн газраас батлан гаргасан хэм хэмжээний актууд хуульд нийцэж байгаа эсэхэд нэгдсэн хяналт тавих тогтолцоо хангалтгүй байсаар ирлээ.

Албан тушаалтнаас асуулгын хариуг 30 хоногт, асуултын хариуг 14 хоногт багтаан ирүүлэх үүрэгтэй боловч Улсын Их Хурлын гишүүнээс тавьсан асуулга, асуултад ирүүлсэн хариу шаардлага хангахгүй байх, хуульд заасан хугацаанд ирүүлэхгүй байх зөрчил байнга гардаг бөгөөд асуулт, асуулга тодорхой үр дүн, ач холбогдолтой хяналтын арга хэрэгсэл болж чадахгүй байна.

Түүнчлэн, хууль тогтоомжийг сурталчлахтай холбоотой Засгийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээллийг Улсын Их Хуралд танилцуулдаггүй, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийн хэрэгжилт болон улсын төсөв, мөнгөний бодлогын хэрэгжилтийг Улсын Их Хуралд ирүүлэхдээ хэрэгжүүлэхээр заасан зорилт, арга хэмжээг дутуу тайлагнах, төөрөгдүүлсэн мэдээлэл ирүүлэх, төлөвлөсөн зорилтуудын биелэлт хангалтгүй хэрэгжсэний шалтгаан нөхцөл тодорхойгүй байхаас гадна Улсын Их Хурлаас эдгээр мэдээлэлд хараат бус дүн шинжилгээ хийлгэх, хяналт тавих чадавхи сул байна. Улсын Их Хурлын Тамгын газрын холбогдох нэгжээс яамд, холбогдох газруудаас хяналт-шинжилгээ, үнэлгээнд шаардагдах тоо, мэдээллийг гаргуулан авахад хүндрэлтэй, мэдээллийн эх

үүсвэрийг ирүүлэхгүй байх, хугацаа хоцроох, заавал албан бичиг шаардах зэрэг хүнд суртал байнга гардаг байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхий сайд танхимаа бүрдүүлэх эрхээ дангаар эдэлж, Улсын Их Хурлын төсөв батлах бүрэн эрх хязгаарлагдсан зэргээс үүдэн эрх мэдэл хоорондын хяналт-тэнцлийг хангах, хууль тогтоолын биелэлтийг хангах Засгийн газрын үйл ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлж, хянан шалгах арга хэрэгсэл, үйл явцыг нарийвчлан зохицуулах, парламентын хяналт шалгалтад хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага, хөндлөнгийн шинжээч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийн хараат бус байдлыг сайжруулах, хараат бус, бодит мэдээлэлд тулгуурлах, авлига, ашиг сонирхол, хүнд суртлаас ангид, хариуцлагатай гүйцэтгэх засаглалыг бэхжүүлэх, төрийн албаны бүх шатанд хариуцлага, сахилгыг бэхжүүлэх практик хэрэгцээ, шаардлага үүссэн.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик хэрэгцээ шаардлагад нийцүүлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Иймд Улсын Их Хурлын хяналт шалгалттай холбоотой дараах асуудлаар хуулийн зохицуулалт шаардлагатай болсон гэж үзэж байна. Үүнд:

- Засгийн газраас хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулах Үндсэн хуулийн чиг үүргийнхээ хүрээнд хууль тогтоомжийг тайлбарлан таниулах /сурталчлах/ ажлаа Улсын Их Хуралд тогтмол тайлагнах механизм бүрдүүлэх;
- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн улсын төсөв, төсвийн гүйцэтгэлийг батлахдаа Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д нийцэж байгаа эсэх, тэдгээрийн хэрэгжилтийг хэлэлцэхдээ зорилго, зорилт, хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрсэн, хоорондын уялдаа холбоо хэрхэн хангагдаж байгааг тайлагнах тайлагналтын нэгдсэн систем бий болгох;
- Улсын Их Хурлаас хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх арга хэрэгсэл, түүнийг хэрэгжүүлэх субъектууд, хяналт шалгалтын процессыг Улсын Их Хурлын хяналтын хэлбэр тус бүрээр зохицуулж, хариуцлагын механизмтай уялдуулах;
- Улсын Их Хурлаас байгууллагдаг, хараат бус хяналтын байгууллагуудыг чиг үүргийнх нь хүрээнд парламентын хяналтад татан оролцуулах, тэдгээрийн оролцооны үр дүнд түшиглэх эрх зүйн механизмыг бүрдүүлэх;
- Улсын Их Хурлыг хяналт шалгалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь мэргэшсэн экспертүүд, хөндлөнгийн шинжээчид, төрийн бус байгууллага, олон нийтийг татан оролцуулах эрх зүйн механизмыг бүрдүүлэх;
- хууль тогтоомжийн хэрэгжилтээс үүдэн гарч байгаа үр дагаврын талаар хөндлөнгийн эх сурвалжаас мэдээлэл, баримт нотолгоо цуглуулах, сэдэвчилсэн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулах зэрэг шүүмжлэлт мэдээллийн хяналтыг бий болгох;
- хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох, мэдээллийн сан бүрдүүлэх, үнэн зөв, баримт нотолгоонд суурилсан мэдээллээр Улсын Их Хурлыг шуурхай хангах журмыг тогтоох;
- Улсын Их Хурлын түвшинд хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг тодорхой болгох, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тайлагналын системийг бий болгох;

- Хянан шалгах түр хороо /мөрдөн шалгах түр хороо/-ны бүрэн эрх, үйл ажиллагааны журмыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн агуулгад нийцүүлэн нарийвчлан зохицуулах.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийн зорилго нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хангах Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих Улсын Их Хурлын хяналт шалгалтын бүрэн эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чиглэнэ. Хуулийн төсөл нь бүтцийн хувьд доор дурдсан долоон бүлэгтэй байна. Үүнд:

- Нийтлэг үндэслэл;
- Улсын Их Хурлын хяналтын арга хэрэгсэл, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо;
- Улсын Их Хурлын хяналт шалгалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх:
 - нэгдүгээр дэд бүлэг: асуулт, асуулга;
 - хоёрдугаар дэд бүлэг: тайлан, мэдээлэл, илтгэл;
 - гуравдугаар дэд бүлэг: хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;
- Төсвийн хяналт шалгалт;
- Хяналтын сонсгол;
- Хянан шалгах /мөрдөн шалгах/ түр хороо:
 - нэгдүгээр дэд бүлэг: хянан шалгах /мөрдөн шалгах/ түр хорооны эрх зүйн байдал;
 - хоёрдугаар дэд бүлэг: нотлох баримт;
 - гуравдугаар дэд бүлэг: хянан шалгах түр хорооны сонсгол;
 - дөрөвдүгээрдэд бүлэг: хянан шалгах түр хорооны хуралдаан, тайлан.
- Бусад.

Хуулийн төсөлд Монгол Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэх арга хэрэгсэл, хууль зүйн үр дагаварыг нарийвчлан тодорхойлох, мөн Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ төрийн аудитын байгууллага, Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Санхүүгийн зохицуулах хороо, Хүний эрхийн үндэсний комисс, Төрийн албаны зөвлөл зэрэг бие даасан, хараат бус байгууллагад түшиглэн, тэдгээрийг хянан шалгах чиг үүргийнх нь хүрээнд татан оролцуулах, Улсын Их Хурлын хяналт шалгалтын явц, үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх зарчмыг бүрдүүлэх, хяналт шалгалт нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэлбэртэй байх, хяналт шалгалтын арга хэрэгслийг Улсын Их Хурлын зохион байгуулалтын ямар хэлбэрээр хэрэгжүүлэхийг тус бүрт нь тодорхойлон заах, Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлэх хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоог хөгжүүлэх, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн бодлогыг уялдаа холбоотой хэрэгжүүлэхэд чиглэсэн Улсын Их Хурлын хяналт шалгалтын төрөлжсөн мэдээллийн нэгдсэн сан бий болгох, гишүүний асуулт, асуулгыг ялгамжтай тодорхойлж, нарийвчлан зохицуулж, үр нөлөөг нь сайжруулах зорилгоор нэгдсэн хуралдааны үеэр чөлөөт мэтгэлцээн явуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх зохицуулалтыг нарийвчлах, Байнгын, дэд, түр хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хийх хяналт шалгалтыг нарийвчлах, төсвийн хяналтыг тасралтгүй байнгын үйл явц байх нөхцөлийг хангах, хяналтын сонсголын төрлийг тогтоож, журамлах болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах /мөрдөн шалгах/ түр хороо байгуулж, үйл ажиллагааг нь журамлан зохицуулахтай холбоотой харилцааг зохицуулахаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөлд шинээр байгууллага байгуулахтай холбоотой болон улсын төсвийн зардал нэмэгдүүлж, орлого бууруулахтай холбоотой зохицуулалтыг тусгахгүй.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийг хэлэлцэн баталснаар эдийн засаг, нийгмийн дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

- Улсын Их Хурлын хяналт шалгалтын нэгдмэл, цогц байдлыг хангах;
- Төсвийн хяналтыг хэрэгжүүлэх парламентын бүрэн эрх, хяналтын процедур болон чадавхи бүрдсэн байх;
- Улсын Их Хурлын хяналт шалгалтын бүх үйл ажиллагаанд хүний эрхийн хяналт хийгддэг байх;
- шаардлагатай тохиолдолд томилгооны эрх болон хуульд заасан хяналт шалгалтын арга хэлбэрүүдээр дамжуулан Засгийн газрын хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах;
- Улсын Их Хурлын хяналт шалгалтыг нийтийн эрх ашигт нийцсэн байдлаар илүү үр нөлөөтэй, нээлттэй явуулах байнгын тогтолцоо бүрдэх;
- Үндсэн хуулиар хуваарилсан төрийн эрх мэдэл хоорондын хяналт-тэнцэл хангагдаж, хууль тогтоомжийн чанар, хэрэгжилт сайжирснаар нийгэм, хууль зүйн эерэг үр дагавар бий болно гэж тооцож байна.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаарх санал

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл боловсруулахтай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай, Нийтийн сонсголын тухай, Зөрчлийн тухай, Төсвийн тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг баталсны дараа хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сангийн журам, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам, аргачлалыг батлах бөгөөд уг аргачлалаар хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тогтооно.

Хууль санаачлагч





**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАНИЛЦУУЛГА**



1.4.МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу эрх мэдэл хоорондын хяналт-тэнцлийг хангах, Засгийн газрын хууль тогтоомжийн биелэлтийг хангах үйл ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, Улсын Их Хурлын хянан шалгах арга хэрэгсэл, хяналт шалгалтын үйл ажиллагаа, түүнээс гарах үр дагавар болон Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хянан шалгах түр хороо байгуулах, түүний үйл ажиллагааг журамлахтай холбоотой харилцааг бие даасан хуулиар нарийвчлан зохицуулах шаардлага үүссэн.

Түүнчлэн Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн улсын төсөв, төсвийн гүйцэтгэлийг батлахдаа Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д нийцэж байгаа эсэхийг хянах, мөн эдгээр баримт бичгийн хэрэгжилтийг хэлэлцэхдээ тухайн баримт бичгийн зорилго, зорилт нь өөрийн болон урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрч биелсэн, бодлогын зорилго, зорилт хоорондын уялдаа холбоо хэрхэн хангагдаж байгаа зэргийг нэгтгэн хянах механизм бүрдүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн.

Мөн парламентын хяналт шалгалтад хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан байгууллага, хөндлөнгийн шинжээч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, парламентын хяналт шалгалт нь бодит мэдээлэлд тулгуурлан үр нөлөөтэй хяналт шалгалт явуулах замаар хүнд суртлаас ангид, хариуцлагатай гүйцэтгэх засаглалыг бэхжүүлэх, төрийн албаны бүх шатанд сахилга, хариуцлагыг бэхжүүлэх хэрэгцээ, шаардлага бий болсон. Эдгээр хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуулийн төслийг боловсрууллаа.

2017 онд Олон улсын парламентын холбоо, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хамтран дэлхийн 150 гаруй орнуудын парламент болон парламентын гишүүдийн дунд парламентын хяналтын асуудлаар судалгаа явуулж “Дэлхийн парламентын тайлан-2017: Парламентын хяналт ба Парламентаас Засгийн газрыг хянах чадамж” сэдэвт тайлан, судалгаанд авагдсан орнуудын сайн туршлагад тулгуурлан Олон улсын парламентын холбооноос парламентын хяналтыг боловсронгуй болгох чиглэлээр гаргасан зөвлөмж, түүнчлэн парламентын хяналтын эрх зүйн орчин, тогтолцооны талаарх бусад орны туршлага, дэлхий нийтийн парламентын хяналтын тогтолцоо, эрх зүйн орчны жишгийг харьцуулан судалж, өнгөрсөн 30 жилийн хугацаанд Улсын Их Хурлын хуулийн биелэлтэд хяналт тавих онцгой бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд тулгамдаж байсан асуудлыг хууль, эрх зүйн орчин болон практикт тулгарч буй хүндрэл бэрхшээлийг судалсны үндсэн дээр хуулийн төслийг боловсруулсан болно.

Хуулийн төсөл нь бүтцийн хувьд доор дурдсан долоон бүлэгтэй бөгөөд нийт 60 зүйлтэй байна. Үүнд:

- Нийтлэг үндэслэл;
- Улсын Их Хурлын хяналтын арга хэрэгсэл, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоо;
- Улсын Их Хурлын хяналт шалгалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх:
 - нэгдүгээр дэд бүлэг: асуулт, асуулга;

- хоёрдугаар дэд бүлэг: хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;
- гуравдугаар дэд бүлэг: мэдээлэл, тайлан, илтгэл;
- Төсвийн хяналт шалгалт;
- Хяналтын сонсгол;
- Хянан шалгах /мөрдөн шалгах/ түр хороо:
 - нэгдүгээр дэд бүлэг: хянан шалгах /мөрдөн шалгах/ түр хорооны эрх зүйн байдал;
 - хоёрдугаар дэд бүлэг: нотлох баримт;
 - гуравдугаар дэд бүлэг: хянан шалгах түр хорооны сонсгол;
 - дөрөвдүгээр дэд бүлэг: хянан шалгах түр хорооны хуралдаан, тайлан.
- Бусад.

Хуулийн төсөл батлагдсанаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг бодитой, үр нөлөөтэй хянах, төрийн эрх мэдэл хоорондын хяналт-тэнцлийг хангаж, Улсын Их Хуралд итгэх ард түмний итгэлийг нэмэгдүүлэх, хууль тогтоох байгууллагын хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих тогтолцоо, механизмыг уялдуулан системчлэх, сайжруулах нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийг хэлэлцэн баталснаар эдийн засаг, нийгмийн дараах эерэг үр дагавар бий болно. Үүнд:

- Улсын Их Хурлын хяналт шалгалтын нэгдмэл, цогц байдлыг хангана;
- Төсвийн хяналтыг хэрэгжүүлэх парламентын бүрэн эрх, хяналтын процедур болон чадавх бүрдүүлнэ;
- Улсын Их Хурлын хяналт шалгалтын бүх үйл ажиллагаанд хүний эрхийн хяналт хийгддэг болно;
- хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн биелэлтийг төсөв, мөнгөний бодлоготой уялдуулан нэгтгэн хянан хэлэлцсэнээр төсөв үр нөлөөтэй төлөвлөгдөх, хэрэгжих, хөгжилд чиглэсэн байхаас гадна төрийн бодлого үр дүнтэй, бодитой хэрэгжих боломжтой болно;
- хууль тогтоомжийн хэрэгжилтэд үнэлгээ хийн, Улсын Их Хуралд тайлагнаж, зохих арга хэмжээ авдаг тасралтгүй эргэлтийн тогтолцоо бий болсноор Улсын Их Хурлаас батлан гаргах хууль тогтоомжийн чанар сайжирна;
- хянан шалгах түр хорооны үйл ажиллагааг нарийвчлан зохицуулснаар нийтийн эрх ашгийг хөндсөн тодорхой асуудлаар иргэдийг төөрөлдүүлсэн, талцуулсан, холбогдох байгууллагын үйл ажиллагаанд саад учруулдаг зэрэг сөрөг үр дагавар үгүй болно.

Ийнхүү хууль батлагдсанаар Үндсэн хуулиар хуваарилсан төрийн эрх мэдэл хоорондын хяналт-тэнцэл хангагдаж, Засгийн газрын хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны хариуцлага нэмэгдэж, хууль тогтоомжийн чанар, хэрэгжилт сайжирснаар нийгэм, хууль зүйн эерэг үр дагавар бий болно гэж тооцож байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл боловсруулахтай холбоотойгоор Монгол Улсын Их Хурлын тухай, Нийтийн сонсголын тухай, Төсвийн тухай, Зөрчлийн тухай зэрэг 19 хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсрууллаа.

Хууль санаачлагч



II
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛД ХОЛБОГДОХ СУДАЛГАА



2.1.ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫН ҮР АШИГТАЙ ЗОХИЦУУЛАЛТЫН МЕХАНИЗМЫГ БҮРДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛОН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨМЖ

/Парламентын судалгааны хүрээлэн/

Эх сурвалж: Global Parliamentary report-2017:
Parliamentary oversight - Parliament's power to hold
government to account. IPU and UNDP, 2017.

	Парламентын хяналтын механизмын бүрдэл хэсгүүд	Бусад орнуудын сайн туршлага, ОУПХ-ноос гаргасан зөвлөмж, нийтлэг жишиг
1.1.Парламентын хяналтын эрх мэдэл		
Судалгааны дүгнэлт: Сайн засаглалыг хөгжүүлэх, ардчиллыг бэхжүүлэх, Засгийн газрын үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн хэрэгжилтэд үр нөлөөтэй хяналт тавихын тулд Парламент нь мандатын болон хуулиар олгогдсон бүрэн эрхтэй, эрхээ хэрэгжүүлэх бодлого, зохицуулалттай байх шаардлагатай.		
1.1.1	Парламентаас Засгийн газарт хяналт тавих мандатын онцгой бүрэн эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулсан байх. Парламент ба Засгийн газрын хяналт, тайлагналын ялгаатай үүргийг зааглаж, Засгийн газар нь иргэдэд үйлчлэх, Парламент нь түүний үйл ажиллагаанд хяналт тавьж асуух, шалгах, чиглэл өгөх, хариуцлага тооцох эрхтэй байх	Хяналт ба тайлагналын систем нь хоорондоо уялдаа холбоо бүхий дараах 3 цогц үүргийн нэгдэл байх ёстой. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Засгийн газар болон төрийн байгууллагууд нь гаргасан шийдвэр, хэрэгжүүлсэн үйл ажиллагааныхаа үр дүнг Парламент болон ард түмэнд тайлагнах; • Парламент нь Засгийн газар болон бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, шийдвэрт дүн шинжилгээ хийж үндэслэл бүхий цагаа олсон зөвлөмж өгөх; • Засгийн газар нь Парламентаас өгсөн үүрэг, чиглэл, зөвлөмжийг биелүүлж, үр дүнг эргэн тайлагнах.
	Парламентхяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх хангалттай эрх мэдэл ба чадамжтай байх	<ul style="list-style-type: none"> • Хуулиар мандат олгогдсон байх; • Шаардагдах санхүү, хүний нөөц, зохион байгуулалтын институционал бүтэцтэй байх; • Засгийн газраас хараат бусаар хяналт хэрэгжүүлэх чадамжтай, Үндсэн хуулиар олгогдсон засаглалын хяналт тэнцлийг хангах нөхцөл бүрдсэн байх.
	Парламентын хяналтын арга хэрэгсэл ба процессын механизм бүрдсэн байх	Парламент дотооддоо Засгийн газарт хяналт тавих улс төрийн болон процессын архитектуртай байх шаардлагатай. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> • Засгийн газрын сайд нарт тодорхой бодлогын асуудал, түүний санхүүжилттэй холбоотой асуудлаар (үүнд төсвийн асуудал хамаарна) амаар болон бичгээр асуулга, асуулт тавих; • Хариуг Байнгын хороонд сонсох, шийдвэрт өөрчлөлт оруулах, зөвлөмж өгөх, иргэдийн санаа бодлыг сонсох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх гэх мэт.

	Парламентын гишүүдийн хяналтын эрх үүрэг хангагдсан байх	Парламентын гишүүд ард түмнээс сонгогдож, нийтийн эрх ашгийг төлөөлж байгаагийн хувьд тэдний нэрийн өмнөөс гүйцэтгэх засаглалд хяналт тавих Үндсэн хуулиар олгогдсон мандатын эрхтэй байх ёстой.
	Парламентын хяналтын хүрээг тодорхойлсон байх	<p>Парламентын хяналтын цар хүрээний хувьд, Засгийн газар болон төрийн байгууллагуудын үйл ажиллагаа (хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүд, төсвийн хэрэгжилт)-нд хяналт шалгалт хийх, үр дүнг нягтлан шалгах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.</p> <p>Өөрөөр хэлбэл, Парламентаас бодлого, хөтөлбөр, төсөв зэрэг хууль ёсны салбараас гадна иргэдэд өдөр тутмын үйлчилгээ үзүүлж байгаа төрийн байгууллагуудыг хянах эрхтэй байдаг. Зарим оронд Байнгын хороод иргэний нийгэм, академи, хувийн сектор зэрэг олон төрлийн субъектүүдээс баримт нотолгоо бүхий мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх эрхтэй байдаг. Иймээс парламентын хяналтын хууль ёсны хүрээг аль болох өргөнөөр тогтоох, парламентын хяналтаас гадуур нэг ч секторыг үлдээхгүй, ялангуяа үндэсний хэмжээний онцгой, гамшгийн нөхцөл байдал үүссэн ямар ч цаг үед Парламентаас хяналтаа хэрэгжүүлэх чадамжтай байх нь чухал.</p>
	Парламентын хяналтад оролцогчид	Парламент Засгийн газрын үйл ажиллагаанд дангаар дүн шинжилгээ хийж чадахгүй. Тиймээс Парламентад хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, хяналтын мэдээллийн санд нэвтрэх, салбар дундын болон мэргэшсэн хяналтын чиг үүрэг бүхий Засгийн газраас хараат бус бие даасан омбудсман, комисс, зохицуулах хороод, аудитын байгууллага, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд зэрэг субъектүүдтэй хамтран ажиллана.
1.1.2	Үр нөлөөтэй хяналтын тогтолцоог бий болгох шаардлага	Хууль тогтоох үйл ажиллагааны чанарыг сайжруулах, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх шатанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, ардчиллыг хөгжүүлэх, эдийн засаг, нийгмийн хөгжил, хүний эрхийн хамгаалалтыг сайжруулж авилгыг бууруулах, тэгш бус байдлыг арилгах гэх мэт зорилтуудад парламентын хяналт чиглэх ба эцсийн дүндээ бодлогын үр нөлөөг сайжруулах, ардчиллын хөгжилд ахиц гаргах зорилготой.
1.1.3	Парламентын хяналтыг парламентын үндсэн функцуудтай уялдуулах	<ul style="list-style-type: none"> Төлөөллийн мандат авсан Парламентын гишүүн иргэдийн оролцоо, хяналтыг хангаж олон нийтийн санаа бодолд тулгуурлан хяналтын үүргээ биелүүлэх; Хууль тогтоох хүрээнд хуулийн хэрэгжилтийн явцад гарч байгаа хийдэл, зөрчлийг арилгаж хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хууль хэрэгжүүлэх, зөрчлийг арилгуулах чиглэлээр Засгийн газарт шаардлага тавьж ажиллах; төсвийн хяналтын хүрээнд Засгийн газарт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд нь зориулж хуваарилсан төсвийн хөрөнгийг хэрхэн зарцуулсныг Парламент хянах ёстой. Жилийн төсөв, мөнгөний бодлого, төсвийн бодлого, банкны сектор, татвар, төгрөгийн худалдан авах чадвар зэргийг Парламентаас хянах механизмтай байх шаардлагатай.

1.1.4	Парламентын хяналтыг урт хугацааны хөгжлийн нэгдсэн бодлогын хэрэгжилтийг хангах тэргүүлэх чиглэл болгон авч үзэх	<ul style="list-style-type: none"> • Үндэсний хөгжлийн бодлогын зорилтууд хэрхэн хэрэгжиж байгааг урт, дунд, богино хугацаанд нь уялдуулан нэгтгэн тайлагнах хууль зүйн механизм бүрдүүлэх; • “Дэлхийн тогтвортой хөгжлийн бодлогын зорилтууд–2030” гэх мэт бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хяналтыг Парламентаас хэрэгжүүлж улс орныг урт хугацааны нийгэм-эдийн засгийн хөгжилд хөтлөх; • Тогтвортой хөгжил, жендэрийн тэгш байдлыг тэргүүлэх чиглэл болгох.
1.1.5	Парламентын хяналтын бодлого	<p>Институциональ бүтэц:</p> <ul style="list-style-type: none"> • Үндсэн хуулиар засаглалын эрх мэдлийн хуваарилалт, Парламент болон Засгийн газрын эрх үүрэг, зааг ялгааг тодорхойлсон байх; • Парламент нь хяналтын бүрэн эрхээ Засгийн газраас хараат бусаар хэрэгжүүлэх эрх зүйн болон институцийн чадамжтай байх; • Улс төрийн намууд, Парламентад суудалтай сөрөг хүчний зүгээс Засгийн газарт хяналт тавих эрх, боломж хангагдсан байх; • Парламент болон Засгийн газар хоорондын хяналтын механизм бүрдсэн байх; • Олон нийтийн зүгээс Парламентын үйл ажиллагаанд итгэлтэй байх, нийтийн эрх ашгийн үүднээс Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, авилгал, хүний эрхийн зөрчил, тэгш бус байдлыг таслан зогсоож эдийн засаг, нийгэм, хувь хүний хөгжлийг хангана гэдэгт итгэлтэй байх.
1.1.6	Парламентын хяналтад тулгарч буй асуудлууд	Гишүүдийн үг хэлэх, үйл ажиллагаа явуулах эрх чөлөө, Парламент доторх олонх-цөөнх, эрэгтэй-эмэгтэй гишүүдийн оролцооны тэгш байдлыг хангах шаардлагатай.
<p>1.2.Парламентын хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх нь</p> <p>Судалгааны дүгнэлт: Парламентын хяналтыг үр нөлөөтэй явуулахад хууль ёсны эрх үүргээс гадна хяналтыг үр ашигтай хэрэгжүүлэх тогтолцоо, чадавх чухал юм. Тухайлбал: Засгийн газраас хараат бусаар ажиллахад хүрэлцээтэй төсөв, мэргэшсэн ур чадвартай ажилтнууд, үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь авах мэдээллийн сан болон мэдээлэлд дүн шинжилгээ хийх ажилтнуудын чадавхыг бүрдүүлэх шаардлагатай. Ингэснээр Парламентын хяналт мэргэшсэн, олон нийтийн итгэл даахуйц хэмжээнд явагдана.</p>		
1.2.1	Парламентаас хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эрхүүдийг хуулиар баталгаажуулах	<ol style="list-style-type: none"> 1. Үндсэн хуулиар баталгаажсан эрх 2. бусад хуулиар олгосон эрх 3. Дэгийн тухай хуулийн зохицуулалт 4. практик үйл ажиллагаа <p>Мэдээлэл авах эрх, мандатын эрхээ хэрэгжүүлэх журам, дэг тодорхой байх, маргаан шийдвэрлэх чадамж, ил тод байдал, хуулийн зохицуулалт, төсвийн нөлөөлөл, хариуцлагын санхүү зэргийг журамлах шаардлагатай.</p>
1.2.2	Парламентын хяналтыг Засгийн газраас хараат бусаар явуулах чадавх бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> • Засгийн газраас санхүүгийн хувьд хараат бус байх; • Парламент өөрийн төсвөө батлах эрхтэй байх; • Хараат бус мэргэшсэн ажилтнуудтай байх (хяналтыг журмын дагуу явуулах, шаардлагын дагуу процессыг хэрэгжүүлэх, дүн шинжилгээ хийх, хуулийн төсөл бэлтгэх экспертийн түвшний мэдлэг, ур чадвартай улс төрийн

		<p>нөлөөнөөс ангид төвийг сахисан үйл ажиллагаа явуулах ажилтнууд);</p> <ul style="list-style-type: none"> Мэдээлэл авах эрхтэй байх (шаардлагатай мэдээллийг гаргуулж авах, мэдээллийн санд нэвтрэх эрх, Засгийн газрын нэгжүүдийн жилийн тайлан, мэдээ гэх мэт); Парламент нь мэдээлэл, судалгааны үйлчилгээгээр хангагдах, номын сан-мэдээллийн төв, судалгааны алба, төсвийн болон жендэрийн анализ хийх албатай байх.
1.2.3	Парламентын гишүүд хяналтын чиглэлээр хамтран ажиллах хүсэл эрмэлзэл, чадавхтай байх, оролцоо баталгаажсан байх	<ul style="list-style-type: none"> Гишүүд дотроо хяналтын үүргээ хамтран хэрэгжүүлэх; Гишүүд мэдээлэл авах сүлжээтэй, иргэний нийгмийн экспертүүдтэй ойр хамтран ажилладаг, хяналтыг үр ашигтай хэрэгжүүлэх арга зүй, ур чадварыг эзэмшсэн байх; Гишүүд аналитик дүн шинжилгээ хийх, хяналтын үүргээ хэрэгжүүлэх ур чадвараа хөгжүүлэх, сургалтад хамрагдах.
1.2.4	Парламентын хяналтын соёлыг бий болгож төлөвшүүлэх	<ul style="list-style-type: none"> Парламентын хяналтын үр дүн, ач холбогдлыг олон нийтэд ойлгуулах; Хяналтын чиглэлээр хамтран ажиллаж байгаа байгууллагуудаа олон нийтэд таниулах.
1.2.5	Парламентын хяналтын хэрэгжилтэд дотоод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах тогтолцоотой байх	<p>Парламент болон Парламентын гишүүд хяналтын үүргээ хэрхэн биелүүлснээ иргэдийн өмнө тайлагнана. Парламентын хяналтын үйл ажиллагаа тасралтгүй, тууштай, ул суурьтай, баримт нотолгоонд суурилсан байдлаар явагдах шаардлагатай. Иймд парламентын хяналтын үйл ажиллагаанд дотоод мониторинг, үнэлгээ хийдэг байх.</p>
<p>1.3.Парламентын хяналтыг хэрэгжүүлэх арга хэлбэрүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх нь</p> <p>Судалгааны дүгнэлт: Парламентын хороод нь парламентын хяналтыг хэрэгжүүлэх арга хэлбэрүүд болон дүн шинжилгээ хийх чадавхтай байх. Ингэхдээ аль болохоор Засгийн газар болон Парламент дахь улс төрийн намын удирдлагуудаас хараат бус ажиллах боломжтой байх. Хороодын хяналтын мандатын эрх, чиг үүрэг тодорхой байх, хуулиар баталгаажсан байх, хяналт шалгалтын үр дүнг хороод болон Парламентын чуулганаар хэлэлцдэг байх соёлыг бий болгох шаардлагатай. Мөн Парламентын хянан шалгах тусгай хороо байгуулах, хүний эрхийн зөрчил, авилгал, Засгийн газрын үүргийн биелэлт зэрэг онцлох асуудлуудаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж олон нийтийн санаа бодлыг сонсох эрхтэй байх. Хороод нь хяналтыг үр нөлөөтэй явуулах чадвартай, зөвхөн баримт нотолгоо цуглуулах биш олон нийтийн дэмжлэг, оролцоог хангах, ил тод мэдээлэл, гаргасан зөвлөмжийнхөө биелэлтийг хангуулах чадавхтай байх.</p>		
1.3.1	Цөөнхөд боломж олгох (Opportunities for opposition)	<ul style="list-style-type: none"> Хяналтын чиг үүрэгтэй хороог цөөнхийн төлөөллөөр удирдуулах; Нэгдсэн хуралдаан дээр “сөрөг хүчин”-д асуулт, хэлэлцүүлгийн тусгайлсан цаг гаргах; Төсвийн хэлэлцүүлэг болон сайд нарын асуулт хариултыг сонсох үед “хариулах эрх”-ийг ашиглах; Байнгын хороодын тайланд хавсаргах, ажлын хэсэгт оруулах гэх мэт.
1.3.2	Парламентын байнгын хороо (Permanent oversight committees)	<p>Байнгын хороодын хяналт бол парламентын хяналтыг хэрэгжүүлэх гол арга хэлбэр. Олон улсад хороодын олон янзын хэлбэр байх ч тэдгээрээс парламентын хяналтын мандатын эрхтэй хороод нь баримтад тулгуурлан Засгийн газарт асуулга тавих, дүгнэлт зөвлөмж гаргах, Парламент болон олон нийтэд танилцуулах эрхтэй.</p>

	<p>Парламент болон Засгийн газрын хамтын ажиллагааны хүрээнд хяналт явагдах бөгөөд Засгийн газар үүргийнхээ дагуу мэдээллээр хангах, Парламентын хороод тулгамдсан асуудлыг хэлэлцэх үүрэгтэй. Батлан хамгаалах, аюулгүй байдал, бизнесийн нууц болон хувь хүний нэр төртэй холбоотой асуудлыг тусгайлсан журмаар хэлэлцэх ба хорооны гишүүд асуудлыг улс төржүүлэхгүй, баримт нотолгоонд тулгуурлан хэлэлцэх ёстой. Шаардлагатай гэж үзвэл, хорооны гишүүд цөөн хүнийг томилон хяналт шалгалт хийж болох бөгөөд өргөн хүрээтэй ярвигтай асуудлуудыг олон нийт, мэргэжлийн шинжээчид, судлаачид, ТББ-уудыг оролцуулан судлан дүгнэх, тэдний санал бодлыг сонсож хэлэлцэх боломжтой.</p> <p>Гишүүд Засгийн газрын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг нарийвчлан хянах, асуудалд дүн шинжилгээ анализ хийх, цаашид нэгдсэн хуралдаанд асуудлыг танилцуулах, хэлэлцүүлэг хийх шаардлагатай тулгардаг учраас хяналтын хороодын гишүүд тохирсон ур чадвар, техникийг эзэмших шаардлагатай.</p>
	<p>Хяналт шалгалтын тайланг хороодын болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын хуваарьт оруулж, хэлэлцэх тусгайлсан цаг гаргах шаардлагатай. Зарим улсад 2 долоо хоногт 1 удаа тогтоосон байдаг.</p>
	<p>Хяналтын байнгын хороо байгуулах замаар зарим улсад парламентын хяналтыг системтэй, тогтмол хэрэгжүүлж байна. Судалгаанд хамрагдсан орнуудын 80% нь Хяналтын байнгын хороотой байх бөгөөд үүний давуу тал нь хороодын гишүүд парламентын бүрэн эрхийн хугацаанд тогтвортой ажиллах, төлөвлөлт, зохион байгуулалт сайн, мэргэшсэн ажилтнуудтай учраас хяналтын ажлыг илүү гүнзгий, судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан явуулах, үндэслэл бүхий шийдвэр гаргах нөөц боломжтой байдаг. Үндэсний аудитын газар Засгийн газрын төсвийн зарлага, үр дүнг хянахад чухал үүрэгтэй оролцоно.</p>
Нээлттэй сонсгол зохион байгуулах (Committee hearings in public)	<p>Парламентаас хяналт шалгалт явуулж байгаа тодорхой асуудлыг Засгийн газрын төлөөлөл, олон нийт, экспертүүдийг оролцуулан хэлэлцэх нь баримт нотолгоо цуглуулах, мөрдөн шалгах чухал арга хэлбэр бөгөөд Хороодын санаачилгаар зохион байгуулна.</p>
Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх (Monitoring the implementation of legislation)	<p>Хороод нь хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх үүрэгтэй болж эхэлсэн зорилго нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх буюу ямар үр дүнд хүрэв, цаашид ямар арга хэмжээ авах вэ, хэдий хэмжээний нэмэлт эх үүсвэр шаардагдах вэ гэх мэт асуудлуудыг шийдэхэд чиглэгдэнэ. Судалгаанаас үзэхэд, хуулийн хэрэгжилтэд мониторинг хийх үйл ажиллагаа сүүлийн үед парламентын хяналтын чухал арга хэлбэр болсон бөгөөд судалгаанд хамруулсан орнуудын 54% нь ямар нэг байдлаар мониторинг хийдэг гэсэн байна.</p> <p>Жишээ нь, Их Британи 2010 оноос эхлэн хууль батлагдсанаас хойш 3-5 жилийн дараагаар холбогдох байнгын хороо нь хэрэгжилтийг хянан хэлэлцдэг, Италид Парламентын хяналтын газар хариуцан Засгийн газар болон холбогдох бусад институт, эх үүсвэрүүдээс цуглуулсан мэдээлэл дээр үндэслэн хяналт шинжилгээ хийдэг байна. Испанид, жендэрийн тэгш байдлыг хариуцсан дэд хороо жендэрийн хүчирхийллийн асуудлаарх хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийдэг.</p>

	Тайлан, зөвлөмж гаргах (Reports and recommendations)	Хороод нэгдсэн хуралдаанд амаар болон бичгээр тайлан тавих ба судлан шалгах явцад олж илрүүлсэн зөрчил, түүнийг арилгах талаарх дүгнэлт зөвлөмж, шийдвэрийн төсөл хэлэлцүүлнэ.
	Хянан шалгах тусгай хороо байгуулах (Special committee of inquiry)	Парламентын байнгын хороодын зэрэгцээ тухайн Парламентын бүрэн эрхийн хугацаанд үйл ажиллагаа явуулах хянан шалгах тусгай хороог байгуулж, зарим асуудлаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно. Ийм хороод нь хянан шалгаж буй асуудалтай холбогдуулан мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрхтэй байдгаараа онцлогтой. Тухайн асуудлыг шалгаж дуусаад тайланг Парламентад хүргүүлснээс хойш уг хороог татан буулгана. Судалгаанд авагдсан Парламентуудын 90% гаруй нь ийм төрлийн тусгай хянан шалгах хороог байгуулж болох юм гэж хариулсан. Уг хороог үндэсний хэмжээний ноцтой асуудлаар байгуулах ба 2013 онд 81, 2014 онд 84, 2015 онд 101 Хянан шалгах тусгай хороо байгуулагдаж байсан. Уг хороог Парламентын олонхын саналаар байгуулах ба хэнийг хороонд дуудаж яриулах, хэнээс мэдээлэл авах зэрэг асуудлуудад цөөнх түлхүү оролцдог туршлага Австрид байна.
	Засгийн газарт өгсөн үүргийн биелэлтэд мониторинг хийх (Monitoring government commitments)	Парламентад Засгийн газрын сайд нар үүргийн биелэлтээ тайлагнах ёстой. Уганда, Гана, Замби, Энэтхэг, Мьянмар зэрэг орнууд Засгийн газрын үүрэг даалгаврын биелэлтийг хянах Парламентын хороотой.
1.3.3	Нэгдсэн хуралдаан дахь хяналт (Oversight in the plenary)	Нэгдсэн хуралдаан бол улс төрийн хэлэлцүүлэг өрнөдөг том талбар. Парламентын гишүүд нэгдсэн хуралдаан дээр Засгийн газрын үйл ажиллагаа, бодлогын хэрэгжилтийн үр дүнгийн талаар нээлттэй хэлэлцэж, санал шүүмж, асуулт хариулт, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар асуудлыг олон нийтийн анхаарлын төвд аваачих боломжтой байх ёстой. Чуулганы хэлэлцүүлгийн үед асуудлыг нэг бүрчлэн ярихгүй ч гэсэн хэвлэл мэдээллийг оролцуулан асуудлыг авч хэлэлцсэнээр олон нийтэд нээлттэйгээр асуудлыг том зургаар нь хэлэлцэх, улс төрийн үзэл бодлоо илэрхийлэх, нээлттэй байдлаа хангахад чухал ач холбогдолтой.
	Асуулга тавих, хэлэлцэх (Motions and debates)	Парламентын гишүүд Засгийн газрын сайд нарт тавьсан асуулгын хариуг сонсох, нээлттэйгээр хэлэлцэх нь тодорхой асуудлыг нарийвчлан шалгах, олон нийтэд нээлттэй ойлголт өгөх боломж юм. Энэ хэлбэр нь Засгийн газрын сайд нарт шахалт үзүүлж, бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг сайжруулах, Засгийн газар болон сайд нарт итгэл үзүүлэх эсэх болон бусад хариуцлагын асуудлыг ярих боломж олгоно.
	Асуулт тавих, хэлэлцэх (Questions: oral, written)	Энэ бол парламентын хяналтын үндсэн хэлбэрүүдийн нэг. Асуултыг Засгийн газрын гишүүдэд бичгээр болон амаар тавина. Бичгээр тавьж байгаа үед гишүүд холбогдох сайд нараас илүү тодорхой мэдээлэл авах боломжтой бол амаар асуух үед илүү шуурхай хариулт авах, өөрийн улс төрийн байр сууриа илэрхийлэх боломжтой. Мөн Парламентын нэгдсэн хуралдаанд “Засгийн газрын цаг” гаргаж Засгийн газар, холбогдох яамдын сайд нараас асуулт асууж, хариулт авах боломжтой байх шаардлагатай. Ялангуяа сөрөг хүчний хувьд нэгдсэн хуралдааны үйл ажиллагааг мэдээллийн хэрэгслээр дамжуулж байгаа үед

		илүү их асуулт асууж Засгийн газрын гишүүдэд шахалт үзүүлэх сонирхолтой. Бичгээр асуулт асуусан тохиолдолд илүү дэлгэрэнгүй мэдээлэл авч тухайн сэдвийн хүрээндээ гишүүн хэд хэдэн асуулт асуух, ирүүлсэн мэдээллийг дараа дараагийн судалгаа, дүн шинжилгээнд ашиглах, бүрэн мэдээлэлтэй болох боломж бүрддэг гэж судалгаанд авагдсан орнуудын Парламентын гишүүд хариулсан.
1.3.4	Төсвийн хяналт (Oversight of the budget)	<p>Парламент нь төсвийн орлого бүрдүүлэлтээс гадна төрийн санхүү, төсвийн зарцуулалтыг хянах эрхтэй. Засгийн газраас парламентад төсвийн зарцуулалтын саналаа ирүүлэх ба Парламентаас Засгийн газар төсвийн орлогоо хэрхэн бүрдүүлж, хэрхэн зарцуулах гэж байгаа, төсөв зарцуулах тэргүүлэх салбар буюу бодлого нь юу байх, олон нийтийн эрэлт хэрэгцээнд энэ хуваарилалт нийцэж байгаа эсэхийг хянаж, төсвийг аль болох иж бүрэн, ил тод, үндэслэл тооцоотой байлгахыг хичээнэ.</p> <p>Парламентаас төсвийн хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Төсвийн шинжилгээ маш чухал. Энэхүү чадавхыг бүрдүүлснээр Парламентаас төсвийн хувилбаруудыг тооцоолох, Засгийн газраас хараат бусаар төсөв хэлэлцэх чадавх бүрддэг гэж үзэж байна. Парламентын хувьд төрийн санхүүгийн менежмент, төсвийн циклийг хянах асуудал нь мөрдөн шалгах, судалгаа дүн шинжилгээ хийх ур чадварыг шаардах тул улс орнуудын Парламент янз бүрийн түвшинд олон асуудлуудтай тулгарсаар байна.</p>
	Төсвийн хяналтыг хэрэгжүүлэх боломжууд	<p>Дэлхийн 100 Парламентын танхимууд төсвийн хяналтын дараах арга механизмуудыг ашиглаж байна:</p> <ul style="list-style-type: none"> • төсвийн төслийг боловсруулахаас өмнө Парламент дээр төсвийн тэргүүлэх чиглэл, бодлогын баримт бичгийг хэлэлцэж баталдаг - 40%; • төсвийн төслийг Парламентаар хэлэлцэн батлахаас дор хаяж 3 сарын өмнө хүлээж авдаг - 30%; • төсвийн төслийг 1 ба түүнээс олон хороогоор нягтлан шалгадаг - 80%; • төсвийн төсөлд жендэрийн нөлөөллийн анализ хийдэг - 20%; • Парламент өөрөө төсвийн төсөлд өөрчлөлт оруулах эрхтэй - 40%; • төсвийн жилийн туршид Парламентад төсвийн орлого, зарлагын талаарх мэдээллийг тодорхой хугацааны үечлэлээр тогтмол ирүүлдэг - 50%; • Үндэсний аудитын байгууллагаас Парламентад төсвийн талаарх тайлан ирүүлдэг - 90%; • уг тайланг Парламентаар нарийвчлан хэлэлцэх тодорхой журам тогтоодог - 60%; • төсвийн дүн шинжилгээ хийх чадавхтай дотоод бүтцийн нэгжтэй байх - 60%.
	Төсвийн дүн шинжилгээ хийх чадавх бүрдүүлэх	Төсвийн дүн шинжилгээ хийх нь мэргэшсэн ур чадвартай экспертийн ажил. Гишүүдийн хувьд төсвийн концепц болон арга зүйг ерөнхийд нь мэдэх шаардлагатай бол Парламентын ажлын албаны мэргэшсэн шинжээчид нарийвчилсан анализ хийх чадвартай байх. Бусад орнуудын туршлагаас үзвэл энэ чиглэлээр гишүүд болон ажилтнууд тусгайлсан сургалтууд авч байна.

	Мэдээлэл цуглуулах, дата сан бүрдүүлэх	Төсвийн хяналт шинжилгээ хийхэд дата сан бүрдүүлэх нь асуудал чухал. Парламентаас ТХЗ-2030 зорилтуудыг хангах, хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэх хүрээнд ҮСХ-той хамтран ажиллаж ямар мэдээллийг, ямар аргачлалаар, ямар эх үүсвэрээс, хэрхэн бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэх.
	Парламентын Төсвийн шинжилгээний алба	2008 оны дэлхийн хямралаас хойш ихэнх Парламентууд дүн шинжилгээний чадавхаа бэхжүүлэхэд анхаарч Төсвийн шинжилгээний алба (ТША)-ыг дотоод бүтцэдээ байгуулж эхэлсэн, хөндлөнгийн ТША-ны үйлчилгээг ч авч эхэлсэн. ТША нь олон улсын болон үндэсний зохицуулалтад нийцүүлэн төсөвт мониторинг, дүн шинжилгээ хийх, төсвийн техникийн нарийн мэдээллүүдийг хялбаршуулан танилцуулах зэрэг үүрэг хүлээнэ. Италийн туршлагаас үзэхэд, ТША нь макро-эдийн засгийн бодлого, төсвийн төсөөлөлд анализ хийх, төсвийн хэрэгжилтийг ЕХ болон үндэсний хууль тогтоомжуудад нийцүүлэн мониторинг хийх, Хороодын захиалгын дагуу төсөвтэй холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийх үүрэгтэй. Бусад орнуудын туршлагаас үзэхэд, хүчин чадал сайтай Парламентуудын ТША илүү мэргэшсэн, иж бүрэн төсвийн анализ хийх чадавхтай байгаа бол жижиг орнуудын хувьд санхүү, хүний нөөц хомс байх тул Үндэсний аудитын газрыг төсвийн шинжилгээний чиглэлээр Парламентад зөвлөх, хараат бус дүн шинжилгээ гаргаж өгөх хөндлөнгийн мэргэшсэн байгууллага гэж үздэг.
	Жендэрийн мэдрэмжтэй төсөв батлах	Ихэнх орнууд төсвийн төсөлд жендэрийн мэдрэмжийн анализ хийдэг.
1.4. Парламентын хяналтын тусгайлсан салбарууд		
Судалгааны дүгнэлт: Хяналтын зорилго, механизм нь нийтлэг байдаг боловч тодорхой сэдэвчилсэн чиглэлүүд нь ерөнхий зарчмуудыг тодорхой тайлбарлаж ашиглахыг шаарддаг. Парламент бэрхшээлээ шийдвэрлэхийн тулд хяналтын хэрэгслүүдээ хэрхэн нийцүүлэн хөгжүүлэх нь тухайн парламентаас хамаарна.		
1.4.1	Аюулгүй байдлын салбарын хяналт	Мэдээллийн нууцлал, аюулгүй байдал талаас парламентын хяналтыг явуулахад тодорхой хориг саад, бэрхшээл гардаг тул аюулгүй байдлын хяналтыг тусгайлсан журмаар явуулна. Энэ хяналтыг явуулахын тулд Парламентаас аюулгүй байдлын салбарт хяналт явуулах эрх бий юу, хэрэв тийм бол аюулгүй байдлаар мэргэшсэн ажилтан, шинжээчид болон салбарын мэдээллийг авах эрх, холбогдох байгууллагаас шаардагдах мэдээлэл гаргаж өгөх боломж бий юу, энэ төрлийн хяналтыг хэрэгжүүлэхийг Парламентын гишүүд хүсч байгаа юу гэх зэрэг асуудлуудыг тодруулан судлах шаардлагатай.
1.4.2	Олон улсын хүний эрхийн хэрэгжилтийг хянах	Парламент бүхэн хяналтын бүрэн эрхийнхээ хүрээнд хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. Бусад орнуудын жишгээс үзэхэд, хүний эрхийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхийн тулд Парламентууд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна: <ul style="list-style-type: none"> Олон улсын хүний эрхийн зарчмуудад нийцүүлэн хүний эрхийг Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжуудаар баталгаажуулсан байх; Засгийн газарт хүний эрхийг хамгаалах хангалттай төсөв, институциональ бүтэц, дүрэм журам болон техникийн хүчин чадалтай байгаа эсэхийг хянах;

		<ul style="list-style-type: none"> Хүний эрхийн механизм, дүгнэлт, зөвлөмжүүдийн Засгийн газрын хэрэгжилтэд хяналт тавих; НҮБ-ын Хүний эрхийн мониторингийн механизмын дагуу Засгийн газраас шаардлагатай мэдээллийг гарган өгч хамтран ажиллаж байгаа эсэхийг хянах; Дээрх механизм болон холбогдох мэдээллийн өөрчлөлтийг Парламентад шинэчлэн хүргүүлдэг байх.
1.4.3	Тогтвортой хөгжлийн зорилтууд-2030 ба хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих	<p>2015 онд батлагдсан Тогтвортой хөгжлийн зорилт–2030-ийг дэлхийн бүх орнуудын Засгийн газрууд хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн бөгөөд энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үүргийг Парламент хүлээсэн. Иймд уг хөтөлбөрийн агуулгад нийцүүлэн үндэсний зорилтуудаа тодорхойлох, хэрэгжилтийг хянах механизмыг парламентын хяналтын бүрэн эрхэд хамааруулан зохицуулахыг ОУПХ, НҮБХХ-ээс зөвлөсөн байна. Парламентын хяналтыг хэрэгжүүлж буй бусад орнуудын туршлагуудаас үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> ТХЗ-ууд, шалгуур үзүүлэлттэй уялдуулан үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөр батлах; Парламентаас баталсан хууль тогтоомж, төсвийн зарцуулалт, төлөөллийн болон хяналтын эрх мэдлийг уг зорилтын хэрэгжилтийг хангахад чиглүүлэх системийг бий болгож тасралтгүй ажиллуулах. <p>Тухайлбал, ҮСХ-ноос холбогдох дата мэдээллийг гаргуулах, хууль тогтоомж батлах, өөрчлөлт оруулахдаа энэ чиглэлээр өөрчлөлт оруулах иргэний нийгэмтэй зөвлөлдөх, шаардлагатай санхүүжилтийг гаргах, Парламентын хэлэлцүүлэг, асуулга, асуулт, хороодын хяналт шалгалт, хэлэлцүүлгийн явцад энэ асуудлыг хянах, тулгамдсан асуудлуудыг илрүүлж, цаашид хэрэгжилтийг идэвхжүүлэх гэх мэт.</p>
<p>1.5.Парламентын хяналтын харилцааны сүлжээ</p> <p>Судалгааны дүгнэлт: Ардчилсан нийгмийн бүх гишүүд төрийн удирдлагын чанарыг сайжруулах сонирхолтой байдаг. Улс төрийн чухал үүрэг бол Парламент ба нийгэм, тэр дундаа иргэний нийгэм, олон нийт, түүнчлэн хяналт, хяналтын чиг үүрэг бүхий олон оролцогчдын хоорондын харилцан үйлчлэлийг нэмэгдүүлэх явдал юм. Ийм өргөн хүрээг хамарсан хяналтын түншүүдтэй харьцахад албан болон албан бус хандлага адил өргөн хүрээг хамардаг. Хяналтын талаарх албан бус хандлага нь албан ёсны үйл явцыг хэрхэн ашиглаж байгаагаас нь хамааран тойрч гарч, доройтуулж болзошгүй зүйлсийг нөхөж байгаа юм. Албан бус хэрэгслийг ашиглах улс төрийн сэдлийг ойлгох нь тэдгээрийг хэрхэн, яагаад ашиглаж байгааг шинжлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.</p>		
1.5.1	Парламентын хяналтын албан ба албан бус аргууд	Парламентын хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд зөвхөн Засгийн газраас албан ёсоор мэдээлэл авах нь хангалтгүй байдаг. Иймд олон улсын практикт албан бус шугамаар хөндлөнгийн мэдээлэл олж авах, тухайлбал, хөндлөнгийн хяналтын байгууллагууд, Засгийн газар, хэвлэл мэдээлэл, ТББ-ууд, мэргэжлийн бүлгүүд, нийгмийн сүлжээ эх сурвалжуудыг ашиглах зэргээр харилцаа үүсгэдэг байна. Эдгээр эх сурвалжуудаас авах мэдээлэл нь тайлан, зөвлөмж, нотлох баримт, санал шүүмж хэлбэртэй байх ба үр дүнд нь Парламентын гишүүд асуудлын талаар илүү бодитой албан болон албан бус мэдээлэлтэй болох, үзэл бодлоо хуваалцах, олон нийтийн хяналтыг бий болгох ач холбогдолтой.
1.5.2	Хөндлөнгийн хяналтын	Ихэнх орны Парламентууд өөрийн хяналтын бүрэн эрхийн хүрээнд тодорхой салбар хариуцсан байгууллагуудтай хяналтын

	байгууллагуудтай хамтран ажиллах	чиг үүргээ хуваалцана. Тухайлбал, Үндэсний аудитын байгууллага, Засгийн газрын бодлого, үйл ажиллагаа, төсвийн дансыг хараат бусаар хянах, Хүний эрхийн үндэсний хороо, Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон мандатын эрхийн хүрээнд хүний эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх, Омбудсман-төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа, зөрчлийг хянаж нотлох баримт цуглуулах Үндсэн хуулиар эрх олгогдсон төрийн институт бөгөөд хариуцсан чиглэлийн хүрээнд парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд оролцдог практик байна.
1.5.3	Бусад оролцогчидтой хамтран ажиллах: а) Засгийн газартай харилцах	Засгийн газрын газар, хэлтсүүдээс ирүүлж байгаа мэдээлэл, дүн шинжилгээ бол Парламентын хяналтын нэг чухал эх сурвалж мөн. Гэвч Парламент болон Засгийн газрын албан хаагчдын хооронд зарчмын хувьд ялгаа бий. Засгийн газрын зүгээс аль болохоор ажлаа сайн дүгнүүлэх, хуулийн хэрэгжилт хэвийн яваа мэтээр тайлагнах эрмэлзэлтэй байдаг бол парламентын зүгээс Засгийн газрын үүсгэж байгаа шат дамжлага, хүнд суртлыг илрүүлэн гаргах зорилготой. Ийм учраас Парламент тусгайлсан мэдлэг, дүн шинжилгээ хийх чадавхтай байхын зэрэгцээ Засгийн газартай хэл амаа ололцож, аль болохоор бодлогын хэрэгжилтийг идэвхжүүлэх чиглэлд хамтран ажиллах шаардлагатай.
	б) Сайд нартай харилцах	Засгийн газрын сайд нартай “хэл амаа ололцох”. Судалгаанд хамруулсан орнуудын Парламентын гишүүдийн хариултаас үзэхэд, сайд нартай тусгайлсан асуудлаар ярилцлага өрнүүлэх явцад тодорхой мэдээлэл авч, бодлогын асуудалд нөлөөлөх боломжтой байдаг гэсэн байна. Иймээс парламентын гишүүд сайд нарт хандаж мэдээллийг шууд гаргуулан авах, шууд асуулт тавьж хариулт авах боломжтой байх нь зүйтэй гэж үзсэн. Гишүүдийн мэдээлэл авах эрхийн хувьд хэд хэдэн сөрөг зүйл ажиглагддаг: 1/ Мэдээлэл авах эрхийн ялгаатай байдал: Парламентын гишүүн бөгөөд Засгийн газрын гишүүн, сайдын хувьд бусад гишүүд болон сөрөг хүчний гишүүдээс илүү мэдээллийн давуу эрхтэй байдаг. 2/ Парламентын гишүүн хяналтын үүргээ биелүүлэхдээ сайд нартай албан бусаар харьцаж мэдээлэл авч байгаа тохиолдолд гишүүн-сайдын хувьд парламентын хяналтын албан ёсны процедурыг үл ойшоох хандлагатай байдаг. 3/ Хяналтын процесс ил тод биш байх нь авилгын эрсдэлийг нэмэгдүүлдэг гэж үздэг.
	в) Иргэний нийгэмтэй харилцах	Парламентын гишүүд иргэний нийгэмд хандан Парламентын үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөхөөс гадна хууль тогтоомжийн хэрэгжилтэд тулгарч байгаа асуудлаар талаар иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, үзэл бодлыг сонсох шаардлагатай. Ялангуяа Парламентын нээлттэй сонсголд иргэний нийгмийн байгууллага, иргэдийн санал, байр суурийг нь сонсдог байх шаардлагатай гэж үздэг.
	г) Хувийн сектортой харилцах	Хувийн секторын зүгээс эдийн засаг, мэргэжлийн ашиг сонирхол болон хөгжлийн идеологи талаасаа ЗГ-ыг дэмжиж байдаг бол төрөөс татвар, шударга өрсөлдөөн, бизнесийн эрх, эрх чөлөөг хангаж хувийн секторт дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Ихэнх орнуудын туршлагаас үзэхэд, хувийн секторынхан эдийн засгийн лобби бүлэг үүсгэн тухайлсан салбар, эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд ямар асуудал байна, яаж шийдвэрлэх вэ

		гэдэг дээр нөлөөлөх оролдлого хийж байдаг бол хууль тогтоогчдын хувьд энэ талаар мэдээлэлтэй байж, талуудын ялгаатай эрх ашиг, зорилгыг ойлгож, мэргэшсэн ажилтнуудынхаа дэмжлэгтэйгээр сайн, муу мэдээллийг ялгаж салган хууль тогтоох үйл ажиллагаандаа ашиглаж байдаг.
	д) Хэвлэл мэдээлэлтэй харилцах	Олон нийт Засгийн газрын үйл ажиллагаа төдийгүй, Парламентаас Засгийн газарт хэрхэн хяналт тавьж байгаа талаар мэдээлэл авч байх ёстой. Иймд хэвлэл мэдээллийн байгууллагууд парламентын хяналтын талаарх мэдээллийн контент бэлтгэх чадвартай мэдлэгтэй, мэргэшсэн сэтгүүлчдийг ажиллуулах нь зүйтэй. Түүнчлэн эрэн сурвалжлах сэтгүүлчдийн мэдээлэл нь парламентын хяналтын нэгэн чухал эх үүсвэр болдог учраас хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Парламентын гишүүд аль аль нь олон нийтийн эрх ашгийн үүднээс мэдээлэл цуглуулах, олон нийтийн санаа бодлыг тандан судлах, хамтран ажиллах нь түгээмэл байдаг.
	е) Нийгмийн сүлжээг ашиглах	Парламентын хяналтыг үр нөлөөтэй болгох чухал нөхцөл бол олон нийтийн оролцоог хангах. Техник технологи өндөр хөгжсөн өнөө үед нийгмийн идэвхтэй хэсэг, тэр дундаа залуучууд нийгмийн сүлжээг өргөнөөр ашиглаж байгаа тул Парламентын зүгээс онлайн харилцааг чухалчлан үзэх нь зүйтэй хэмээн судалгаанд авагдсан орнуудын Парламентын гишүүд үзсэн байна. Нийгмийн сүлжээгээр дамжуулж Парламент үйл ажиллагаагаа хэрхэн хэрэгжүүлж байгаа талаарх мэдээллийг олон нийтэд хүргэхээс гадна олон нийт хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар ямар санаа бодолтой байгаа, юуг яаж өөрчлөхийг хүсэж байгаа зэргийг тандан судалж гишүүдийн зүгээс input буюу хяналт шалгалтын санаа олж авдаг гэж судалгаанд оролцогсад хариулсан байна.
1.5.4	Парламент дахь намын бүлгүүд ба бусад албан бус хяналт	Парламентын гишүүд хууль ёсны хяналтын хэлбэрүүдийг ашиглахаас гадна намын бүлгүүд дангаараа, эсхүл Парламентад суудалтай намын бүлгийн гишүүд хамтрах буюу сонирхлын бүлгээрээ нэгдэж хяналтын үйл ажиллагаа явуулдаг практик байна. Тухайлбал, парламент дахь эмэгтэйчүүдийн бүлэг.
1.6.Парламентын хяналт ба парламентын гишүүдийн оролцоо Судалгааны дүгнэлт: Парламентад хяналтын олон арга хэрэгслийг ашиглах боломжтой. Эдгээр арга хэрэгслийг Парламентын гишүүд шаргуу ажил хэрэг болгохгүй бол үнэ цэнэгүй болно. Хяналтыг байнга, цуцалтгүй явуулж буй гишүүдэд албан тушаалаа алдах хүртэл эрсдэл тулгарч болзошгүй ч энэхүү ажилд өөрийгөө бүрэн зориулж, хичээнгүйлэн ажиллаж буй парламентын гишүүний нэр хүнд олон нийтийн дунд өсөх магадлал өндөр байдаг. Эерэг боломжууд нь мэргэжлийн хөгжил, өндөр нэр хүндийг олж авах, Засгийн газрын болон хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулахад шууд хувь нэмэр оруулах явдал юм.		
1.6.1	Парламентын гишүүдийг хяналтын үйл ажиллагаанд татан оролцуулах хөшүүрэг	Парламентын гишүүд бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үр нөлөөг үнэлэх хүсэл эрмэлзэл, сонирхолтой байдаг. Тухайлбал, авилгыг бууруулах, бодлогын зорилго зорилтуудыг төгөлдөржүүлэх, улс төрчийн хувьд туршлага хуримтлуулах, хууль хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох, нийгмийн эмзэг бүлгийг хамгаалах, гэх мэт Засгийн газрын үйл ажиллагааны үнэлгээг дараах 5 төлөвийг хэрхэн хангаж байгаагаар үнэлдэг. Үүнд: шударга байдал, найдвартай байдал, эрх тэгш байдал, үр ашигтай байдал, үр нөлөөтэй байдал (<i>probity, fidelity, equity, efficiency, effectiveness</i>).

1.6.2	Хяналтыг үр ашигтай явуулах нөхцөл	<p>Парламентад хуулиар олон төрлийн хяналтын бүрэн эрхийг олгодог ч Засгийн газрын үйл ажиллагаанд үнэхээр бодитой, үр нөлөөтэй хяналт тавья гэвэл зайлшгүй шаардагдах нөхцөлийг бүрдүүлэх хэрэгтэй. Практикт улс төрийн нөлөө болон чадавх дутагдсанаас үүдэн хяналтын үр нөлөө төдийлөн сайнгүй байдаг нь нууц биш. Зөвхөн тайлан, зөвлөмж бичих бол хяналт биш юм. Иймд дараах нөхцөлүүдийг бүрдүүлэхээс гадна хэвлэл мэдээлэл, олон нийтийн дэмжлэгийг авч байж л парламентын хяналтын үр нөлөө дээшилнэ гэж судалгаанд оролцогчид үзсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Шүүмжлэлт мэдээллийн суваг бий болгох: Нэг талаас Засгийн газар нь мэдээллийн томоохон сантай, мэдээж гишүүд яам, газруудаас мэдээлэл авах давуу эрхтэй ч энэ нь өрөөсгөл. Иймд Парламент өөрийн харьяа байгууллага, хамтрагч хөндлөнгийн субъектүүдээс мэдээллийн эх үүсвэртэй байх хэрэгтэй. Парламентын мэдээллийн эх үүсвэр бие даасан байх тусам хяналтын чадавх сайн байна. • Санхүүгийн хангалттай нөөцтэй байх: Мэдээжийн хэрэг Парламент санхүүгийн хангалттай нөөцтэй байж хяналтын үйл ажиллагааг үр нөлөөтэй явуулна. Мэргэшсэн экспертийн туслалцаа авах, ажилтнуудад зохистой цалин хөлс олгох, баталгаатай мэдээллийн эх үүсвэрийг ашиглах гэх мэт. Хяналтын үйл ажиллагаанд зарцуулах төсөв хөрөнгөнөөс хамааран улс орнуудын парламентын хяналтын чадавх янз бүр байна. • Мэдээллийн хангамж сайн байх: Сайн хяналтын үндэс нь сайн мэдээлэл юм. Гэвч Парламент-Засгийн газрын мэдээллийн тэнцвэртэй байдал төдийлөн сайн биш, Парламентын цөөнх зарим тохиолдолд шаардлагатай мэдээллийг авч чаддаггүй гэх мэт асуудлууд практикт гардаг. Түүнчлэн Парламент мэдээллийн вакуум орчинд ажиллаж болохгүй, иймд хөндлөнгийн мэдээллийн эх сурвалжуудыг авах хэрэгтэй. Парламент Засгийн газраас мэдээлэл гаргуулан авах бүрэн боломжтой, давуу талтай боловч хамгийн гол нь мэдээллийг үнэлэх, шүүмжлэлт өнцгөөс мэргэшсэн дүгнэлт хийх чадавх сул байх нь хяналтын үр нөлөөг бууруулдаг. Иймд Парламентын зүгээс аль болохоор мэдээлэл сайтай, мэргэшсэн субъектүүдийн сонирхлыг татах, нээлттэй хамтран ажиллах шаардлагатай болдог.
-------	------------------------------------	--



2.2.ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫГ БИЕ ДААСАН ХУУЛИАР ЗОХИЦУУЛЖ БУЙ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

/Парламентын судалгааны хүрээлэн/

Босни-Херцеговин Улс: Босни-Херцеговин нь парламентын хяналтын үйл ажиллагааг зохицуулдаг бие даасан хуультай цөөхөн улсуудын нэг юм. Тус улсын Парламентын хяналтын тухай хуулийн төслийг 2016 онд санаачлан боловсруулж, 2017 онд ЕАБХАБ-ын Босни-Херцеговин дахь төлөөлөгчийн газраас өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулан 2018 оны 3, 4 дугаар сард Парламентын Ассамблей 2 танхим болох Төлөөлөгчдийн болон Нийтийн танхимын хуралдаанаар тус тус хэлэлцэж баталжээ.

Парламентын хяналтын тухай хууль⁹ нь 5 бүлэг, 69 зүйлтэй бөгөөд Босни-Херцеговиний төсвийн болон төрийн өмчит бүх байгууллагууд болон тус улсын төсвийн эх үүсвэрээс санхүүжилт авсан аливаа байгууллагуудын үйл ажиллагаанд, Парламентын Ассамблейн нэг, эсхүл хоёр танхимаас томилгоог нь баталгаажуулдаг, эсхүл зөвшөөрдөг албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих харилцааг зохицуулна.

Оросын Холбооны Улс: Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Парламентын хяналтын тухай хуулийг 2013 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Холбооны Хурлын Төрийн Думаар баталж, 27-ны өдөр Холбооны Зөвлөлөөс дэмжсэн байна. Харин 2013 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна.

Парламентын хяналтын тухай хууль¹⁰ нь 3 бүлэг, 15 зүйлтэй бөгөөд тус улсын Үндсэн хууль, ОХУ-ын субъектүүдийн Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль болон Холбооны Хурлын танхимуудаас гаргасан эрх зүйн актын хүрээнд Холбооны Хурлын танхимууд, хороод, комиссууд, танхимуудын гишүүд, Тооцооллын танхим, Парламентын мөрдөн шалгах хорооноос асуудлын шалтгаан нөхцөл, баримт нотолгоог мөрдөн шалгах болон парламентын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг харилцааг зохицуулна.

ОХУ-ын субъектүүдийн Парламентын хяналтын тухай загвар хуулийн төсөл: ОХУ-ын субъектүүдийн Парламентын хяналтын тухайн загвар хуулийн төсөл нь тус улсын субъектийн хууль тогтоох байгууллага, түүний төлөөлөгчид ОХУ-ын субъектийн Үндсэн хууль (дүрэм), ОХУ-ын субъектийн хууль тогтоох байгууллагын журмын дагуу парламентын хяналтыг хэрэгжүүлэх нийтлэг харилцааг зохицуулна.

Энэхүү загвар хуулийн төслийг ОХУ-ын хууль зүйн ухааны доктор (Ph.D.) Л.А.Славовнагийн "ОХУ-ын субъектүүдийн парламентын хяналт: Онол ба практикийн асуудлууд" сэдэвт эрдмийн зэрэг горилсон бүтээлдээ¹¹ дүн шинжилгээ хийх явцдаа боловсруулсан байна. Энэ нь ОХУ-ын субъектүүдийн парламентын хяналтыг зохистой нэгтгэх, үр дүнтэй болгоход хувь нэмэр оруулах зорилгоор боловсруулжээ.

⁹Босни ба ГерцеговинУлс: Парламентын тухай хууль, 2018 - Законом Парламентарном надзору (серби хэлээр), 2018. Эх сурвалж: <http://static.parlament.ba/doc/ARHIVASGBiH/2018/broj025.pdf>

¹⁰Федеральный законО парламентском контроле. Эх сурвалж: <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&prevDoc=102077052&backlink=1&nd=102165151>

¹¹ Л.А.Славовна. Проект модельного закона "О парламентском контроле в субъекте Российской Федерации". Приложение №1. "Парламентский контроль в субъектах Российской Федерации: Вопросы теории и практики" (диссертация на соискание ученой степени кандидата юридических наук). Работа выполнена на кафедре конституционного права ЧОУ ВПО "Институт международного права, экономики, гуманитарных наук и управления им. К.В. Россинского". Москва, 2014.

2.2.1. БОСНИ-ХЕРЦЕГОВИН УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ¹²

Албан бус орчуулга

ХУУЛИЙН БҮТЭЦ

I бүлэг. Нийтлэг үндэслэл

- 1-р зүйл. Зохицуулах харилцаа
- 2-р зүйл. Хуулийн нэр томъёог ашиглах
- 3-р зүйл. Ялгаварлан гадуурхахыг хориглох
- 4-р зүйл. Нэр томъёоны тайлбар
- 5-р зүйл. Парламентын хяналтын зарчим
- 6-р зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч субъектүүд
- 7-р зүйл. Хяналтын зорилго
- 8-р зүйл. Парламентын хяналтад байдаг байгууллагуудын хурал
- 9-р зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын бүрэн эрх

II бүлэг. Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд

- 10-р зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх
- 11-р зүйл. Гэрчүүдийг дуудаж, асуулт асуух
- 12-р зүйл. Сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтан, эсхүл байгууллагын мэдэгдэл
- 13-р зүйл. Аудитын товчооны зөвлөмж гаргах журам
- 14-р зүйл. Бие даасан шинжээч, байгууллагуудаас дэмжлэг авах журам
- 15-р зүйл. Хяналтад байдаг байгууллагуудад ажлын айлчлал хийх
- 16-р зүйл. Парламентын хяналтад шаардлагатай мэдээлэлтэй танилцах
- 17-р зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудаас хууль сахиулах байгууллагыг хянан шалгах бусад арга

III бүлэг. Парламентын хяналтыг хэрэгжүүлэх арга хэлбэр

Хэсэг А. Нийтлэг үндэслэл

- 18-р зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэх арга хэлбэр

Хэсэг Б. Сонсгол

- 19-р зүйл. Сонсгол явуулах
- 20-р зүйл. Сонсголыг эхлүүлэх
- 21-р зүйл. Дуудлагад хариу өгөх
- 22-р зүйл. Сонсгол явуулах үйл явц
- 23-р зүйл. Сонсгол явуулсан талаарх илтгэл
- 24-р зүйл. Хараат бус, зохицуулах байгууллагуудын сонсгол

Хэсэг В. Олон нийтийн мэтгэлцээн, сэдэвчилсэн уулзалт

- 25-р зүйл. Олон нийтийн мэтгэлцээн, сэдэвчилсэн уулзалт зохион байгуулах)
- 26-р зүйл. Олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалтад оролцогчдын санал бодол
- 27-р зүйл. Олон нийтийн мэтгэлцээн, сэдэвчилсэн уулзалтын үр дүн

Хэсэг Г. Хуваарьт бус парламентын болон олон нийтийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах

- 28-р зүйл. Мөрдөн шалгах хороо
- 29-р зүйл. Мөрдөн шалгах хорооны эрх, үүрэг
- 30-р зүйл. Мөрдөн шалгах хорооны тайлан

Хэсэг Д. Гишүүд асуулт асууж, тайлбар авах

- 31-р зүйл. Гишүүд асуулт асуух, санаачилга гаргах
- 32-р зүйл. Аман асуулт
- 33-р зүйл. Асуулт асуух

¹²Босни ба ГерцеговинУлс: Парламентын тухай хууль, 2018 - Законо Парламентарном надзору(серби хэлээр), 2018. Эх сурвалж: <http://static.parlament.ba/doc/ARHIVASGBiH/2018/broj025.pdf>

- 34-р зүйл. Асуултын хариу
- 35-р зүйл. Асуулт асуух, санаачилга гаргах
- 36-р зүйл. Бичгээр хариу өгөх
- 37-р зүйл. Хоёр Танхимын хамтарсан хуралдаанаар асуулт асууж, хариулт авах
- 38-р зүйл. Хамтарсан хуралдааны журам
- 39-р зүйл. Тодруулах асуулт явуулах, түүнийг хэлэлцэх
- 40-р зүйл. Тодруулах асуултыг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах
- 41-р зүйл. Тодруулах асуултыг хэлэлцэх
- 42-р зүйл. Тодруулах асуултын үр дүнд шаардлагатай арга хэмжээ авах

Хэсэг Е. Ерөнхийлөгчийн Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Парламентын Ассамблейн Танхимуудад мэдээлэл хийх

- 43-р зүйл. Төлөөлөгчдийн танхимын хуралдааны талаар Ерөнхийлөгчийн Зөвлөлд мэдэгдэх
- 44-р зүйл. Танхимуудад Ерөнхийлөгчийн Зөвлөлийн эрхлэх асуудлаар мэдээлэл хийх

Хэсэг Ё. Сайд нарын Зөвлөлд итгэл үзүүлэх эсэх, эсхүл дахин сэргээх шаардлагатай тухай хэлэлцэх

- 45-р зүйл. Сайд нарын Зөвлөлийн үүрэг, хариуцлага
- 46-р зүйл. Сайд нарын Зөвлөлд итгэл үзүүлэх эсэх асуудлыг санаачлах
- 47-р зүйл. Хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах
- 48-р зүйл. Итгэл үзүүлэх эсэх талаарх Сайд нарын Зөвлөлийн илтгэл
- 49-р зүйл. Дахин сэргээх тухай Сайд нарын Зөвлөлийн илтгэл
- 50-р зүйл. Сайдын Зөвлөлийн санал, хариулт
- 51-р зүйл. Санал хураалт явуулах
- 52-р зүйл. Сайд, дэд сайдыг өөрчлөх журам
- 53-р зүйл. Хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах
- 54-р зүйл. Саналын үндэслэл болон түүнийг хэлэлцэх
- 55-р зүйл. Сайд, дэд сайдыг өөрчлөх талаар санал хураах

Хэсэг Ж. Тайлан хэлэлцэх

- 56-р зүйл. Ирүүлсэн тайланг хэлэлцэх
- 57-р зүйл. Тайланд тавигдах шаардлага
- 58-р зүйл. Үгүйсгэсэн тайлан гаргах журам
- 59-р зүйл. Хариуцагч буюу эрх бүхий этгээдийн үйл ажиллагааны мэдээлэл
- 60-р зүйл. Сайд нарын Зөвлөлийн үйл ажиллагааны тайлан
- 61-р зүйл. Арга зүй
- 62-р зүйл. Парламентын хяналтын бусад хэлбэр
- 63-р зүйл. Парламентын хяналтад үл хамаарах асуудал

IV бүлэг. Хариуцлага тооцох

- 64-р зүйл. Парламентын хяналтын талаар хяналтанд байдаг байгууллагуудын хариуцагч болон эрх бүхий этгээдэд торгууль ногдуулах
- 65-р зүйл. Парламентын мөрдөн шалгалтын явцад хяналтад байгаа байгууллагын хариуцагч болон эрх бүхий этгээдэд торгууль ногдуулах
- 66-р зүйл. Хариуцлага тооцох норматив зохицуулалт
- 67-р зүйл. Торгууль

V бүлэг. Шилжилтийн заалтууд

- 68-р зүйл. Дүрэм
- 69-р зүйл. Хүчин төгөлдөр болох

I БҮЛЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Зохицуулах харилцаа

(1) Парламентын хяналтын тухай хууль /цаашид “хууль” гэх/ нь Босни-Херцеговиний төсөвт болон төсөвт бус бүх байгууллагууд, төрийн захиргааны болон төрийн өмчит байгууллагууд /цаашид “хяналтад байдаг байгууллагууд” гэх/-ын үйл ажиллагаанд хяналт тавих, түүнчлэн прокуророос тавьсан хэмжээг үл харгалзан төсвийн эх үүсвэрээс, эсхүл төрийн байгууллагуудаас хандив өргөсөн төсвийн зарим хэсгийг болон төсвийн бус эх үүсвэрийг удирддаг этгээдийн, ашгийн болон ашгийн бус байгууллагуудын, Парламентын Ассамблейн нэг, эсхүл хоёр Танхимаас томилгоог нь баталгаажуулдаг, эсхүл зөвшөөрдөг албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих харилцааг зохицуулна.

(2) Ерөнхийлөгчийн Зөвлөл¹³, Үндсэн хуулийн шүүх, Хүний эрхийн омбудсмены институт /Institution of ombudsman for human rights/, Аудитын байгууллагууд нь зөвхөн санхүүгийн гүйцэтгэлд, Төв банк нь Төв банкны тухай хуулийн 64 дүгээр зүйлд заасны дагуу тус тус хяналт тавина.

(3) Энэ хуулиар парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх зүйн байдал, парламентын хяналтыг хэрэгжүүлэх үйл явц, парламентын хяналтын чиглэл дэх хамтын ажиллагаа, Парламентын Ассамблейд хариуцан тайлагнах журам, түүнчлэн парламентын хяналтыг хэрэгжүүлэх явцад хариуцлага тооцох арга хэмжээг зохицуулна.

2 дугаар зүйл. Энэ хуулийн нэр томъёог ашиглах

Энэ хуульд хэрэглэгдсэн нэр томъёо нь хэл зүйн хувьд дан ганц утгыг илэрхийлнэ.

3 дугаар зүйл. Ялгаварлан гадуурхахыг хориглох

Төсөвт болон төсвийн бус бүх байгууллагууд, төрийн өмчит байгууллагууд, түүнчлэн хувийн хэвшлийн бүхий л салбарт хувь хүн, хуулийн этгээдийг ялгаварлан гадуурхахыг хориглоно.

4 дүгээр зүйл. Нэр томъёоны тайлбар

Энэ хуульд заасан доорх нэр томъёог дараах утгаар ойлгоно:

а) **хяналт** (oversight) гэдэг нь Парламентын Ассамблейн хяналтын эрх, үүргийг хэрэгжүүлэх зорилгоор энэ хууль болон бусад эрх зүйн актад тодорхойлсон цогц арга хэмжээ, журмыг;

б) **үйл ажиллагаа** (activity) гэдэг нь парламентын хяналтыг хэрэгжүүлдэг тодорхой байгууллагын үүрэг даалгавар, үйл ажиллагаа болон процедурыг;

в) **хамтын ажиллагаа** (co-operation) гэдэг нь зарим салбарын нөхцөл байдлыг бүрэн сайжруулах зорилгоор байгууллагуудын хооронд туршлага солилцох, итгэлцлийг бий болгоход чиглэсэн үйл явцыг;

г) **хариуцагч этгээд** (responsible person) гэдэг нь хууль тогтоомжийн үндсэн дээр төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй байгууллагуудын эрх бүхий албан тушаалтан, өөрөөр хэлбэл, хяналтад хамрагддаг сайд, агентлаг, түүнтэй адилтгах байгууллагын захирал, даргыг;

д) **эрх бүхий этгээд** (authorized face) гэдэг нь хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэхтэй холбогдсон чиг үүрэг, эсхүл тодорхой бүрэн эрхийн дагуу тодорхой үүрэг хүлээсэн хяналтад хамрагддаг байгууллагын албан тушаалтныг;

¹³Босни Херцеговинийн Ерөнхийлөгчийн Зөвлөл (хорват хэлээр - Predsjedništvo Bosne i Hercegovine) нь Босни Херцеговинийн төрийн тэргүүний үүргийг хамтын зарчмаар хэрэгжүүлдэг байгууллага юм. Тус улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Ерөнхийлөгчийн Зөвлөл нь гурван гишүүний бүрэлдэхүүнтэй: Босни болон Хорватын гишүүнийг Босни Херцеговинийн холбооны хамтарсан сонгуулийн тойргоос, Сербийн гишүүнийг Бүгд Найрамдах Серб Улсын сонгогчдоос сонгоно.

е) **парламентын мөрдөншалгах үйл ажиллагаа** (parliamentary investigation) гэдэг нь парламентын хяналтад байдаг байгууллагуудын үйл ажиллагаанд хууль зөрчсөн үйлдлийг илрүүлэх зорилгоор парламентын хяналтыг хэрэгжүүлэх цогц арга хэмжээг;

ё) **сонсгол** (hearing) гэдэг нь парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудаас тухайлсан сэдвээр шаардлагатай мэдээлэл, баримтыг шалгах зорилгоор тодорхой этгээдээс асуулт асуух тусгай хэлбэрийг ойлгоно. Энэ нь олон нийтэд нээлттэй, эсхүл хаалттай байж болно;

ж) **олон нийтийн мэтгэлцээн** (public debate) нь хуулийн талаар сонирхсон байгууллага, хувь хүмүүсийн санал, байр суурийг авах зорилгоор зохион байгуулсан уулзалт (хурал)-ын хэлбэрийг.

5 дугаар зүйл. Парламентын хяналтын зарчим

Парламентын хяналтыг хэрэгжүүлэхдээ үндсэн хуульт ёс, эрх зүйт ёс, ардчилал, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх зарчимд суурилна.

6 дугаар зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч субъектүүд

(1) Парламентын хяналтыг Парламентын Ассамблейн Танхимууд, байнгын ажиллагаатай байгууллагууд, шаардлагатай бол хяналтын тодорхой чиг үүрэг хэрэгжүүлдэг тусгай байгууллагууд /цаашид “парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд” гэх/-аар дамжуулан хэрэгжүүлнэ.

(2) Парламентын Ассамблейн гишүүд парламентын хяналтыг тус бүрт нь асуулт асууж тодруулах замаар хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл. Хяналтын зорилго

(1) Парламентын хяналт нь энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан байгууллагуудын үйл ажиллагаа, эсхүл үйл ажиллагааны зарим хэсэгт хариуцлага, үр нөлөө, үр ашиг, ашигт байдал, тогтвортой байдлыг нэмэгдүүлэх зорилгоор тэдгээрийн тайлан, ил тод байдал болон үйл ажиллагаанд хяналт тавина.

(2) Парламентын хяналтыг олгогдсон бүрэн эрх, төсвийн санхүүжилтийн удирдлагыг сайжруулах, түүнчлэн албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглах, материаллаг болон санхүүгийн эх үүсвэрийг ашиглах зэрэг хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалахын тулд байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, баримтыг цуглуулах зорилгоор хийнэ.

8 дугаар зүйл. Парламентын хяналтад байдаг байгууллагуудын хурал

(1) Парламентын хяналтад байдаг байгууллагуудын хурал олон нийтэд нээлттэй байна.

(2) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд нь өөрт хамааралтай тодорхой асуудлуудыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэж болно.

9 дүгээр зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын бүрэн эрх

(1) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

а) төрийн захиргааны байгууллагуудын, эсхүл тэдгээрийн эрх бүхий этгээдийн хууль ёсны ерөнхий байдлыг хянах;

б) төрийн захиргааны байгууллагууд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах;

в) тухайн салбарын нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор хянах;

г) хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн болон материаллаг нөөцийн хууль ёсны зарцуулалтыг хянах;

д) хяналтад байдаг байгууллагуудаас боловсруулсан хяналтын объектоор холбоотой, эсхүл хяналт хийсэн талаарх тайланг хянаж батлах;

- е) хяналтад байдаг байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой шинэ хуулийн санал, эсхүл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулах;
- ё) парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудад ирүүлсэн санал, өргөдлийг хэлэлцэх.

(2) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд нь энэ зүйлийн 1-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлсэн талаарх тайлангаа Парламентын Ассамблейн өмнө хариуцан тайлагнах ба энэ хуульд заасан журмын дагуу дүгнэлт, саналаа уламжилна.

II БҮЛЭГ. ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУД

10 дугаар зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын эрх

- (1) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд нь дараах эрхтэй:
- а) аливаа байгууллагаас гэрчүүдийг дуудаж, асуулт асуух;
 - б) аливаа сонгогдсон, эсхүл томилогдсон эрх бүхий албан тушаалтнаас тайлан шаардах;
 - в) аудитороос дэмжлэг авах;
 - г) даасан мэргэжилтнүүдээс дэмжлэг авах;
 - д) олон талт идэвхтэй үйл ажиллагаа явуулж, хяналтад байдаг байгууллагуудад очих;
 - е) хяналтад хэн байгаагаас үл хамааран парламентын хяналтад шаардлагатай баримт бичигтэй танилцаж ойлгох;
 - ё) үйл ажиллагааны үр дүнгийн тайлан, захиргааны хяналт шалгалтын тайлан, дотоод аудитын тайлан, мөрдөн шалгах болон хууль сахиулах байгууллагуудын тайлан, Аудитын товчооны тайлан, төрийн бус байгууллагуудын хяналт, үнэлгээ хийсэн тайлан зэргийг судлах замаар, түүнчлэн мэдэгдэл, эсхүл нийтийн сонсгол хийх замаар, түүнчлэн мэдээллийн бусад эх сурвалж, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрэн сурвалжлах сэтгүүл зүй зэргийг ашиглан хууль сахиулах байгууллагуудад аудит хийх.
- (2) Парламентын хяналтыг хэрэгжүүлэхдээ хүний эрхийн Омбудсмэны дүгнэлт, түүнчлэн парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад баримт, баримт бичгийг төрийн бусад байгууллагуудаас шаардах.
- (3) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд нь сонсгол явуулж, эсхүл албан ёсны баримт бичгүүдийг судалж тогтоогдсон баримт дээр үндэслэн Парламентын Ассамблейгаас авах арга хэмжээний саналыг тусгасан тайлан гаргана.
- (4) Арга хэмжээний саналд эрх бүхий албан тушаалтныг ажлаас нь халах санал байж болно.

11 дүгээр зүйл. Гэрчүүдийг дуудаж, асуулт асуух

- (1) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд нь аль ч байгууллагаас гэрчүүдийг дуудаж, асуулт асуух, тэднээс бүх асуултад хариулах, бүх баримт, нууцын зэрэглэлтэй болон бусад мэдээллийг шаардаж болно.
- (2) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын дуудлагад хяналтад байдаг байгууллагын аливаа этгээд хариу өгөх, парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын хуралдаанд оролцох, бүрэн эрхийнхээ хүрээнд мэдээлэл өгөх, парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын гишүүдийн асуултад хариулах үүрэгтэй.
- (3) Дуудагдсан этгээд нь бүрэн эрхийнхээ хүрээнд үнэнийг хэлэх, шаардсан баримт бичгийг ирүүлэх, мэдээлэл өгөх, парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын гишүүдээс тавьсан асуултад хариулах үүрэгтэй.

(4) Хэрэв дуудлага хүлээн авсан этгээд ирэх боломжгүй бол хуралдаан эхлэхээс 48 цагийн өмнө шалтгааныг парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудад мэдэгдэх ёстой.

12 дугаар зүйл. Сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтан, байгууллагын мэдэгдэл

(1) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд нь парламентын хяналтыг хэрэгжүүлэхдээ сонгогдсон буюу томилогдсон аль нэг албан тушаалтан, байгууллагаас тодорхой асуудал, тодорхой салбар, тодорхой хугацааны тусгай тайлан гаргаж өгөхийг шаардаж болно.

(2) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын шаардсанаар, хяналтад байгаа байгууллагуудын сонгогдсон буюу томилогдсон албан тушаалтан, эсхүл хариуцагч этгээд тайлангаа амаар нотлох үүрэгтэй, өөрөөр хэлбэл, хяналтад байгаа байгууллага нь парламентыг хяналтын байгууллагын гишүүдийн асуултад энэ хуулийн дагуу хариулах үүрэгтэй.

13 дугаар зүйл. Аудитын товчооны зөвлөмж гаргах журам

(1) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд нь Аудитын товчооноос өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина.

(2) Аудитын товчооноос тусгайлсан хуулийн дагуу хяналт шалгалт хийсэн байгууллага нь тайланг зөвлөмжийн хамт хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор уг зөвлөмжийг хэрэгжүүлэх хуваарьтай хөтөлбөр боловсруулах үүрэгтэй.

(3) Шалгагдсан байгууллага зөвлөмжийг хэрэгжүүлэх хуваарьтай хөтөлбөрийг тогтоосон хугацаанд боловсруулаагүй бол парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд нь Парламентын Ассамблейн Танхимуудад байгууллагуудыг хянан шалгах тухай хууль (Law on the Revision of BiH Institutions)-ийн 16 дугаар зүйлийн (4)-т заасан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг санал болгоно.

(4) Энэ зүйлийн (2)-т заасан зөвлөмжийг хэрэгжүүлэх хуваарьтай хөтөлбөрийг тухайн байгууллагын болон Парламентын Ассамблейн цахим хуудсанд нийтэлнэ.

14 дүгээр зүйл. Бие даасан шинжээч, байгууллагуудаас тусламж авах журам

Парламентын хяналтыг мэргэшсэн, зорилтот түвшинд илүү үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагууд нь хараат бус шинжээч, байгууллагуудаас тусламж авч болно.

15 дугаар зүйл. Хяналтад байдаг байгууллагуудад ажлын айлчлал хийх

(1) Хяналтад байдаг байгууллагуудын хүн бүр парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах үүрэгтэй.

(2) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудаас хяналтад байдаг байгууллагуудад хийх ажлын айлчлалыг урьдчилан мэдэгдэх, эсхүл мэдэгдэхгүйгээр хийж болно.

(3) Хариуцагч этгээд нь парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудад хяналтад байдаг байгууллагуудын бүх байр болон албан өрөөнд нэвтрэх боломжийг Нууцын зэрэглэлтэй мэдээлэл хамгаалах тухай хууль (Law on the protection of classified data)-ийн дагуу олгоно.

16 дугаар зүйл. парламентын хяналтад шаардлагатай мэдээлэлтэй танилцах

(1) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь хяналтад байгаа байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хяналтад байгаа байгууллагаас боловсруулсан бүх мэдээлэл, баримт бичгийг шаардах эрхтэй.

(2) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь энэ зүйлийн (1)-д заасан баримт бичигтэй танилцаж, ойлгох ажлыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- а) ажлын айлчлалын үеэр авсан баримт бичгийн протокол үйлдэх;
- б) хяналтад байгаа байгууллагаас баримт бичиг хүлээн авах.

(3) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь энэ зүйлийн (2) (б)-д заасан баримт бичгийг хүлээн авахдаа дараах шаардлагыг хангана: шаардагдах баримт бичигт хяналтад байгаа байгууллагын нэр, баримт бичгийн төрөл, хэлбэр, хүлээлгэн өгсөн цаг, минутыг заавал тусгасан байна.

(4) Баримт бичгийг нууцын зэрэглэлд хамруулсан бол Нууцын зэрэглэлтэй мэдээлэл хамгаалах тухай хууль, төрийн нууцын зэрэглэлтэй мэдээлэл боловсруулахтай холбогдсон дүрмийг дагаж мөрдөнө.

(5) Баримт бичиг нь НАТО, Европын холбоо, олон улсын, эсхүл бүс нутгийн байгууллагын нууцлалын тодорхой тэмдэгтэй бол парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага олон улсын гэрээ, Нууцын зэрэглэлтэй мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу нууцын зэрэглэлтэй баримт бичгийг ойлгоно.

17 дугаар зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудаас хууль сахиулах байгууллагыг хянан шалгах бусад арга

(1) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудаас хяналтад байдаг байгууллагуудын хүрээнд хууль сахиулах байгууллагуудад дараах байдлаар хяналт тавина:

- а) ажлын тайланг хянах;
- б) захиргааны хяналтын тайланг хянах;
- в) дотоод аудитын тайланг хянах;
- г) мөрдөн шалгах болон хууль сахиулах байгууллагуудын тайланг хянах;
- д) Аудитын товчооны тайланг хянах;
- е) төрийн бус байгууллагуудын хяналт, үнэлгээ хийсэн тайланг хянах;
- ё) мэдэгдэл, эсхүл нийтийн сонсгол хийх;
- ж) хэвлэл мэдээллийн хэрэгсэл, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг ашиглах.

III БҮЛЭГ. ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭЛБЭР

Хэсэг А. Нийтлэг үндэслэл

18 дугаар зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэх арга хэлбэр

(1) Парламентын хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- а) сонсгол явуулах;
- б) олон нийтийн мэтгэлцээн, сэдэвчилсэн уулзалт зохион байгуулах;
- в) хуваарьт бус парламентын болон олон нийтийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах;
- г) тодруулах асуулт асуух, түүнийг хэлэлцэх;
- д) Ерөнхийлөгчийн Зөвлөлд тайланг бичгээр ирүүлэх тухай хүсэлт гаргах;
- е) Парламентын Ассамблейгаас Сайд нарын Зөвлөлд итгэл үзүүлэх эсэх, эсхүл дахин сэргээх талаар санал хураах;
- ё) тайлан хэлэлцэх.

Хэсэг Б. Сонсгол

19 дүгээр зүйл. Сонсгол явуулах

(1) Мэдээлэл, эсхүл шинжээчийн дүгнэлт сонсох, эрх бүхий байгууллагын тодорхой чиг үүргийн хэрэгжилтийг судлах, хяналтад байгаа байгууллагуудын үйл ажиллагаанд зөрчил гарсан, эсхүл зөрчил гарсан тухай мэдээлэл байгаа зэрэг тодорхой асуудлын шийдлийг олох зорилгоор парламентын хяналтын байгууллагын шийдвэрээр сонсгол явуулна.

(2) Сүүлийн гурван жилийн хугацаанд ижил буюу төстэй агуулга бүхий аудитын бие даасан үр дүн хоёроос багагүй удаа давтан гарсан бөгөөд энэ талаар Аудитын товчоо, Парламентын Ассамблейн хоёр Танхимын Санхүү, төсвийн хорооны албан ёсны тайланд дурдагдсан, мөн аудитын гүйцэтгэлийн тайлангуудад дурдагдсан бол парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын шийдвэрээр сонсгол явуулна.

(3) Энэ зүйлийн (2)-т заасны дагуу сонсголын талаар аудитын сүүлийн тайлан хэвлэгдсэнээс хойш 90 хоногийн дотор хяналтад байгаа байгууллагын хариуцагч, эсхүл эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

(4) Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж буй байгууллагаас олон нийтэд нээлттэй, эсхүл хаалттай сонсголыг бие даан, эсхүл бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран явуулж болно.

20 дугаар зүйл. Сонсголыг эхлүүлэх

(1) Парламентын Ассамблейн танхимуудын аль нэг, эсхүл парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага сонсгол явуулах тухай шийдвэрийг гаргана.

(2) Төлөөлөгчдийн Танхимаас сонсгол явуулах тухай шийдвэр гаргасан бол Нийтийн танхимын Удирдах зөвлөлөөс сонсгол явуулах талаар парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагад мэдэгдэнэ.

(3) Танхимын шийдвэрт дараах зүйлсийг заасан байна:
а) сонсголын сэдэв, зорилгыг;
б) сонсгол явуулах болон илтгэлийг Парламентын Ассамблейд танилцуулах эцсийн хугацааг.

(4) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагаас сонсгол явуулах тухай шийдвэр гаргасан бол тус байгууллагын дарга нь Төлөөлөгчдийн Танхимын Удирдах зөвлөлийн хуралдаанд сууна. Хэрэв Парламентын Ассамблейн хоёр Танхимын Хамтарсан зөвлөлөөс сонсгол явуулах тухай шийдвэр гаргасан бол Удирдах зөвлөлийн дарга хоёр Танхимын хуралдаанд сууна.

(5) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын сонсгол явуулах тухай шийдвэрт энэ зүйлийн (3)-т заасан агуулгыг заана.

21 дүгээр зүйл. Дуудлагад хариу өгөх

(1) Сонсгол зохион байгуулахаар томилогдсон, эсхүл сонсгол явуулахаар шийдвэрлэсэн парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь түүнд оролцох хүмүүсийн нэрсийн жагсаалт, хуралдаан болох товыг бичгээр гаргана.

(2) Байцаагдах хүмүүсийн нэрсийн жагсаалтыг /үүнд төрийн албан тушаалтнаас бусад/ сонсголын аль ч үед өргөжүүлж болно.

(3) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын урилгаар хяналтад байдаг байгууллагаас дуудагдсан этгээд нь парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын нээлттэй сонсголд оролцох үүрэгтэй.

22 дугаар зүйл. Сонсгол явуулах үйл явц

Сонсголын үйл явцыг дууны бичлэг хийж баримтжуулах ба техникийн болон бусад залруулгыг зөвхөн сонсголд оролцогчдын зөвшөөрлөөр хийнэ.

23 дугаар зүйл. Сонсгол явуулсан талаарх илтгэл

(1) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь олон нийтийн сонсголын тайланг бэлтгэж эрх бүхий Танхимд хүргүүлнэ.

(2) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь холбогдох санал дүгнэлтийг Танхимд танилцуулж, батлуулна.

(3) Хэрэв энэ зүйлийн (1)-т заасан тайланд эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгааг өгүүлсэн бол парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагаас уг тайланг прокурорын газарт шилжүүлнэ.

(4) Сонсголын тайланг дүгнэлтийн хамт Нууцын зэрэглэлтэй мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу Парламентын Ассамблейн болон хяналтад байдаг тухайн байгууллагын цахим хуудсанд нийтэлнэ.

24 дүгээр зүйл. Хараат бус, зохицуулах байгууллагуудын сонсгол

Хараат бус, зохицуулагч байгууллагуудын сонсгол нь тэдгээрийн үйл ажиллагааны хуульт ёсны байдал, хараат бус, эсхүл зохицуулах агентлагийн үйл ажиллагаан дахь үлс төрийн нөлөөллийг үнэлэх, өөрөөр хэлбэл, тухайн агентлагийн удирдлагад томилогдсон этгээдийн үлс төрийн нөлөөллийг үнэлэх зэрэг болно.

Хэсэг В. Олон нийтийн мэтгэлцээн, сэдэвчилсэн уулзалт

25 дугаар зүйл. Олон нийтийн мэтгэлцээн, сэдэвчилсэн уулзалт зохион байгуулах

(1) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагаас парламентын хяналт тавих асуудлыг хэлэлцэх үеэр олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалт хийх тухай шийдвэр гаргах, энэ талаарх тайлангаа Танхимд хүргүүлнэ.

(2) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалтад хяналтад байдаг байгууллагуудын төлөөллийг урина.

(3) Олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалтад гаднын мэргэжилтнүүд, сонирхсон байгууллага болон хувь хүмүүсийн оролцоог хангаж болно.

(4) Олон нийтийн мэтгэлцээн эхлэхээс өмнө хөндлөнгийн шинжээч, сонирхсон байгууллага, хувь хүмүүс санал, дүгнэлтээ парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагад бичгээр гаргаж болно.

(5) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагаас олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалтыг төлөвлөсөн өдрөөс хойш 15 хоногийн дотор явуулна.

(6) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь Парламентын Ассамблейн цахим хуудсанд олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалтын зар сурталчилгааг хийнэ.

26 дугаар зүйл. Олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалтад оролцогчдын санал бодол

(1) Олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалтад оролцогчид парламентын хяналтын чиг үүрэгт хамаарах асуудлаар байр сууриа илэрхийлнэ.

(2) Олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалт дууссаны дараа, парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын дүгнэлтийн дагуу олон нийтийн хэлэлцүүлэг, эсхүл сэдэвчилсэн уулзалтын үеэр танилцуулсан шинжээчийн баримт бичиг, мэдээлэл болон бусад материалыг хавсаргаж болно.

(3) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалтын үеэр хавсаргасан мэргэжлийн бүх баримт бичиг, бусад материалын талаар хэлэлцэнэ.

27 дугаар зүйл. Олон нийтийн мэтгэлцээн, сэдэвчилсэн уулзалтын үр дүн

Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалтын тайлан, тэмдэглэл, олон нийтийн мэтгэлцээн, эсхүл сэдэвчилсэн уулзалтын үеэр баримт бичиг, материалын талаар хэлэлцсэн бол танилцуулна.

Хэсэг Г. Хуваарьт бус парламентын болон олон нийтийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах

28 дугаар зүйл. Мөрдөн шалгах хороо

(1) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага олон нийтийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж болно.

(2) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын харьяанд мөрдөн шалгах тусгай хороонуудыг түр хугацаагаар, эсхүл тодорхой хэрэгцээний хүрээнд мөрдөн шалгах хороод, дэд хороод болон ажлын хэсгүүдийг байгуулж болно.

(3) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь гишүүдээсээ мөрдөн шалгах хороонд томилох, тухайн хорооны бүтэц, үүрэг болон чадамжийг зохицуулсан шийдвэр гаргана.

(4) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын дотор мөрдөн шалгах хороо байгуулах бол сонгогчид, сөрөг хүчний гишүүд, хүйсийн тэнцвэртэй төлөөллийг харгалзана.

29 дүгээр зүйл. Мөрдөн шалгах хорооны эрх, үүрэг

(1) Мөрдөн шалгах хороо нь парламентын мэргэшсэн болон зорилтот хяналтыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор байгуулагдаж, парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагаас өгсөн үүрэг, даалгаврыг хэрэгжүүлнэ.

(2) Мөрдөн шалгах хороо нь нотлох баримт, гэрчүүдийг дуудах журам, тэдний эрх, үүрэг, оролцоо, ялангуяа парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан шийдвэрийг өөрөө гаргана.

(3) Мөрдөн шалгах хороо нь чиг үүргээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэрчүүдийг урих, мэдээлэл, баримт бичих авах эрхтэй.

(4) Уригдсан хүмүүс дуудлагад хариулах, нотлох баримт өгөх, тайлбар өгөх болон асуултад хариулах үүрэгтэй.

(5) Хорооноос шаардсан мэдээлэл, баримт бичгийг тогтоосон хугацаанаас өмнө ирүүлнэ.

(6) Хяналтад байгаа байгууллагууд нь энэ хууль болон Нууцын зэрэглэлтэй мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу мөрдөн шалгах хороотой хамтран ажиллаж, шаардлагатай бүхий л туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах үүрэгтэй.

30 дугаар зүйл. Мөрдөн шалгах хорооны тайлан

(1) Мөрдөн шалгах хороо нь гүйцэтгэсэн ажлын тайлангаа парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлнэ.

(2) Хэлэлцсэн асуудал, гэрчүүдийн мэдүүлэг, тэмдэглэл, протокол, тайланг Нууцын зэрэглэлтэй мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу Парламентын Ассамблейн цахим хуудсанд нийтэлнэ.

(3) Мөрдөн шалгах хорооны тайланд оролцсон тус хорооны гишүүн бүр харилцан зөвшилцөд хүрээгүй саналаа бие даасан илтгэлд, эсхүл тус хорооны олохын саналыг тусгасан үндсэн тайланд хавсаргах эрхтэй.

Хэсэг Д. Гишүүд асуулт асууж, тайлбар авах

31 дүгээр зүйл. Гишүүд асуулт асуух, санаачилга гаргах

(1) Гишүүд Сайд нарын Зөвлөлийн тэргүүн, түүний гишүүд, эсхүл тэдгээрийн харьяа бусад байгууллагууд, ялангуяа нийгмийн амьдралын зарим салбар, хууль сахиулах байгууллагууд дахь нөхцөл байдлын талаар, түүнчлэн Парламентын Ассамблейгаас баталсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар, өөрөөр хэлбэл, яамд болон төрийн захиргааны бусад байгууллагуудын үйл ажиллагааны талаар асуулт асууж, санаачилга гаргаж болно.

(2) Парламентын, эсхүл гишүүдийн асуултыг амаар болон бичгээр асууж, санаачлагыг зөвхөн бичгээр гаргаж болно.

(3) Асуултын хариуг Парламентын Ассамблейн бүх гишүүдэд хүргүүлнэ.

32 дугаар зүйл. Аман асуулт

(1) Гишүүд нэг сарын хугацаанд Танхимуудын хуралдааны эхэнд Сайд нарын Зөвлөлд, өөрөөр хэлбэл, Сайд нарын Зөвлөлийн гишүүн бүрт аман асуулт тавьж болно. Хуралдааныг телевизээр шууд дамжуулна.

(2) Асуулт тавих дарааллыг гишүүдийн асуулт асуух талаар мэдүүлсэн дарааллын дагуу тогтооно.

(3) Гишүүд нэг асуултыг 2 хүртэлх минутад асууна. Асуулт нь богино, тодорхой томъёолсон байх бөгөөд асуултад бэлтгэлгүйгээр тэр даруй хариулах боломжтой байна.

(4) Гишүүд асуултад хангалттай хариу авсан эсэх талаар байр сууриа 1 хүртэл минутад тайлбарлаж болно.

(5) Гишүүд асуултын хариу хангалтгүй гэж үзвэл, хариуг бичгээр 15 хоногийн дотор хүсэж болно.

33 дугаар зүйл. Асуулт асуух

(1) Гишүүд аман асуултын талаар Төлөөлөгчдийн Танхимын хуралдаан эхлэхээс 24 цагийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

(2) Энэ зүйлийн (1)-д заасан асуултыг хаягласан Сайд нарын Зөвлөлийн тэргүүн, эсхүл гишүүдэд илгээнэ. Мэдүүлэгт аман асуулт асуух хүсэлтэй гишүүний овог, нэр, асуулт болон асуултын хүрээг тодорхой тусгана.

(3) Сайд нарын Зөвлөлийн тэргүүн нь гишүүдийн аман асуултад хариулах Төлөөлөгчдийн Танхимын хуралдаанд Сайд нарын Зөвлөлийн гишүүдийн талаас багагүйг байлцуулах үүрэгтэй.

34 дүгээр зүйл. Асуултын хариу

(1) Асуултад Сайд нарын Зөвлөлийн гишүүн тухайн хуралдаанд хариулах бөгөөд хэрэв хариулах боломжгүй бол шалтгаанаа тайлбарлах үүрэгтэй. Энэ тохиолдолд тэрээр Төлөөлөгчдийн Танхимын ээлжит чуулганы эхний хуралдааны аман асуултын цагт амаар хариулах үүрэгтэй.

(2) Асуултад хоёр хүртэл минутад хариулна.

35 дугаар зүйл. Асуулт асуух, санаачилга гаргах

(1) Гишүүд асуулт асуух, санаачилга гаргахдаа Төлөөлөгчдийн Танхимын даргаар дамжуулан бичгээр өгч болно.

(2) Асуултыг энэ зүйлийн (1)-д заасны дагуу томъёолсон бол Танхимын дарга гишүүний асуулт, санаачлагыг хаягласан хүнд илгээнэ.

(3) Нийтийн Танхимын дарга хуралдаан бүрийн эхэнд гишүүдийн ямар асуултад хариулт өгсөн тухай мэдээлнэ.

36 дугаар зүйл. Бичгээр хариу өгөх

(1) Техникийн асуудал (technical issues)-тай холбоотой, эсхүл аман асуултад хангалтгүй хариулсан гэж үзвэл бичгэн асуултыг тавина.

(2) Асуултыг хаягласан хүнд илгээсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор хариуг бичгээр өгнө.

(3) Сайд нарын Зөвлөлийн гишүүд энэ зүйлийн (2)-т заасан хугацаанд хариу өгөх боломжгүй бол боломжгүй болсон шалтгаан, хариу өгөх хугацааг гишүүдэд мэдэгдэнэ.

(4) Төлөөлөгчдийн Танхимын дарга нь хариуг хүлээн авсны дараа түүний хуулбарыг бүх гишүүдэд тараана. Танхимын дарга нь хариу хүссэн гишүүнд асуултдаа хангалттай хариу авсан эсэх талаар тайлбар өгөхийг зөвшөөрнө. Гишүүн хангалтгүй хариу авсан бол нэмэлт асуулт бичгээр тавьж болно.

37 дугаар зүйл. Хоёр Танхимын хамтарсан хуралдаанаар асуулт асууж, хариулт авах

(1) Хамтарсан зөвлөлөөс жилд хоёроос доошгүй удаа “Гишүүд асуулт асууна - Сайд нарын Зөвлөл хариу өгнө” гэсэн сэдвээр хоёр Танхимын тусгай хамтарсан хуралдааныг зохион байгуулна.

(2) Гүйцэтгэх засаглалд хамаарах бүх асуудлаар харилцан ярианы хэлбэртэй энэ хуралдаанаар олон нийтэд зориулан телевиз, радио шууд дамжуулах, иргэдэд мэдээлэл өгөх нөхцөлийг бүрдүүлнэ.

(3) Гишүүд нэг асуултыг 3 минутад багтаан тавина. Асуултыг хуралдаан болохоос хамгийн багадаа 7 хоногийн өмнө Сайд нарын Зөвлөлд хэлэлцүүлэхээр өгнө.

(4) Энэ зүйлийн (1)-д заасан хуралдааныг 30 хоногийн өмнө товлон бөгөөд 4 цагаас илүүгүй хугацаанд үргэлжилнэ.

38 дугаар зүйл. Хамтарсан хуралдааны журам

(1) Асуултад дараах журмаар хариулна: гишүүн 3 хүртэл минутад асуулт асууж дууссаны дараа Сайд нарын Зөвлөлийн тэргүүн, эсхүл гишүүн мөн хугацаанд хариулна. Үүний дараа гишүүн хариуны талаар тайлбар өгөх, эсхүл 2 хүртэлх минутад тодруулах асуулт асууж

болно. Сайд нарын Зөвлөлийн тэргүүн, эсхүл гишүүн мөн хугацаанд хариулсны дараа Танхимын дарга хэлэлцүүлгийг дуусгаж, эрх бүхий дараагийн хүнд үг хэлэх эрхийг өгнө.

(2) Сайд нарын Зөвлөлийн тэргүүн, эсхүл гишүүн тодорхой шалтгааны улмаас, зөвхөн нэг удаа уг асуудлын хэлэлцүүлгийг Танхимын дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр хойшлуулж болно.

39 дүгээр зүйл. Тодруулах асуулт явуулах, түүнийг хэлэлцэх

- (1) Тодруулах асуулт бол Төлөөлөгчдийн Танхимын хуралдааныг нээж байгаа асуулт бөгөөд энэ нь Сайд нарын Зөвлөлийн үйл ажиллагааны тухай, Сайд нарын Зөвлөлийн, эсхүл тодорхой сайд нарын шийдвэрийн тухай, хууль тогтоомжийн хэрэгжилтийн тухай асуулт байна.
- (2) Гишүүд Сайд нарын Зөвлөлөөс бичгээр өгсөн нэмэлт хариуг мөн хангалтгүй гэж үзсэн бол тодруулах асуултын үед тайлбар өгч болно. Энэ нь Танхимын хэлэлцүүлгийг эхлүүлэх шалтгаан болно.
- (3) Төлөөлөгчдийн Танхимын 8 гишүүн, Нийтийн Танхимын 3 төлөөлөгч хамтран Танхимын даргад тодорхой үндэслэл бүхий асуултыг бичгээр гаргаж болно.
- (4) Танхимуудын Удирдах зөвлөл асуултыг хэлэлцэж, хаягласан хүнд илгээнэ.

40 дүгээр зүйл. Тодруулах асуултыг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах

- (1) Асуултыг хаяглагдсан этгээдэд илгээсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор Танхимын хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулна.
- (2) Хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад зөвхөн нэг асуултыг оруулах бөгөөд хэрэв хэд хэдэн асуулт ирсэн бол тэдгээрээс хамгийн эхэнд ирснийг оруулна.

41 дүгээр зүйл. Тодруулах асуултыг хэлэлцэх

- (1) Асуулт илгээсэн гишүүн 30 хүртэлх минутад тодруулах асуултынхаа талаар тайлбар өгсний дараа уг асуултыг хүлээн авсан этгээд мөн хугацаанд үг хэлнэ. Үүний дараа бусад гишүүд тэдний хүсэлтээр 10 хүртэлх минутад үг хэлнэ.
- (2) Асуулт илгээсэн гишүүн, хүлээн авсан этгээд хэлэлцүүлэг дуусахаас өмнө түүнийг цуцалж болно.

42 дугаар зүйл. Тодруулах асуултын үр дүнд шаардлагатай арга хэмжээ авах

Хэлэлцүүлгийн дараа Танхим нь тодруулах асуултын хэлэлцүүлгийн үед гарсан асуудалд дүгнэлт өгч, уг асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг тогтоож, шаардлагатай бол үүссэн нөхцөл байдалд тохирсон хариуцлага тогтооно.

Хэсэг Е. Ерөнхийлөгчийн Зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Парламентын Ассамблейн Танхимуудад мэдээлэл хийх

43 дугаар зүйл. Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны талаар Ерөнхийлөгчийн Зөвлөлд мэдэгдэх

- (1) Төлөөлөгчдийн Танхимын дарга тус Танхимын бүх хуралдаанд Ерөнхийлөгчийн Зөвлөлийг оролцуулна.
- (2) Ерөнхийлөгчийн Зөвлөлийн санаачилсан хуулийн төсөл, эсхүл тус Зөвлөлийн эрхлэх асуудлыг хэлэлцэх хуралдаануудад тус Зөвлөлийн хамгийн багадаа нэг гишүүн оролцоно.

(3) Ерөнхийлөгчийн Зөвлөл энэ зүйлийн (2)-т заасны дагуу Төлөөлөгчдийн Танхимын хуралдаанд төлөөлөгчөө оруулах бөгөөд хуралдаанд өөрийн тааллаар оролцох эрхтэй.

44 дүгээр зүйл. Танхимуудад Ерөнхийлөгчийн Зөвлөлийн эрхлэх асуудлаар мэдээлэл хийх

(1) Танхимуудын хүсэлтээр Ерөнхийлөгчийн Зөвлөл нь Төлөөлөгчдийн Танхимын хуралдаанд эрхлэх асуудлаараа мэдээлэл хийж, байр сууриа илэрхийлнэ.

(2) Танхимын хуралдаан эхлэхээс өмнө Ерөнхийлөгчийн Зөвлөлөөс тайлангаа бичгээр ирүүлэхийг хүсэж болно.

(3) Танхим хэлэлцүүлгийн дараа холбогдох асуудлаар өөрийн байр суурь, эсхүл удирдлага болгох зарчмыг тусгасан тогтоол баталж болно.

(4) Ерөнхийлөгчийн Зөвлөл Үндсэн хуулийн дагуу жилд нэгээс багагүй удаа зардлын тайлангаа Танхимд ирүүлнэ.

Хэсэг Ё. Сайд нарын Зөвлөлд итгэл үзүүлэх эсэх, эсхүл дахин сэргээх шаардлагатай тухай хэлэлцэх

45 дугаар зүйл. Сайд нарын Зөвлөлийн үүрэг, хариуцлага

(1) Сайд нарын Зөвлөл нь Танхимуудын өмнө дараах асуудлаар хариуцан тайланана: бодлого боловсруулж хэрэгжүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, Үндсэн хууль болон бусад хуулиар тогтоосон бүрэн эрхийг хэрэгжүүлэх, түүнчлэн яамдын үйл ажиллагааг удирдлагаар хангах, зохицуулах зэрэг асуудлууд болно.

(2) Сайд нарын Зөвлөл нь Танхимын хүсэлтийн дагуу бүх үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл өгөх үүрэгтэй.

46 дугаар зүйл. Сайд нарын Зөвлөлд итгэл үзүүлэх эсэх асуудлыг санаачлах

(1) Төлөөлөгчдийн Танхимын наймаас доошгүй гишүүн, эсхүл Нийтийн Танхимын гурваас доошгүй төлөөлөгч хамтран Сайд нарын Зөвлөлд итгэл үзүүлэх эсэх, эсхүл дахин сэргээх шаардлагатай талаар санал гаргаж болно.

(2) Ерөнхийлөгчийн Зөвлөлөөс Сайд нарын Зөвлөлийн тэргүүнийг өөрчлөх тухай санал гаргаж болно.

(3) Энэ зүйлийн (1), (2)-т заасан саналыг Танхимын даргад бичгээр гаргах ба саналд үндэслэлээ тусгах бөгөөд гарын үсэг зурсан байна.

(4) Төлөөлөгчдийн Танхимын дарга саналыг Ерөнхийлөгчийн Зөвлөл, Сайд нарын Зөвлөл, Парламентын Ассамблейн гишүүдэд нэн даруй хүргүүлнэ.

47 дугаар зүйл. Хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах

Сайд нарын Зөвлөлд итгэл үзүүлэх эсэх, эсхүл сэргээх саналыг Сайд нарын Зөвлөлд оруулснаас хойш 20-оос багагүй, 30-аас ихгүй хоногийн дотор Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулна.

48 дугаар зүйл. Итгэл үзүүлэх эсэх талаарх Сайд нарын Зөвлөлийн илтгэл

(1) Сайд нарын Зөвлөлд итгэл үзүүлэх эсэх талаар санал хураах хуралдаан эхлэхээс өмнө тус Зөвлөлөөс илтгэлээ үзэл бодол, дүгнэлтийн хамт бичгээр ирүүлж болно.

(2) Илтгэлийг хуралдаан эхлэхээс 48 цагийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.

49 дүгээр зүйл. Дахин сэргээх тухай Сайд нарын Зөвлөлийн илтгэл

(1) Сайд нарын Зөвлөлийг даних сэргээх тухай санал хураах хуралдаан эхлэхээс өмнө Сайд нарын Зөвлөлөөс илтгэлээ үзэл бодол, дүгнэлтийн хамт бичгээр ирүүлж болно.

(2) Өөрчлөхөөр санал болгосон сайд нар өөрийн тайланг Танхимд ирүүлж болно.

(3) Илтгэлийг хуралдаан эхлэхээс 48 цагийн өмнө гишүүдэд хүргүүлнэ.

50 дугаар зүйл. Сайдын Зөвлөлийн санал, хариулт

(1) Санаачлагч нь Төлөөлөгчдийн Танхимын хуралдаанд Сайд нарын Зөвлөлд итгэл үзүүлэх эсэх, эсхүл дахин сэргээх тухай саналын үндэслэлээ нотлох эрхтэй бөгөөд нотлох үүрэгтэй.

(2) Сайд нарын Зөвлөл уг саналд хариу өгөх, санал бодлоо илэрхийлэх эрхтэй бөгөөд үүний дараа уг асуудлаар хэлэлцүүлгийг эхлүүлнэ.

51 дүгээр зүйл. Санал хураалт явуулах

(1) Хэлэлцүүлэг дууссаны дараа Сайд нарын Зөвлөлд итгэл үзүүлэх эсэх, эсхүл дахин сэргээх талаар санал хураалт явуулна.

(2) Санал дэмжигдээгүй бол уг саналтай холбоотой өөр санал гаргаж болно.

(3) Танхимын дарга Сайд нарын Зөвлөлд итгэл үзүүлэх эсэх, эсхүл дахин сэргээх талаарх санал хураалтын дүн, мөн уг саналтай холбоотой бусад санал гарсан бол Төлөөлөгчдийн Танхим, Сайд нарын Зөвлөл, Ерөнхийлөгчийн Зөвлөлд мэдэгдэнэ.

52 дугаар зүйл. Сайд, дэд сайдыг өөрчлөх

(1) Сайд нарын Зөвлөлийн тэргүүн нь сайд, дэд сайдыг өөрчлөх тухай санал гаргаж болно.

(2) Энэ зүйлийн (1)-д заасан үндэслэл бүхий саналаа Танхимын даргад бичгээр хүргүүлнэ.

(3) Төлөөлөгчдийн Танхимын дарга уг саналыг нэн даруй гишүүдэд болон нөгөө Танхимд хүргүүлнэ.

53 дугаар зүйл. Хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах

Төлөөлөгчдийн Танхимын дарга нь сайд, дэд сайдыг огцруулах тухай Сайд нарын Зөвлөлийн тэргүүний саналыг хүлээн авснаас хойш 15-аас доошгүй хоногийн дотор Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулна.

54 дүгээр зүйл. Саналын үндэслэл болон түүнийг хэлэлцэх

(1) Сайд нарын Зөвлөлийн тэргүүн нь саналаа Төлөөлөгчдийн Танхимын хуралдаанд нотлох эрхтэй бөгөөд үүний дараа уг асуудлаар хэлэлцүүлгийг эхлүүлнэ.

(2) Өөрчлөх санал болгосон сайд, дэд сайд нар Танхимд хандах эрхтэй.

55 дугаар зүйл. Сайд, дэд сайдыг өөрчлөх талаар санал хураах

(1) Хэлэлцүүлгийн дараа сайд, дэд сайдыг өөрчлөх талаар санал хураана.

(2) Санал дэмжигдээгүй бол уг саналтай холбоотой өөр санал гаргаж болно.

(3) Нийтийн Танхимын дарга нь санал хураалтын дүн, мөн уг саналтай холбоотой өөр санал гарсан бол Төлөөлөгчдийн Танхим, Сайд нарын Зөвлөл, Ерөнхийлөгчийн Зөвлөлд мэдэгдэнэ.

Хэсэг Ж. Тайлан хэлэлцэх

56 дугаар зүйл. Ирүүлсэн тайланг хэлэлцэх

(1) Хяналтад байдаг бүх байгууллагууд тайлангаа хууль тогтоомжоор, эсхүл парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын хүсэлтээр Парламентын Ассамблейгаар хэлэлцүүлж, батлуулахаар хүргүүлнэ.

(2) Танхимын харьяанд байгаа парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага энэ зүйлийн (1)-д заасан тайланг авч үзнэ.

(3) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага нь аливаа сонгогдсон, эсхүл томилогдсон албан тушаалтан, эсхүл тухайн байгууллагаас парламентын хяналтад чухал ач холбогдолтой асуудлаар тусгай тайлан гаргаж өгөхийг шаардаж болно.

57 дугаар зүйл. Тайланд тавигдах шаардлага

(1) Хяналтад байгаа байгууллагууд нь журамд заасан шаардлагын дагуу тайлангаа парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагад хүргүүлнэ.

(2) Хяналтад байдаг байгууллагуудын тайланд бичгэн болон хүснэгтэн хэлбэрийг ашигласан, харьцуулалтууд, үзүүлэлтүүд, статистикийг багтаасан байна. Улсын төсөвт болон төсвөөс гадуур хэрэглэгчдийг санхүүжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн тайланг маягтын дагуу ирүүлнэ.

(3) Хяналтын байгууллага нь шийдвэр болон үйл ажиллагааны харилцаа тогтоох тухай зарыг албан ёсны сонин болон бусад албан ёсны сонин, өөрийн цахим хуудсанд нийтэлнэ.

(4) Төрийн албаны газар нь парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын хүсэлтийн дагуу шинээр элссэн бүх ажилчдын талаарх шинэчилсэн тайлан, бүх менежерүүдийн нэрсийн жагсаалт, албан тушаалд томилогдсон огноо, түүнээс чөлөөлөгдсөн огноо болон тэдний гүйцэтгэх чиг үүргийн жагсаалтыг гаргаж өгнө.

58 дугаар зүйл. Үгүйсгэсэн тайлан гаргах журам

Парламентын Ассамблейн хоёр Танхим дахь хяналтын байгууллагуудын тайлан нь үгүйсгэсэн тайлан болох бөгөөд тэдгээрийг Парламентын Ассамблейн цахим хуудсанд Нууцын зэрэглэлтэй мэдээлэл хамгаалах тухай хуулийн дагуу нийтэлнэ.

59 дүгээр зүйл. Хариуцагч буюу эрх бүхий этгээдийн үйл ажиллагааны мэдээлэл

Парламентын хяналт шалгалтаар хариуцагч буюу эрх бүхий этгээд хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл хийсэн нь тогтоогдсон бол түүнийг томилох эрхтэй байгууллага нь мэдээлэл цуглуулан холбогдох байгууллагад хүргүүлнэ.

60 дугаар зүйл. Сайд нарын Зөвлөлийн үйл ажиллагааны тайлан

(1) Сайд нарын Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг жилд нэг удаа хянаж батална.

(2) Парламентын хяналтыг хэрэгжүүлэхдээ Парламентын Ассамблейн нэг, эсхүл хоёр Танхимаас Сайд нарын Зөвлөлийг тодорхой асуудлаар, салбараар, үйл ажиллагааны талаар, эсхүл тодорхой хугацаанд гүйцэтгэсэн үйл ажиллагааны талаар тайлагнахыг шаардаж болно.

61 дүгээр зүйл. Арга зүй

Парламентын Ассамблей илтгэл танилцуулах арга зүйг энэ хуулийн 60 дугаар зүйлийн 2-т заасан үндэслэл, мөн тайлан танилцуулах хугацааг тодорхойлж болно.

62 дугаар зүйл. Парламентын хяналтын бусад хэлбэр

Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага энэ хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу парламентын хяналтыг хэрэгжүүлэх бусад арга хэрэгслэлийг ашиглаж болно.

63 дугаар зүйл. Парламентын хяналтад үл хамаарах асуудал

(1) Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллага дараах тохиолдолд хяналтад байгаа байгууллагуудын баримт бичигтэй танилцах боломжгүй, эсхүл албан тушаалтнаас асуултын хариу шаардахгүй:

- а) парламентын хяналтад үл хамаарах асуудлаар баримт бичиг, эсхүл хариу шаардсан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр байгаа бол энэ тухай түүнд анхааруулна;
- б) нууцын зэрэглэлтэй мэдээлэл хамгаалах тухай хууль тогтоомжид заасан;

(2) Хэрэв энэ зүйлийн 1-д заасан этгээдийн баримт бичиг, эсхүл шаардлага эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа бол Парламентын Ассамблей эрх бүхий прокурорын газарт өргөдөл гаргана.

IV БҮЛЭГ. ХАРИУЦЛАГА ТООЦОХ

64 дүгээр зүйл. Парламентын хяналтын талаар хяналтанд байдаг байгууллагуудын хариуцагч болон эрх бүхий этгээдэд торгууль ногдуулах

(1) Хяналтад байдаг байгууллагад ажилладаг хариуцагч, эсхүл эрх бүхий этгээдийг дараах зөрчилд 100.00–1000.00 КМ хүртэл хэмжээний торгууль ногдуулна:

- а) үндэслэлгүйгээр хариу өгөөгүй, эсхүл бичгээр ирүүлээгүй, парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын гишүүдэд бүрэн эрхийнхээ хүрээнд мэдээлэл өгөөгүй, асуултад хариулаагүй бол (11, 21, 25, 29, 34.36 дугаар зүйл);
- б) хяналтад байдаг байгууллагаас парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагад тусгай тайлан ирүүлээгүй, парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагын гишүүдийн асуултад хариулаагүй бол (12, 21, 25, 29, 34, 36 дугаар зүйл);
- в) хяналтад байгаа байгууллагын аливаа этгээдийн хийсэн бүх мэдээлэл, баримт бичиг, түүнчлэн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тэмдэглэлтэй танилцаж, ойлгоход саад учруулсан бол /16 дугаар зүйлийн (1) дэх хэсэг/.

(2) Байгууллага, хуулийн этгээдийн бүрэн эрхийг зөрчсөн бол 1.000.00–40.000.00 КМ хүртэл хэмжээний торгууль ногдуулна:

- а) парламентын хяналтыг хэрэгжүүлэхийг хориглосон бол /11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг/;
- б) парламентын хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын хүсэлтээр мэдэгдэл өгөөгүй, хүссэн мэдээлэл, баримт бичгийг өгөөгүй бол /16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг/.

(3) Энэ зүйлийн (2) дахь хэсгийг зөрчсөн тохиолдолд тухайн байгууллага, хуулийн этгээд, болон хариуцагчид 60.00–400.00 КМ хүртэл торгууль ногдуулна.

65 дугаар зүйл. Парламентын мөрдөн шалгалтын явцад хяналтад байгаа байгууллагын хариуцагч болон эрх бүхий этгээдэд торгууль ногдуулах

Парламентын мөрдөн шалгалтын тухай мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор парламентын мөрдөн шалгалтын үеэр энэ хуульд заасан үйл ажиллагаа явагдаагүй бол хяналтад байдаг байгууллагын хариуцагч, эсхүл эрх бүхий этгээдэд 500.00-аас 300.00 КМ хүртэл торгууль ногдуулна.

66 дугаар зүйл. Хариуцлага тооцох норматив зохицуулалт

Энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор Парламентын Ассамблей энэ хуулийн хариуцлагын заалтыг дагаж мөрдөх журмын одоо мөрдөж байгаа зохицуулалтыг хэвээр, эсхүл шинээр баталж хэрэглэнэ.

67 дугаар зүйл. Торгууль

Энэ хууль болон бусад хуульд заасан зөрчилтэй холбогдуулан торгууль ногдуулах замаар төвлөрсөн хөрөнгө нь төсвийн орлого болно.

V БҮЛЭГ. ШИЛЖИЛТИЙН ЗААЛТУУД

68 дугаар зүйл. Дүрэм

(1) Энэхүү хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор Парламентын Ассамблей парламентын хяналтыг хэрэгжүүлэх хэсэгт хоёр Танхимын дүрэм, эдийн засгийн актуудад нэмэлт, өөрчлөлт оруулна.

(2) Хяналтад байдаг байгууллагууд энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш зургаан сарын хугацаанд энэ хуулийн заалтыг саадгүй хэрэгжүүлэхийг зөвшөөрөх хүчин төгөлдөр дүрмийг тохиролцоно.

69 дүгээр зүйл. Хүчин төгөлдөр болох

Энэ хууль албан ёсны сонин нийтлэгдсэн өдрөөс хойш найм дахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр, Сариево



2.2.2.ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ¹⁴

Албан бус орчуулга

2013.05.07-ны өдөр Холбооны хууль №77 (Сүүлчийн редакци)
2013.04.23-ны өдөр ОХУ-ын Төрийн Думаар баталсан.
2013.04.27-ны өдөр Холбооны Зөвлөлөөс дэмжсэн.
2013.05.07-ны өдөр батлагдаж, 05.14-ний өдөр хэвлэгдсэн.
2013.05.09-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

ХУУЛИЙН БҮТЭЦ

I бүлэг. Парламентын хяналтын үндэс

- 1-р зүйл. Хуулиар зохицуулах харилцаа
- 2-р зүйл. Парламентын хяналтын зорилго
- 3-р зүйл. Парламентын хяналтын зарчмууд
- 4-р зүйл. Парламентын хяналтын субъектүүд
- 5-р зүйл. Парламентын хяналтын хэлбэрүүд
- 6-р зүйл. Холбооны хууль тогтоомжийг дагалдан гарч буй эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актуудыг парламентаас хянах

II бүлэг. Парламентын хяналтын тусгайлсан хэлбэрүүд

- 7-р зүйл. Төрийн Думын төлөөлөгчид, Холбооны дээд зөвлөлийн гишүүдээс Засгийн газрын гишүүд, холбогдох бусад албан тушаалтнуудаас асуулт асуух, хариуг сонсох
- 7.1-р зүйл. Засгийн газрын төлөөлөгчийн жил бүрийн улс, үндэсний хэмжээний тайлан, илтгэл, мэдээлэл сонсох
- 8-р зүйл. Парламент болон парламентын гишүүний асуулга
- 9-р зүйл. Холбооны Хурлын парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаа
- 10-р зүйл. Холбооны Хурлын танхимуудын төлөөлөгчдийн үйл ажиллагаанд тавих парламентын хяналт
- 11-р зүйл. Холбооны Хурлын танхимуудаас төсвийн эрх зүйн харилцааны хүрээнд тавих парламентын хяналт
- 12-р зүйл. Онцгой нөхцөл байдал үүссэн шалтгааныг мөрдөн шалгах, түүний үр дагаврыг арилгах Засгийн газрын комиссын үйл ажиллагаанд парламентын оролцоо

III бүлэг. Парламентын хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх

- 13-р зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт
- 14-р зүйл. Парламентын хяналтын эрх зүй, зохион байгуулалт, арга зүйн хангамж
- 15-р зүйл. Парламентын хяналтын үр дүнгээр Холбооны Зөвлөлийн танхимаас гаргах шийдвэрүүд

I БҮЛЭГ. ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫН ҮНДЭС

1 дүгээр зүйл. Хуулиар зохицуулах зүйл

Энэ хуулиар Оросын Холбооны Улсын Үндсэн хууль, субъектүүдийн Үндсэн хууль, энэ хууль болон холбогдох бусад хууль болон Холбооны Хурлын танхимуудаас гаргасан регламентуудын хүрээнд Холбооны Хурлын танхимууд, хороод, комиссууд, Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн гишүүд болон Төрийн Думын төлөөлөгчид, Тооцооллын танхим, Парламентын мөрдөн шалгах хорооноос асуудлын шалтгаан нөхцөл, баримт нотолгоог мөрдөн шалгах болон парламентын хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой нийтлэг харилцааг зохицуулна.

¹⁴Федеральный закон О парламентском контроле.

Эх сурвалж: <http://pravo.gov.ru/proxy/ips/?docbody=&prevDoc=102077052&backlink=1&nd=102165151>

2 дугаар зүйл. Парламентын хяналтын зорилго

Парламентын хяналтыг дараах зорилгоор хэрэгжүүлнэ:

1. Үндсэн хууль, субъектүүдийн Үндсэн хууль болон бусад хуулиудыг дагаж мөрдөх, хэрэгжилтийг хангуулах;
2. Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, иргэний эрхийг хамгаалах;
3. хууль ёс, дэг журмыг бэхжүүлэх;
4. хууль хэрэгжүүлэх шатанд төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд гарч буй алдаа дутагдал, тулгамдсан асуудлуудыг тогтоож, төрийн удирдлагын системийн үр нөлөөг дээшлүүлэх, парламентын хяналтын явцад төрийн байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлуудыг арилгуулах арга хэмжээ авах;
5. авилгын эсрэг тэмцэх;
6. хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг судлан шинжилж, хууль тогтоомжийн хэрэгжилт, практик үр нөлөөг сайжруулах, шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох талаар зөвлөмж гаргах.

3 дугаар зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэх зарчмууд

1. Парламентын хяналтыг хэрэгжүүлэх зарчмууд:

- 1) эрх зүйт ёсны байдал;
- 2) иргэн болон хувь хүний эрх, эрх чөлөөг хангах;
- 3) засаглалын эрх мэдлийн хуваарилалтыг хэрэгжүүлэх;
- 4) парламентын хяналтыг хэрэгжүүлэх субъектүүдийн бие даасан, хараат бус байдал хангагдсан байх;
- 5) системтэй байх;
- 6) ил тод байх.

2. Парламентын хяналтын тухай мэдээллийг олон нийт болон хэвлэл мэдээллийн хэрэгсэл, тэр дундаа цахим сүлжээгээр нээлттэй түгээж болно. Холбооны Хурлаас баталсан хуулиар хязгаарласнаас бусад парламентын хяналттай холбоотой мэдээллийг аль болохоор олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

3. Парламентын хяналт нь шүүн таслах, гэмт хэргийг мөрдөн шалгах, шуурхай эрэн хайх зэрэг өөрийн бүрэн эрх, эрх хэмжээний хүрээнд явуулж буй төрийн бусад байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын үйл ажиллагааг орлохгүй. Парламентын хяналтыг хэрэгжүүлж буй субъектүүд дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох эрхгүй.

4 дүгээр зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэх субъектүүд

1. Парламентын хяналтыг хэрэгжүүлэгч эрх бүхий субъектүүдэд дараах субъектүүд хамаарна. Үүнд:

- 1) Холбооны Хурлын танхимууд – Холбооны Зөвлөл болон Төрийн Дум;
- 2) Холбооны Хурлын танхимуудын хороод, комиссууд;
- 3) Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаанд шаардагдах нөхцөл байдал, баримт нотолгоог мөрдөн шалгах хороо;
- 4) Холбооны Зөвлөлийн гишүүд болон Төрийн Думын төлөөлөгчид.

2. Тооцооллын танхим нь төрийн хяналт (аудит)-ыг хэрэгжүүлэх байнгын ажиллагаатай төрийн дээд байгууллага бөгөөд Холбооны Хуралд ажлаа хариуцан тайлагнах байгууллага тул парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд энэ хууль болон 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан Тооцооллын танхимын тухай хуульд заасан эрхийн хүрээнд тодорхой хэлбэр, журмыг баримтлан оролцоно.

5 дугаар зүйл. Парламентын хяналтын хэлбэрүүд

Парламентын хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1) Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг Төрийн Думаар хэлэлцэх;
- 2) Холбооны Хурлын танхимууд, хороод, Төрийн аудитын байгууллагаас төсвийн асуудлаар урьдчилсан, явцын болон дараагийн шатны парламентын хяналтыг хэрэгжүүлэх;
- 3) Төрийн Думаар Засгийн газрын үйл ажиллагааны үр дүнгийн талаарх жилийн тайлан, Төрийн Думын төлөөлөгчдөөс тавьсан асуултын хариулт сонсох;
- 4) Төрийн Думаар Төв банкны жилийн тайланг хэлэлцэж, шийдвэр гаргах;
- 5) Төв банкны ерөнхийлөгчийн Төв банкны үйл ажиллагааны жилийн тайлан, төрийн мөнгө-зээлийн бодлогын үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлан, илтгэлийг сонсох;
- 6) Төв банкны үйл ажиллагаанд Төв банкны тухай хуульд заасан бусад арга хэлбэрээр парламентын хяналтыг хэрэгжүүлэх;
- 7) Холбооны Хурлын танхимуудаас асуулга тавих;
- 8) Холбооны Зөвлөлийн гишүүд, Төрийн Думын төлөөлөгчдөөс асуулга тавих;
- 9) Холбооны Хурлын танхимуудаас Засгийн газрын гишүүд, гүйцэтгэх засаглалын байгууллагууд, холбооны бусад байгууллага, төсвөөс гадуурх тусгай төрийн сангийн удирдлага, албан тушаалтнуудын мэдээллийг сонсох, “Засгийн газрын цаг”-ын хүрээнд Холбооны Зөвлөлийн гишүүд, Төрийн Думын төлөөлөгчдөөс тавьсан асуулга, асуултын хариуг сонсох, түүнчлэн Холбооны Хурлын танхимуудын хороод, комисст дээр нэр дурдсан байгууллага, албан тушаалтнуудын мэдээллийг сонсох;
- 10) онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд Засгийн газрын тэргүүн, шадар сайд, Ерөнхий прокурор, Төв банкны ерөнхийлөгч, Сонгуулийн ерөнхий хорооны дарга зэрэг холбогдох албан тушаалтнуудыг мэдээлэл авах зорилгоор дуудаж сонсох;
- 11) Тооцооллын танхимын дарга, орлогч, аудиторруудыг томилох, чөлөөлөх;
- 12) Холбооны Хурлаас Тооцооллын танхимтай Тооцооллын танхимын тухай хуульд заасан хэлбэрээр хамтран ажиллах;
- 13) Төрийн Думаас хүний эрхийн асуудлаар эрх бүхий төлөөлөгчидтэй хамтран ажиллах;
- 14) Ерөнхий прокурорын жилийн тайлан илтгэл, хууль хэрэгжүүлэх, сахин мөрдүүлэх ажиллагааны өнөөгийн байдал, цаашид бэхжүүлэх чиглэлээр хийгдэж буй ажлын талаар мэдээлэл сонсох;
- 15) Холбооны Хурлын төлөөний хүмүүсийг хуулийн дагуу байгуулагдсан байгууллагад илгээх, эгүүлэн татах;
- 16) Засгийн газрын гишүүд, холбогдох албан тушаалтнуудыг Холбооны Хурлын танхимуудын хороод болон комиссын хуралдаанд дуудах;
- 17) Парламентын сонсгол зохион байгуулах;
- 18) Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах.

6 дугаар зүйл. Холбооны хуулийг дагаж гарах эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актуудыг боловсруулах, батлан гаргах, хэвлүүлэх үйл ажиллагаанд тавих парламентын хяналт

1. Холбооны Хурлын танхимуудаас холбогдох регламентад заасан журмын дагуу Засгийн газар болон гүйцэтгэх засаглалын байгууллагуудаас хуульд заасан хугацаанд холбогдох хэм хэмжээ тогтоосон актуудыг батлан гаргаж буй эсэх, батлан гаргасан актууд нь тухайн харилцааг зохицуулах иж бүрэн зохицуулалт болж буй эсэх, хийдэл, зөрчил бий эсэхийг шалгана.

2.Засгийн газраас улирал тутамд (улирал дуусахаас 30 хоногийн өмнө) хууль тогтоомжийг дагалдан гарах эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актуудыг батлан гаргах үйл ажиллагааны явц, батлан гаргасан актуудын талаарх мэдээлэл ирүүлнэ.

II БҮЛЭГ. ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫН ТУСГАЙЛСАН ХЭЛБЭРҮҮД

7 дугаар зүйл. Засгийн газрын гишүүн, холбогдох албан тушаалтанд тавьсан асуултын хариуг сонсох

1.Холбооны Хурлын танхимууд Засгийн газрын тэргүүн, холбогдох бусад албан тушаалтнуудыг Холбооны Зөвлөлийн гишүүд болон Төрийн Думын төлөөлөгчдийн тавьсан асуултад хариулах зорилгоор танхимын хуралд дуудах эрхтэй.

2.Холбооны Хурлын танхимын хуралдаанд Засгийн газрын гишүүд болон холбогдох албан тушаалтанд тавьсан асуултын хариуг сонсох цагийг тусгайлан гаргаж болно. “Засгийн газрын цаг”-ийн хүрээнд гишүүдийн асуултад хариулах албан тушаалтантай хамт Тооцооллын танхимын газрын тухайн асуудлыг хариуцсан чиглэлийн аудиторыг урьж болно.

3.“Засгийн газрын цаг” дээр асуудлыг хэлэлцэх явцад тухайн чиглэлээр төсвийн хөрөнгийг хэр үр ашигтай зарцуулж байгаа, төрийн бодлого, хөтөлбөрүүдэд тусгасан зорилтот үзүүлэлт хангагдах боломжтой эсэх, ямар арга хэмжээ авч байгаа талаар хэлэлцэнэ.

4.Холбооны Хурлын танхимуудын хороод, комиссууд нь Холбооны сайд, итгэмжлэгдсэн албан тушаалтнуудыг хороод, комиссын хуралд урьж оролцуулах эрхтэй.

7-1 дүгээр зүйл. Засгийн газрын төлөөлөгчдийн улсын болон үндэсний жилийн тайлангийн талаарх мэдээлэл

1.Хууль тогтоомжид заасан журмын дагуу Холбооны Хурлын танхимуудад Засгийн газрын төлөөлөгчдийн улсын болон үндэсний тайлан илтгэлийн талаарх мэдээллийг сонсоно.

2.Холбооны Хурлын танхимуудад Засгийн газрын төлөөлөгчдийн улсын болон үндэсний тайлан илтгэлийг сонсоход Засгийн газрын төлөөлөгчид, холбогдох албан тушаалтнуудтай хамт Тооцооллын (аудит) танхимын тухайн чиглэлийн асуудлыг хариуцсан албан тушаалтны илтгэлийг сонсоно.

3. Улсын болон үндэсний хэмжээний жилийн тайлан илтгэлийн талаарх мэдээллийг сонсох явцад үндэсний хөтөлбөрийн батлагдсан зорилтот үзүүлэлтүүдийг хангасан эсэх, тухай арга хэмжээнд зарцуулсан төсвийн хөрөнгийн үр ашиг ямар байгаа талаарх асуудлыг заавал хэлэлцэнэ.

8 дугаар зүйл. Парламентын асуулга, төлөөлөгчийн асуулга

1.Холбооны Хурлын танхимууд Холбооны Хурлын танхимын дүрэмд заасны дагуу Холбооны Зөвлөлийн гишүүд парламентын асуулга, Төрийн Думын төлөөлөгчид нь төлөөлөгчдийн асуулгыг Засгийн газрын тэргүүн, Засгийн газрын гишүүд, Улсын Ерөнхий прокурор, Төв банкны тэргүүн, холбооны бусад төрийн байгууллагуудын тэргүүн, улсын төсвийн тусгай сангуудын тэргүүн, субъектүүдийн төрийн эрх бүхий байгууллагуудын тэргүүн, нутгийн өөрөө удирдах байгууллагуудын тэргүүнд тэдгээр байгууллагууд болон албан тушаалтны бүрэн эрхэд хамаарах асуудлын хүрээнд тавих эрхтэй.

2.Парламентын асуулгын хариуг тухайн албан тушаалтан Холбооны Хурлын танхимуудын хуралдаанд биечлэн оролцож, эсхүл танхимтай тохиролцсоны дагуу асуулгыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор, эсхүл Холбооны Хурлын танхимын тогтоосон хугацаанд бичгэн хэлбэрээр өгнө.

3.Хэрэв Холбооны Хурлын танхим нь асуулгын хариуг хангалтгүй гэж үзвэл асуулгыг дахин тавьж болно.

9 дүгээр зүйл. Холбооны Хурлын парламентын мөрдөн шалгалт

Нийгэм болон төрд сөрөг үр дагавар учруулсан баримт нотолгоо, нөхцөл байдлын талаарх парламентын мөрдөн шалгах ажиллагаа, үүнд дотроо Холбооны Хурлын танхимууд паритатын үндсэн дээр парламентын мөрдөн шалгах үндэслэл болох баримт нотолгоо, нөхцөл байдлыг судлах үүрэг бүхий парламентын комисс байгуулах ажлыг 2005 оны 12 дугаар сарын Холбооны Хурлын парламентын мөрдөн байцаалтын тухай 196 тоот Холбооны хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл. Холбооны Хурлын танхимын төлөөлөгчдийн ажилд тавигдах парламентын хяналт

Холбооны хуулийн дагуу байгуулагдсан байгууллагуудын хяналтын зөвлөлийн гишүүд (ОХУ-ын Холбооны Хурлын танхимын төлөөлөл), түүнчлэн бусад байгууллага дахь Холбооны Хурлын танхимын төлөөлөгчид жил бүр Холбооны Хурлын холбогдох танхимын холбогдох хорооны хуралдаанд, эсхүл Холбооны Хурлын танхимын холбогдох журамд заасны дагуу үйл ажиллагааныхаа тайланг гаргаж өгөх үүрэгтэй.

11 дүгээр зүйл. Холбооны Хурлын танхимуудаас төсвийн эрх зүйн харилцааны хүрээнд тавих парламентын хяналт

1.Төсвийн эрх зүйн харилцааны хүрээнд тавих парламентын хяналт нь урьдчилсан, явцын, дараагийн шатны хяналтаас тогтоно.

2.Парламентын урьдчилсан хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- 1) төсвийн бодлогын үндсэн чиглэлийн төсөл болон татварын бодлогын үндсэн чиглэлийн төслийг хэлэлцэх;
- 2) төрийн хөтөлбөрийн төсөл болон түүнд оруулах өөрчлөлтийн талаарх саналуудыг авч үзэх;
- 3) Ирэх тайлант жил болон төлөвлөсөн хугацааны холбооны төсвийн тухай холбооны хуулийн төсөл, төсвийн тусгай сангийн тухай холбооны хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцох;
- 4) Ирэх тайлант жил болон төлөвлөсөн хугацааны холбооны төсвийн тухай холбооны хуулийн төсөл, төсвийн тусгай сангийн тухай холбооны хуулийн төслийг Төсвийн тухай хуулийн дагуу хэлэлцэн батлах.

3.Төрийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх үүрэг бүхий холбооны гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд холбогдох хөтөлбөрийн төслийг Засгийн газар болон Төрийн Думд хэлэлцүүлэхээр зэрэг өргөн мэдүүлнэ.

4.Сангийн яам нь төсвийн бодлогын үндсэн чиглэлийн төсөл болон татварын бодлогын үндсэн чиглэлийн төслийг Засгийн газар, Төрийн Думд хэлэлцүүлэхээр зэрэг өргөн мэдүүлнэ.

5.Энэ зүйлд заасны дагуу Төрийн Думд өргөн мэдүүлсэн төрийн хөтөлбөрийн төсөл, төсвийн бодлогын үндсэн чиглэлийн төсөл болон татварын бодлогын үндсэн чиглэлийн төслийг Төрийн Дум хүлээн авсны дараа Төрийн Думын Зөвлөл нэг ажлын өдөрт багтааж Холбооны Зөвлөлд хүргүүлнэ. Парламентын амралтын хугацаанд Төрийн Думын дарга хүргүүлнэ.

6.Төрийн Дум шаардлагатай тохиолдолд Аудитын танхим, Холбооны Зөвлөлийн хороодыг оролцуулан холбогдох төслүүдээр парламентын сонсгол явуулж болно

7.Холбогдох төслийн талаарх Төрийн Дум болон Холбооны Зөвлөлийн холбогдох хороод, Төрийн Думын Төсөв, татварын хороо, Холбооны Зөвлөлийн Төсөв, санхүүгийн зах зээлийн асуудал эрхэлсэн хороо, Холбооны Зөвлөлийн Холбооны бүтэц, бүс нутгийн бодлого, нутгийн өөрийн удирдлага, Умардын асуудал эрхэлсэн хорооны дүгнэлт, түүнчлэн парламентын сонсголын зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлнэ.

8.Парламентын явцын хяналтын хүрээнд Холбооны Зөвлөлийн танхимын хороо, комиссын хуралдаан, парламентын сонсголын үеэр парламентын асуулга, төлөөлөгчийн асуулгатай холбогдуулан Холбооны төсвийн болон улсын төсвийн тусгай сангийн төсвийн гүйцэтгэлийн талаарх асуудлыг хэлэлцэнэ.

9.Парламентын дараагийн шатны хяналтын хүрээнд холбооны төсвийн гүйцэтгэл, улсын төсвийн тусгай сангийн төсвийн тайланг хэлэлцэн батлах ажлыг Төсвийн тухай хуулийн дагуу явуулна. Төрийн Дум холбооны төсвийн гүйцэтгэлийн жилийн тайланг хэлэлцэхдээ холбооны төсвийн гүйцэтгэлийн талаарх Сангийн сайдын илтгэл, холбооны төсвийн гүйцэтгэлийн жилийн тайлантай холбоотой Аудитын танхимын дүгнэлтийн талаарх тус танхимын даргын тайланг сонсоно. Холбооны төсвийн гүйцэтгэлийн жилийн тайланг хэлэлцсэний дараа Төрийн Дум Холбооны төсвийн гүйцэтгэлийн тухай холбооны хуулийг батална, эсхүл батлахаас татгалзана.

10.Аудитын танхим нь 2013 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн Аудитын танхимын тухай 41 тоот Холбооны хуулийн дагуу төсвийн эрх зүйн харилцааны хүрээнд парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд оролцоно.

12 дугаар зүйл. Онцгой байдлын шалтгааныг шалгах, тэдгээрийн үр дагаврыг арилгах үүрэг бүхий Засгийн газрын комиссын үйл ажиллагаанд оролцох

1.Холбооны Хурлын танхимын төлөөлөгчид нь онцгой байдлын шалтгааныг шалгах, тэдгээрийн үр дагаврыг арилгах үүрэг бүхий Засгийн газрын комиссын (цаашид Засгийн газрын комисс) үйл ажиллагаанд Засгийн газрын шийдвэрээр оролцож болно.

2.Холбооны Хурлын танхимын төлөөлөгчдийг засгийн газрын комиссын үйл ажиллагаанд оролцуулах шийдвэр гарсан тохиолдолд Холбооны Хурлын танхимуудад засгийн газрын комиссын ажилд оролцох урилга явуулна.

3.Холбооны Хурлын танхимын холбогдох хорооны санал болгосноор Холбооны Хурлын танхимын төлөөлөгч (төлөөлөгчид)-ийг Засгийн газрын комиссын бүрэлдэхүүнд оруулах шийдвэр гаргана. Энэхүү шийдвэрийг Холбооны Хурлын танхимын тогтоолоор албан ёсоор батална.

4.Засгийн газрын комиссын бүрэлдэхүүнд оролцсон Холбооны Хурлын танхимын дарга Холбооны Хурлын танхимын холбогдох хорооны хуралдаан дээр засгийн газрын комиссын үйл ажиллагааны үр дүнгийн талаарх тайланг тавина.

5.Энэ зүйлийн 4-т заасан тайланг хэлэлцсэний үр дүнгээр онцгой байдлын шалтгаан, түүний үр дагаврыг арилгахад холбогдох мэдээлэл бүрэн бус байсан тохиолдолд Холбооны Хурлын Танхимын холбогдох хороо энэ тухай мэдээллийг Засгийн газар, эсхүл холбогдох төрийн байгууллага, албан тушаалтанд явуулна.

III БҮЛЭГ. ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫГ ТӨЛӨВЛӨХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ

13 дугаар зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх

1.Парламентын хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээ нь байнгын, эсхүл нэг удаагийн арга хэмжээ байж болно.

2.Парламентын байнгын хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээг Төрийн Дум дахь фракцууд, Холбооны Хурлын танхимын хороод, комиссууд, Холбооны Зөвлөлийн гишүүд, Төрийн

Думын төлөөлөгчдийн бичгээр гаргасан саналын дагуу Холбооны Хурлын танхимын үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулж болно.

3.Холбооны Хурлын танхимууд нь Аудитын танхимын оролцоотойгоор явуулсан парламентын байнгын хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээг Аудитын танхимын ирэх жилийн ажлын төлөвлөгөөнд тусгах бөгөөд 2013 оны 4-р сарын 5-ны өдрийн Аудитын танхимын тухай 41 тоот Холбооны хуулиар тогтоосон журмын дагуу хийнэ.

14 дүгээр зүйл. Парламентын хяналтын зохион байгуулалт, хууль эрх зүй болон арга зүйн дэмжлэг

1.Зохион байгуулалтын ерөнхий удирдлага болон парламентын байнгын хяналтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг Холбооны Хурлын танхимын дарга, түүний орлогч нар Холбооны Хурлын танхимын дүрэмд заасны дагуу хэрэгжүүлнэ.

2.Парламентын хяналтын зохион байгуулалт, хууль эрх зүй болон арга зүйн дэмжлэгийг Холбооны Хурлын танхимын ажлын алба Холбооны Хурлын танхимын дүрэм, бусад хууль эрх зүйн актад заасны дагуу явуулна.

15 дугаар зүйл. Парламентын хяналтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд үндэслэн Холбооны Хурлын танхимуудын гаргах шийдвэр

1.Парламентын хяналтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд үндэслэн Холбооны Хурлын Танхим нь Үндсэн хууль болон холбооны хуулиар тогтоосон бүрэн эрхийнхээ хүрээнд дараах эрхтэй:

- 1) Холбооны Хурлын танхимын хороо, комисст хууль санаачилгын дагуу Холбооны хуулийн төслийг боловсруулж, Төрийн Думд өргөн барихыг даалгах;
- 2) хууль тогтоомжийн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, түүнчлэн зөрчил гаргахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах талаар төрийн байгууллага, холбогдох албан тушаалтанд санал оруулах;
- 3) Засгийн газарт итгэл үзүүлэхтэй холбогдох асуудлыг авч үзэх;
- 4) Холбооны Хурлын Танхимын холбооны хууль тогтоомж, журамд тогтоосон журмын дагуу өөрийн харьяалалд хамаарах хүмүүсийг албан тушаалаас нь чөлөөлөх;
- 5) Үндсэн хууль, холбооны хууль тогтоомжийн дагуу ажил үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн албан тушаалтныг ажлаас халах тухай шийдвэр гаргах, эсхүл албан тушаалаас нь чөлөөлөх талаар санал оруулах;
- 6) прокурорын байгууллагад, эсхүл Мөрдөн байцаах хороонд хандах.

2.Холбооны Хурлын Танхимын парламентын хяналтын үр дүнд үндэслэн гаргасан саналыг төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, эсхүл холбогдох албан тушаалтныг сарын дотор, эсхүл Холбооны Хурлын Танхимаас тогтоосон хугацаанд авч хэлэлцэж, үр дүнгийн талаар Холбооны Хурлын Танхимд мэдэгдэх үүрэгтэй.

ОХУ-ын Ерөнхийлөгч

В.Путин

Нэмэлт, өөрчлөлт:

2017.03.28-ны өдрийн, Парламентын хяналтын тухай холбооны хуулийн 11 дүгээр зүйлд өөрчлөлт оруулах тухай 47 тоот Холбооны хууль;



2.3.ПАРЛАМЕНТЫН ХЯНАЛТЫГ БУСАД ХУУЛИАР ЗОХИЦУУЛЖ БУЙ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА

Судалгаанд АНУ, ХБНГУ, Итали, Их Британи, Канад, Өмнөд Африк, Польш, Швед, Энэтхэг, Япон зэрэг орны гүйцэтгэх засаглал дахь парламентын хяналтын механизмын талаарх мэдээллийг оруулсан болно. Судалгаанд хамруулсан Швед Улсаас бусад улс нь хоёр танхим бүхий парламенттай.

Судалгаанд хамрагдсан улс орны гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд парламентын хяналтыг хэрэгжүүлэх арга хэрэгсэл нь ихэвчлэн гишүүдийн асуулга, асуулт, холбогдох улсын засгийн газруудад итгэл үзүүлэх эсэх асуудал багтдаг.

2.3.1.АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын Үндсэн хуулийн дагуу хууль тогтоох засаглал болох Конгресс нь Төлөөлөгчдийн танхим болон Сенатын гэсэн хоёр танхимтай; гүйцэтгэх засаглал нь Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Сайд нарын танхим болон бусад агентлагууд, байгууллагуудаас бүрддэг; шүүх засаглал нь Дээд шүүх, холбооны давж заалдах болон анхан шатны шүүхээс бүрдэнэ. Хууль тогтоох байгууллага нь гүйцэтгэх засаглалд хяналт тавих, хязгаарлах замаар хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

Хянан шалгах үйл ажиллагаа: Гүйцэтгэх засаглалд тавих Конгрессын хяналт нь холбооны төсөвт болон бүх салбарын үйл ажиллагаанд хяналт тавих, мөрдөн шалгах, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох, Сенатаас өндөр албан тушаалд томилсон хүмүүсийг батламжлах, агентлагуудад болон хөтөлбөрүүдэд зөвшөөрөл олгох, төсөв хуваарилах зэрэг хэрбэрээр хэрэгжүүлнэ.

а) Мөрдөн шалгах үйл ажиллагаа – Конгрессын мөрдөн шалгах эрх нь баримт бичгийг ил болгохыг шаардах, албадах, гэрчийг зарлан дуудах хуудас өгч сонсголд оролцуулж, мэдүүлэг өгөхийг шаардаж болно. Хүчин төгөлдөр зарлан дуудах хуудсан дахь заалтыг биелүүлээгүй болон Конгрессод хуурамч мэдээлэл өгвөл эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Ийм сонсголд зориулж гаргасан тайлангууд нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн тархаж, холбогдох албан тушаалтнууд огцрох, ажлаасаа халагдах, хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авч болзошгүй юм.

б) Итгэл үзүүлэх эсэх – Үндсэн хуулиар Конгресст нь Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон холбооны бусад иргэний албан тушаалтнуудыг эх орноосоо урвасан, хээл хахууль авсан, бусад ноцтой гэмт хэрэг, зөрчилд холбогдсон болохыг тогтоосны дараа албан тушаалаас нь огцруулах бүрэн эрхийг өгдөг. Төрийн албан тушаалтанд хариуцлага тооцох энэхүү чухал арга хэрэгслийг бараг ашигладаггүй, харин гүйцэтгэх засаглалд хяналт тавихын тулд ашиглагддаг улс төрийн механизм гэж үзэж болно.

в) Албан тушаалтныг батламжлах – Үндсэн хуулийн дагуу Сенатаас зарим өндөр дээд тушаалуудыг батламжлана. Энэ үйл явцыг сенатч нар нэр дэвшигчдэд бодлогын чиглэл өгөх, амлалт авах зорилгоор хэрэгжүүлдэг. Хөрөнгө төсөв гаргах үйл явц

г) Төсөв хуваарилах – Үндсэн хуулиар тус улсын Засгийн газрын ерөнхий үйл ажиллагаанд зориулагдсан төсөв хуваарилах, зарим хөтөлбөрийг санхүүжүүлэх тухай заасан байдаг. Тэтгэмж олгох арга хэмжээнд хууль тогтоомжоор санхүүжилтийн зарцуулалтыг тодорхой заах, хязгаарлах зэргээр хяналт тавина. Хэрэв холбогдох байгууллагууд нь Конгрессын зөвлөмжийг үл тоомсорлосон бол тэдний цаашдын санхүүжилтийг бууруулах, тэдэнд тавих хяналтыг нэмэгдүүлнэ.

д) Зөвшөөрөл олгох – агентлаг, хөтөлбөр, эсхүл үйл ажиллагаа зэрэг нь тогтмол, эсхүл тодорхой хугацаанд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, өөрчлөхийг тогтоосон эрх зүйн зохицуулалт бөгөөд үүнийг эрх зүйн зохицуулалтын дагуу тодорхой удирдамж хэлбэрээр, эсхүл Конгрессын хороодоос тогтоосон хяналтын нэг хэлбэр болно.

е) Төсвийн хяналт – Конгрессын гишүүд төсвийн төсөл хэлэлцэх үед тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрт үндэсний төсвөөс шаардлагатай санхүүжилтийг олгохын тулд шаардлага багатай хөтөлбөрүүдээс татгалзах замаар өөрсдийн сонирхсон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг дэмждэг.

Хяналт хэрэгжүүлэгч байгууллагууд: Конгресс хяналтын үйл ажиллагаа өөрийн хяналтын хороо болон Холбооны агентлаг, албад, түүний дотор Шударга болон үр ашигт байдал хариуцсан ерөнхий байцаагч нарын зөвлөл (CIGIE), Удирдлага, төсвийн алба (OMB), Засгийн газар тооцооллын алба (GAO), Конгрессын судалгааны алба (CRS), Конгрессын Төсвийн алба (CBO)-тай хамтарч хэрэгжүүлдэг.

а) Хороод - Конгрессын хоёр танхимын хянан шалгах бүрэн эрхийг Хороод хэрэгжүүлнэ. Хянан шалгах асуудал нь Хороодын харьяалалд байгаа тохиолдолд гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг хянан шалгах Хороодын чадавх нь өргөн цар хүрээтэй байж чаддаг.

б) Шударга болон үр ашигт байдал хариуцсан ерөнхий байцаагч нарын зөвлөл Ерөнхий байцаагч нь харьяа байгууллагууддаа хянан шалгах, мөрдөн шалгах эрх бүхий, хараат бус байдлыг хангах тусгай хамгаалалттай, холбогдох дүрмээр байгуулагдсан гүйцэтгэх засаглалын албан тушаалтан юм. Холбооны эрүүгийн хууль зөрчих болон ерөнхий байцаагчдын тогтоосон бусад чухал асуудлуудыг Конгресст мэдээлэх ёстой. Зөвлөл нь ерөнхий байцаагчдын хоорондын уялдаа холбоог хангаж, Конгресст тайлан тогтмол тавих бөгөөд хяналт шалгалтын асуудлаар Конгресстай байнга холбоотой ажилладаг.

в) Засгийн газрын тооцооллын алба нь холбооны сангуудыг үр дүнтэй зарцуулж байгаа эсэхийг тогтоох, зохисгүй үйл ажиллагааны талаарх мэдээллийг шалгах, Засгийн газрын хөтөлбөрүүд зорилгоо хангаж байгаа эсэхийг мэдээлэх, бодлогын шинжилгээ хийх, агентлагийн дүрмийн талаар хууль зүйн дүгнэлт, тайлан гаргах замаар аудитын агентлагуудын үйл ажиллагаанд Конгрессын хяналтыг хэрэгжүүлдэг.

г) Конгрессын судалгааны алба нь Конгрессын гишүүдэд хяналт тавих зэрэг олон асуудлаар бодитой, нам бус бодлогын дүн шинжилгээ, судалгааны үйлчилгээ үзүүлэх боловч хянан шалгах, мөрдөн байцаах үйл ажиллагаа явуулахгүй.

д) Удирдлага, төсвийн алба нь АНУ-ын Ерөнхийлөгчид бодлого, төсөв боловсруулахад үндсэн чиг үүрэгтэй хэдий ч гүйцэтгэх засаглалын байгууллагуудын мэдээллийн сангийн төв болох төдийгүй хянан шалгах, мөрдөн байцаах хороодод агентлагийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн эх сурвалж нь болдог.

е) Конгрессын төсвийн алба нь Конгресст төсвийн талаар дүн шинжилгээ хийх нам бус, бодит эх үүсвэр болж ажилладаг. Тус албаны гүйцэтгэдэг гол бүтээгдэхүүнд зардлын тооцоо, хууль тогтоомжийн тооцоолол ордон байна.

2.3.2.ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Герман Улсын хууль тогтоох байгууллага бол Бундестаг (Парламент) юм. Харин Герман нь холбоо улс тул түүний 16 муж улс (Länder) нь Үндсэн хуулийн өөр нэг байгууллага болох Бундесрат (Холбооны Зөвлөл)-аар дамжуулан хууль тогтоох үйл явцад оролцдог. Парламент нь хууль тогтоохоос гадна гүйцэтгэх засаглал, түүний үйл ажиллагаанд нягт хяналт тавьж ажилладаг.

Тус улсын гүйцэтгэх засаглал нь Холбооны ерөнхийлөгч, Холбооны засгийн газраас бүрдэж, харин Холбооны засгийн газар нь Холбооны канцлер болон Холбооны сайн нараас бүрдэнэ.

Германы Үндсэн хуулиар Холбооны канцлерт томоохон эрхийг олгосон ч хууль тогтоох байгууллага нь бүрэн эрхийнхээ хүрээнд түүнд хяналт тавьж ажилладаг. Хууль тогтоох байгууллага нь үнэмлэхүй олонх болсон тохиолдолд албан үүргээ хашиж байгаа Холбооны канцлерийн залгамжлагчийг сонгож, Холбооны ерөнхийлөгчөөс албан үүргээ хашиж байгаа Холбооны канцлерт итгэл үзүүлэхгүй байна гэсэн үндэслэлээр огцруулахыг шаардаж болно.

Хууль тогтоох байгууллагаас гүйцэтгэх засаглалд тавих хяналтын нэг хэлбэр бол Холбооны засгийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл авах юм. Хууль тогтоох байгууллага өөрөө мэдээллийг цуглуулах, эсхүл Холбооны засгийн газраас шаардлагатай мэдээлэл шаардах эрхтэй.

Хууль тогтоох байгууллага мэдээлэл цуглуулах: Хууль тогтоох байгууллагын мэдээлэл авах чухал арга бол байнгын хороо, шалгах хороо, парламентын хяналтын хороо байгуулах явдал юм. Бундестаг нь ихэвчлэн байнгын хороог яам бүрээр байгуулдаг. Одоогийн хууль тогтоох байгууллагын арван найм дахь бүрэн эрхийн хугацаанд нийт 23 байнгын хороо байгуулсан байна.

Мөн Бундестагт Батлан хамгаалах байнгын хорооноос гадна батлан хамгаалах чиглэлийн бодлого дахь парламентын хяналтыг Парламентын зэвсэгт хүчний комиссар хэрэгжүүлнэ. Комиссар нь Бундестагийн гишүүн болон төрийн албан хаагч биш байна.

Ер нь Бундестаг Холбооны засгийн газрын удирддаг бүртгэл, мэдээллийн санд нэвтрэх боломж хязгаарлагдмал байдаг.

Холбооны засгийн газраас хууль тогтоох байгууллагад өгөх мэдээлэл: Тус улсын Үндсэн хуулийн дагуу Бундестаг болон түүний байнгын хороод Холбооны засгийн газраас мэдээлэл авах эрхтэй. Энэ нь Бундестаг болон байнгын хороодын гишүүдийн олонхын саналаар хуралдаанд Холбооны засгийн газрын аль нэг гишүүнийг байлцуулахыг шаардана. Ийм эрхийг мөн Бундесратад олгосон.

Бундестаг дахь цөөнхийн бүлгүүд, бие даагч гишүүд Холбооны засгийн газарт, эсхүл аль нэг Холбооны сайдад хандаж асуулга авч болно. Бундестагийн гишүүдийн 5-аас доошгүй хувийг төлөөлж буй бүлэг, аль нэг намын бүлэг Холбооны засгийн газарт бичгээр асуулга тавина. Асуулгын хариуг Парламентын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэнэ. Холбооны засгийн газар гишүүдийн асуулгад 14 хоногийн дотор бичгээр хариу өгөх боломжтой бөгөөд ийм хариуг Парламентаар хэлэлцэхгүй.

Мөн Бундестагийн бие даагч гишүүд Холбооны засгийн газарт амаар болон бичгээр богино асуулт асуух боломжтой. Харин цөөнхийн бүлгүүд Холбооны засгийн газарт хандаж “Сүүлийн үеийн асуудлын цаг” (Aktuelle Stunde) хэмээх нэртэй цаг үеийн асуудлаарх мэтгэлцээнд оролцож болох бөгөөд энэ үед Холбооны сайд нар өөрсдийн эрх мэдлийн хүрээнд багтсан сүүлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг танилцуулсны дараа нь Парламентын гишүүдийн зүгээс асуулт асуудаг байна. Дээрх эрхүүдийг хэрэгжүүлэхэд Бундестаг дэх цөөнхийн бүлгүүд, бие даагч гишүүд Холбооны Үндсэн хуулийн шүүхэд хандаж болно.

2.3.3. БҮГД НАЙРАМДАХ ИТАЛИ УЛС

Италийн парламент нь Сенат ба Төлөөлөгчдийн танхим гэсэн хоёр танхимаас бүрдэнэ. Төлөөлөгчдийн танхим нь Парламентын Аудитын хороогоор дамжуулан гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаа нь хууль тогтоомж, холбогдох журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавина.

Төлөөлөгчдийн танхимын дотоод зохион байгуулалтыг Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай хууль (Rules of Procedure of the Chamber of Deputies) болон Төлөөлөгчдийн танхимын товчооноос баталсан бусад эрх зүйн актуудаар зохицуулдаг. Түүнчлэн Италийн

парламентын үйл ажиллагаанд 1900 орчим ажилчинтай Төлөөлөгчдийн танхимын Тамгын газар (Chamber of Deputies Administration) дэмжлэг, туслалцаа үзүүлдэг. Төлөөлөгчдийн танхимын Тамгын газрын үйл ажиллагааг Төлөөлөгчдийн танхимын Ерөнхийлөгчийн Ажлын албаны баталсан эрх зүйн актууд болон Төлөөлөгчдийн танхимын Ерөнхий нарийн бичгийн даргын баталсан журмуудаар зохицуулна.

Парламентын хяналтын албаны бүтэц, чиг үүрэг: Төлөөлөгчдийн танхимын дэгийн тухай хууль болон бусад дотоод журмаар тус танхимын үйл ажиллагааг зохицуулна. Дэгийн тухай хуулийн “Танхимын хэлтэс, алба” (“Servizi ed uffici della Camera”) нэртэй 2 дугаар хэсэгт тус танхимд байгуулагдсан 18 алба (тухайлбал, Тамгын газрын албад, Чуулганы албад, Номын сангийн албад)-ын үйл ажиллагааг зохицуулжээ. Тэдгээрийн нэг нь Парламентын хяналтын алба байна.

Дэгийн тухай хуулийн 2 дугаар хэсэгт тус албаны үндсэн чиг үүргийг тодорхойлсон:

- Холбогдох гүйцэтгэх байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийн дагуу Парламентын хууль тогтоомж, түүнд холбогдох журмын хэрэгжилтийн техник хяналтыг хийх;
- хууль тогтоомж зөрчсөн тухай асуудлаар хийсэн хэлэлцүүлэг болон Парламентын санаачлагаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх;
- Засгийн газрын зүгээс парламентын хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих.

Энэхүү алба болон бусад албадад Баримтжуулалт, номын сангийн хяналтын хороо хяналт тавина. Тус хорооны үйл ажиллагааг Баримтжуулалт, номын сангийн хяналтын хорооны үйл ажиллагааны журмаар зохицуулдаг.

2.3.4.КАНАД УЛС

Парламентын хяналтын тогтолцоо: Канад Улсад хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг холбооны болон муж улсууд гэсэн түвшинтэй бөгөөд энд зөвхөн холбооны хяналтын албадын талаарх мэдээллийг оруулсан болно. Муж улсууд нь өөрийн парламентын хяналтын албатай байдаг.

Парламентын бүрэн эрхт комиссарууд: Гүйцэтгэх засаглалд тавих парламентын хяналтын тогтолцоо нь Парламентын бүрэн эрхт 9 комиссараас бүрдэх бөгөөд байнгын, мэргэшсэн эдгээр комиссаруудын бүрэн эрх, хүрээ хязгаарыг Парламентын тухай хуулиар тогтооно. Эдгээр комиссаруудын гүйцэтгэх засаглалаас хараат бус байдал нь тэдний хяналт шалгалтын үйл ажиллагааг шударгаар хэрэгжүүлэхэд нь чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Парламентын бүрэн эрхт 9 комиссар нь Сенат, эсхүл Нийтийн танхимд, эсхүл хоёуланд нь хариуцан тайлагнах бөгөөд дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

а) Ерөнхий аудиторын газар нь Нэгдсэн орлогын сан зэрэг улсын сангуудын удирдлагад хяналт тавих бөгөөд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн мэдээллийн хуулийн дагуу эсэх бөгөөд үнэн зөв эсэхийг хянан шалгана;

б) Канадын сонгуулийн асуудал хариуцсан комиссарын газар нь холбооны сонгуулийг шударга, хараат бус явуулна;

в) Албан ёсны хэлний асуудал эрхэлсэн комиссарын газар нь холбооны бүх байгууллагуудад франц болон англи хэлний хэрэглээний тэгш байдлыг хангах, хоёр хэлний цөөнхийн нийгэмлэгүүдэд дэмжлэг үзүүлэх, хөгжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ;

г) Мэдээллийн асуудал эрхэлсэн комиссарын газар нь иргэдийн хуулиар зөвшөөрөгдсөн холбооны мэдээлэл олж авах эрхийг хангах бөгөөд Мэдээлэл олж авах тухай хуулийн дагуу мэдээлэл олж авахтай холбоотой иргэдийн гомдлыг хүлээн авч, хянан шалгана;

д) Нууцлалын асуудал эрхэлсэн комиссарын газар нь хувийн нууцыг зөрчсөн, хувийн мэдээллийг хууль бусаар ашигласан, хувийн мэдээлэлд нэвтрэхийг хориглосон гомдлыг хянан шийдвэрлэнэ;

е) Төрийн албаны шударга байдлыг хариуцсан комиссарын газар нь төрийн албан хаагчдын мэргэжлийн ёс зүй, хариуцлагатай холбоотой гомдлыг хянан шалгана;

ё) Ашиг сонирхлын зөрчил, ёс зүй хариуцсан комиссарын газар нь хувийн ашиг сонирхол ба төрийн албан тушаалтны ажил үүргийн зөрчилдөөнд хяналт тавьж ажиллана;

ж) Лобби үйл ажиллагаа хариуцсан комиссарын газар нь нөлөөллийн үйл ажиллагаанд буруу хандсан тухай гомдлыг шийдвэрлэж, лобби бүлгүүдийг бүртгэнэ;

з) Парламентын төсвийн асуудал хариуцсан албан тушаалтан үндэсний сангууд, улсын санхүү болон эдийн засгийн чиг хандлагад бие даасан дүн шинжилгээ хийх бөгөөд албан тушаалтан нь Парламентын номын сангийн нэг хэсэг болдгоороо Парламентын бусад албан тушаалтнаас ялгаатай.

Комиссарууд нь Засгийн газрын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд тэдний санаачилга, хууль, Парламентын асуулга, хувийн гомдолд үндэслэж мөрдөн шалгах эрх үүсдэг. Парламентын бүрэн эрхт төлөөлөгчдийн хүсэлтээр тодорхой асуудлаар хянан шалгалт хийх түр комиссарыг томилж болно.

Парламентын бүрэн эрхт комиссаруудыг томилох: Комиссаруудыг Амбан захирагчийн санал болгосныг Сенат, Нийтийн танхим дахь нам бүрийн удирдагчтай зөвшилцсөний дараа Сенат ба Нийтийн танхимын тогтоолоор томилно. Харин Сонгуулийн асуудал хариуцсан комиссарыг Нийтийн танхимын дарга, Парламентын төсвийн асуудал хариуцсан албан тушаалтныг Амбан захирагч тус тус томилно.

Парламентын бүрэн эрхт комиссаруудын бүрэн эрхийн хугацаа 7 жил байх бол Ерөнхий аудитор болон Сонгуулийн асуудал хариуцсан комиссар 10 жил, Парламентын төсвийн асуудал хариуцсан албан тушаалтан 5 жилийн хугацаатайгаар томилогдоно.

3.2.5.ӨМНӨД АФРИКИЙН БҮГД НАЙРАМДАХ УЛС

Үндсэн хуулиар Парламентад олгосон мандат: Парламент нь Засгийн газар, түүний бүх байгууллагууд, түүний дотор муж, орон нутгийн засаг захиргааны түвшинд хяналт тавих бүрэн эрхтэй гэж Өмнөд Африкийн Үндсэн хуулиар тогтоосон байна. Парламент дараах чиглэлээр хяналт тавина:

- хууль тогтоомжийн хэрэгжилт;
- төсвийн зарцуулалт;
- Үндсэн хууль болон Парламентаас баталсан хуулийг чанд сахих;
- Засгийн газрын төв байгууллагуудын үр дүнтэй удирдлага.

Өмнөд Африкийн Парламент нь Үндэсний ассамблей (**National Assembly**), Үндэсний мужийн зөвлөл (**National Council of Provinces**) гэсэн хоёр танхимаас бүрдэх ба танхим тус бүр хяналтын тодорхой үүрэг гүйцэтгэнэ.

Үндэсний ассамблей нь ард түмнийг төлөөлж, Үндсэн хуулийн дагуу тэдний засаглах эрхийг хангах зорилгоор сонгодох ба хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- Засгийн газрын үндэсний түвшний бүх гүйцэтгэх байгууллагууд Үндэсний ассамблейн өмнө хариуцлага хүлээнэ;
- үндэсний Засгийн газрын бүрэн эрхийн хэрэгжилт, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавина.

Үндсэн хуулийн 181.5-д заасны дагуу дараах байгууллагууд Үндэсний Ассамблейд жил бүр үйл ажиллагаа, чиг үүргийн гүйцэтгэлээ тайлагнана. Үүнд:

- Ерөнхий аудитор;
- Жендэрийн тэгш байдлын комисс;
- Олон нийтийн өмгөөлөгч;
- Сонгуулийн хороо;
- Өмнөд Африкийн хүний эрхийн комисс;
- Соёлын өвийг сурталчлах хамгаалах комисс;
- Хэл шинжлэлийн нийгэмлэгүүд.

Үндэсний мужийн зөвлөл нь үндэсний Засгийн газрын үйл ажиллагаанд мужуудын эрх ашгийг харгалзан үзэхийн тулд мужуудыг төлөөлөх бөгөөд хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- муж, орон нутгийн засаг захиргаанд хяналт тавих;
- үндэсний, эсхүл мужийн Засгийн газрын гишүүн, аливаа албан тушаалтан Үндэсний мужийн зөвлөлийн, эсхүл хорооны хуралдаанд оролцохыг шаардах;
- төсвийн хэрэгжилт, хариуцлага, ил тод байдал ба олон нийтийн оролцоог хангах.

Үндсэн хуулийн 89.1-д зааснаар Үндэсний Ассамблейн гишүүдийн 3/2-ын доошгүй саналаар Үндсэн хууль зөрчсөн, ноцтой зөрчил гаргасан, ажлын чиг үүргээ гүйцэтгэх чадваргүй болсон зэрэг үндэслэлээр Ерөнхийлөгчийг огцруулж болно. Харин Үндсэн хуулийн 102.2-т зааснаар Үндэсний Ассамблейн гишүүдийн олонхын саналаар Ерөнхийлөгч итгэл үзүүлэхгүй байх санал гаргаж болно.

Хороодын гүйцэтгэх үүрэг: Үндсэн хууль болон Танхимуудаас тогтоосон дүрмийн дагуу Засгийн газрын үйл ажиллагаанд тавих парламентын хяналтыг Хороодоор дамжуулан хэрэгжүүлнэ. Хороод хяналт шалгалтын олон арга хэрэгсэлтэй. Үүнд, хэлтсийн мэдээлэл, төсвийн дүн шинжилгээ хийх, олон нийтээс ирүүлсэн өргөдөл, стратеги төлөвлөгөө, жилийн тайлан хэлэлцэх, олон нийтийн сонсгол хийх гэх мэт.

Үндсэн хуулийн 56, 69 дүгээр зүйлд заасны дагуу төрийн байгууллагуудын жилийн тайлан, Ерөнхий аудиторовын тайланг Хороод хянан үзэх явдал юм. Хяналтын зорилгоос хамааран Хороо Засгийн газрын агентлагаас товч мэдээлэл авах, бодит байдлыг тодруулна.

Өмнөд Африкийн Парламентын тухай хуулийн 16 дүгээр зүйлд сонсголд мэдүүлэг өгөхөөр ирсэн гэрч нь өөрт тавьсан аливаа асуултад үнэн зөв, бүрэн хариулах, өөрөөс шаардсан аливаа баримт бичгийг гаргаж өгөх үүрэгтэй. Гэрч нь танхим, хорооны өмнө тангараг өргөх, батлах замаар өгсөн нотлох баримтыг тухайн этгээд хуурамчаар, эсхүл яллагдагчаар татсан эрүүгийн байцаан шийтгэхээс бусад тохиолдолд Парламентын гаднах аль ч шүүх, газарт тухайн хүний эсрэг ашиглаж болохгүй.

Хороод нь олон нийттэй харилцах үүргийг гүйцэтгэх бөгөөд ашиг сонирхлын бүлгүүд болон Засгийн газрын хооронд зуучлагч байгууллага болж ажилладаг. Хороод нь Парламентын өмнөөс үйл ажиллагаа явуулдаг тул хяналт тавьсан талаар түүний өмнө тайлагнана.

Хяналтын механизмууд:

а) Төсөвт санал өгөх

- Сангийн сайд дараагийн санхүүгийн жилийн төсвийн урьдчилсан мэдээг зарлана;
- Парламент улсын төсвийг батална;
- Төсвийн талаарх санал хураалтын дүнг танилцуулсны дараа Хороо тус бүр хяналт тавьдаг харьяа төрийн байгууллагуудын сонсгол явуулна;
- Хорооны сонсгол нь Засгийн газрын департаментуудын өмнөх жилийн амлалтаа биелүүлж, татвар төлөгчдийн мөнгийг зөв зарцуулсан эсэхийг тодорхойлох зорилготой.

б) Асуулга тавих нь Парламентаас Засгийн газарт хариуцлага тооцох нэг арга хэрэгсэл юм. Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Засгийн газар, сайд нараас хариуцсан асуудлаар нь амаар болон бичгээр хариу авахын тулд асуулгыг тавина. Асуулгын цагаар Парламентын гишүүд Засгийн газрын гишүүдээс улс төрийн нам, сонгогчдынхоо өмнөөс сонирхсон асуудлаар асуулт тавих боломжийг олгодог байна.

в) Гишүүдийн мэдэгдэл хийх процессыг ашиглан Парламентын гишүүд аливаа асуудлаар Танхимын хуралдаанд мэдэгдэл хийх боломжийг олгодог.

г) Асуудал дэвшүүлэх – Парламентын гишүүн нь Парламентын хуралдаанаар тулгамдсан аливаа асуудлыг гаргаж ирэх замаар хяналтын үүргээ хэрэгжүүлдэг.

д) Чуулганы нэгдсэн хуралдааны мэтгэлцээн нь үйл ажиллагааг сайжруулахад шаардлагатай Засгийн газрын тодорхой хөтөлбөрүүд, эсхүл хууль тогтоомжийн талаар чухал мэдээлэлд Засгийн газрын анхаарлыг хандуулах өөр нэг арга хэрэгсэл юм.

е) Сонгуулийн тойрогтоо ажиллах нь Парламентын гишүүдэд хувь хүний хяналт тавих хамгийн том боломж юм. Тойрогтоо ажиллах нь парламентын гишүүд болон олон нийт хоорондын харилцан үйлчлэлийн хамгийн ойр хэлбэр бөгөөд гишүүд энэ үед илэрсэн аливаа асуудлын талаар Парламентад анхааруулах үүрэгтэй.

Парламентын хяналтад иргэдийн оролцоог хангах

Санал гаргах – Иргэдийн зүгээс Парламентын Хороодод санал оруулах нь түүнд дуу хоолойгоо хүргэх, тодорхой хуулийн төслийг хэлэлцүүлгийн үед нь үзэл бодлоо илэрхийлэх нэг арга болдог.

Өргөдөл гаргах – Өмнөд Африкийн Бүгд Найрамдах иргэн бүр Үндсэн хуульд заасны дагуу Парламентад өргөдөл гаргах эрхтэй. Үүнд байгууллага ч хамаарна. Өргөдөл нь эрх бүхий байгууллагаас арга хэмжээ авахыг хүссэн албан ёсны хүсэлт гэж ойлгох бөгөөд энэ нь шаардлага, талархал, гомдол гэсэн хэлбэртэй байдаг.

2.3.6.БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС

Сейм (Парламент) болон Сайд нарын Зөвлөлийн хоорондын харилцааг Үндсэн хуулиар тодорхойлдог. Үндсэн хуулийн 95.2-т “Сейм нь Үндсэн хууль, Парламентын тухай хуулиар тогтоосон хүрээ хязгаарт Сайд нарын Зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана” гэж заасан байдаг. Сеймийн гишүүдийн хүсэлтээр хяналтыг мөрдөн шалгах хороодоор дамжуулан явуулдаг. Сейм гүйцэтгэх засаглалын үйл ажиллагааг Сайд нарын Зөвлөлд итгэл үл үзүүлэх замаар үнэлдэг.

Сеймийн Хороод: Сейм нь 25 Хороо тус бүр өөрийн эрхлэх асуудлаар захиргааны байгууллагыг шалгах эрхтэй. Хорооны бүрэн эрхийг төлөөлөгчийн, эсхүл сенатын бүрэн эрхийг хэрэгжүүлэх тухай хууль, Бүгд Найрамдах Польш Улсын Сеймийн дэгийн тухай хуулиар тодорхойлдог Хороод сайд, удирдлагуудын ирүүлсэн тайлан, мэдээллийг хэлэлцэх, хуралдаандаа сайд нарыг ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэх үед заавал байлцуулах, өөрийн харьяаллын төрийн байгууллагуудын үйл ажиллагааг шалгах зэргээр хяналтын чиг үүргээ хэрэгжүүлнэ.

Хороо нь тодорхой асуудлаар санал, дүгнэлт гаргах бөгөөд Сайд нарын Зөвлөл болон түүний гишүүдэд, Аудитын ерөнхий газрын даргад, Польшийн Үндэсний банкны ерөнхийлөгч, Хөдөлмөрийн ерөнхий байцаагчид хандаж бичгээр асуулга тавих ба холбогдох албан тушаалтан асуулгыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор бичгээр хариу өгөх үүрэгтэй. Хариуг хугацаанд өгөөгүй, эсхүл Хороо уг хариуг нь хангалтгүй гэж үзвэл дахин хариу хүсэх, эсхүл Хорооны хүсэлтээр Сеймийн маршал хариуг хангалтгүй гэж үзэн татгалзаж, Сеймийн зохих шийдвэрийг гаргана.

Сеймийн Хороод нь нутгийн өөрөө удирдах байгууллага, олон нийтийн байгууллага, төрийн болон хувийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон олон нийтийн өмчит аж ахуйн нэгжүүдээс мэдээлэл, тодруулга хүсч болно.

Гишүүний асуулга: Сеймийн бие даагч гишүүд сайд нарт бичгээр асуулга тавих, хариуг 3 долоо хоногийн дотор бичгээр авах хэлбэрээр хяналтаа хэрэгжүүлэх боломжтой. Энэхүү

эрхийг Үндсэн хуулиар заасан бөгөөд Улсын Сеймийн дэгийн тухай хуулиар нарийвчлан зохицуулсан.

Итгэл үзүүлэх эсэх санал оруулах: Сейм нь итгэл үл үзүүлэх замаар Сайд нарын Зөвлөлийг татан буулгаж болно. Итгэл үл үзүүлэх талаарх саналыг дор хаяж 46 гишүүн оруулна. Хэрэв Сейм итгэл үл үзүүлэх талаар саналыг дэмжсэн бол Ерөнхийлөгч нь Сайд нарын Зөвлөлийн огцорсонд тооцож, Сеймээс сонгогдсон дараагийн Ерөнхий сайдыг томилно. Хэрэв Сейм итгэл үл үзүүлэх талаар саналыг хамгийн багадаа 115 гишүүн дэмжээгүй бол итгэл үл үзүүлэх талаар хоёр дахь саналыг анхны санал хураалт явуулснаас хойш 3 сарын дотор оруулахгүй.

2.3.7.ШВЕДИЙН ВАНТ УЛС

Шведийн Вант Улс бол парламентын хаант улс бөгөөд хаан нь төрийн тэргүүн байна. Засгийн газар нь Ерөнхий сайд, сайд нараас бүрдсэн байна. Засгийн газар нь Парламентын өмнө хариуцлага хүлээнэ. Засгийн газарт хяналт тавих нь Шведийн парламентын үндсэн чиг үүргийн нэг юм.

Парламентад хяналт тавих үйл ажиллагаагаа дараах арга хэрэгслээр хэрэгжүүлдэг: Үндсэн хуулийн хороо байгуулах, Парламентын гишүүд сайд нарт асуулга тавих, нэгдсэн хуралдаанаар аль нэг сайдад “үл итгэх” үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлөх, хараат бус агентлаг болох Парламентын омбудсмен нь сайд нарын болон холбогдох албан тушаалтнуудын хууль бус үйлдлийг мөрдөн шалгах зэрэг болно.

а) Үндсэн хуулийн хороо – Үндсэн хуулийн хороо нь Засгийн газар Швед Улсын Үндсэн хууль болон бусад хуулийг дагаж мөрдүүлэх үүргийг хүлээсэн бөгөөд Парламент дахь бүх намуудын төлөөллийг багтаасан 44 гишүүнээс бүрдэнэ.

Тус Хороо нь сонсгол зохион байгуулах, мөрдөн шалгалт явуулах, Парламентын гишүүдээс нууц материал шаардах эрхтэй. Хороо Парламентын гишүүдийн гомдлын дагуу (anmälningar) бие даан (ex officio)ажиллагаа явуулж болно. Тийм учраас иргэд шууд Үндсэн хуулийн хороонд гомдол гаргах боломжгүй. Үндсэн хуулийн хороо бол шүүх биш, гэхдээ энэ нь эрүүгийн хянан шалгах ажиллагааг эхлүүлж болно. Парламентын гишүүн нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа үйлдсэн гэмт хэргийг Үндсэн хуулийн хороо мөрдөн шалгаж, Дээд шүүх шийдвэрийг гаргана. Үндсэн хуулийн хорооноос тодорхой үйлдлүүдийн талаар зөвхөн “шүүмжлэл” өгч, үүнийг нь чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлдэг. Хатуухан шүүмжлэлийн мөрөөр Парламент аль нэг сайдад итгэл эс үзүүлэх замаар огцруулахад хүргэж болзошгүй хэдий ч одоогийн байдлаар ийм тохиолдол гараагүй байна. Үндсэн хуулийн хороо жилд хамгийн багадаа нэг удаа ямар нэгэн асуудлаар хянан шалгалт хийж, дүгнэлт тайлагнана. 2016-2017 оны хугацаанд Үндсэн хуулийн хороонд Парламентын гишүүдээс нийт 32 гомдол ирсэн бөгөөд эдгээрийн аль нь ч эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл болоогүй байна.

б) Парламентын гишүүдийн асуулт - Парламентын гишүүд чуулганы нэгдсэн хуралдаанаар сайд нараас асуулт асууж, мэтгэлцээн өрнүүлэх эрхтэй. Парламентын танхимд тавьсан асуултууд нь тодорхой асуудалтай холбоотой байх бөгөөд хариултыг шууд өгнө. Мөн Парламентын гишүүд сайдад бичгээр асуулга тавих ба Пүрэв гарагийн 10:00 цагаас өмнө ирүүлсэн асуулгын хариуг дараагийн Лхагва гараг ирүүлсэн байна.

в) Итгэл үл үзүүлэх – Парламентын гишүүдийн олонхын саналаар сайдыг үүрэгт ажлаас нь огцруулна. Хамгийн багадаа Парламентын 35 гишүүн буюу нийт гишүүдийн 10 хув нь итгэл үл үзүүлэх тухай санал оруулна.

г) Парламентын омбудсмен – Парламентын бие даасан хянан шалгах үүрэг бүхий Парламентын омбудсмен (Riksdagens ombudsmän) нь төрийн бүх байгууллагууд, албан тушаалтнуудын хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, Парламентын өмнө шууд хариуцан тайлагнана. 1809 оны шинэ Үндсэн хуулиар байгуулагдсан Парламентын омбудсмен нь олон улсад ийм төрлийн анхны

байгууллагуудын нэг бөгөөд гүйцэтгэх байгууллагуудад бие даасан хяналт шалгалт хийдэг. Парламентын омбудсменийг Парламентаас сонгох боловч Парламентын гишүүн биш гэдгээрээ Үндсэн хуулийн хорооны гишүүдээс ялгаатай. Парламентын омбудсмен нь Үндсэн хуулийн хорооны зөвлөмжөөр сайдын эсрэг үүсэн аливаа эрүүгийн хэргийг мөрдөн шалгах үүрэгтэй. Харин сайдыг байцаах нь Үндсэн хуулийн хорооны бүрэн эрхэд хамаарна.

Тус улсын иргэд Парламентын омбудсменаас төрийн аль нэг байгууллага, эсхүл албан тушаалтны хууль зөрчсөн үйлдлийг шалгаж өгөх гомдлыг бичгээр гаргах бөгөөд энэ тохиолдолд нэрээ нууцлах боломжгүй.

3.2.8. БҮГД НАЙРАМДАХ ЭНЭТХЭГ УЛС

Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Үндсэн хуулийн¹⁵ 79 дүгээр зүйлд зааснаар тус улсын Парламент нь Ерөнхийлөгч болон Төрийн зөвлөл (Раджья сабха), Ардын танхим (Лок сабха) гэсэн хоёр танхимаас бүрдэнэ.

Доод танхим болох Лок сабха нь шууд сонгогдсон ард түмний төлөөллөөс бүрдэнэ. Үндсэн хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу Лок сабхагийн гишүүдийн тоо 552 байх бөгөөд тэдгээрийн 530 нь муж улсуудыг, 20 нь холбооны нутаг дэвсгэрийг, Ерөнхийлөгчөөс нэр дэвшсэн хоёроос илүүгүй гишүүн нь Англи-Энэтхэгийн нийгэмлэгийг тус тус төлөөлнө.

Тус Танхимын хууль тогтоох, Засгийн газарт хяналт тавих, улсын төсвийг батлах зэрэг үйл ажиллагааг Лок сабхагийн хуралдааны дэг болон үйл ажиллагааны тухай (цаашид “Дэгийн тухай”) хуулиар¹⁶ зохицуулдаг.

*Дэгийн тухай хууль*¹⁷: Тус хууль нь Парламентын үйл ажиллагааг зохицуулдаг ба 1952 онд батлагдсан, 27 бүлэг, 389 зүйлтэй. Үндсэн хуулийн 118 (2)-т заасны дагуу Лок Сабхагийн спикерт Дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулж батлах эрхийг олгосон.

Энэхүү эрхийнхээ хүрээнд Лок Сабхагийн спикер Дүрмийн хорооны зөвлөмжийн дагуу үе үе өөрчлөлт оруулж иржээ. 1954 оны 9-р сард Дүрмийн хороо эдгээр зөвлөмжийг нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос өмнө Танхим батлах ёстой гэж шийдвэрлэсний үр дүнд (энэ хэвлэлийн 331-р дүрэм) дүрэмд өөрчлөлт оруулах журам 1954 оны 10-р сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр болжээ.

Харин 2015, 2016, 2018 онуудад хуульд өөрчлөлт оруулсан байна. Лок Сабхагийн хуралдааны дэг болон үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар бүлэг (Асуултууд), 8-р бүлэг (Half-an-Hour Discussions), 14-р бүлэг (Motions), 15-р бүлэг (Богино хугацааны хэлэлцүүлэг - Short Duration Discussions), 16-р бүлэг (Calling Attention), 17-р бүлэг (Motion of No-confidence in Council of Ministers and Statement by Minister who has resigned)-т тус тус парламентын хяналтын үйл ажиллагааны талаар зохицуулсан байна.

Хуульд зааснаар Лок Сабхагийн гишүүд өглөө бүр хэлэлцэх асуудлын талаарх мэдээлэл, өмнөх өдрийн үйл ажиллагааны тоймыг багтаасан багцыг түүний Тамгын газар (Lok Sabha Secretariat)-аас хүлээн авдаг.

Лок Сабхагийн үдээс өмнөх үйл ажиллагаанд “Асуултын цаг” (Question hour) ба “Тэг цаг” (Zero Hour) орно. Энэ үед гишүүд хууль тогтоох, төсөв батлах болон үндэсний ач холбогдол бүхий асуудлаар мэтгэлцэх бөгөөд тэд энэхүү үйл явцад өөрсдийн намын улс төрийн үзэл бодлоос үл хамаарч, бие даасан хууль тогтоогчийн хувиар оролцдог байна. Харин үдээс хойших үйл ажиллагаанд гишүүд улс төрийн намынхаа төлөөллийн үүргийг гүйцэтгэнэ.

Лок Сабха буюу Танхим дахь Засгийн газрын үйл ажиллагааг Бизнесийн зөвлөх хороо (Business Advisory Committee) удирдана. Хороог спикер даргалах ба бүрэлдэхүүнд нь тус

¹⁵<https://www.advocatekhoj.com/library/bareacts/constitutionofindia/index.php?Title=ConstitutionofIndia,1949>

¹⁶ Rules of Procedure and Conduct of Business in Lok Sabha. Эх сурвалж: http://164.100.47.194/loksabha/rules/RULES-2010-P-FINAL_1.pdf

¹⁷ Rules of Procedure and Conduct of Business in Lok Sabha. Sixteenth edition Эх сурвалж: <http://loksabhaph.nic.in/rules.aspx>

Танхим дахь улс төрийн намуудын удирдлагууд багтана. Хороо нь долоо хоногийн хэлэлцэх асуудлыг шийдэж, хэлэлцүүлэг бүрт цаг хуваарилдаг.

Танхимын хуралдаанд оролцохын тулд урьдчилсан төлөвлөгөө шаардлагатай байдаг. Хуульд зохицуулснаар гишүүд асуулт асуух, асуудал дэвшүүлэх, мэтгэлцээн эхлүүлэх, түүнд оролцохын тулд Тамгын газарт болон спикерийг урьдчилан мэдээллээр хангахыг шаарддаг. Үүнийг “мэдэгдэл өгөх” (“giving notice”) хэмээн нэрлэдэг. Тухайлбал, Танхимд асуулт асуухын тулд 15 хоногийн өмнө мэдэгдэх шаардлагатай. Гэхдээ хуульд мэтгэлцээнийг урьдчилан мэдэгдэл өгөхгүйгээр хийх боломжтойгоор уян хатан зохицуулсан байх ба үүнийг спикерийн өөрийн үзэмжээр сонгоно.

*Парламентын хяналтын механизм*¹⁸

Парламент нь иргэдийг төлөөлөх, хууль тогтоох, гүйцэтгэх засаглалыг хянах, төсвийн хяналт тавих гэсэн дөрвөн үндсэн чиг үүрэгтэй. Энэтхэгт Үндсэн хуулиар парламентын засаглалын хэлбэрийг тогтоож, гүйцэтгэх засаглал нь парламентынхаа өмнө хариуцлага хүлээнэ. Парламент нь гүйцэтгэх засаглалыг хянахдаа мэтгэлцээн, хэлэлцүүлгээр хэрэгжүүлдэг. Энэ нь асуулт, богино хугацааны хэлэлцүүлэг, тэг цаг, анхааруулах мэдэгдлийн санал (calling attention motion), хойшлуулах санал, итгэл үл үзүүлэх санал, шүүмжлэх санал (censure motion) гэх мэт арга хэрэгслүүдтэй¹⁹.

Түүнчлэн Засгийн газрын баталгааны хороо, харьяа хууль тогтоомжийн хороо, өргөдлийн хороо гэх мэт хороодынхоо тусламжтайгаар гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд хяналт тавьдаг байна.

Парламент нь өөрийн хяналтын чиг үүргээрээ дамжуулан засгийн газрыг хариуцлагыг нэмэгдүүлж, бодлогын үр дүнтэй бөгөөд ард иргэдийн хүсэл шаардлагад нийцсэн бодлого, үйл ажиллагааг баталгаажуулна. Үүнээс гадна парламентын хяналт нь Засгийн газрыг аливаа дур зоргын болон Үндсэн хуулийн бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлнэ. Парламентын хяналтын гол түлхүүр болсон хоёр механизм бий:

- Танхимын асуулт, хариулт, мэтгэлцээн;
- Засгийн газрын бодлогыг хянан шинжилж байдаг парламентын хороод гэх мэт.

а) Асуултын цаг – Лок сабхагийн үйл ажиллагааны эхний цаг нь “Асуултын цаг” байх ба үүнийг парламентын гишүүд Засгийн газарт хариуцлага хүлээлгэхэд ашигладаг. Асуултын 4 хэлбэр бий:

- *Аман асуулт* (Starred Questions) нь хуралдааны танхимд гишүүдийн аман асуултад хариуцсан сайд нар хариулна. Нэг хуралдаанд гишүүн нэг л асуулт асуух ба уг асуултаа 15 хоногийн өмнө урьдчилж ирүүлнэ. Тухайн өдөрт зөвхөн 20 асуултад аман хариулт авахын тулд санал хураах замаар сонгоно. Асуулт асууж байгаа гишүүн нэмэлт хоёр хүртэлх асуулт тавьж болно. Дараа нь бусад гишүүд нь спикерийн үзэмжээр нэмэлт асуулт асууж болно.
- *Бичгэн асуулт* (Unstarred Questions) нь гишүүний бичгээр ирүүлсэн асуултад Сайд бичгээр хариулан гишүүнд хүргүүлнэ. Бичгэн асуултын хариуг хуралдааны танхимд амаар хариулах шаардлагагүй бөгөөд нэмэлт асуулт асуух боломжгүй.
- *Товч асуулт* (Short Notice Questions) – Гишүүн олон нийтийн нэн чухал асуудал, яаралтай шинжтэй асуудлаар тавьсан асуултад 10 хоногийн дотор амаар хариулж болно. Ийм асуултыг ‘Богино мэдэгдлийн асуулт’ гэж нэрлэдэг.
- *Бие даагч гишүүдэд хандсан асуулт* (Questions to Private Members) – хэрвээ асуултын агуулга нь ямар нэг хуулийн төсөл, шийдвэртэй холбоотой, эсхүл тухайн гишүүний үүрэг хариуцлагатай нь холбоотой Танхимын ажил хэрэгтэй холбогдох бусад асуудал бол асуултыг бие даагч гишүүнд хандан асууж болно. Ийм төрлийн

¹⁸ <https://www.prsindia.org/parliamenttrack/discussion-papers/parliamentary-oversight-executive>

¹⁹ <https://triumphias.com/blog/parliamentary-control-over-executive-in-india-a-brief-note/>

асуултыг хэрвээ хуралдаан даргалагч шаардлагатай гэж үзвэл аль нэг сайдаас ч бас асууж болно.

Дээр дурдсанчлан “Асуултын цаг” нь парламентын гишүүдэд сайд нараас Засгийн газрын бодлоготой холбоотой асуултуудыг тавьж, Засгийн газрын үйл ажиллагааны хариуцлагыг нэмэгдүүлнэ. Зарим тодорхой асуулгад хуралдааны танхимд амаар хариулна. Зарим хариултыг холбогдох яамдаас бичгээр авна. Жишээлэхэд, улсын ямарваа нэг бодлогын хүрээнд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй ажлын талаар, Засгийн газрын гүйцэтгэлийн талаар Парламентын гишүүд асууж болно. Лок сабхагийн өдөр тутмын хуралдаанаар 20 хүртэлх асуултыг (Раджья сабхад 15 хүртэл) сонгож хуралдааны танхимд амаар хариулт тайлбарыг авах ба 230 хүртэлх асуултад (Раджья сабхад 160 хүртэл) яамдаас бичгээр хариулт авна. Ийнхүү сайдын амаар хийсэн хариулт тайлбарын дараа гишүүд хоёр асуулт асууж тодруулга авч болно. Раджья сабха нь “Асуултын цаг”-ийг бага тасалдуулах үүднээс цагийг нь хуралдааны эхний цагаас хоёр дахь цаг руу шилжүүлнэ.

б) Мэтгэлцээн ба санал – Мэтгэлцээн ба санал нь парламентын хяналтын чиг үүрэгт чухал үүрэг гүйцэтгэнэ. Учир нь энэ нь гишүүдэд яриа хэлэлцүүлэг өрнүүлж, засгийн газрын бодлогын талаар тодруулга авах боломж нөхцөлийг бүрэлдүүлж өгдөг. Гишүүдийн зүгээс хуралдааны танхимд асуудал дэвшүүлэн хэлэлцүүлэг өрнүүлэх хоёр үндсэн төрөл бий:

- хэлэлцүүлгийн төгсгөлд санал хураах шаардлагагүй мэтгэлцээн,
- хэлэлцүүлгийн төгсгөлд санал хураадаг санал төсөл.

Мэтгэлцээн: Гишүүний асуулгын хариуг Танхим хэлэлцдэг ч санал хураалт явуулдаггүй. “Богино хугацааны мэтгэлцээн”-ий үеэр (Лок сабхагийн 193 дугаар дүрэм, Раджья сабхагийн 176 дугаар дүрэм), аль ч гишүүн улсын чухал асуудлыг хөндөж, холбогдох яамны сайдын мэдэгдлийн талаар бусад гишүүдтэй мэтгэлцэх эрхтэй. Урьд өмнө гишүүдийн зүгээс будааны үнэ, гангийн нөхцөл байдал зэрэг асуудлаар “Богино хугацааны хэлэлцүүлэг”-ийн цагийг ашиглан хэлэлцэж байсан. Түүнчлэн, “Анхаарал хандуулахыг уриалах” цагийг холбогдох яамны сайдад цаг үеийн чухал асуудлаар асуулга тавьж хариулт авахад ашиглана.

Парламентын танхимд өгсөн хариултад тодруулга шаардлагатай бол “Хагас цагийн хэлэлцүүлэг”-ийг хийж болно. Энэ тохиолдолд тухайн сайд хариулт өгөх шаардлагагүй. Энэхүү дүрмийг баримтлан парламентын гишүүд алслагдсан бүс нутгуудын дэд бүтцийг сайжруулахаас эхлээд нийгмийн эмзэг хэсгийнхний сайн сайхны төлөөх схемийн нөхцөлийг хүртэлх олон зүйлийн асуудлыг дэвшүүлэн хэлэлцэж болно.

Санал: Хэлэлцүүлгээс ялгаатай нь энд хэлэлцүүлгийн төгсгөлд санал хураахыг зөвшөөрдөг. Парламентын хяналтын чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой гурван төрлийн санал дэвшүүлэх хэлбэр байдаг. Тэдгээр нь:

- *Үл итгэх санал* (No Confidence Motions)-ыг Парламентын гишүүдийн 50-аас илүү хувь нь дэмжсэн тохиолдолд Сайд нарын зөвлөлийн эсрэг гаргана. Хэрэв санал хураалтаар дэмжигдвэл засгийн газар огцорно.
- *Хойшлуулах санал* (Adjournment Motions) дэмжигдэн батлагдсанаар Танхимыг түр завсарлуулах ба энэ нь Танхим Засгийн газрын бодлоготой санал нийлэхгүй байгааг илэрхийлнэ. Гэхдээ энэ тохиолдолд Засгийн газар заавал огцрох шаардлагагүй.
- Дээрх хоёроос гадна Лок сабхагийн 184 дүгээр дүрмийн дагуух саналыг (Раджья Сабхагийн тухайд 167 дугаар дүрэм) Засгийн газрын бодлогыг дэмжих, эсхүл эсэргүүцэх тухайд санал хураах хэлбэрээр явуулна.

в) “Тэг цаг” – Асуултын цагийг дагалдах цагийг “Тэг цаг” гэх ба үүнийг парламентын гишүүд тулгамдсан чухал асуудлыг дэвшүүлэн хэлэлцэхэд ашиглана. Гишүүд хурлын даргад мэдэгдэж хурлын дарга асуудлыг дэвшүүлэх хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ. Үндсэндээ парламентын гишүүд энэ цагийг “Тусгайлан тэмдэглэх” буюу 377 дугаар дүрмийг (Rule 377/Special Mention) үндэслэн тулгамдсан яаралтай асуудлуудын талаар мэдэгдэл хийхэд ашиглана. Энэ цагийг бас Засгийн газрын байгууллагуудын жилийн тайланг

танилцуулахад ашигладаг. Раджья Сабха нь хуралдааны өдрийг “Тэг цаг”-аар эхлүүлж, дараа нь Асуултын цагаар үргэжлүүлэх шийдвэрийг гаргасан байдаг.

Хороодын тогтолцоо: Парламентад хэлэлцэх асуудлын тоо асар их байх тул парламентын гишүүдээс бүрдсэн хуулийн төслүүд, яамдын төсөв, Засгийн газрын бодлогуудыг нягтлах парламентын хороодтой байдаг. Эдгээр хороод нь Парламентыг илүү нарийн сайн мэдээлэл бүхий хэлэлцүүлэг хийх нөхцөлийг бүрдүүлнэ. Мөн эдгээр нь иргэд Парламентын үйл ажиллагаанд оролцох боломжийг бий болгох үүргийг гүйцэтгэнэ. Хороод нь байнгын, эсхүл түр хугацаагаар байгуулагдана. Дараах хороод нь Парламентын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг:

Яам, газруудтай холбоотой Байнгын хороод (DRSCs)	Харьяа яамдын ажлыг хянан шалгаж байдаг 24 хороо бий. Эдгээр хороод нь өөрсдийн чиг үүрэгт харгалзах яамдын Парламентад өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдээс гадна тэдгээрийн бодлого, үйл ажиллагааг хянадаг. Мөн тэд яамдын төсвийг хянах эрхтэй байна.
Санхүүгийн хороод	Парламентын санхүүгийн гурван байнгын хороо байдаг. Улсын дансны хороо, Тооцооны хороо, Улсын аж ахуйн нэгжийн хороо (Public Accounts Committee, Estimates Committee, Committee on Public Undertakings) Эдгээр нь Засгийн газрын санхүүгийн хяналтыг хариуцна. Яамдтай холбоотой Байнгын хороодоос ялгаатай нь энэ 3 хороо нь төсөв батлагдсаны дараагаар Засгийн газрын зардалд мониторинг хийнэ.
Өргөдөл гомдлын хороо	Төв болон мужийн засгийн газар, эсхүл аливаа албан хаагчтай холбоотой гомдлоо иргэд энэ хороонд хандан гаргана. Сүүлийн үеийн ихэнх өргөдөл гомдлууд нь хүнсний аюулгүй байдал, хуурамч эм, усан цахилгаан станцын төслийн асуудлуудын талаар байжээ.
Засгийн газрын амлалт, баталгааны хороо	Энэ хороо нь сайд нарын парламентын танхимын хуралдааны өмнө өгсөн амлалтыг тогтмол хянан үзэх бөгөөд тэдгээрийг хэрхэн хэрэгжүүлж буй талаар илтгэл тайлан гаргана.
Парламентын нэгдсэн хороод (JPCs)	Парламентын нэгдсэн хороод нь улс нийтийн чухал ач холбогдолтой асуудлуудыг шалгах үүднээс тодорхой зорилго, хугацаатайгаар байгуулдаг түр хугацааны хяналт, шалгалтын хороод юм.

Мөн Парламентын асуудал эрхэлсэн яам (Ministry of Parliamentary Affairs)-аас хөдөө аж ахуй, батлан хамгаалах, төмөр замын гэх зэрэг 34 яамдтай холбоотой Зөвлөлдөх Хороод (Consultative Committees)-ыг байгуулсан байдаг.

2.3.9. Япон Улс

Япон Улсад Парламентын танхимын тогтолцоог Үндсэн хуулиар тогтоосон бөгөөд Парламент нь Төлөөлөгчдийн танхим болон Зөвлөхүүдийн танхим гэсэн хоёр танхимаас бүрдэнэ. Ерөнхий сайдыг Парламентын гишүүдээс сонгох ба Ерөнхий сайд нь төрийн сайд нарын ихэнхийг нь Сеймийн Парламентын томилно. Хэрэв Төлөөлөгчдийн танхим Засгийн газарт итгэл үзүүлэхгүй бол Төлөөлөгчдийн танхим тарах, эсхүл Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорно.

Ерөнхий сайд болон төрийн бусад сайд нар Парламентын хуралдаанд хуулийн төслүүдийн талаар үг хэлэх боломжтой. Мөн Парламентын аль нэг танхим Ерөнхий сайд, эсхүл төрийн сайд нарыг хуралдаанд оролцуулахыг шаардах үед тэд хариулт өгөх, тайлбар хийхээр хүрэлцэн ирэх үүрэгтэй.

Төрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлын талаарх шалгалт: Танхим бүр Засгийн газрын үйл ажиллагаанд мөрдөн шалгалт явуулах бөгөөд гэрч нарыг байлцуулах, мэдүүлэг авах, тэмдэглэл хөтлөхийг шаардаж болно. Танхим нь мөн хорооны гишүүдийг мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулж болно. Мөрдөн шалгах үйл ажиллагааг нэгдсэн хуралдаанд хийж болох боловч ихэвчлэн Хороодын хуралдаанаар хийдэг. Мөрдөн шалгах үйл ажиллагааг Хорооны гишүүдийн хүсэлтээр, эсхүл Хорооны Удирдах зөвлөлийн шийдвэрээр эхлүүлж болно.

Төлөөлөгчдийн танхим, түүний хороод Засгийн газар, түүний харьяа агентлагаас тайлан, холбогдох баримт бичгийг шаардах тохиолдолд Засгийн газрын агентлаг шаардсан баримт бичгийг хүргүүлэх үүрэгтэй. Хэрэв Засгийн газрын агентлаг нь шаардлагыг биелүүлжгүй, эсхүл биелүүлэхээс татгалзсан бол шалтгаанаа тайлбарлах ёстой. Хэрэв танхим, эсхүл хороо уг шалтгааныг нь хүлээн зөвшөөрөхгүй гэж үзвэл, тайлан гаргах тухайн явц нь үндэсний ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах тухай мэдэгдэхийг Засгийн газарт хандаж болно.

Гэрчийн тангараг, мэдүүлгийн тухай хуулийн дагуу хэрэв танхим гэрчийг хуралдаанд оролцож мэдүүлэх өгөх, баримт бичиг ирүүлэхийг шаардвал тухайн этгээд нь заавал биелүүлнэ. Хэрэв гэрч ирээгүй, тангараг өргөж гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзсан, баримт бичгийг танилцуулаагүй бол тухайн этгээдэд нэг хүртэл жилийн хугацаагаар хорих ял оногдуулж, эсхүл 100,000 хүртэл иений торгууль ногдуулна.

Парламентын гишүүд Засгийн газрын чухал асуудлаар цогц судалгаа хийх зорилгоор судалгааны хороог байгуулдаг. 1986 оноос хойш 3 жилд гурван удаа судалгааны хороо байгуулагдсан. Одоо Олон улсын эдийн засаг, дипломат харилцаа, Ард иргэдийн өдөр тутмын амьдрал ба эдийн засаг, Байгалийн баялаг, эрчим хүчний хороо гэсэн судалгааны гурван хороо үйл ажиллагаагаа явуулж байна.



2.4.ХБНГУ-ЫН БУНДЕСТАГИЙН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООДЫН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ²⁰

/Фридрих-Эбертийн сангаас орчуулав/

Албан бус орчуулга

§ 1 Түр хороо байгуулах

- (1) Бундестаг нь хянан шалгах түр хороо байгуулах эрхтэй ба гишүүдийн дөрөвний нэг нь санал гаргасан тохиолдолд байгуулах үүрэгтэй.
- (2) Түр хороог Бундестагийн тогтоолоор байгуулна.
- (3) Үндсэн хуулиар Бундестагт олгосон бүрэн эрхийн хүрээнд хянан шалгалтыг явуулна.

§ 2 Түр хороо байгуулахад цөөнхийн эрх

- (1) Бундестагийн гишүүдийн дөрөвний нэг санал гаргасан бол Бундестаг хойшлуулахгүйгээр Хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоол гаргана.
- (2) Түр хороо байгуулах тухай тогтоолд санал гаргагчийн шалгуулахаар тусгасан асуудлыг тэдгээр тухайлан зөвшөөрөөгүй бол өөрчилж болохгүй.
- (3) Түр хороо байгуулах санал нь хэсэгчлэн Үндсэн хуульд харшилж байна гэж Бундестаг үзвэл түр хороо байгуулахдаа шалгах асуудлыг Үндсэн хуульд нийцнэ гэж Бундестаг үзсэн хэсгээр хязгаарлана. Ингэснээр санал гаргагчийн саналыг нь хэсэгчлэн буцаасанд Үндсэн хуулийн Цэцэд гомдол гаргах эрх нь хөндөгдөхгүй.

§ 3 Хянан шалгах асуудал

Хянан шалгах түр хороо өөрт нь ногдуулсан хянан шалгах даалгаврыг мөрдлөг болгоно. Хянан шалгах даалгаврыг өөрчлөх бол Бундестагийн тогтоол гарах шаардлагатай ба 2-р зүйлийн 2-р хэсгийг тухайлан хэрэглэнэ.

§ 4 Бүрэлдэхүүн

Бундестаг түр хороо байгуулахдаа түүний жинхэнэ болон ижил тооны орлогч гишүүдийн тоог тогтооно. Гишүүдийн тоо тогтоохдоо Бундестаг дахь олонх цөөнхийн харьцааны зэрэгцээ тавигдсан даалгавар болон хянан шалгах хорооны ажлын чадамжийг харгалзан үзнэ. Намуудын бүлэг бүрийн төлөөллийг оролцуулна. Намын бүлэг бүрт ногдох гишүүдийн тоог математик пропорцын зарчмаар тогтооно.

§ 5 Түр хорооны гишүүд

Түр хорооны жинхэнэ болон орлогч гишүүдийг намын бүлгүүд томилох ба эгүүлэн татна.

§ 6 Түр хорооны дарга

- (1) Түр хорооны даргыг сонгохдоо намын бүлгүүдийн гишүүдийн тоог харгалзан үзнэ. Хянан шалгах түр хороо нь Ахмадын зөвлөл дэх зөвшилцөөний дагуу өөрийн гишүүдийн дундаас түр хорооны даргыг сонгоно.
- (2) Түр хорооны дарга хянан шалгалтыг удирдах ба Бундестагийн Хянан шалгах түр хороог байгуулах тухай тогтоол, түр хорооны тогтоолуудыг мөрдлөг болгоно.

²⁰ 2001 оны 6-р сарын 19-нд баталсан Хянан шалгах түр хороодын тухай хууль (BGBl. I S. 718)“ 2004 оны 5 сарын 5-ны хуулийн 4.1-р зүйлээр өөрчлөлт орсон

§ 7 Түр хорооны орлогч дарга

(1) Хянан шалгах түр хороо нь Ахмадын зөвлөл дэх зөвшилцөөний дагуу түр хорооны нэг гишүүнийг орлогч даргаар томилох бөгөөд орлогч дарга түр хорооны даргаас өөр намын бүлгийн харьяалалтай байна.

(2) Түр хорооны даргын эзгүйд орлогч дарга түүний бүх эрх үүргийг эдэлнэ.

§ 8 Зарлан хуралдуулах

(1) Түр хорооны дарга хэлэлцэх асуудлын жагсаалтыг баталж, Хянан шалгах түр хороог зарлан хуралдуулна.

(2) Хянан шалгах түр хорооны гишүүдийн дөрөвний нэг нь хэлэлцэх асуудлыг нэрлэж хуралдахыг шаардсан бол түр хорооны дарга хамгийн ойрын боломжтой хуваарьт хугацаанд түр хороог зарлан хуралдуулах үүрэгтэй.

(3) Түр хорооны дарга нь хуваарьт бус хугацаанд эсвэл Бундестагийн байнгын байрлалын бус газар түр хороог зөвхөн түр хорооны гишүүдийн дөрөвний нэг хэлэлцэх асуудлыг нэрлэснээс гадна холбогдох санал гаргасан бөгөөд Бундестагийн Ерөнхийлөгчзөвшөөрөл олгосон тохиолдолд зарлан хуралдуулах эрхтэй.

§ 9 Шийдвэр гаргах чадамж

(1) Хуралдаанд гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр Хяналтын түр хороо шийдвэр гаргах чадамжтай. Холбогдох санал гарсны дагуу чадамжгүй нь тогтоогдох хүртэл түр хороог шийдвэр гаргах чадамжтайд тооцно.

(2) Шийдвэр гаргах чадамжгүйг нь тогтоосон бол түр хорооны дарга тэр даруйд хуралдааныг тодорхой хугацаагаар завсарлуулна. Уг хугацааны дараа түр хороо мөн л шийдвэр гаргах чадамжгүй хэвээр бол цаг алдалгүй шинэ хуралдааныг товлон. Энэ хуралдаан нь гишүүдийн олонхын ирцгүй ч шийдвэр гаргах чадамжтай ба үүнийг хуралдааны урилгад тэмдэглэнэ.

(3) Шийдвэр гаргах чадамжгүй Хянан шалгах түр хороо аливаа нэгэн хяналт шалгалтын ажиллагаа явуулах эрхгүй.

(4) Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Хянан шалгах түр хороо өгсөн саналуудын олонхоор шийдвэр гаргана. Санал тэнцсэн тохиолдолд өргөдлийг буцаана.

§ 10 Хянан шалгагч

(1) Хянан шалгах түр хороо нь аль ч үед өөрийн хяналт шалгалт хийх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор мөрдөн байцаагч томилох эрхтэй бөгөөд түр хорооны гишүүдийн дөрөвний нэг шаардсан бол тогтоол гаргах үүрэгтэй болно. Мөрдөн байцаалтын ажлыг цагхугацааны хувьд дээд тал нь зургаан сараар хязгаарлана.

(2) Тогтоол батлагдсаны дараа гурван долоо хоногийн дотор мөрдөн байцаагчийг 1-р заалтын дагуу хүрэлцэн ирсэн гишүүдийн гуравны хоёрын олонхоор томилно. Энэхүү томилгоог заасан хугацаанд нь хийгээгүй бол дараагийн гурван долоон хоногийн дотор түр хорооны дарга, дэд даргатай болон намын бүлгүүдийн төлөөлөгчдийн ахлагч нартай зөвшилцөн мөрдөн байцагчийг томилно.

(3) Мөрдөн байцаагч нь зарчмын хувьд Хянан шалгах түр хорооны хяналт шалгалтын бэлтгэл ажлыг гүйцэтгэнэ. Мөрдөн байцаагч шаардлагатай нотолгооны эд зүйл, баримтуудыг гаргуулж, тэдгээрт үзлэг хийж танилцана. Мөрдөн байцаагч нь 18-р

зүйлийн дагуу нотлох баримтуудыг гаргуулах эрхтэй ба 19-р зүйлийн дагуу тэдгээртээ танилцах эрхтэй болно. Мөрдөн байцаагч 30-р зүйлийн дагуу нотлох баримт гаргуулах шаардлагыг тавих эрхтэй. Сайн дураараа түүний эрхийг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд 17-р зүйлийн 1-р хэсгийн дагуу нотлох баримт цуглуулах тухай тогтоол гарах шаардлагатай. Мөрдөн байцаагч мэдээлэл авах зорилгоор хувь хүмүүсээс асуух эрхтэй. Мөрдөн байцаагч нийт Хянан шалгах түр хорооны өмнө хариуцлага хүлээнэ. Түүний ажлын үр дүн Хяналтын түр хорооны нийт гишүүдэд нээлттэй байна. Хяналт шалгалтыг дуусгаад мөрдөн байцаагч үр дүнгийн талаар түр хороонд амаар болон бичгээр тайлан тавих буюу гаргана. Тайланд түр хорооны цаашдын үйл ажиллагааг хэрхэн үргэлжлүүлэх талаар мөрдөн байцагчийн зүгээс саналаа тусгана. Мөрдөн байцаагч нь гадна харилцаанд зохих ёсоор нууцыг хадгалж, олон нийтэд мэдэгдэл хийхгүй.

(4) Мөрдөн байцаагч өөрт нь ногдуулсан даалгаврын хүрээнд хараат бус байна. Хүрэлцэн ирсэн түр хорооны гишүүдийн гуравны хоёрын олонхоор түүнийг аль ч үед эгүүлэн татаж болно. Мөрдөн байцаагч хяналт шалгалтын ажилд туслах ажилтнуудыг зохих хэмжээнд оролцуулах эрхтэй.

§ 11 Тэмдэглэл хөтлөлт

(1) Хянан шалгах түр хорооны хуралдааны тухай тэмдэглэл хөтөлнө.

(2) Нотлох хурлын үг бүрчлэн тэмдэглэнэ. Тэмдэглэл хөтлөх зорилгоор дуу хураагуур ашиглахыг зөвшөөрнө.

(3) Хуралдааны тэмдэглэл хөтлөх аргыг Хянан шалгах түр хороо тогтооно.

§ 12 Хянан шийдвэрлэх хуралдаан

(1) Хянан шалгах түр хорооны хуралдаан, шийдвэр гаргах явц олон нийтэд хаалттай байна.

(2) Хянан шалгах түр хороо намын бүлгүүдийн нэрлэсэн ажилтнуудад хуралдаанд оролцох зөвшөөрөл олгож болно.

(3) Хаалттай хуралдаанаас олон нийтэд өгөх мэдээллийн хэлбэр, хэмжээг Хянан шалгах түр хороо тогтооно.

§ 13 Хэлэлцэх хуралдаан

(1) Нотолгооны хэлэлцүүлгийг нээлттэй явуулна. Дууны, дүрсийн бичлэг хийх болон дуун ба дүрс бичлэг үзүүлэх нь хориотой. Онцгой тохиолдолд Хянан шалгах түр хороо 1-р өгүүлбэрээс өөрөөр шийдэж болно. 2-р өгүүлбэрт заасан онцгой тохиолдолд хүрэлцэн ирсэн гишүүдийн гуравны хоёрын олонх болон мэдүүлэг өгөх эсвэл асуугдах хүмүүсийн зөвшөөрөл шаардлагатай.

(2) Шүүхийн тухай хуулийн шүүх хуралдааны дэг журмыг хангах тухай §§ 176-с 179-р зүйлүүд хүчин төгөлдөр үйлчилнэ.

§ 14 Нийтэд хаалттай байдал

(1) Дараах тохиолдолд Хянан шалгах түр хорооны ажил олон нийтэд хаалттай байна:

1. Гэрч эсвэл гуравдагч этгээдийн хувийн амьдралын нөхцөл байдлыг олон нийтэд нээлттэй хэлэлцэх нь тэдгээрийн хамгаалах ёстой ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах эрсдэлтэй;

2.Гэрчийн эсвэл бусад өөр хүний амь нас, эрүүл мэнд эсвэл эрх чөлөөнд эрсдэл үүсэх;

3.Худалдаа, аж үйлдвэр, оюуны өмч /нээлт/ эсвэл татварын нууцыг олон нийтэд нээлттэй хэлэлцэх нь тэдгээрийн хамгаалах ёстой ашиг сонирхолд ноцтой хохирол учруулах эрсдэлтэй;

4.Холбооны эсвэл муж улсын ашиг сонирхолд харшлах онцгой шалтгаантай, ялангуяа Холбооны Герман Улсын аюулгүй байдал эсвэл түүний олон улсын харилцаанд сөрөг үр дагавартай байх бол.

(2)Хянан шалгах түр хороо хаалттай хуралдаанд тодорхой этгээдийг оролцуулах зөвшөөрөл олгож болно, § 12, 2-р зүйл хүчин төгөлдөр үйлчилнэ.

(3)Олон нийтийг оролцуулахгүй эсвэл оролцоог хязгаарлах саналыг даараах этгээд гаргах эрхтэй:

1. Хянан шалгах түр хорооны хуралд хүрэлцэн ирсэн гишүүд,
2. Бундесратын буюу Засгийн газрын гишүүд болон тэдгээрийн төлөөлөгчид,
3. Гэрч, шинжээч болон бусад мэдээлэл өгөх хүмүүс

(4) Олон нийтийг оролцуулах эсвэл оролцоог хязгаарлах тухай шийдвэрийг Хянан шалгах түр хороо гаргана. Түр хорооны тогтоолын дагуу түр хорооны дарга олон нийтэд нээлттэй хуралдаанаар энэ шийдвэрийн үндэслэлийг танилцуулна.

§ 15 Нууцыг хамгаалах

(1) Нотолгооны баримт, хянан шийдвэрлэх хурал болон хэлэлцүүлгүүдэд Хянан шалгах түр хороо тодорхой нууцын зэрэглэл тогтоож болно. 1-р өгүүлбэрийн дагуу шийдвэр гаргахаас өмнө Хянан шалгах түр хорооны дарга нууцын түр зэрэглэл тогтоож болно.

(1) Нууцын зэрэглэл тогтоохдоо Бундестагийн нууцыг хамгаалах тухай журмыг баримтална. 14. 3-р зүйл хүчин төгөлдөр үйлчилнэ.

(2) Энэхүү хуульд өөрөөр заагаагүй бол нууц бичиг баримт болон онц чухал нууц, маш нууц, нууц хуралдаан болон тэдгээрийн тэмдэглэл хөтлөлтөд Бундестагийн нууцыг хамгаалах тухай журам хүчин төгөлдөр үйлчилнэ.

§ 16 Нууцтай танилцах эрх, нууц хадгалах

(1) VS-НУУЦ болон түүнээс дээш нууцын зэрэглэлийг Хянан шалгах түр хороо тогтоосон эсвэл бусад байгууллагаас шилжүүлэн өгсөн баримтуудтай зөвхөн Хянан шалгах түр хорооны гишүүд, Бундесратын болон Засгийн газрын гишүүд болон тэдгээрийн төлөөлөгчид танилцах эрхтэй. Мөрдөн байцаагч, түүний туслах болон Хянан шалгах түр хорооны гишүүдийн ажилтан, тамгын газар болон намын бүлгүүдийн ажилтан зөвхөн нууц баримтуудтай харьцах зөвшөөрөлтэй ба албан ёсоор нууцыг хадгалах үүрэг хүлээсэн тохиолдолд нууцтай танилцах эрхтэй болно.

(2) Хянан шалгах түр хорооны гишүүд, мөрдөн байцаагч болон 1-р хэсэгт заасан ажилтан, туслах ажилтан нар хороог татан буулгасны дараа ч тэдэнд ил болсон 1-р хэсэгт дурдсан нууц баримтуудын нууцыг хадгалах үүрэгтэй. Бундестагийн Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр тэд шүүх болон өөр байгууллагад мэдүүлэг өгч болохгүй. Парламентын гишүүний тухай хуулийн § 44с. 2-р зүйлийн 2-р өгүүлбэр мөн 3-р хэсэг хүчин төгөлдөр үйлчилнэ.

(3) Хянан шалгах түр хорооны гишүүд хяналт шалгалтын хүрээнд олж авсан бусдын нууц, нэр бүхий хувь хүний хувийн амьдралын нууцыг зөвхөн эрх бүхий албан тушаалтны

зөвшөөрөлтэй задруулна. Энэ нь хуулийн дагуу ил болгох ёстой нууцыг задруулахад хамаарахгүй.

§ 17 Нотлох баримт цуглуулах

(1) Хянан шалгах түр хороо тогтоол гаргаж хянан шалгах даалгаврын дагуу нотлох баримтуудыг цуглуулна.

(2) Нотолгоо цуглуулах нь хуулиар хориглосон эсвэл энэ хуульд заасан албадлагын арга хэмжээг хэрэглэсэн ч нотлох баримт олдоогүйгээс бусад нөхцөлд Хянан шалгах түр хорооны гишүүдийн дөрөвний нэг санал гаргасны дагуу нотлох баримтуудыг цуглуулна.

(3) Хянан шалгах түр хорооны аль болох нэгдмэл шийдвэрийн үндсэн дээр гэрч болон шинжээчдийн мэдүүлэг өгөх дарааллыг тогтооно. Хянан шалгах хорооны гишүүдийн дөрөвний нэг эсэргүүцэл илэрхийлсэн тохиолдолд дээрх дарааллыг Бундестагийн чуулганы дэгийн тухай заалтуудын дагуу тогтооно.

(4) Хянан шалгах түр хороо нь тодорхой нотлох баримт цуглуулах эсвэл санал болгосон албадлагын арга хэмжээг /21-р зүйлийн 1-р хэсэг, 27-р зүйлийн 1-р хэсэг, 28-р зүйлийн 6-р хэсэг, 29-р зүйлийн 2-р хэсгийн 1-р өгүүлбэрийн дагуу/ хэрэглэхээс татгалзсан бол, түр хорооны гишүүдийн дөрөвний нэг санал гаргаснаар нотлох баримт цуглуулах эсвэл албадлагын арга хэмжээ авах тухай Холбооны улсын дээд шүүхийн шүүгч шийдвэр гаргана.

§ 18 Нотлох баримтуудыг гаргаж өгөх

(1) Холбооны улсын Засгийн газар, төрийн албан байгууллага болон Холбооны улсад шууд харьяалагдах байгууллага, нэгж ба нийтийн эрх зүйн сангууд нь албан хүсэлтийн дагуу нотолгооны бүгд эд зүйл, ялангуяа хянан шалгаж буй асуудалтай холбоотой баримтуудыг Үндсэн хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээнд гаргаж өгөх үүрэгтэй.

(2) Албан хүсэлтийг хүлээн авах тухай шийдвэрийг хуулиар Холбооны улсын Засгийн газар хариуцахгүй бол асуудал эрхэлсэн Холбооны улсын сайд гаргана. Хүсэлтийн биелүүлэхээс татгалзан эсвэл нотлох баримтуудыг нууцын зэрэглэл тогтоон ирүүлэх бол Хянан шалгах түр хороонд татгалзсан эсвэл нууцын зэрэглэл тогтоосон шалтгаануудыг бичгээр тайлбарлана. Илрүүлсэн баримт нь бүрэн эсэх тухай мэдэгдлийг хавсаргана.

(3) Хянан шалгах түр хороо эсвэл түүний гишүүдийн дөрөвний нэгийн саналаар Холбооны Улсын Үндсэн хуулийн цэц хүсэлтэд өгсөн татгалзсан хариу нь хууль ёсны эсэх, Холбооны улсын Дээд шүүхийн шүүгч нууцын зэрэг тогтоосон нь хууль ёсны эсэхийг тогтооно.

(4) Шүүх болон захиргааны албад эрх зүй болон албаны туслалцаа үзүүлэх, ялангуяа нотлох баримтуудыг илрүүлэх үүрэгтэй. Маргаантай асуудлыг Хянан шалгах түр хороо эсвэл түүний гишүүдийн дөрөвний нэгийн өргөдлөөр Холбооны улсын Дээд шүүхийн шүүгч шийдвэрлэнэ.

§ 19 Үзлэг хийх

Үзлэг хийхэд §18, 1-3 хэсгийн 1-р өгүүлбэр болон 4-р хэсэг зохих ёсоор үйлчилнэ.

§ 20 Гэрчийг зарлан дуудах

(1) Хянан шалгах түр хороо зарлан дуудсанаар гэрч хүрэлцэн ирэх үүрэгтэй. Эрүүгийн

хэрэг хянан шийдвэрлэх тухай журмын 50-р зүйлийг хэрэглэхгүй.

(2) Зарлан дуудах хуудаст гэрчид нотлох сэдвийг танилцуулж, түүний эрх үүргийн тухай зааварчилга өгөх ба хүрэлцэн ирээгүйн хуулийн үр дагавар болон мэдүүлэг өгөхдөө өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс эрх зүйн туслалцаа авах боломжтойг зааж өгнө.

§ 21 Гэрч ирээгүйн үр дагавар

(1) Журам ёсоор зарлан дуудагдсан гэрч ирээгүйн улмаас гарсан зардлыг Хянан шалгах түр хороо түүнээс гаргуулах, түүнд 10.000 евро хүртэлх захиргааны торгууль ногдуулж, албадан ирүүлэхийг тогтоож болно. Удаа дараа ирээгүй тохиолдолд торгуулийг дахин ногдуулж болно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 135-р зүйлийн 2-р өгүүлбэрийг хэрэглэнэ.

(2) Гэрч зохих хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаан мэдүүлсэн тохиолдолд 1-р хэсгийн дагуу авах хэмжээ авахгүй. Заагдсан хугацаанд ирээгүй нь өөрийн буруугаас болоогүй гэдгийг дараа нь нотолсон бол 1-р хэсэгт заасан арга хэмжээг хүчингүй болгоно.

§ 22 Гэрчлэх болон мэдүүлэг өгөхөөс татгалзах эрх

(1) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 53 болон 53а-р зүйл хүчин төгөлдөр үйлчилнэ.

(2) Гэрч нь мэдүүлэг өгснөөс үүдэн өөрөө болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 52-р зүйлийн 1-р хэсэгт заагдсаны дагуу тэдний гэр бүлийн гишүүнд хамаарагдах этгээд хуулийн зохицуулалттай хяналт шалгалтад өртөх эрсдэлтэй бол гэрч асуултад хариулахаас татгалзах эрхтэй.

(3) Эхний мэдүүлэг авахаас өмнө гэрчид 1 болон 2-р хэсэгт заасан эрхийн тухай зааварчилгаа өгнө.

(4) Гэрч мэдүүлэг өгөхөөс татгалзсан шалтгаанаа шаардсанаар итгэл үнэмшилтэй тайлбарлах үүрэгтэй.

§ 23 Албан тушаалтнаас мэдүүлэг авах

(1) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 54-р зүйл хүчин төгөлдөр үйлчилнэ.

(2) Мэдүүлэг өгөхөд шаардлагатай зөвшөөрлийг Холбооны улсын Засгийн газар олгох үүрэгтэй; 18-р зүйлийн 1-3-р өгүүлбэр хүчин төгөлдөр үйлчилнэ.

§ 24 Гэрчээс мэдүүлэг авах

(1) Мэдүүлэг өгөх гэрчээс ганцаарчилсан мэдүүлэн авна. Дараагийн мэдүүлэг өгөх гэрчүүдээс тусгаарлан мэдүүлэг авна.

(2) Хянан шалгах зорилгод нийцэх бол бусад гэрчүүдтэй нүүрэлдүүлж болно.

(3) Мэдүүлэг авахаас өмнө Хянан шалгах түр хорооны дарга гэрчийг үнэн зөв ярихыг сануулж, мэдүүлэг авах асуудлыг танилцуулж, худал эсвэл бүрэн бус мэдүүлгийн эрүүгийн хуулийн үр дагаврын тухай зааварчилгаа өгнө.

(4) Хянан шалгах түр хорооны дарга гэрчээс биеийн байцаалт авна. Гэрчээс мэдүүлэг авахаас өмнө гэрчид хэлэлцэгдэх асуудлаар түүний мэдэж буй зүйлийг бүрэн илтгэх боломж олгоно.

(5) Тодруулах, мэдүүлгийг бүрэн болгох ба гэрчийн мэдүүлгийн суурийг судлах зорилгоор эхлээд Хянан шалгах түр хорооны дарга асуулт тавьж болно. Үүний дараа хорооны бусад гишүүд асуулт тавих эрхийг эдэлнэ. Хянан шалгах түр хороо санал нэгтгэйгээр өөр зохицуулалт гаргаагүй тохиолдолд, асуулт тавих гишүүдийн дараалал болон намын бүлэг тус бүрийн асуух эрхийн хугацааны хувьд Бундестагийн дэг болон үг хэлэх дараалал, байр сууриа илэрхийлэх зохицуулалтын нийтлэг заалтуудыг тус тус хэрэглэнэ.

(6) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 136а-р зүйл хүчин төгөлдөр үйлчилнэ.

§ 25 Гэрчид тавих асуултын зөвшөөрөгдөх эсэх

(1) Зүй бус эсвэл асуудалд хамаарахгүй асуултыг Хянан шалгах түр хорооны дарга таслан зогсооно. Гэрч нь Хянан шалгах түр хорооны даргаас асуултыг таслан зогсоохыг шаардаж болно. Асуулт зөвшөөрөгдөх эсэх болон асуултыг таслан зогсоосон талаарх эрх зүйн эргэлзээтэй тохиолдолд түр хорооны гишүүдийн өргөдлийн дагуу Хянан шалгах түр хороо шийдвэрлэнэ. Асуултыг таслан зогсоохын тулд хүрэлцэн ирсэн гишүүдийн гуравны хоёрын олонх шаардлагатай.

(2) Хянан шалгах түр хороо тодорхой нэг асуултыг зөвшөөрөгдөөгүй гэж үзсэн бол энэхүү асуулт болон түүнд нэгэнт өгсөн хариуд Хянан шалгах түр хорооны тайланд ач холбогдол өгөхгүй.

§ 26 Мэдүүлэг авахыг дуусгах

(1) Мэдүүлгийн тэмдэглэлийг гэрч бүрд хүргүүлнэ.

(2) Хянан шалгах хороо тухайн гэрчээс мэдүүлэг авч дууссан тухай тэмдэглэл бүхий тогтоол гаргана. Мэдүүлгийн тэмдэглэлийг хүргүүлснээс хойш хоёр долоо хоног өнгөрсөн, эсвэл энэ хугацааг баримтлахаас татгалзсан тохиолдолд шийдвэр гаргана.

(3) Гэрч мэдүүлэг өгч дууссаны дараа Хянан шалгах түр хорооны дарга түүнд мэдүүлэг авах ажиллагааг 2-р хэсгийн дагуу ямар нөхцөлөөр хаасны тухай мэдээлэл өгнө.

§ 27 Шалтгаангүй гэрчлэхээс татгалзах

(1) Хууль ёсны аливаа нэгэн шалтгаангүйгээр гэрчлэхээс татгалзвал Хянан шалгах түр хороо татгалзсаны улмаас үүссэн зардлыг гэрчээс гаргуулах шийдвэр гаргах ба 10.000 евро хүртэл захиргааны торгууль ногдуулж болно.

(2) 1-р хэсэгт заасан нөхцөлд Хянан шалгах түр хороо эсвэл түүний гишүүдийн дөрөвний нэгийн өргөдлийн дагуу Холбооны улсын Дээд шүүхийн шүүгчийн захирамжаар гэрчийн мэдүүлгийг албадан гаргуулахаар гэрчийг цагдан хорих арга хэмжээ авч болох боловч энэ нь хяналт шалгалтын ажиллагаа дуусгах хугацаанаас хэтрэхгүй болон зургаан сараас илүүгүй хугацаатай байна.

(3) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 70-р зүйлийн 4-р хэсэг хүчин төгөлдөр үйлчилнэ.

§ 28 Шинжээч

(1) Хойно өөрөөр зохицуулаагүй бол 20, 22-26-р зүйлийн заалтуудыг шинжээчийн хувьд тус бүр хэрэглэнэ.

(2) Ажиллуулах шинжээч нарын сонголтыг Хянан шалгах түр хороо хийнэ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 74-р зүйлийг хэрэглэхгүй.

(2) Хянан шалгах түр хороо шинжээч нартай зөвшилцөн шинжээчийн дүгнэлт гаргах хугацааг тохирно.

(3) Шинжээч нь тохирсон хугацаанд хараат бус, бүрэн болон үнэн зөв дүгнэлт илтгэх үүрэгтэй бөгөөд Хяналтын түр хороо шаардвал бичгээр үйлдэх ба түүний нарийвчилж тайлбарыг амаар өгнө.

(4) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн шинжээчийн дүгнэлт гаргаж өгөхөөс татгалзах эрхийн тухай 76-р зүйлийн заалтуудыг тус тус хэрэглэнэ.

(5) Шинжээчийн дүгнэлт гаргах үүрэгтэй шинжээч 3-р хэсэгт заагдсан тодорхой хугацаа тохирохоос татгалзсан, эсвэл тохирсон хугацааг хожимдуулсан бол Хянан шалгах түр хороо түүнд 10.000 евро хүртэл захиргааны торгууль ногдуулж болно. Журам ёсоор дуудагдсан шинжээч ирээгүй эсвэл шинжээчийн дүгнэлт гаргах буюу тайлбарлахаас татгалзсан бол мөн дээрх торгууль ногдуулж болно. Үүний зэрэгцээ Хянан шалгах түр хороо хугацаа хожимдуулсан эсвэл татгалзсаны улмаас учирсан зардлыг гаргуулж болно. 21-р зүйлийн 2-р хэсэг хүчин төгөлдөр үйлчилнэ.

§ 29 Гаргаж өгөх үүрэг

(1) Хянан шалгалтад нотолгооны ач холбогдолтой байж болзошгүй эд юмс эзэмшиж буй этгээд Хянан шалгах түр хороо шаардсаны дагуу үүнийг гаргаж өгөх, ирүүлэх үүрэгтэй. Нотолгооны зүйл нь холбогдох хүмүүсийн ил болгож боломжгүй хувь хүний ноцтой нууц мэдээллийг агуулсан бол энэхүү үүргээс чөлөөлөгдөнө.

(2) Эзэмшигч этгээд татгалзсан бол Хянан шалгах түр хороо түүнд 10.000 евро хүртэлх захиргааны торгууль ногдуулж болно. Холбооны улсын Дээд шүүхийн шүүгч Хянан шалгах түр хороо эсвэл түүний гишүүдийн дөрөвний нэгийн өргөдлийн дагуу гаргуулан авах зорилгоор цагдан хорих захирамж гаргаж болно. 27-р зүйлийн 2 болон 3-р хэсэг тус тус үйлчилнэ. 22-р зүйлийн 1 болон 2-р хэсгийн дагуу гэрчлэхээс эсвэл мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй этгээдэд энэ хэсэгт заасан захиргааны болон албадлагын арга хэмжээ ногдуулахгүй.

(3) 1-р хэсэгт заасан эд юмсыг сайн дураараа гаргаж өгөөгүй бол Холбооны улсын Дээд шүүхийн шүүгч Хянан шалгах түр хороо эсвэл түүний гишүүдийн дөрөвний нэгийн өргөдлийн дагуу эдгээр зүйлийг хураан авах ба Хянан шалгах түр хороонд ирүүлэх тухай шийдвэр гаргана. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 97-р зүйл хүчин төгөлдөр үйлчилнэ. Холбооны улсын Дээд шүүхийн шүүгч нотолгооны эд юмс байж болох газрын тухай тодорхой баримтуудыг үндэслэн 1-р хэсэгт заасан эд зүйлийг хураан авах зорилгоор тодорхой байрлалд нэгжлэг хийх захирамж гаргаж болно. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журмын §§ 104, 105-ийн 2-р, 3-р хэсэг, §§ 106, 107, 109 зохих ёсоор хэрэглэнэ.

§ 30 Ирүүлсэн нотлох баримтуудыг үнэлэх

(1) Ирүүлэхийг шаардсан нотлох баримтууд хяналт шалгалтад ач холбогдолгүй гэх эсвэл § 14, 1-р хэсгийн 1-4 заалтад тодорхойлсон нууцад хамаарах гэх гомдлыг нотлох баримт эзэмшигч гаргасан бол § 29, 2-р хэсэгт заасан захиргаа ба албадлагын болон §29, 3-р хэсгийн 1-р өгүүлбэрт заасан албадан гаргуулах арга хэмжээг зөвхөн нотолгооны эд зүйл нь холбогдох хүмүүсийн хувь хүний ил болгох боломжгүй нууцыг агуулаагүй бөгөөд энэхүү нотолгооны зүйлд Хянан шалгах түр хороо нууцлалын “Нууц” зэрэг тогтоосон тохиолдолд хэрэгжүүлнэ.

(2) Ирүүлсэн нотлох баримтуудад үзлэг хийж нотолгооны ач холбогдлыг үнэлэх нь Хянан шалгах түр хорооны бүрэн эрхэд хамаарна. Хяналт шалгалтад ач холбогдолгүй гэж санал нэгтгэйгээр Хянан шалгах хороо үзсэн нотолгооны зүйлийг цаг алдалгүй эзэмшигчид буцаан өгнө.

(3) 1-р хэсэгт заасан нотолгооны зүйлсэд үзлэг хийж, үнэлгээ явуулсны үр дүнгээр нотолгооны зүйл хяналт шалгалтад ач холбогдолтой бол нууцын зэрэглэлийг “Нууц” болгон өндөржүүлж болно. §14 1-р хэсгийн 1-р заалтад заасан нууц хөндөгдөх бол зөвхөн түүнийг ил болгох нь хянан шалгах даалгаврыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай ба нөхцөл байдалд тохирсон нөхцөлд Хянан шалгах түр хороо 1-р өгүүлбэрийн дагуу тогтоол гаргана.

(4) 3-р хэсгийн 1-р өгүүлбэрийн дагуу тогтоол гаргахаас өмнө нотолгооны эд зүйлийг эзэмшигч хувь хүнийг сонсоно. Тэрбээр “Нууц” зэрэглэлийг хүчингүй болгохыг эсэргүүцсэн ба Холбооны улсын Дээд шүүхийн шүүгч Хянан шалгах түр хорооны эсвэл түүний гишүүдийн дөрөвний нэгийн өргөдлийн дагуу зөвшөөрөл олгоогүй бол нууцын зэрэглэлийг хүчингүй болгохгүй.

§ 31 Тэмдэглэл болон бичиг баримтуудыг уншиж танилцуулах

(1) Бусад хянан шалгах түр хороод шүүх болон албан байгууллагын хяналт шалгалтын тэмдэглэл болон нотлох баримт болох бичиг баримтуудыг Хянан шалгах түр хороо хуралдааны үеэр уншиж танилцуулна.

(2) Тэмдэглэл эсвэл бичиг баримтуудыг Хянан шалгах түр хорооны гишүүн бүрт хүргүүлсэн бол Хянан шалгах түр хороо баримтуудыг уншиж танилцуулахаас татгалзаж болно.

(3) 14 дүгээр зүйлийн 1-р хэсгийн нөхцөл байдал хангагдсан бол олон нийтэд нээлттэй хуралдааны үеэр тэмдэглэл, бичиг баримтууд буюу тэдгээрийн гол агуулгыг уншиж танилцуулахгүй.

§ 32 Эрх зүйн тэгш байдал

(1) Хаалтын тайланг нийтлэхэд эрх нь ихээхэн хэмжээнд хохирол амсах болзошгүй хувь хүмүүст хяналт шалгалт дуусахаас өмнө тайлангийн төсөлд тусгасан өөрт нь хамааралтай нотлох баримтуудыг үнэлэх хуралдааны үеэр тэдэнтэй хэлэлцээгүй бол хоёр долоо хоногийн хугацаанд үүнд байр сууриа илэрхийлэх боломж олгоно.

(2) Байр суурийг нь илэрхийлсэн гол санаа бодлыг тайланд тусгана.

§ 33 Тайлагналт

(1) Хяналт шалгалт дууссаны дараа Хянан шалгах түр хороо Бундестагт бичгээр тайлан өгнө. Тайлан нь ажиллагааны явц, олж мэдсэн бодит зүйлс болон хяналт шалгалтын үр дүнг толилуулна.

(2) Хянан шалгах түр хороо санал нэгтгэйгээр тайлан батлаагүй бол тайланд зарчмын өөр саналуудыг тусгана.

(3) Хянан шалгах түр хороо парламентын бүрэн эрхийн ээлжит хугацаанд өөрийн хяналт шалгалтыг дуусгах боломжгүй нь илэрхий бол хяналт шалгалтын явц болон тухайн үеийн үр дүнгийн тухай тайланг Бундестагт өгнө.

(4) Бундестагийн тогтоолын дагуу Хянан шалгах түр хороо Бундестагт завсрын тайлан тавина.

§ 34 Батлан хамгаалахын хорооны хянах шалгах эрх

(1) Батлан хамгаалахын хороо аливаа нэг асуудлыг хянан шалгах тухай тогтоол баталсан бол тэрбээр хяналт шалгалт явуулахдаа Хянан шалгах түр хорооны эрхүүдийг

эдэлнэ. Батлан хамгаалахын хорооны гишүүдийн дөрвөний нэг шаардсан бол Батлан хамгаалахын хороо Хянан шалгах түр хорооны зохион байгуулалтад орно. § 1-3 зохих ёсоор үйлчилнэ.

(2) Түр хороог Батлан хамгаалахын хорооны дарга даргална.

(3) Батлан хамгаалахын хороо аливаа нэг асуудлыг хянан шалгах тухай тогтоол баталсан бол түүнийг хэрэгжүүлэхээр Батлан хамгаалахын хорооны орлогч гишүүдийг томилж болох дэд хороо байгуулж болно.

(4) Батлан хамгаалахын хороо Хянан шалгах түр хорооны хувиар ажиллагаа явуулахад энэ хуулийн заалтууд үйлчилнэ. Өөрийн хяналт шалгалтын үр дүнгийн тухай Батлан хамгаалахын хороо Бундестагт тайлан тавина. Хэлэлцүүлэг нь зөвхөн нийтлэгдсэн тайлангаар хязгаарлагдана.

§ 35 Зардал, урьдчилгаа төлбөр

(1) Хяналт шалгалтын зардлуудыг Холбооны улс хариуцна.

(2) Гэрч, шинжээч болон хянан шалгагч нар хууль зүйн төлбөр, нөхөн олговрын тухай хуулийн дагуу нөхөн олговор, төлбөр авна. Өргөдлийн дагуу эрх зүйн туслалцааны хураамжийг гэрчид олгохоор Хянан шалгах түр хороо тогтоол баталж болно. Хууль зүйн төлбөр, нөхөн олговрын тухай хуулийн § 9, 1-р хэсгийн 1-р өгүүлбэрийн дагуу төлбөрийн дээд ангиллаар хянан шалгагч нарт төлбөр олгоно.

(3) Нөхөн олговор, төлбөр болон урьдчилгаа төлбөрийн олголтын хэмжээг Бундестагийн Ерөнхийлөгч тогтооно.

§ 36 Шүүхийн харьяалал

(1) Үндсэн хуулийн 93-р зүйл, Холбооны улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн § 13 болон энэ хуулийн заалтуудаар өөрөөр зохицуулаагүй бол энэ хуулийн талаарх маргаан Холбооны улсын Дээд шүүхэд харьяалагдана.

(2) Холбооны улсын Дээд шүүх түр хороо байгуулах тогтоолыг Үндсэн хуульд харш гэж үзсэн ба шийдвэр гаргах нь тогтоол хүчинтэй эсэхээс хамаарах бол хяналт шалгалтыг зогсоож Холбооны улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт авна. 1-р өгүүлбэр зохих ёсоор Холбооны улсын Дээд шүүхийн шүүгчид мөн үйлчилнэ.

(3) Холбооны улсын Дээд шүүхийн шүүгчийн шийдвэрт гомдол гаргах боломжтой ба үүнийг Холбооны улсын Дээд шүүх шийдвэрлэнэ.



2.5. ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА САЙН ТУРШЛАГА: УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО²¹

*/Ажлын дэд хэсгийн гишүүн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн профессор,
хууль зүйн доктор О.Мөнхсайхан/*

I. ОРШИЛ

Парламентаас гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналт нь түүний хууль тогтоох чиг үүрэгтэй адилхан чухалд тооцогддог. Засгийн газар, түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагаа, бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэн бодит мэдээллийн тусламжтайгаар хянах, хэлэлцүүлэх нь нэг талаар гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналт, нөгөө талаар хууль тогтоох ажиллагааны хэсэг мөн. Учир нь, Үндсэн хуулийн эх баригч Б.Чимид багшийн онож тодорхойлсноор: “Эцсийн дүнд сайн хууль гаргаж түүнийхээ биелэлтийг хянан шалгаж, бодитой үр дүнд хүргэх явдал хууль тогтоох үйл ажиллагааны үндсэн агуулга билээ. Хураангуйлбал, хууль тогтоох үйл ажиллагаа = хууль гаргах + биелэлтийг хянаж шалгах /хоёрын нийлбэр/ гэж бүдүүвчилж болно. Тэгэхээр хууль гаргаж орхиод байвал хамаг ажлынхаа тэн хагасыг умартсан хэрэг гэхээс яах вэ? Хууль олигтой хэрэгжихгүй байгаагийн нэг гол шалтгаан ч энд бий.”²² Парламентын хяналт нь хүний эрх, эрх чөлөөг хангах, Засгийн газрын үйл ажиллагааг үр ашигтай, ил тод, нээлттэй, хариуцлагатай байлгах болон хууль тогтоох ажилд туслах зорилготой.

Парламентын хяналтын үр нөлөөтэй арга хэрэгслүүдийн нэг бол парламентын мөрдөн шалгалт (parliamentary investigation) буюу хянан шалгалт (parliamentary inquiry). Хянан шалгах хороо нь байнгын хорооны бүтцээс тусдаа бие даасан байдлаар тухайлсан асуудлаар илүү эрх мэдэлтэйгээр хяналт хэрэгжүүлэх боломж олгодог. Парламентын эрх хэмжээний асуудлаар үнэн, бодит мэдээлэл авч, дүгнэлт хийж нээлттэй хэлэлцэх зорилгоор гэрчийн мэдүүлэг авч сонсох, мэдээлэл, бичиг баримт гаргуулах, шинжээч томилох, газар дээр нь очиж шалгах, баримт бичгийн дүн шинжилгээ хийх, энэ явцад нийтийн сонсгол зохион байгуулах, тайлан гаргах зэрэг бүрэн эрхийг цогцоор нь парламентын мөрдөн шалгалт буюу хянан шалгалт гэж хэлж болно. Парламентын мөрдөн шалгалтыг байнгын хороогоор дамжуулж эсхүл түр хороо байгуулж хэрэгжүүлдэг. Хянан шалгах хороог байгуулах болон мөрдөн шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд цөөнхийн санаачилга, бодит оролцоог хангаж өгвөл энэ нь парламентын хяналтын ердийн, уламжлалт хэлбэрүүдээс илүү үр нөлөөтэйгээр гүйцэтгэх эрх мэдэлд хяналт тавихад тусалдаг.

2007 оны байдлаар Олон улсын парламентын холбооны судалгаанд хамрагдсан 88 улсын 76-д нь хянан шалгах хороо (committee of inquiry) байгуулах боломжтой байсан.²³ 2017 оны судалгаагаар 83 улсын 103 парламентын танхимыг хамарсан асуулга авахад парламентуудын 90 хувьд хянан шалгах түр хороо байна.²⁴ Эдгээр хянан шалгах хороод нь засгийн газар, түүний байгууллага, албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах, төсвийг

²¹ Энэхүү судалгааг УИХ-ын Тамгын газар, Парламентын судалгааны хүрээлэнгийн дэмжлэгтэйгээр гүйцэтгэсэн. Өгүүлэл бичих санал тавьж бүхий л талаар дэмжиж хамтран ажилласан УИХ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Парламентын судалгааны хүрээлэнгийн захирал Т.Баярмаа, тус хүрээлэнгийн секторын эрхлэгч Д.Аюуш нарт талархаж буйгаа илэрхийлж байна.

²² Мөн, тэрээр хяналт шалгалт гэдгийг ерөнхийд нь ингэж тодорхойлжээ: “Хяналт шалгалт гэдэг шийдвэр, үр дүн хоёрыг хооронд нь жишиж үзээд таарсныг нь бататгаж, тасалдал, гажигийг арилгах үйл ажиллагаа юм. Ер нь шийдвэр гаргах түвшний байгууллага, албан тушаалтан нар хоёр үйлдлийг заавал өөрөө хийж байх ёстой гэдэг. Өөрөөр хэлбэл бусдад найдаж, дайж болохгүй удирдлагын зайлшгүй үүрэг бол бодлогын шийдвэрийг өөрөө гаргаж, бодит биелэлтийг нь биечилэн (механик утгаар бус) тооцож байх явдал мөн. Нэгдэхийг эс гүйцэтгэвээс хөгжлийг чөдөрлөгч, хоёр дахь үүргийг эс биелүүлвээс хариуцлага сулруулагч болно.” Б.Чимид, “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх нь /Цаас үйлдвэрлэж мөнгө тараахаас цааш юу харагдана вэ?/,” *Хууль дээдлэх ёс*, 2010, №2(29), 6-7.

²³ Hironori Yamamoto, *Tools for Parliamentary Oversight: A Comparative Study Of 88 National Parliaments* (Inter-Parliamentary Union 2007), 39.

²⁴ *Global Parliamentary Report 2017: Parliamentary Oversight: Parliament's Power To Hold Government To Account* (Inter-Parliamentary Union and United Nations Development Programme, 2017), 55.

үр ашиггүй зарцуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангахгүй байх зэрэг нийтлэг ашиг сонирхлыг хөндсөн, ноцтой асуудлаар мөрдөн шалгаж ажилладаг.

2019.11.14-нд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 28.2-т “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж заасан. Энэ зохицуулалт нь УИХ-ын 19-ээс доошгүй гишүүн санаачилбал хянан шалгах түр хороо заавал байгуулж, түүний бүрэлдэхүүнийг тогтоох болон мөрдөн шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь цөөнхийн бодит оролцоог хангах, нийтийн сонсгол, тайлагналаар үнэн, бодит мэдээллийг ил тод, хэлэлцэх, улмаар гүйцэтгэх эрх мэдэлд тавих парламентын хяналтыг сайжруулах чухал алхам болсон.

Энэхүү өгүүлэл нь оршил, дүгнэлтээс гадна хоёр үндсэн бүлэгтэй. II бүлэгт хянан шалгах хорооны талаарх олон улсын сайн туршлагыг судалж танилцуулна. III бүлэгт хянан шалгах түр хорооны талаарх Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалыг товч тодорхойлно.

II. ОЛОН УЛСЫН САЙН ТУРШЛАГА: ХЯНАН ШАЛГАХ ХОРОО

Өгүүллийн энэ бүлэгт үндсэн хууль, хууль эсхүл дэгээр хянан шалгах хороог зохицуулах; хянан шалгах хороо нь түр эсхүл байнгын шинжтэй ажиллах; парламентын эрх хэмжээний хүрээнд нийтийг ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг тодорхой хугацаанд мөрдөн шалгах; хянан шалгах түр хороог байгуулах босгыг оновчтой тогтоох; түр хорооны бүрэлдэхүүн, дарга, илтгэгч гишүүнийг томилоход болон бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд цөөнхийн эрхийн баталгаа, бодит оролцоог хангах; мөрдөн шалгах бүрэн эрхийг тодорхойлох; нийтийн сонсгол зохион байгуулах; хянан шалгах түр хорооны тайланг гаргах; хянан шалгах түр хороог үл хүндэтгэвэл шийтгэл хүлээлгэх; хянан шалгах түр хороо ба эрүүгийн процессын зааг ялгааг гаргах гэсэн арван сэдвийг судалж танилцуулна.

Үндсэн хууль, хууль болон дэгээр зохицуулах

Хянан шалгах түр хорооны зохицуулалтын үндсийг Үндсэн хуульд заах нь олон. Жишээлбэл, ХБНГУ-ийн Үндсэн хуулийн 44, Португалийн Үндсэн хуулийн 178.4, Чехийн Үндсэн хуулийн 30, Латвийн Үндсэн хуулийн 26-д ийм зохицуулалт бий. Хянан шалгах түр хорооны нарийвчилсан харилцааг хууль эсхүл парламентын дэгээр зохицуулдаг. Зарим улсад хянан шалгах түр хорооны эрх хэмжээ, бүрэн эрх, үйл ажиллагааг зохицуулсан тусгайлан хууль тогтоомжтой. Жишээлбэл, ХБНГУ-д Бундестагийн “Хянан шалгах хорооны тухай хууль” (Committees of Inquiry Act – *Untersuchungsausschussgesetz*) нэртэй 2001 оны хууль үйлчилж байна. Харин, Австрид Үндэсний зөвлөлийн дэгийн тухай 1975 оны холбооны хуулийн хавсралтаар баталсан “Парламентын хянан шалгах хорооны үйл ажиллагааны дэг” (Rules of Procedure for Parliamentary Investigating Committees) бий.

Хянан шалгах түр эсхүл байнгын хороо

Хянан шалгах хороо нь түр эсхүл байнгын хороо байдлаар ажилладаг. 88 парламентын 13-т нь байнгын хороо мөрдөн шалгах бүрэн эрхтэй боловч энэ бүрэн эрхээ хэрэгжүүлэх зөвшөөрлийг нэгдсэн хуралдаанаас авдаг.²⁵ Жишээлбэл, АНУ-ын Конгрессын байнгын хороо нь мөрдөн шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Тодорхой хугацаанд тодорхой асуудлыг мөрдөн шалгаж тайлан гаргах ажлыг хянан шалгах түр хороонд хариуцуулдаг бөгөөд энэ шийдвэрийг нэгдсэн хуралдааны тогтоолоор гаргадаг. Тухайлбал, ХБНГУ-д парламент дахь хүчтэй цөөнхийн эсхүл олонхын санаачилгаар нэгдсэн хуралдаанаар

²⁵ Hironori Yamamoto, *Tools for Parliamentary Oversight: A Comparative Study Of 88 National Parliaments* (Inter-Parliamentary Union 2007), 40.

байгуулсан түр хороо нь цөөнхийн төлөөлөл, бодит оролцоотойгоор мөрдөн шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

Хянан шалгах хороо нь дийлэнхдээ түр хороо байдлаар ажилладаг. Нэгд, түр хороо яагаад байгуулагдсан бэ гэдэг нь түүний хянан шалгах асуудалтай шууд холбогддог учраас тухайн асуудалд илүү төвлөрч ажиллахад түлхэц болдог. Өөрөөр хэлбэл, тухайн асуудлыг хянан шалгах зорилгоор байгуулагдсан тул түр хороо түүндээ анхаарахаас аргагүй бөгөөд таарч тохирсон гишүүдээр бүрдүүлэх боломжтой. Хоёрт, “хянан шалгах байнгын хороо нь өөрийн давуу эрхийг ашиглаж засгийн газарт байнгын хохирол учруулах эрсдэлтэй, харин хянан шалгах түр хороо нь гүйцэтгэх эрх мэдлийн хамгаалалт болдог.”²⁶

Түр эсхүл байнгын эсэхээс үл хамааран хянан шалгах хороо нь дараах нийтлэг шинжтэй.²⁷

- Мөрдөн шалгах тусгай бүрэн эрхүүд хэрэгжүүлдэг;
- Өөрийн мөрдөн шалгах асуудлаар хязгаарлагдсан явцуу хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлдэг;
- Хянан шалгах хороо нь парламентын бүрэн эрхийн хугацаанд эсхүл тодорхой чуулганы хугацаанд ажилладаг;
- Нэгдсэн хуралдаанаар байгуулдаг;
- Эцсийн тайлангаа нэгдсэн хуралдаанд хүлээлгэн өгснөөр үйл ажиллагаа нь зогсдог.

Хянан шалгах түр хороо нь тодорхой асуудлаар тодорхой хугацаанд нухацтай мөрдөн шалгаж тайлан гаргаад дуусгавар болдог. Ийм түр хороод нь хянан шалгах хорооны нийтлэг шинжээс гадна дараах онцлогтой.²⁸

- Нэгдсэн хуралдааны тогтоолоор түүний ажиллах хугацааг нь заадаг;
- Хянан шалгалт нь нэгдсэн хуралдаанаас баталсан тогтоолд дурдсан тодорхой асуудлаар л хязгаарлагдсан явцуу хүрээнд хийгддэг;
- Хянан шалгалтын мөн чанарыг тогтоолд зааж өгдөг;
- Түр хорооны бүрэлдэхүүн нь ердийн хороодынхоос арай цөөн тоотой боловч парламентын бүлгүүдийн зохистой төлөөллийг хангадаг.

Жишээлбэл, Бельгийн парламентын төлөөлөгчдийн танхим нь хянан шалгах комисс (хороо) байгуулахдаа ямар тогтоол гаргасныг доорх ишлэлээс харна уу.²⁹

Зүйл 1

Хэсэг 1. Үндэсний агаарын тээврийн компани болох Сабенагийн дампуурлын шалтгаан, үр дагаврыг шалгах зорилгоор хянан шалгах комисс байгуулна.

Хэсэг 2. Комисс нь улс төрийн болон бусад хариуцлагыг боломжтой хэмжээнд тодорхойлно. Энэ үүднээс, комисс нь хувьцаа эзэмшигчид болон нийтийн эрх мэдэл хэрэгжүүлэгчид хувьцаа эзэмшигчдийн үүргээ хэрэгжүүлж ирсэн арга замыг шалгана.

Хэсэг 3. Нийтийн эрх мэдлийг хэрэгжүүлэгчид хувьцаа эзэмшдэг эсхүл өмчилдөг компанид тавих хяналт болон түүний зохицуулалтыг сайжруулах боломжтой бүх зөвлөмжийг томъёолж танилцуулах шаардлагатай...

Зүйл 5

Танхимаас нэмэлт хугацаа өгснөөс бусад тохиолдолд комисс нь тайлангаа 2002.06.30-ны дотор танхимд танилцуулна.

2001.11.14

Парламентын есөн гишүүний гарын үсэгтэй

²⁶ Olivier Rozenberg, *Inquiries by Parliaments: the Political Use of a Democratic Right* (European Union, 2020), 17.

²⁷ Hironori Yamamoto, *Tools for Parliamentary Oversight: A Comparative Study Of 88 National Parliaments* (Inter-Parliamentary Union 2007), 39-40.

²⁸ Мөн тэнд, 40.

²⁹ Мөн тэнд, 41.

Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүн нь парламент дахь нам, эвслийн хүчний харьцааг хувь тэнцүүлэн эсхүл тэнцүү тусгахыг сайн туршлагад тооцдог. Зарим улсад хянан шалгах түр хороо нь зөвхөн парламентын гишүүдээс бүрддэг бол заримд нь парламентын нэрийн өмнөөс мөрдөн шалгалт явуулж тайлагнах чиг үүрэгтэй шинжээчийг парламентын гаднаас томилон ажиллуулдаг.³⁰

Парламентын эрх хэмжээний хүрээнд нийтийг ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг тодорхой хугацаанд мөрдөн шалгах

Хянан шалгах түр хорооны мөрдөн шалгах ажил нь ихэнхдээ нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудал байдаг. Тухайлбал, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах түр хороо байгуулахаар Чехийн Үндсэн хуулийн 30, Эстонын парламентын дэгийн 20(1)-д тус тус тусгайлан заажээ. Хянан шалгах түр хороо нь “тодорхой үйл явдал эсхүл нөхцөл байдал (жишээлбэл, Засгийн газрын албан тушаалтны буруутгагдаад буй авилгын хэрэг, байгалын гамшгийн үеийн буруу менежмент, улсын эрүүл мэнд тогтолцооны тааруу байдал)-ыг мөрдөн шалгах мандаттай ажилладаг.”³¹

Парламентууд 2013 онд 81, 2014 онд 84, 2015 онд 101 хянан шалгах түр хороо байгуулж ажиллуулсан бөгөөд мөрдөн шалгах сэдэв нь шүүгчийг тагнаж чагнасан (Румын), шилэн кабелийн тасалдал (Бүгд найрамдах ардчилсан Конго), уугуул эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэл (Чили) зэрэг үндэсний хэмжээний олон янзын асуудлыг хамарчээ.³² Жишээлбэл, ХБНГУ-ын Бундестагт 2014-2017 онд Үндэсний аюулгүй байдлын албанаас явуулдаг мөрдөн мөшгих ажиллагаа, хүүхдийн порнографын дуулиант явдал, ногдол ашиг хуваарилахтай холбоотой луйврын дуулиант явдал (Cum/Ex), хэт барууны террорист бүлэглэл (NSU), машинаас ялгаруулах бохирдлын дуулиант явдал, 2018 оноос хойш Исламын террорист халдлага (Breitscheidplatz), Батлан хамгаалах сайдын гадаад зөвлөхийн асуудал, Европын холбооны шүүхээс хориглосон хурдны замын хураамж авах ажиллагаа гэсэн сэдвээр тус тус хянан шалгах түр хороо байгуулжээ.³³ Эдгээрээс харахад улсын бүрэн эрхэт байдал, гэмт хэрэг, санхүүгийн дуулиант явдал, байгал орчин, эдийн засаг, аюулгүй байдал, батлан хамгаалалт, муу удирдлага (maladministration)-тай холбоотой сэдвээр хянан шалгах түр хороо байгуулж байжээ. Сонирхсон иргэн, сэтгүүлч, ТББ зэрэг гуравдагч этгээдийг сөхөж тавьсан асуудал нь хянан шалгах түр хороог байгуулах сэдэв болох нь олонтой.³⁴

Хянан шалгах түр хороог ажиллуулах хугацаа нь харилцан адилгүй. Нэг талаар, Францын Үндэсний Ассамблей, Румын танхимаас байгуулсан ийм түр хороо нь зөвхөн 6 сар л ажилладаг.³⁵ Францын хянан шалгах түр хорооны хувьд хугацаа хэт богино төдийгүй эрх мэдлийн хувьд сулд тооцогддог. Нөгөө талаар, Испанид хянан шалгах түр хороо ямар хугацаанд ажиллуулах талаар заагаагүй бөгөөд уг хороо нь өөрт ногдсон ажлаа хийж дуусгаснаар эсхүл хууль тогтоох байгууллагын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсноор татан буугддаг.³⁶ Хянан шалгах түр хороонуудын хувьд ихэнхдээ түүнийг байгуулсан нэгдсэн хуралдааны тогтоолд хугацааг нь тодорхой зааж өгдөг. Жишээлбэл, өгүүллийн энэ бүлгийн эхэнд танилцуулсан Бельгийн парламентын тогтоолд Үндэсний агаарын тээврийн компани болох Сабенагийн дампуурлын шалтгаан, үр дагаврыг шалгах зорилгоор хянан шалгах комисс (хороо)-ыг 2001.11.14-ны өдөр байгуулж, “Танхимаас нэмэлт хугацаа өгснөөс бусад тохиолдолд комисс нь тайлангаа 2002.06.30-ны дотор танхимд танилцуулна” гэж 8 сар гарангийн хугацаа заажээ.

³⁰ “Parameters On The Relationship Between The Parliamentary Majority And The Opposition In A Democracy: A Checklist,” Adopted by the Venice Commission at its 119th Plenary Session (Venice, 21-22 June 2019), Opinion No. 845/2016, CDL-AD(2019)015, §131.

³¹ Мөн тэнд.

³² *Global Parliamentary Report 2017: Parliamentary Oversight: Parliament's Power To Hold Government To Account* (Inter-Parliamentary Union and United Nations Development Programme, 2017), 55.

³³ Olivier Rozenberg, *Inquiries by Parliaments: the Political Use of a Democratic Right* (European Union, 2020), 29.

³⁴ Мөн тэнд, 19.

³⁵ Diane Fromage, *The European Parliament's Right of Inquiry in Context: A comparison of the national and European legal frameworks* (European Union, 2020), 35.

³⁶ Мөн тэнд, 35.

Парламент нь адилхан асуудлаар хянан шалгах түр хороог дахин дахин байгуулж болдог гэж Олон улсын парламентын холбооны судалгаанд бичжээ.³⁷ Жишээлбэл, Бенин Улсын парламент 2003-2007 онд дараах дөрвөн асуудлаар хянан шалгах хороо давтан байгуулсан гэж уг судалгаанд бичжээ: Котоноугийн бие даасан боомт дахь нэг цэгийн үйлчилгээ, Ганын Такорадид байрлах цахилгаан станцын эзэмшил, хуучин авто машины худалдаа, Аригбо дэ Дасса-Зумэ Мариан агуй руу чиглэх аялал жуулчлал.

Хянан шалгах түр хороо байгуулах босго

Цөөнхийн санаачилгаар хянан шалгах түр хороо заавал байгуулах зохицуулалт нь парламентын хянан шалгалтыг хэрэгжүүлэхэд цөөнхийн оролцоог хангасан хамгийн сайн хувилбарын нэгд тооцдог. Парламентын гишүүдийн тодорхой хувь буюу хүчтэй цөөнхөөс санал тавивал нэгдсэн хуралдаанаар нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах түр хороог байгуулна. Европын долоон улсад хүчтэй цөөнх (нийт гишүүний 1/5-ээс 1/3 хүртэл) нь санал тавивал нэгдсэн хуралдаанаар хянан шалгах түр хороог байгуулах үүрэгтэй.³⁸ Жишээлбэл, ХБНГУ-д Бундестагийн гишүүдийн 1/4 нь хянан шалгах түр хороог байгуулах санал тавивал нэгдсэн хуралдаан дахь олонх эсрэг байсан ч гэсэн заавал байгуулдаг.³⁹ Мөн, Латвид 1/3, Новегид гишүүдийн 1/3, Австрид цөөнхийн бүлэг шаардсаны дагуу хянан шалгах түр хороо байгуулдаг.

Олон улсын зөвлөмжүүдэд хянан шалгах түр хороо байгуулах босгыг доогуур буюу хүчтэй цөөнх байхаар тогтоохыг зөвлөдөг. Жишээлбэл, сөрөг хүчний гишүүдээс хянан шалгах түр хороо байгуулах санал тавих, түр хорооны гишүүнээр ажиллах эрхтэй байх хэрэгтэй гэж Европын зөвлөлийн парламентын хурал зөвлөжээ.⁴⁰ Хянан шалгах түр хороо байгуулах босгыг 1/5 болговол жижиг сөрөг хүчний оройлыг илүү бэхжүүлнэ гэж Венецийн комисс дэмжсэн бөгөөд дараахыг онцлон хэлсэн:⁴¹

“Тогтоолоор” байгуулна гэсэн шаардлага нь энэ процессод олонх дур мэдэн хэрэгжүүлэх бүрэн эрхтэй гэж тайлбарлаж болохгүй, тэгвэл цөөнхийн эрхийг дордуулна гэдгийг онцлон хэлэх ёстой. Ингэж ойлгохгүй бол ...парламент дахь сөрөг хүчний эрх зүйн байдлыг дээрдүүлэх зорилгынхоо эсрэг болчихно. Парламентын гишүүдийн тавны нэг санал тавьсан тохиолдолд парламентын комисс байгуулж, үүнээс өөр нэмэлт шаардлагыг парламентын дэгээр тавьж болохгүй.

Мөн, парламентын бүлэг бүр өөрийн сонгосон сэдвээр хянан шалгах комисс байгуулуулах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд сөрөг хүчний төлөөллийг уг комиссод оруулах хэрэгтэй гэж Олон улсын парламентын холбоо зөвлөжээ.⁴² Зарим тохиолдолд парламентын олонх болсон нам, эвслийн бүлгээс өмнөх засгийн газрын үеийн эргэлзээтэй асуудлуудаар түр хороо байгуулах нь бий.

Хэрэв хянан шалгах түр хороог байгуулах эсэхийг парламент дахь олонх шийддэг байвал өөрийн итгэл хүлээлгэж буй Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих уг түр хороог байгуулахаас татгалзах эсхүл хянан шалгалтын хүрээ, боломжийг хэт хумих эрсдэлтэй. Тодорхой тооны гишүүдийн буюу цөөнхийн санаачилгаар хянан шалгах түр хороог заавал байгуулах боловч түр хороо байгуулж хянан шалгах асуудал нь парламентын

³⁷ Hironori Yamamoto, *Tools for Parliamentary Oversight: A Comparative Study Of 88 National Parliaments* (Inter-Parliamentary Union 2007), 42.

³⁸ Мөн тэнд, 42.

³⁹ Eva-Maria Poptcheva, “Parliament’s Investigative Powers: Committees Of Inquiry And Special Committees,” *Briefing* (European Parliament, February 2015), 9.

⁴⁰ Council of Europe Parliamentary Assembly Resolution 1601(2008) on “Procedural guidelines on the rights and responsibilities of the opposition in a democratic parliament”, par 13.2.8, <https://pace.coe.int/pdf/bf3f279f3f169da482749ec1086e1602230e76ea3326667a8259ffe25682ae848428feba12/doc.%2011465.pdf>

⁴¹ “Final Opinion On The Draft Constitutional Law On Amendments And Changes To The Constitution Of Georgia,” Adopted by the Venice Commission at its 84th Plenary Session (Venice, 15-16 October 2010), Opinion no. 543/2009, CDL-AD(2010)028, §25.

⁴² “Guidelines On The Rights And Duties Of The Opposition In Parliament,” (libreville, Gabon, 17–19 May 1999), III.3, <http://archive.ipu.org/dem-e/opposition.pdf>

эрх хэмжээний хүрээнд байх шаардлагатай. Хянан шалгах түр хороо байгуулах асуудал нь парламентын эрх хэмжээнээс хальсан байвал тухай асуудлыг хасаж, парламентын эрх хэмжээнд багтсан асуудлаар нь хянан шалгах түр хороо байгуулдаг. Жишээлбэл, ХБНГУ-ын Бундестаг хянан шалгах түр хороо байгуулах саналд туссан асуудлын зарим нь Үндсэн хуульд нийцэхгүй байвал түүний хүрээг хумьж Үндсэн хуульд нийцсэн асуудлаар нь хянан шалгах түр хороо байгуулдаг.⁴³ Олонхын энэ шийдвэрийн эсрэг хүсэлтийг Холбооны Үндсэн хуулийн шүүхэд гаргах эрх парламентын гишүүдэд нь бий (Хянан шалгах түр хорооны тухай хуулийн 2(3)) учраас хянан шалгах асуудал нь парламентын эрх хэмжээнд багтсан эсэх маргааныг парламентын олонх бус, харин Үндсэн хуулийн шүүх эцэслэн шийдвэрлэдэг.

Цөөнхийн эрхийн баталгаа ба бодит оролцоо: түр хорооны бүрэлдэхүүн, дарга, илтгэгч гишүүн, бүрэн эрх

Хянан шалгах түр хороог байгуулахад болон байгуулсны дараа цөөнхийн оролцоог бодитой хангах нь олон улсын сайн туршлага мөн. Жишээлбэл, Австрийн Үндэсний зөвлөлийн гишүүн Райнхольд Лопатка ингэж хэлжээ:

Цөөнх болсон намууд хянан шалгах хороо байгуулах эрхтэй. Хэрэв ийм хороо байгуулагдвал цөөнх нам нь хэн уг хороонд орохыг шийдвэрлэх, хэн үг хэлэх, хэн нотлох баримт өгөхийг ч шийдвэрлэх эрхтэй. ...Хорооны гишүүн бүр санал гаргаж, мэдээж хорооны гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Гэхдээ, гишүүдийн 25 хувийн цөөнх нь хянан шалгах хороо байгуулах эрхтэй.⁴⁴

Парламентын хяналт нь “Ерөнхийлөгчийн засаглалын хэлбэрт парламентын хороод, парламентын засаглалын хэлбэрт цөөнхөд түшиглэсэн чиг үүрэг байдаг” учраас “парламент дахь цөөнхийн эрхийг тэлэх замаар хэрэгждэг: цөөнх гишүүд санаачлах эрхтэй байх, хороог даргалах, хороонд олонх цөөнх тэнцүү тоогоор орох, мандатыг, цуглуулах мэдээллийг тодорхойлоход ажил жинтэй байх, Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байх гэх мэт.”⁴⁵

Хянан шалгах түр хорооны шийдвэр олонхоор гарахаар зохицуулбал тухайн хорооны цөөнх гишүүдийн процедурын эрхийг хүлээн зөвшөөрч хамгаалах нь чухал. Жишээлбэл, “цөөнхийн санаачилсан мөрдөн шалгах хорооны чиглэлтэй давхцуулж мөрдөн шалгах хороо байгуулахыг парламентад хориглодог. Цөөнхийн санаачилсан хяналтын чиглэл, хязгаар дээр парламентын олонх санаачилга гаргаж чиглэл, сэдэв нэмэх эрхгүй.”⁴⁶

Хянан шалгах түр хороо дахь цөөнхийн гишүүд нь гэрчээс асуулт асуух, баримт бичгийг шинжлэн судлахад олонхын гишүүдтэй тэгш эрх эдлэх бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтны хадгалж буй нотлох баримтыг гаргуулах хүсэлт гаргах боломжтой байх хэрэгтэй.⁴⁷ Жишээлбэл, ХБНГУ-ын Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 17 (4)-д зааснаар түр хорооны нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь нотлох баримтыг цуглуулах санал тавибал түр хороо энэ тухай тогтоол гаргах бөгөөд ийнхүү нотлох баримт цуглуулахаас татгалзсан бол түр хорооны нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь нотлох баримтыг цуглуулах хүсэлтийг Холбооны дээд шүүхийн мөрдөн шалгалт хариуцсан шүүгчид гаргах эрхтэй. Мөн, гэрч түр хорооны дуудсанаар хүрэлцэн ирээгүй, гэрч хууль бус үндэслэлээр мэдүүлэг өгөхөөс татгалзсан, зайлсхийсэн; шинжээч нь дүгнэлт гаргах

⁴³ Diane Fromage, *The European Parliament's Right of Inquiry In Context: A Comparison Of The National And European Legal Frameworks* (European Union, 2020), 36.

⁴⁴ *Global Parliamentary Report 2017: Parliamentary Oversight: Parliament's Power To Hold Government To Account* (Inter-Parliamentary Union and United Nations Development Programme, 2017), 55.

⁴⁵ Х.Номингэрэл, “Парламентын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх механизм, бусад орнуудын жишиг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын чиг үүргийг боловсронгуй болгох асуудал,” *Байнгын ажиллагаатай парламент 25 жил*, Эрдэм шинжилгээний хурал, 2015.09.15, 26.

⁴⁶ Х.Тэмүүжин, “Парламент үнэнийг мэдэх эрхтэй /Парламентын хяналт ба мөрдөн шалгах эрх мэдэл/,” *Эрх зүй*, 1-2/ 2010 (18-19), МУИС-ийн Хууль зүйн сургууль, 174.

⁴⁷ “Parameters On The Relationship Between The Parliamentary Majority And The Opposition In A Democracy: A Checklist,” Adopted by the Venice Commission at its 119th Plenary Session (Venice, 21-22 June 2019), Opinion No. 845/2016, CDL-AD(2019)015, §135.

хугацааг тохиролцох талаар хэлэлцэхээс зайлсхийсэн, тогтоосон хугацаанд дүгнэлт гаргаж өгөөгүй, түр хорооны хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй, дүгнэлтийн талаар тайлбар, мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан; нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр түр хороонд ирүүлээгүй, гаргаж өгөөгүй зөрчил гаргасан бол түр хорооны шийдвэрээр торгох, албадан авч ирэхийг заалгах зэрэг арга хэмжээг авдаг. Хэрэв ийм арга хэмжээг түр хороо аваагүй бол түр хорооны нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь уг арга хэмжээг авах хүсэлтийг Холбооны дээд шүүхийн мөрдөн шалгалт хариуцсан шүүгчид гаргах эрхтэй (Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 17 (4)).

Түр хорооны дарга нь зохион байгуулалтаар хангах чиг үүрэгтэй тул хянан шалгах ажиллагаанд нөлөө бүхий этгээд. Хянан шалгах түр хороо дахь олонх болон цөөнхийн тэнцвэрийг хангах нэг арга бол түүний даргыг цөөнхөөс томилох явдал. Жишээлбэл, Унгарт Засгийн газар эсхүл түүний харьяа байгууллагын талаарх хянан шалгах хорооны дарга нь сөрөг хүчний намын харьяалалтай гишүүн болдог.⁴⁸ Мөн, Францад хянан шалгах комиссын дарга эсхүл илтгэгч гишүүн нь цөөнхийн гишүүн байхыг хуулиар шаарддаг.⁴⁹

Хянан шалгах түр хороо нь тухайн асуудлыг тусгайлан судлах үүрэг бүхий илтгэгч гишүүнийг томилох нь элбэг. Илтгэгч гишүүн нь мэдүүлэг авах гэрч, очих газрыг сонгохтой холбоотой санал гаргах, сонсголын үеэр эхний асуулт асуух, эцсийн тайлан, зөвлөмжийн төслийг бэлтгэх зэрэг үүрэг хүлээдэг.⁵⁰ Хэдийгээр илтгэгч гишүүн ийм үүрэг хүлээдэг боловч түр хорооны бусад гишүүн ч идэвхтэй оролцоотой байдаг. Зарим улсад өөр өөр нам, эвслийн бүлгээс санал болгосон хоёр илтгэгч гишүүнийг зэрэгцүүлэн томилдог нь олонх болон цөөнхийн оролцоог тэгш хангасан сайн туршлага. Хянан шалгах түр хорооны олонхоос болон цөөнхөөс томилсон нийт 2 илтгэгч гишүүнтэй байхаар зохицуулахыг Венецийн комисс зөвлөсөн.⁵¹ Сөрөг хүчний гишүүдээс санаачилсан хянан шалгах хороо бүрийн дарга эсхүл илтгэгч гишүүнийг сөрөг хүчний гишүүдээс томилох хэрэгтэй гэж Европын зөвлөлийн парламентын хурал зөвлөжээ.⁵²

Мөрдөн шалгах бүрэн эрх

Хянан шалгах хороо нь мөрдөн шалгах ажиллагааны шүүгч (investigative judge)-тэй төстэй бүрэн эрхийг хэрэгжүүлдэг учраас ердийн байнгын хороодоос илүү эрх мэдэлтэйгээрээ онцлог. Хянан шалгах түр хороо өөрийн мандатын асуудлаар мөрдөн шалгах бүрэн эрх эдлэхгүй бол түүнийг байгуулсны хэрэг гарахгүй. Хянан шалгах түр хороонд дараах таван төрлийн бүрэн эрхийг хуулиар олгодог: гэрчийн мэдүүлэг авч сонсох; мэдээлэл, бичиг баримт гаргуулах; шинжээч томилох; газар дээр нь очиж шалгах; бичиг баримтад дүн шинжилгээ хийх.

1. *Гэрчийн мэдүүлэг авч сонсох.* Европын холбооны 17 парламентын танхимд хийсэн судалгааны дагуу харвал 17 танхимын 17-д нь гэрчийг сонсголд дуудаж мэдүүлэг авах бүрэн эрхийг хянан шалгах хороонд өгдөг.⁵³ Жишээлбэл, Чех (Парламентын дэгийн 48.4), Эстони (Парламентын дэгийн 22(1), 22(2)), Латви (Парламентын мөрдөн шалгах хорооны хуулийн 8, 9, 10), Польш (Сэймийн мөрдөн шалгах хорооны тухай хуулийн 11.1), ХБНГУ (Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 20(1))-д гэрчээс мэдүүлэг авдаг.

⁴⁸ Eva-Maria Poptcheva, "Parliament's Investigative Powers: Committees Of Inquiry And Special Committees," *Briefing* (European Parliament, February 2015), 9.

⁴⁹ Lika Sajaia, *Strengthening Parliamentary Control in Georgia* (Transparency International Georgia and USAID, 2018), 16.

⁵⁰ Olivier Rozenberg, *Inquiries by Parliaments: the Political Use of a Democratic Right* (European Union, 2020), 17.

⁵¹ "Parameters On The Relationship Between The Parliamentary Majority And The Opposition In A Democracy: A Checklist," Adopted by the Venice Commission at its 119th Plenary Session (Venice, 21-22 June 2019), Opinion No. 845/2016, CDL-AD(2019)015, §138.

⁵² Council of Europe Parliamentary Assembly Resolution 1601(2008) on "Procedural guidelines on the rights and responsibilities of the opposition in a democratic parliament", par 13.2.8, <https://pace.coe.int/pdf/bf3f279f3f169da482749ec1086e1602230e76ea3326667a8259ffe25682ae848428feba12/doc.%2011465.pdf>

⁵³ Diane Fromage, *The European Parliament's Right of Inquiry in Context: A comparison of the national and European legal frameworks* (European Union, 2020), 37.

Болгар, Хорват, Франц, Унгар, Португалид гэрч нь сонсголд заавал оролцож мэдүүлэг өгөх үүрэгтэй. Хянан шалгах түр хороо нь ихэнхдээ засгийн газрын гишүүн болон төрийн албан хаагчаас мэдүүлэгч авч хянан шалгалт явуулдаг бөгөөд энэ бол түүний гол чиг үүрэг мөн.⁵⁴ Гэхдээ, нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар хувь хүнийг гэрчээр дуудах зайлшгүй шаардлагатай бол дуудахыг зөвшөөрдөг улсууд бий бөгөөд энэ талаар харилцан адилгүй зохицуулалттай. Тухайлбал, Австри болон ХБНГУ-д тухайн улсад оршин суугч, Болгар, Хорватад тухайн улсын иргэн, Чехд аливаа хувь хүнийг гэрчээр дуудаж болдог.⁵⁵

2. *Мэдээлэл, бичиг баримт гаргуулах.* Европын холбооны 17 парламентын танхимыг судлахад бүгдэд нь буюу 17-д нь мэдээлэл, баримт бичиг гаргуулах бүрэн эрхийг хянан шалгах хороонд өгдөг бөгөөд үүнийг зөрчвөл торгох хүртэл шийтгэл хүлээлгэдэг.⁵⁶ Жишээлбэл, Чех (Парламентын дэгийн 48.4), Эстон (Парламентын дэгийн 22(1), 22(2)), Латви (Парламентын мөрдөн шалгах хорооны хуулийн 8, 9, 10), Польш (Сэймийн мөрдөн шалгах хорооны тухай хуулийн 14.1), ХБНГУ (Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 18, 29)-д мэдээлэл, нотлох баримт гаргуулан авах бүрэн эрхийг олгосон.

Засгийн газар, төрийн захиргааны байгууллагаас мэдээлэл, баримт бичиг гаргаж өгөхийг шаардах бүрэн эрх хянан шалгах түр хороонд бий гэсэн үг. Эдгээр байгууллагаас хамтран ажиллахаас татгалзвал яах вэ гэдгийг улс орон бүр өөр өөрийн онцлогтойгоор зохицуулдаг. Ийм тохиолдолд захиргааны журмаар торгох (Австри зэрэг улс)-оос эхлээд хорих ял (Нидерланд зэрэг улс) оногдуулах хүртэл шийтгэдэг.

Хянан шалгах түр хороо нь тухайн асуудлаар мөрдөн өгөх ажиллагаа явуулж байхдаа шүүх, прокурор, захиргааны байгууллагаас туслалцаа хүсэх боломжтой. Австри, Бельги, Герман, Итали, Польшид ийм туслалцаа хүсэх бүрэн эрхийг хянан шалгах түр хороонд өгдөг бөгөөд Словенид хянан шалгалтын сэдэвт холбогдох баримт бичгийг хянан шалгах түр хороонд өгөх үүргийг шүүхэд хүлээлгэдэг.⁵⁷ Жишээлбэл, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 44(3)-д “Шүүхийн болон эрх бүхий захиргааны байгууллагуудыг хууль зүйн болон захиргааны дэмжлэг, туслалцаа үзүүлнэ” гэж бий.

Зарим улсын хувьд нотлох баримт гаргуулах хүсэлтийг шүүхэд гаргах боломжтой. Жишээлбэл, Австри, Бельги, Финланд, Итали зэрэг улсад хянан шалгах түр хороо нь нотлох баримт цуглуулах хүсэлтийг шүүхэд гаргадаг бөгөөд шүүх ерөнхийдөө эдгээр хүсэлтийг хангаж шийдвэрлэдэг.⁵⁸ Харин, Франц, Ирланд, Грек, Нидерландад хянан шалгах түр хороо болон шүүхийн хооронд ийм хамтын ажиллагаа байхгүй бөгөөд тэдгээр нь тус тусдаа өөрийн чиг үүргийг бие даан хэрэгжүүлдэг.⁵⁹

3. *Шинжээч томилох.* Европын холбооны 17 парламентын танхимд хийсэн судалгааны дагуу харвал 17 танхимын 17-д нь шинжээч томилох бүрэн эрхийг хянан шалгах хороонд өгдөг.⁶⁰ Жишээлбэл, Чех (Парламентын дэгийн 48.4), Польш (Сэймийн мөрдөн шалгах хорооны тухай хуулийн 12а), ХБНГУ (Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 28)-д ийм зохицуулалт бий.

⁵⁴ Amicus Curiae Brief in the case of *Rywin v. Poland* (Applications Nos 6091/06, 4047/07, 4070/07) pending before the European Court Of Human Rights (On Parliamentary Committees Of Inquiry) Adopted by the Venice Commission at its 98th plenary session (Venice, 21-22 March 2014), Study No. 759 / 2014, CDL-AD(2014)013, §14; Wilhelm Lehmann, “Parliamentary Committees Of Inquiry In National Systems: A Comparative Survey Of EU Member States” (European Parliament, 2010), 5.

⁵⁵ Diane Fromage, *The European Parliament's Right of Inquiry in Context: A comparison of the national and European legal frameworks* (European Union, 2020), 37.

⁵⁶ Мөн тэнд.

⁵⁷ Eva-Maria Poptcheva, “Parliament's Investigative Powers: Committees Of Inquiry And Special Committees,” *Briefing* (European Parliament, February 2015), 9.

⁵⁸ Wilhelm Lehmann, “Parliamentary Committees Of Inquiry In National Systems: A Comparative Survey Of EU Member States” (European Parliament, 2010), 5.

⁵⁹ Мөн тэнд.

⁶⁰ Diane Fromage, *The European Parliament's Right of Inquiry in Context: A comparison of the national and European legal frameworks* (European Union, 2020), 37.

4. Газар дээр нь очиж шалгах (*on-the-spot investigations/fact-finding visits*). Газар дээр нь очиж шалгах нь иргэд болон улс төрийн элитийн хоорондын зайг ойртуулах, орон нутагт парламентын ажлыг хүргэх, орон нутгийн бодит байдлыг ажиглах боломжийг парламентын гишүүдэд олгох ач холбогдолтой.⁶¹ Европын холбооны 17 парламентын танхимыг судлахад тэдгээрийн 11-т нь газар дээр нь очиж шалгах бүрэн эрхийг хянан шалгах хороонд өгдөг.⁶² Жишээлбэл, Нидерландад хянан шалгах хорооны гишүүн тухайн улсын нутаг дэвсгэрт аливаа газарт өмчлөгчийнх нь зөвшөөрөлгүйгээр нэгжлэг хийх боломжтой.⁶³ Харин, Австрид орон байранд нэгжлэг хийх болон хөрөнгө хураан авахыг хянан шалгах хороонд хориглодог (Парламентын хянан шалгах хорооны үйл ажиллагааны дэгийн 21). ХБНГУ болон Чехд тусгай мөрдөгч томилох замаар энэ чиг үүргийг гүйцэтгүүлдэг.⁶⁴ Жишээлбэл, ХБНГУ-д хянан шалгах түр хороо нь 6 хүртэлх сарын хугацаагаар тусгай мөрдөгч томилж ажиллуулах боломжтой (Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 10).

5. Бичиг баримтад дүн шинжилгээ хийх. Цуглуулсан бичиг баримтад дүн шинжилгээ хийх нь сонсголын үеэр асуулт асуух, бичиг баримтын талаар гэрчээс асуулт асуух, улмаар хянан шалгах түр хорооны тайланг бичихэд тусалдаг. Бичиг баримтын дүн шинжилгээг ихэнхдээ парламентын хорооны ажлын албаны ажилтнууд, парламентын гишүүний ажилтнууд, эсхүл орон тооны бус шинжээчид хариуцуулж хийлгэдэг.⁶⁵

Англи хэл дээрх “committee of inquiry”, “committee of investigation” гэсэн нэршлээс болж эрүүгийн хэрэгт прокурорын эсхүл шүүхийн зөвшөөрөлтэй хийгддэг мөрдөн шалгах ажиллагаатай хольж хутгаж болохгүй. Тухайлбал, хянан шалгах түр хороо нь нууцаар мөрдөх, тагнах, чагнах ажиллагааг явуулахгүй.

Нийтийн сонсгол

Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нийтийн сонсгол. Тус хорооноос гэрчийн мэдүүлгийг, ялангуяа Ерөнхий сайд, засгийн газрын гишүүн болон төрийн албан хаагчийн мэдүүлгийг сонсох зорилгоор нийтийн сонсгол хийдэг. Сонсголын үеэр гэрч урьдчилан бэлдсэн мэдүүлгээ амаар ярина, араас нь асуулт хариулт үргэлжилдэг бөгөөд нэмэлт асуулт асуух боломжтой.⁶⁶

Сонсголын бусад төрлөөс ялгаатай нь хянан шалгах түр хорооны сонсголоор мэргэжлийн, хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй байдаг онцлогтой. Засгийн газар болон түүний харьяа байгууллагын олон нийттэй хуваалцахыг хүсдэггүй мэдээллийг нийтэд ил болгох замаар парламентын хяналтыг хэрэгжүүлж, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох боломж үүснэ. Тодруулбал, хянан шалгах түр хороо нь шалгаж буй буюу өөрийн шалгахаар байгуулагдсан мандат бүхий асуудлаараа засгийн газрын мэдэлд байгаа мэдээллийг ямар нэг саадгүй гаргуулан авах, холбогдох албан тушаалтнаас үнэн зөв, бүрэн мэдүүлгийг бичгээр авах, аман асуулт хариулт хэлбэрээр сонсголын явцад сонсох бүрэн эрхтэй. Энэхүү баримт мэдээлэл гаргуулан авах бүрэн эрхийн баталгаа нь холбогдох мэдээллийг гаргаж өгөхгүй байх, худал, бүрэн бус мэдээлэх зэрэгт парламентыг үл хүндэтгэсэн учир эрүүгийн, захиргааны эсхүл бусад хариуцлага хүлээлгэх нөхцөл болдог.

Сонсголын үеэр ямар албан тушаалтныг гэрч, шинжээчээр дуудаж сонсох, мэдээлэл, нотлох баримтыг цуглуулж авах нь түр хорооны үйл ажиллагаа үр нөлөөтэй байх эсэхэд нөлөөлдөг. Иймд хороо гишүүдийн олонхиор хүч түрэн мэдээллийг хэт нэг талыг барин цуглуулахгүйн тулд ямар мэдээллийг ямар арга хэргэслээр цуглуулахыг хорооны

⁶¹ Olivier Rozenberg, *Inquiries by Parliaments: the Political Use of a Democratic Right* (European Union, 2020), 17.

⁶² Diane Fromage, *The European Parliament's Right of Inquiry in Context: A comparison of the national and European legal frameworks* (European Union, 2020), 37.

⁶³ Wilhelm Lehmann, “Parliamentary Committees Of Inquiry In National Systems: A Comparative Survey Of EU Member States” (European Parliament, 2010), 15.

⁶⁴ Diane Fromage, *The European Parliament's Right of Inquiry in Context: A comparison of the national and European legal frameworks* (European Union, 2020), 37.

⁶⁵ Olivier Rozenberg, *Inquiries by Parliaments: the Political Use of a Democratic Right* (European Union, 2020), 17.

⁶⁶ Мөн тэнд.

гишүүдийн 1/4-ээр эсхүл гол улс төрийн хүчнүүдийн зөвшилцлөөр шийдвэрлэдэг. Жишээлбэл, ХБНГУ-д Бундестагийн Хянан шалгах түр хорооны тухай хуулийн 17(4)-заасны дагуу түр хорооны нийт гишүүний дөрөвний нэг Холбооны дээд шүүхийн мөрдөн шалгах ажиллагааны шүүгчид хүсэлт гаргаж нотлох баримтыг цуглуулах эсхүл арга хэмжээг авах тухай захирамж гаргуулж болдог талаар өмнө өгүүлсэн билээ.

Хянан шалгах түр хорооны сонсгол нь олон нийтэд нээлттэй явагдах ерөнхий зарчимтай. Сонсгол нь дийлэнхдээ олон нийтэд нээлттэй явагдаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон вэбсайтаар шууд дамжуулдаг.⁶⁷ Гэхдээ, хэргийн мөн чанар, хайж буй мэдээллийн нууц, эмзэг байдлыг харгалзан сонсгол болон хянан шалгах ажиллагааг бүхэлд нь эсхүл зарим талаар хаалттай явуулахыг зөвшөөрдөг. Түр хорооны мэдээлэл цуглуулах, асуух эрхийн хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдалтай холбоотой төрийн нууц болон хувь хүний халдашгүй эрхийн хүрээгээр тодорхойлогддог. Жишээлбэл, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 44(2)-т “Нотлох баримт олж авахын тулд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх процедурын тохирох журмыг хэрэглэнэ. Ингэхдээ хувийн болон захидал харилцааны нууцыг хөндөж үл болно” гэж заасан. Герман төдийгүй Австри, Бельги зэрэг улсад хянан шалгах түр хорооны гишүүд нь түр хорооны үйл ажиллагаатай холбоотой нууцлалыг хадгалах үүрэг хүлээдэг.⁶⁸

Хянан шалгах түр хорооны тайлан

Хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны үр дүн нь улс төрийн үр дагавартай. Парламент цаашид ямар арга хэмжээ авах талаар шийдсэн эсэхээс үл хамааран хянан шалгах түр хорооны тайлан, дүгнэлт, зөвлөмж олон нийтийн анхаарлыг маш ихээр татаж улс төрийн чухал шийдвэр гаргах моментыг бүрдүүлдэг. “Хянан шалгах түр хороо нь өөрийн тайландаа дүгнэлт, зөвлөмжөө тусгах, парламентын нэгдсэн хуралдаанд тайлангаа танилцуулж хэлэлцүүлэх, олон нийтэд зориулан хэвлэн нийтлэх боломжтой байх хэрэгтэй.”⁶⁹ Хянан шалгах түр хороо нь цуглуулсан нотлох баримтад үндэслэсэн тайлан гаргаж нэгдсэн хуралдаанд хүргүүлэхээр Австри (Парламентын хянан шалгах хорооны үйл ажиллагааны дэгийн 26.1, 26.3), Эстон (Парламентын дэгийн 23¹), Польш (Сэймийн мөрдөн шалгах хорооны тухай хуулийн 136g.1), ХБНГУ (Бундестагийн Хянан шалгах түр хорооны тухай хуулийн 33(1))-д зохицуулсан.

Хянан шалгах түр хорооны шалгалтын дүнд цөөнхийн тайлан гаргахын зөвшөөрөх хэрэгтэй гэж Венецийн комисс зөвлөсөн.⁷⁰ Уг судалгаанд Австри, Финланд, Итали, Норвеги, Швед, Швейцарт цөөнхийн тайлан гаргах нь түгээмэл гэдгийг дурджээ. ХБНГУ-д цөөнх болсон гишүүд тусгай саналаа бичиж тайланд хавсаргах эрхтэй (Бундестагийн Хянан шалгах түр хорооны тухай хуулийн 33(2)).

Хянан шалгах түр хороог үл хүндэтгэвэл хүлээлгэх шийтгэл

Европын холбооны 17 парламентын танхимд хийсэн судалгааны дагуу харвал 17 танхимын 11-д нь бичиг баримт гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзах, 12-т нь мэдүүлэг өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзах, худал нотлох баримт өгөх, 10-т нь хувь хүнийг хахуульдах хэрэгт захиргааны эсхүл эрүүгийн шийтгэл оногдуулдаг.⁷¹

⁶⁷ Amicus Curiae Brief in the case of *Rywin v. Poland* (Applications Nos 6091/06, 4047/07, 4070/07) pending before the European Court Of Human Rights (On Parliamentary Committees Of Inquiry) Adopted by the Venice Commission at its 98th plenary session (Venice, 21-22 March 2014), Study No. 759 / 2014, CDL-AD(2014)013, §12.

⁶⁸ Wilhelm Lehmann, “Parliamentary Committees Of Inquiry In National Systems: A Comparative Survey Of EU Member States” (European Parliament, 2010), 6.

⁶⁹ “Parameters On The Relationship Between The Parliamentary Majority And The Opposition In A Democracy: A Checklist,” Adopted by the Venice Commission at its 119th Plenary Session (Venice, 21-22 June 2019), Opinion No. 845/2016, CDL-AD(2019)015, §137.

⁷⁰ Мөн тэнд, §138.

⁷¹ Diane Fromage, *The European Parliament’s Right of Inquiry in Context: A comparison of the national and European legal frameworks* (European Union, 2020), 38.

Хянан шалгах түр хорооны өмнө ирж гэрчийн мэдүүлэг өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзвал шийтгэл хүлээлгэдэг. Энэ тохиолдолд хэн ямар шийтгэл хүлээлгэх нь улс бүрт харилцан адилгүй. Грект хянан шалгах түр хорооны дарга нь албадан ирүүлэх шийдвэр гаргадаг, Ирландад хянан шалгах түр хорооны дуудсанаар ирээгүй бол албадан ирүүлэхээр Дээд шүүхэд ханддаг, Нидерландад хорооны өмнө ирэхээс татгалзсан эсхүл санаатайгаар оролцоогүй бол хорих ялаар шийтгэдэг.⁷² Францад энэ үүргээ биелүүлээгүй бол торгодог. Австрид Хянан шалгах хороонд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирж мэдүүлэг өгөөгүй бол тус хороо нь тухайн этгээдэд торгууль ногдуулах тухай хүсэлтийг захиргааны хэргийн шүүхэд гаргадаг (Парламентын хянан шалгах хорооны үйл ажиллагааны дэгийн 3.3). Бельгид ийм үйлдлийг хорих эсхүл торгох ялаар шийтгэдэг.⁷³

Хянан шалгах түр хорооны өмнө ирж мэдүүлэг өгөөгүй эсхүл баримт бичиг гаргаж өгөөгүй бол Францад 2 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл 7,500 еврогоор торгох ял, Германд 10,000 хүртэл еврогоор торгох эсхүл баривчлах ялаар шийтгэдэг байна.⁷⁴ ХБНГУ, Чех, Эстон, Латви улсуудад энэ талаар нарийвчилсан зохицуулалт үйлчилдэг. Эдгээр улсуудын эрх зүйн зохицуулалтыг товч танилцуулъя.

ХБНГУ-д зохих ёсоор гэрчээр дуудагдсан этгээд хүрэлцэн ирээгүй бол хянан шалгах түр хороо түүний ирээгүйтэй холбоотой гарсан зардлыг төлүүлж, 10,000 евро хүртэл хэмжээтэй захиргааны торгууль оногдуулж, түүнийг албадан авч ирэхийг даалгаж болно (Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 21(1)). Дахин хүрэлцэн ирээгүй тохиолдолд захиргааны шийтгэлийг дахин оногдуулна. Мөн, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр мэдүүлэг өгөхөөс татгалзвал хянан шалгах түр хороо нь татгалзлаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлж 10,000 евро хүртэл захиргааны шийтгэл оногдуулж болдог (Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 27(1)). Энэ нөхцөлд хянан шалгах түр хорооны эсхүл түүний гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн гаргасан хүсэлтээр Холбооны дээд шүүхийн мөрдөн шалгах ажиллагааны шүүгч нь гэрчийг албадан мэдүүлэг өгүүлэх зорилгоор баривчлах захирамж гаргаж болох бөгөөд ийнхүү баривчлах хугацаа нь хянан шалгах ажиллагааны хугацаанаас эсхүл 6 сараас хэтэрч болохгүй (Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 27(2)).

ХБНГУ-д Хянан шалгах түр хорооноос томилсон шинжээч нь дүгнэлт гаргах хугацааг тохиролцох талаар хэлэлцэхээс зайлсхийсэн, тогтоосон хугацаанд дүгнэлт гаргаж өгөөгүй, дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, эсхүл дүгнэлтийн талаар тайлбар, мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан бол тус хороо 10,000 евро хүртэл хэмжээгээр торгох шийтгэл оногдуулдаг.

ХБНГУ-д Хянан шалгах түр хорооноос шаардсан мэдээлэл, нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гаргаж өгөөгүй, ирүүлээгүй тохиолдолд 10,000 евро хүртэл захиргааны шийтгэл оногдуулж болдог (Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 29(2)). Энэ нөхцөлд хянан шалгах түр хорооны эсхүл түүний гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн гаргасан хүсэлтээр Холбооны дээд шүүхийн мөрдөн шалгах ажиллагааны шүүгч нь нотлох баримтыг албадан гаргуулах зорилгоор тухайн этгээдийг баривчлах захирамж гаргаж болох бөгөөд ийнхүү баривчлах хугацаа нь хянан шалгах ажиллагааны хугацаанаас эсхүл 6 сараас хэтэрч болохгүй (Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 29(2)). Хэрэв тухайн этгээд нотлох баримтыг сайн дураараа гаргаж өгөхгүй бол хянан шалгах түр хорооны эсхүл түүний гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн гаргасан хүсэлтээр Холбооны дээд шүүхийн мөрдөн шалгах ажиллагааны шүүгч нь тухайн зүйлийг хураан авч хянан шалгах түр хороонд өгөх захирамж гаргаж болно (Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 29(3)). Мөн, эрж буй зүйл байгаа гэх баримт буй тохиолдолд тухайн газарт

⁷² Wilhelm Lehmann, "Parliamentary Committees Of Inquiry In National Systems: A Comparative Survey Of EU Member States" (European Parliament, 2010), 5.

⁷³ Diane Fromage, *The European Parliament's Right of Inquiry in Context: A comparison of the national and European legal frameworks* (European Union, 2020), 38.

⁷⁴ Eva-Maria Poptcheva, "Parliament's Investigative Powers: Committees Of Inquiry And Special Committees," *Briefing* (European Parliament, February 2015), 9-10.

нэгжлэг хийх захирамжийг мөрдөн шалгах ажиллагааны шүүгч гаргаж болдог бөгөөд энэ тохиолдолд Эрүүгийн процедурын хуулийн холбогдох заалт хэрэглэгддэг.

Чехэд гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүний үйл ажиллагааны талаарх хянан шалгах хороонд мэдүүлэг өгөхөөс татгалзах эрхтэй, мөн мэдүүлэг өгвөл өөрөө эсхүл гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн нь эрүүгийн хэрэгт буруутгах үр дагавар үүсгэх боломжтой бол мэдүүлэг өгөхөөс татгалзахыг зөвшөөрдөг (Хянан шалгах хорооны дэгийн 15(1),(2)). Ийнхүү татгалзан гарахгүйгээр гэрч хүрэлцэн ирээгүй бол түүнийг авч ирж болдог бөгөөд шаардлагатай тохиолдолд хороо нь тухайн гэрчийг авч ирэх хүсэлтийг цагдаагийн байгууллагад тавьдаг.

Эстонид хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хорооны өмнө хүрэлцэн ирээгүй, мэдээлэл, бичиг баримтыг гаргаж өгөөгүй, мэдээлэл өгөх эсхүл асуултад хариулахаас татгалзсан бол 300 нэгж хүртэл хэмжээгээр торгох шийтгэлтэй (Парламентын дэг болон дотоод үйл ажиллагааны тухай хуулийн 23). Эдгээр зөрчилд Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуулийг хэрэглэдэг бөгөөд шүүх уг зөрчилд шийтгэл оногдуулдаг.

Латвид гэрч хянан шалгах түр хорооны өмнө ирээгүй бол уг хорооны хүсэлтээр шүүх албадан ирүүлэхээр шийдвэрлэдэг. Мөн, шаардсан мэдээллийг гаргаж өгөөгүй этгээд нэг жилийн дотор ийм зөрчил дахин гаргасан бол баривчлах, нийтэд тустай ажил хийлгэх, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30 дахин нэмэгдүүлснээс илүүгүй хэмжээгээр торгох шийтгэл оногдуулдаг (Эрүүгийн хуулийн 272 (1)). Хянан шалгах хороо болон төрийн бусад байгууллагад санаатайгаар худал мэдээлэл гаргаж өгсөн бол 2 жил хүртэл хугацаагаар хорих, нийтэд тустай ажил хийлгэх эсхүл хөдөлмөрийн хөлсний хэмжээг 50 дахин нэмэгдүүлснээс илүүгүйгээр торгох шийтгэл оногдуулдаг (Эрүүгийн хуулийн 272 (1)).

Хянан шалгах хороонд хуурамч нотлох баримт өгвөл парламент биш, харин шүүх шийтгэл хүлээлгэх эсэхийг шийдвэрлэдэг. Жишээлбэл, Австрид хуурамч нотлох баримт өгвөл гурав хүртэл жилээр хорих ялаар шүүх шийтгэх боломжтой бол Бельгид хорих болон сонгох эрхийг хасах ялаар шийтгэдэг.⁷⁵ Хянан шалгах хороонд худал мэдүүлэг өгвөл эрүүгийн ял оногдуулдаг. Жишээлбэл, ийм гэмт хэрэгт Латвид 2 жил хүртэл хорих, нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 50 дахин нэмэгдүүлэх хүртэл хэмжээгээр торгох, Люксенбургт 2 сараас 3 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэдэг байна.⁷⁶ Хянан шалгах хорооны үйл ажиллагаатай холбоотой хахууль өгсөн бол мөн л шийтгэдэг ажээ.

Хянан шалгах түр хороо ба эрүүгийн процесс

Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаа нь улс төрийн шинжтэй бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх чиг үүргээс зарчмын ялгаатай. Эрүүгийн хэрэгт яллах нь прокурорын, гэм буруутайд тооцох нь шүүхийн Үндсэн хуулиар тогтоосон чиг үүрэг тул түр хороо хянан шалгалтынхаа явцад эрүүгийн хэрэгт яллах, буруутгах, хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэхгүй бөгөөд ийм үнэлгээ хийж зарлахыг цээрлэх хэрэгтэй.

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах түр хороо ажиллаж байхад үүнтэй зэрэгцэн эрүүгийн, захиргааны зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж болно. Энэ талаар Венецийн комисс ингэж дүгнэжээ:

Улс төрийн “скандал”-ийн мөн чанар нь параллель процессыг эхлүүлж, парламентын хянан шалгалтад буй хэрэгт нэгэн зэрэг захиргааны болон хууль зүйн мөрдөн шалгах, хянан шалгах ажиллагаа явагдаж болно. Үүнд ер бусын эсхүл хууль бус зүйл юу ч байхгүй. Харин парламентын (улс төрийн) хянан шалгалт болон шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа,

⁷⁵ Diane Fromage, *The European Parliament's Right of Inquiry in Context: A comparison of the national and European legal frameworks* (European Union, 2020), 38.

⁷⁶ Eva-Maria Poptcheva, “Parliament's Investigative Powers: Committees Of Inquiry And Special Committees,” *Briefing* (European Parliament, February 2015), 10.

эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааны зохистой заагийг баримтлах нэмэлт хариуцлагыг талуудад өгч буй хэрэг.⁷⁷

Мөн, түр хорооны мөрдөн шалгах ажиллагааны явцад гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй илрэх нь тус хорооны үйл ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй гэж Венецийн комисс үздэг. Хянан шалгах түр хороо нь тухайн хэргийн талаарх өөрийн мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэн явуулж түүний үйл баримт эрүүгийн хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой эсэхээс үл хамааран тэдгээр үйл баримтад өөрийн (улс төрийн) үнэлгээгээ өгөх хэрэгтэй, харин энэ хоёр процесс (эрүүгийн процедур болон хянан шалгах түр хорооны улс төрийн процедур) тусдаа байх шаардлагатай.⁷⁸

Европын холбооны улсуудын олонх (Австри, Бельги, Чех, Эстон, Финланд, Герман, Итали, Латви, Польш, Португали, Словени, Испани)-д хянан шалгах түр хороог байгуулсны дараа хууль зүйн мөрдөн шалгах ажиллагаа эхэлсэн ч гэсэн тус хорооны мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэн явуулахыг илэрхий зөвшөөрдөг талаар энэ талын дагнасан судалгаанд бичжээ.⁷⁹ Жишээлбэл, Франц, Чехд мөрдөн шалгах ажиллагааны явцад илэрсэн үйл баримт нь гэмт хэрэг үйлдэгдсэн байж болзошгүй байдлыг илэрхийлж байвал хянан шалгах хороо зохих хууль сахиулах байгууллагад мэдэгддэг гэдгийг уг судалгаанд дурджээ.

Хянан шалгах түр хорооны шийдвэрийг шүүх хянан үзэхгүй бөгөөд харин тухайн хянан шалгах сонсголын үед олж авсан үйл баримтыг шүүх, прокурор нотлох баримтын хэмжээнд үнэлэх эсэх нь нээлттэй. Тухайлбал, ХБНГУ-ын Үндсэн хуулийн 44 (3)-т “Хянан шалгах хорооны шийдвэрийг шүүхээр хэлэлцүүлж үл болно. Шүүх нь тус хорооны хянан шалгалтын хүрээнд цугларсан баримтыг үнэлэх, өөртөө авах эрхтэй” гэж заасан.

III. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ: ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО

2019.11.14-нд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 28.2-т заасан хянан шалгах түр хорооны заалтыг батлахдаа УИХ-ын зүгээс баримталсан үзэл баримтлал юу вэ гэдгийг “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын 2020.01.09-ний 02-р тогтоол, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан болон Төрийн байгуулалтын хуралдааны тэмдэглэл, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсгийн тайлбар,⁸⁰ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг (цаашид “Эрдэмтэн, судлаачдын ажлын дэд хэсэг” гэх)-ийн бичгээр өгсөн санал,⁸¹ хувь судлаачдын бүтээл зэрэг эх сурвалжид үндэслэн танилцуулъя. Эрдэмтэн, судлаачдын ажлын дэд хэсгийн санал, түүний үндэслэл нь УИХ-ын нэр бүхий 62 гишүүний 2019.06.06-нд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд

⁷⁷ Amicus Curiae Brief in the case of *Rywin v. Poland* (Applications Nos 6091/06, 4047/07, 4070/07) pending before the European Court Of Human Rights (On Parliamentary Committees Of Inquiry) Adopted by the Venice Commission at its 98th plenary session (Venice, 21-22 March 2014), Study No. 759 / 2014, CDL-AD(2014)013, §20.

⁷⁸ “Parameters On The Relationship Between The Parliamentary Majority And The Opposition In A Democracy: A Checklist,” Adopted by the Venice Commission at its 119th Plenary Session (Venice, 21-22 June 2019), Opinion No. 845/2016, CDL-AD(2019)015, §136.

⁷⁹ Diane Fromage, *The European Parliament's Right of Inquiry in Context: A comparison of the national and European legal frameworks* (European Union, 2020), 36.

⁸⁰ Л.Өлзийсайхан, Ц.Болормаа, Ц.Товуусүрэн, Ш.Хишигсүрэн нар дараах тайлбарыг бичиж, УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан Ерөнхий редактороор ажилласан: *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар* (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг, 2017), 53.

⁸¹ Эрдэмтэн, судлаачдын ажлын дэд хэсгийг ахлагчаар Л.Өлзийсайхан, нарийн бичгийн даргаар О.Мөнхсайхан, гишүүнээр П.Амаржаргал, А.Бямбажаргал, Д.Гангабаатар, Б.Гүнбилэг, О.Машбат, Х.Тэмүүжин, Д.Сүнжид, Ц.Цогт, С.Энхцэцэг ажиллаж дараах саналыг Ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн. *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах санал, түүний үндэслэл* (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг, 2019.03.05), 43-48.

оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбарт орж хэвлэгдсэн.⁸² Тодруулбал, хянан шалгах түр хороо байгуулах боломжийг Үндсэн хуульд тусгасан шалтгааныг тодорхойлох; Үндсэн хуулийн үзэл баримтлал болон олон улсын сайн туршлагад үндэслэн хянан шалгах түр хорооны талаар хуульчлах; УИХ-ын эрх хэмжээний хүрээнд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг тодорхой хугацаанд хянан шалгах; хянан шалгах түр хороо байгуулах босгыг тогтоох; цөөнхийн эрхийн баталгаа ба бодит оролцоог хангах; мөрдөн шалгах бүрэн эрхийг эдлүүлэх; нийтийн сонсголыг зохион байгуулах; хянан шалгах түр хорооны тайланг гаргах; хянан шалгах түр хороог үл хүндэтгэвэл шийтгэл хүлээлгэх; хянан шалгах түр хороо ба эрүүгийн процессын зааг ялгааг гаргах гэсэн арван асуудлыг өгүүлийн энэ бүлэгт авч үзнэ.

Хянан шалгах түр хороо байгуулах боломжийг Үндсэн хуульд тусгасан шалтгаан

Засгийн газрыг тогтвортой, үр нөлөөтэй болгох, УИХ-аас харьцангуй бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн чухал зорилгуудын нэг байсан. Тодруулбал, Засгийн газрыг тогтвортой ажиллуулахын тулд Засгийн газрыг дөрвөн янзаар огцруулж болохоор байсныг нэг болгож цөөлж Ерөнхий сайдыг УИХ-ын чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхоор бус, харин нийт гишүүний олонхоор огцруулах эсэхийг шийдвэрлэдэг болсон (Үндсэн хуулийн 44.1). Түүнчлэн, Ерөнхий сайд хариуцлагаа бүрэн хүлээдэг болохын тулд Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх эрхийг түүнд олгосон (Үндсэн хуулийн 39.4). Мөн, УИХ “Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно” (Үндсэн хуулийн 25.1.7).

Гүйцэтгэх эрх мэдлийг бэхжүүлэх заалтуудын нөгөө талд Засгийн газрыг хянах УИХ-ын хяналтын тогтолцоог бэхжүүлж хяналт, тэнцвэрийг хангах зайлшгүй шаардлага үүссэн. Энэ талаар УИХ-ын гишүүн С.Бямбацогт “Засгийн газарт, гүйцэтгэх засаглалд ажлаа хийх боломжийг нь олгож байгаа юм чинь нөгөө талаасаа хяналт тавих эрхээ тодорхой нэмж авъя”⁸³ гэж хэлсэн. Мөн, УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан: “Ерөнхий сайд нь өөрөө танхимаа бүрдүүлээд, Улсын Их Хурлын өмнө хариуцлагаа хүлээгээд, хууль биелүүлэх ажлыг зохион байгуулах энэ эрхийг нь хариуцлагатай нь хамт өөрт нь үүрүүлж байна. Энэ нь парламентаас тавих хяналтыг бол хянан шалгах түр хороо парламентын хяналт, шалгалт давхар дээлийг тайлж гишүүд нь эндээ гол нь хууль тогтоох хянан шалгах ажиллагаан дээрээ хүндийн төвийг өгч байгаа үед бол тэр Засгийн газар бол хяналтаас гарчих юм бол байхгүй.”⁸⁴ Ажлын дэд хэсгийн гишүүн О.Мөнхсайхан: “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслөөр бол одоо тарамдсан гүйцэтгэх эрх мэдлийг нэг толгойтой болгох, хариуцлагыг нь үүрүүлэх, бэхжүүлэх. Ингэснээрээ нийгэм, эдийн засгийн асуудлыг шийддэг төртэй болох агуулга орж ирж байгаа. Энэтэй зэрэгцээд гүйцэтгэх эрх мэдэл дээр тавигдах хяналтыг сайжруулах тав, зургаан зохицуулалт энэ төсөлд орж ирсний нэг нь хянан шалгах түр хороо. Парламентын тогтолцоотой улсад бол парламент дэх олонх бол шийдвэрээ гаргана, бодлогоо тодорхойлно, хариуцлагаа хүлээнэ. Гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналтыг цөөнх хэрэгжүүлдэг ийм зарчим үйлчилдэг.”⁸⁵ Иймээс, хянан шалгах түр хорооны үндсэн зорилго бол засгийн газар болон захиргаанд тавих хяналтыг сайжруулах явдал юм.

Монгол Улсад гүйцэтгэх эрх мэдэлд тавих парламентын хяналт дараах хэлбэрээр хэрэгжиж ирсэн: УИХ-ын гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнд асуулга тавих; УИХ-ын гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнд асуулт тавих; Засгийн газрын тайлан, мэдээлэл, илтгэл сонсох (Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэх; Ерөнхий сайдын мэдээллийг

⁸² Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар, Албан ажлын хэрэгцээнд (Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, 2019), 64-68.

⁸³ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 32.

⁸⁴ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 9 дүгээр сарын 05-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 88.

⁸⁵ Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 14-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 32, 82-84.

сонсож, УИХ дахь цөөнхийн гишүүдээс амаар асуулт тавьж хариулт авах зэргээр); Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг хэлэлцэх; УИХ-ын Байнгын, дэд, түр хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг гишүүд, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор байгуулан ажиллуулах; иргэн, байгууллагаас өргөдөл хүлээн авах, судлах, шийдвэрлэх, шаардлагатай бол хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах (Байнгын хороо);⁸⁶ нийтийн сонсгол зохион байгуулах; Хүний эрхийн үндэсний комисс, Үндэсний аудитын газар зэрэг бие даасан байгууллагуудын тайлан, мэдээлэл, илтгэл сонсох; бусад.

УИХ-ын хянан шалгалтыг хэрэгжүүлэх хэлбэрүүд хэрэгжиж, зарим талаар нийтийн сонсгол зэргээр баяжиж хөгжиж ирсэн ч төдийлөн үр нөлөөгүй гэсэн судалгааны дүгнэлтүүд хийгдсэн. Жишээлбэл, судлаач Х.Номингэрэл Монгол Улсын хувьд “[парламентын] хяналтын талаарх ойлголт, чадавх сул..., мэдээ тайлан сонсох, гишүүдэд асуулт тавихаас өөр тогтмол механизм байхгүй, хяналтын ажлын хэсгийн үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалт байхгүй, парламентын хяналт шалгалтын явцад Улсын Их Хурлаас дуудсанаар хүрэлцэн ирэх, үнэн зөв мэдээлэл өгөх үүргийг хуульчлаад [байгаа ч] тус үүргийг биелүүлээгүй тохиолдолд хэрхэх хариуцлага тодорхойгүй” гэжээ.⁸⁷ Мөн, УИХ-ын нэр бүхий 62 гишүүнээс 2019.06.06-нд өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд “Улсын Их Хурал хяналт шалгалтын бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын мэдээлэл сонсох, гишүүдэд асуулга тавих, богино хугацаанд Засгийн газрын тайланг ерөнхий байдлаар хэлэлцэхээс өөрөөр гүйцэтгэх эрх мэдэлд хяналт тавих үр нөлөөтэй арга хэрэгсэл үгүйлэгдэж байна” гээд УИХ-ын хяналт шалгалтыг илүү сайжруулах зохицуулалтыг Үндсэн хуульд тусгах хэрэгтэй гэж дүгнэсэн.

Засгийн газарт тавих УИХ-ын хяналтын үр нөлөө муутай байсан нь парламентын мөрдөн шалгах эрх мэдлийг хэрэгжүүлдэггүйгээс үнэн, бодит мэдээлэл олж авах боломж хязгаарлагдмал байсантай холбоотой байсан. “Монгол Улсад хуулийн хэрэгжилт хангалтгүй, Засгийн газар УИХ-ын бодит хяналтаас гадуур байх нөхцөл үүссэний нэг том шалтгаан нь УИХ мөрдөн шалгах эрхгүй байгаад оршиж байна” гэж судлаач Ж.Сайнхишиг 2015 онд дүгнэж байжээ.⁸⁸ Учир нь, тодорхой асуудлыг шалгах чиг үүрэгтэй байгуулагдсан ажлын хэсэг эсхүл түр хороо нь нээлттэй сонсголоор хууль сануулж мэдүүлэг, тайлбар авах, шинжээч томилох, нотлох баримт, мэдээлэл гаргуулах бүрэн эрхгүй, эдгээртэй холбоотой үүргээ зөрчвөл хүлээлгэх хариуцлага тодорхойгүй явж ирсэн. Монголд дэлхийн жишигт нийцсэн парламентын мөрдөн шалгалтаас татгалзаж, түүний оронд ямар ч эрх мэдэлгүй “ажлын хэсэг” гаргадаг нь нэлээн хэмжээгээр оромдсон байдалд хүргэсэн ажгуу гэж Үндсэн хуулийн эх баригч Б.Чимид багш шүүмжилсэн. Тэрээр парламентын мөрдөн шалгалтыг “Ёс нь гажсаныг эрслэн засаж гэмтэнд хариуцлага тооцоход тохирсон нэлээд үр дүнтэй хэлбэр”-т тооцож түүнийг хэрэглэх, нэвтрүүлэх саналыг дэвшүүлж байжээ.⁸⁹ Иймд, мөрдөн шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг хянан шалгах түр хороог байгуулах боломжийг Үндсэн хуульд 2019 онд заасан. УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцангийн хэлснээр “Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааг ...сайжруулах үүднээс энэ хороо бол байгуулах нь зүйтэй.”⁹⁰ УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргилын хэлснээр УИХ-ын хувьд хуулийн хэрэгжилтэд

⁸⁶ 2012.08.01-нд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19.3, 20.4, 39.1.11-д нэмэлт, өөрчлөлт оруулж Өргөдлийн байнгын хороог байгуулан ажиллуулсан. 2021 оны Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар өргөдлийн байнгын хороог татан буулгасан ч уг хуулийн 23.2-оор өргөдлийг судлах, шаардлагатай бол хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал боловсруулах нийтлэг бүрэн эрхийг Байнгын хороо бүрт өгсөн.

⁸⁷ Х.Номингэрэл, “Парламентын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх механизм, бусад орнуудын жишиг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын чиг үүргийг боловсронгуй болгох асуудал,” *Байнгын ажиллагаатай парламент 25 жил*, Эрдэм шинжилгээний хурал, 2015.09.15, 27-28.

⁸⁸ Ж.Сайнхишиг, “Улсын Их Хуралд мөрдөн шалгах эрх хэрэгтэй юу?,” *Шүүх эрх мэдэл: мэдээлэл, арга зүйн улирал тутмын эмхэтгэл*, 2015 №4 (Шүүхийн ерөнхий зөвлөл) 124.

⁸⁹ Б.Чимид, *Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал*, Нэгдүгээр дэвтэр (УБ, 2008), 93; Б.Чимид, “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх нь /Цаас үйлдвэрлэж мөнгө тараахаас цааш юу харагдана вэ?/,” *Хууль дээдлэх ёс*, 2010, №2(29), 14, 17.

⁹⁰ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 8 дугаар сарын 23-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл, 49-50.

хяналт тавих, энэ зорилгоор хянан шалгах түр хороо байгуулах нь хууль батлахтай адил хангалттай чухал ажил юм.⁹¹

Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хариуцлагыг дээшлүүлэхийн тулд хянан шалгах түр хороог байгуулах боломжийг Үндсэн хуулиар олгосон. УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан: “энэ нэмэлт, өөрчлөлтийн улаан шугам бол эцсийн эцэст бүх шатанд хариуцлагыг л дээш болгоё. Тухайлбал төсөв батлахдаа хариуцлагатай болъё. Төсвийн зарцуулалтад төрийн санхүү, төсвийн зарцуулалтад хараат бусаар хяналтыг хэрэгжүүлдэг болъё. Нийтийн эрх ашгийг хөндсөн том том асуудлууд байна. Энүүгээр цөөнхийн ¼ нь асуулт санал тавих юм бол хянан шалгах түр хороог бол байгуулдаг байя. Энэ нь бол бас дотроо нэлээд эрх мэдэлтэй байя. Гэхдээ Мөрдөн байцаах болон шүүх, ажиллагаанд шууд хутгалдаж болохгүй гэдэг зааг ялгаануудыг бол энд зааж өгсөн.”⁹² Хянан шалгах түр хороо нь засгийн газар болон захиргааны ил тод, үр нөлөөтэй, хариуцлагатай байдлыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг төдийгүй парламентын өөрийнх нь хууль тогтоох, төсөв батлах ажилд шаардлагатай мэдээллээр хангаж, баталсан хууль тогтоомж нь чиг үүргээ биелүүлж буй эсэхэд хяналт тавьж өгдөг.⁹³

Хянан шалгах түр хороо нь нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг хангахад тустай. 2020.01.09-ний 02-р тогтоолын 1.3.4-т хянан шалгах түр хороог “иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэх зорилгоор байгуулах”-аар заасан. Иймээс, хянан шалгах түр хороог байгуулах нь гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох хөшүүрэг мөн. УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан: “Засгийн үйл ажиллагаа бол голцуу хаалттай хаалганы цаана яригддаг. Ийм учраас зарим асуудал одоо ужгираад улс нийгмийн эрх ашигт хохиролтой асуудлууд гараад явахыг үгүйсгэх арга байхгүй. Мөн одоо ноцтой ноцтой асуудлууд их яригддаг. Тийм ээ. Ийм үед одоо ийм хороог бол цөөнхөөс нь санаачлаад албан ёсоор байгуулна шүү гэдгийг Үндсэн хуульд хуульчилж өгч байгаагаараа ач холбогдолтой.”⁹⁴ Мөн тэрээр өөрийн номдоо “Парламентын байцаан шинжлэх эрх нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас явуулж байгаа үйл ажиллагаатай холбоотой бүх асуудлаар парламент бүрэн мэдээлэл авсан байх ёстой гэдэг зарчмаар урган гардаг” гэж бичжээ.⁹⁵ Ажлын дэд хэсгийн гишүүн О.Мөнхсайхан: “Энэ цөөнхийн хяналтын нэг механизм бол энэ хянан шалгах түр хороо. Яагаад гэхээр парламентын олонхын итгэлийг аваад гарч ирэн ажиллаж байгаа Засгийн газар маань янз бүрийн хууль бус, эсвэл олон нийтийн итгэлийг эвдсэн ийм зүйлүүд гаргасан тохиолдолд яах вэ гэхээр тэр мэдээллээ бол олон нийтэд өгдөггүй, гишүүдэд өгдөггүй. Тэр асуудал үүссэнтэй холбоотой маш их цуурхал бодитой биш мэдээлэл явдаг. Тэгэхээр ...гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага яг хуулийн биелэлтийг хангаж чадаж байна уу, үгүй юу гэдэгтэй холбоотой тодорхой асуудлаар бодитой дүгнэлт гаргаж тавих ийм чиг үүрэгтэй хороо байгаа юм.”⁹⁶

Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 28.2-ыг “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна. Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж өөрчлөн найруулах санал 2019.08.30-ны өдрийн нэгдсэн

⁹¹ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 122.

⁹² Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 6 дугаар сарын 13-ны өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл, 16.

⁹³ Amicus Curiae Brief in the case of *Rywin v. Poland* (Applications Nos 6091/06, 4047/07, 4070/07) pending before The European Court Of Human Rights (On Parliamentary Committees Of Inquiry) Adopted by the Venice Commission at its 98th plenary session (Venice, 21-22 March 2014), Study No. 759 / 2014, CDL-AD(2014)013, 3.

⁹⁴ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 8 дугаар сарын 23-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл, 49-50.

⁹⁵ Д.Лүндээжанцан, *Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт*, Хоёр дахь хэвлэл (УБ, 2014), 162.

⁹⁶ Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 14-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 82-84.

хуралдаанаар дэмжигдэж,⁹⁷ улмаар бусад нэмэлт, өөрчлөлтийн заалтын хамт 2019.11.14-нд эцэслэн батлагдсан.

Үндсэн хуулийн үзэл баримтлал болон олон улсын сайн туршлагад үндэслэн хянан шалгах түр хорооны талаар хуульчлах

Үндсэн хуульд УИХ хянан шалгах чиг үүрэгтэй байнгын хороотой байх заалт байхгүй, харин хянан шалгах хороо нь өөрөө түр хороо байна гэсэн агуулга бий. Ажлын дэд хэсгийн гишүүн О.Мөнхсайхан: “[хянан шалгах түр хороо] бол одоо байнгын ажиллаад байхгүй. Германд бол нэг парламентын бүрэн эрхийн хугацаанд нэгээс хоёр удаа ийм хороо байгуулагддаг гэж байгаа. Нэлээн онцгой нөхцөлд.”⁹⁸ Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг 2017-2019 онд хэлэлцүүлэх явцад мөрдөн шалгах бүрэн эрхтэй хороо хороо нь “түр хороо” байхаар бичигдэж хэлэлцэгдсэн. Учир нь:

Парламентын байнгын хороогоор дамжуулан парламент мөрдөн шалгах эрх мэдлээ хэрэгжүүлэх нь тухайн хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилд автах, авлига, хээл хахуульд холбогдох замаар мөрдөн шалгах ажиллагааг мушгин гуйвуулах, үр нөлөөг нь багасгах, нэг талыг барих зэрэг эрсдэлтэй гэж үздэг. Харин тухайн асуудлаар ашиг сонирхлын зөрчилгүй, төвийг сахисан бүрэлдэхүүн бүхий түр хороо байгуулах замаар мөрдөн шалгалтыг явуулах нь илүү үр дүнтэй байдаг гэж үздэг тул дийлэнх улсын Үндсэн хуульд түр хороо байгуулах эрх зүйн үндсийг тогтоосон байдаг.⁹⁹

Хянан шалгах түр хороо нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан институт. УИХ өөрийн эрх хэмжээний хүрээнд байнгын, түр, дэд хороодыг хуулиар байгуулж, өөрчилж, татан буулгаж болно. Гэвч, Үндсэн хуулийн 28.2-т хянан шалгах түр хороо байгуулж болохоор заасан учраас түр хороог ийнхүү байгуулах боломжийг хаавал эсхүл хаах хууль баталбал Үндсэн хуулийн зөрчил болно.

Үндсэн хуульд парламентын хяналтын хүчтэй хэрэгсэл болох хянан шалгах түр хорооны зохицуулалтыг оруулснаар тухайн харилцааг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлага үүссэн. Учир нь, 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 28.2-т “Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж заасан. Иймд, УИХ-ын бусад хороодын нэгэн адил хянан шалгах түр хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар эсхүл бусад хуулиар тогтооно.

Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үеэр хянан шалгах түр хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтоохдоо олон улсын сайн туршлага, ялангуяа ХБНГУ-ын загварыг баримжаалах талаар ярилцаж хүлээн зөвшөөрсөн. Тухайлбал, УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан “Дэлхийн 70 гаруй улсад одоо ийм хороо бий,” “олон улсын парламентын холбооноос ийм хороо байгуулах асуудлыг удаа дараа манайд одоо уриалга зөвлөмж ирүүлж байсан”¹⁰⁰ гэж хэлсэн. Ажлын дэд хэсгийн гишүүн О.Мөнхсайхан: “Гүйцэтгэх эрх мэдлийг бэхжүүлж байгаа учраас түүнд тавих хяналтыг сайжруулах. Ингэхдээ цөөнхийн хяналт болох тэр цөөнхийн санаачилгаар бий болдог хянан шалгах түр хороог байгуулах эрх зүйн үндсийг бий болгох, төрийн аудитын томилгоог нь эдийн засгийн болон бүтцийн хувьд нэлээн хараат бус байх тэр суурь зарчмыг Германы Үндсэн хуульд байдагтай жишиг болгож харгалзаж оруулж өгсөн байгаа.”¹⁰¹ Мөн, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар (2017) болон

⁹⁷ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 5.

⁹⁸ Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 14-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 82-84.

⁹⁹ *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар* (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг, 2017), 53.

¹⁰⁰ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 8 дугаар сарын 23-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл, 49-50.

¹⁰¹ Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 14-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 133.

Эрдэмтэн, судлаачдын ажлын дэд хэсгийн санал (2019) нь хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны талаарх саналаа олон улсын сайн туршлагад үндэслэн бичигдсэн.¹⁰²

УИХ-ын эрх хэмжээний хүрээнд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг тодорхой хугацаанд хянан шалгах

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 28.2-т хянан шалгах түр хороог “хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар” байгуулна гэж заасан. УИХ-ын 2020.01.09-ний 2-р тогтоолын 1.3.4-т ийм тодорхой асуудал гэдэгт юу багтах вэ гэдгийг “Засгийн газар, түүний байгууллага, албан тушаалтан хууль зөрчсөн эсэх, эрх мэдлээ урвуулан ашигласан эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан эсэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар” гэж тодотгосон. Үндсэн хуулийн эх баригч Б.Чимид багш УИХ-ын мөрдөн шалгалтад ямар асуудлыг хамруулах боломжтой талаар дараах байдлаар бичсэн байна:

Улсын дотоодод төдийгүй гадаад орчинтой холбоотой улс төрийн “зангуутай” гэмт явдал, засаг төрд аюултай хариуцлагагүйн, байгал-техникийн осол сүйрэл улс орон, засаг төрийн үйл ажиллагааны хүрээнд үе үе үүсч гардаг. Улс гүрэн, нам, холбоо дамнасан эдийн засаг, мөнгө санхүү, улс төр бизнесийн холбогдолтой хуйвалдаан, үндэсний аюулгүй байдалд халгаатай бусармаг далд үйлдэл, хүний аюулгүй байдал, Үндсэн хуульт байгуулалд харшилсан улс төр, шашны харгис урсгал /сект/-уудын далд явуулга гээд эдийн засаг-нийгэм улс төрийн харилцаанд үе үе үүсдэг, учрыг нь олж тунгаахад түвэгтэй, “эзэн тодгүй” ноцтой үйл баримт тохиодог. Олон улсын амьдралын баримтаар үзвэл мөнгө, хөрөнгийн “урхитай” засгийн эрхийн төлөөх хуйвалдаан чухамхүү парламентын хүчирхэг хяналт шалгалт шаарддаг. Төр, нийгмийн зүтгэлтнийг улс төрийн шалтгаанаар хороосон хэргийг ЭБША-ны журмаар мөрдөн тогтоох боломжтой хэдий ч алуурчны ард суугаа эздийн үүр, хуйвалдаан мэтийг нь илрүүлэх, захиалагч гэх улс төрийн хүчнийг олж тогтоох улс дамнасан асуудал ч гардаг. Өнгөрсөн зууны эцсээрх АНУ, Франц, Германы ерөнхийлөгчийн болон парламентын сонгуулийн үед зэвсгийн наймаа, улс төрийн буулт хийх зэргээр гадаад улс орноос хууль бус хандив, харамж сэм авч, нам, сонгуулийн компаниа санхүүжүүлж байсан /“Enron” концерноос хандив авсан Бүгд найрамдахчуудын сан, Г.Колийн хэрэг гэх мэт/ том том хэрэг хуйвалдааныг чухамхүү парламентын мөрдөн шалгалтын оролцоотойгоор илрүүлсэн гэдэг.¹⁰³

“Нийтийн ашиг сонирхол” гэдгийг тодорхойлохдоо нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг ойлгоно гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3.1.1-д заасныг харгалзах боломжтой.

Үндсэн хуулийн 28.2-т нийтийн ашиг сонирхлын тодорхой асуудлаар тухайн заалтад буй нөхцөлийг хангавал хянан шалгах түр хороог тодорхой хугацаагаар байгуулахаар заасан. Хянан шалгах түр хороог байгуулах УИХ-ын тогтоолд уг хороо ажиллах хугацаг зааж өгөх бөгөөд уул хугацаа дуусахаас өмнө сунгах эсхүл адилхан асуудлаар хянан шалгах түр хороог дахин дахин байгуулах боломжтой.

Хянан шалгах түр хороо байгуулах босго

¹⁰² Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг, 2017); Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах санал, түүний үндэслэл (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг, 2019.03.05), 43-48.

¹⁰³ Б.Чимид, “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх нь /Цаас үйлдвэрлэж мөнгө тараахаас цааш юу харагдана вэ?/,” Хууль дээдлэх ёс, 2010, №2(29), 18.

Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх явцад нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн санаачилгаар түр хороог заавал байгуулдаг болох нь хамгийн боломжит хувилбар гэж үзсэн. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 28.2-т заасны дагуу УИХ-ын “нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал” УИХ уг хороог байгуулж болно гэж бичээгүй, харин “уг хороог байгуулна” гэж үүрэгжүүлсэн учраас 19-ээс доошгүй гишүүний саналаар уг түр хороог заавал байгуулна. Ингэснээр, УИХ-ын хяналтын тогтолцоог ажиллуулах эсэх нь олонхын үзэмжээс хамаарах, уг хяналтын механизм хэрэгжихэд бэрхшээл үүсгэхээс сэргийлж буй хэрэг.

Цөөнх санаачилбал хянан шалгах түр хороог заавал байгуулна гэдэг бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалын нэг. УИХ-ын нэр бүхий 62 гишүүнээс 2019.06.06-нд өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн үзэл баримтлалд “Ингэснээр цөөнх хяналтын түр хороог санаачлан байгуулах боломж нээгдэх болно” гэж тодорхой бичсэн. Мөн, УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан “Энэ хянан шалгах түр хороог бүтнээр нь 28 дугаар зүйлийг хасах санал бас орж ирсэн. Ажлын хэсэг дээр болоод Байнгын хороон дээр манай зарим гишүүд ер нь энэ түр хороог байгуулах нь зүйтэй юм. Яагаад гэвэл Байнгын, Түр, Дэд хороо байгуулна гээд, байгуулж болно гээд угаасаа Үндсэн хуульд байгаа юм. Гэтэл энэ Түр хорооны хувьд бол хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна гээд албан ёсны үүрэгтэй болгож байгаа юм.”¹⁰⁴ Ажлын дэд хэсгийн гишүүн О.Мөнхсайхан: “Герман зэрэг улсуудын жишигт байдгаар парламентын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь санаачилбал заавал байгуулагдана. Өөрөөр хэлбэл цөөнх. Тэгэхдээ нэлээн хүчтэй цөөнх санаачилгаар байгуулагдаад ажиллана.”¹⁰⁵ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг “тодорхой асуудлаар мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулах санаачилгыг цөөнх буюу сөрөг хүчинд олгох нь цөөнхийн үр дүнтэй хяналтаар хөшүүрэгдэн төрийн эрх мэдлийг гартаа авсан улс төрийн хүчнийг зүй зохистой, үр нөлөөтэй, ёс зүйтэй, хууль дээдлэн, хуулийн хүрээнд ажиллуулах, иргэдийн эрх зөрчигдөх явдлыг таслан зогсоох бодит үнэ цэнэтэй”¹⁰⁶ гэж тайлбарлаж хэлэлцүүлэг өрнүүлж байв. Иймээс, УИХ-ын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавивал нэгдсэн хуралдаанаар хянан шалгах түр хороо байгуулах тухай тогтоолыг гаргах үүрэгтэй.

УИХ дахь олонх бас хянан шалгах түр хороог байгуулахыг илүүд үзэж болно. Ялангуяа, өмнөх УИХ-ын үед өөр нам, эвсэл Засгийн газрыг байгуулж байсан бол уг Засгийн газрын үйл ажиллагаа, ялангуяа хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг хянан шалгах зорилгоор түр хороог УИХ дахь олонх байгуулж болно. Олонхын байгуулсан хянан шалгах түр хороо нь одоогийн гэхээс илүү өмнөх засгийн газрын үйл ажиллагаанд илүү төвлөрөх магадлалтай.

Түр хороог байгуулах тухай УИХ-ын тогтоолд уг хороог байгуулах саналд тусгасан асуудлыг хянан шалгахыг даалгах бөгөөд уул саналыг гаргасан гишүүдийн зөвшөөрлөөр асуудлыг өөрчилж болно. Түр хороо байгуулах саналд тусгасан асуудал нь Улсын Их Хурлын эрх хэмжээнээс хальсан бол уул асуудлаас бусад Улсын Их Хурлын эрх хэмжээнд хамаарах асуудлыг хянан шалгахыг даалгана. УИХ-ын эрх хэмжээнд хамаарахгүй хэмээн зарим асуудлыг хассан тогтоол нь Үндсэн хууль зөрчсөн гэж үзвэл УИХ-ын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргаж болохоор зохицуулдаг болох хэрэгтэй. Үндсэн хуулийн 66.1-д Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай асуудлаар

¹⁰⁴ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 8 дугаар сарын 23-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл, 49-50; Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 6 дугаар сарын 13-ны өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл, 12.

¹⁰⁵ Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 14-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 82-84.

¹⁰⁶ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг, 2017), 53.

УИХ “хүсэлт” гаргахаар заасан тул ийм хүсэлт гаргах бүрэн эрхийг УИХ дахь цөөнхөд эдлүүлэх бүрэн боломжтой.¹⁰⁷

Цөөнхийн эрхийн баталгаа ба бодит оролцоо: түр хорооны бүрэлдэхүүн, дарга, илтгэгч гишүүн, бүрэн эрх

Монгол Улс шиг парламент дахь олонхоос засгийн газрыг байгуулдаг парламентын тогтолцоотой улсад олонх засгийн газарт итгэл хүлээлгэж буй нөхцөлд түүнийг хамгаалах хандлагатай байдаг учраас засгийн газарт тавих парламентын хяналт шалгалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд цөөнх шийдвэрлэх үүрэгтэй. Хянан шалгах түр хороо байгуулах замаар мөрдөн шалгалтыг парламентын олонх, цөөнхийн аль нь ч явуулж болох боловч цөөнхийн санаачилга, бодит оролцоог онцолж үздэг. Үндсэн хуулийн эх баригч Б.Чимид багш “мөрдөн шалгалт явуулах эрх нь “цөөнхийн эрх”, сөрөг хүчний эрх гэж үздэг” бөгөөд түр хорооны “бүрэлдэхүүнд оролцох тэгш эрхийг хангах; Мөрдөн шалгах зүйл /ажил хэрэг/-ийг парламент хэр зэрэг нарийн тодорхойлсноос түүний үр нөлөө тэр хэмжээгээр шалтгаална”¹⁰⁸ гэжээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг “мөрдөн шалгах эрхийг Ерөнхийлөгчийн засагтай улс оронд байнгын хороонд, парламентын засагтай улс оронд парламентын цөөнхөд өгөх нь илүү үр дүнтэй” гэж үзсэн.¹⁰⁹ Мөн, Эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг хянан шалгах түр хорооны үйл ажиллагаанд цөөнхийн оролцоо, эрх хэмжээг нэмэгдүүлэхийн ач холбогдлыг дараах байдлаар тайлбарлаж байсан:

Парламентын тогтолцоонд олонх өөрсдийн байгуулсан засгийн газраа хянан шалгах сэдэл харьцангуй бага байдаг бөгөөд цөөнх хууль санаачлах гэхээсээ парламентын хяналтын чиг үүрэгт илүү төвлөрдөг. Иймд парламентын хяналтын механизмуудад цөөнхийн оролцоо, эрх хэмжээг нэмэгдүүлэх нь парламентын хяналт бодитоор үр нөлөөтэй хэрэгжих нөхцөл болж, нөгөө талаар нэгэнт олонх болсон улс төрийн нам, түүний засгийн газраас парламентын автономийг хамгаалах боломж олгодог.¹¹⁰

Иймээс, Үндсэн хуулийн 28.2-т УИХ-ын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь санал тавивал УИХ уг хороог заавал байгуулаад зогсохгүй уг хорооны бүрэлдэхүүнд “цөөнхийн төлөөллийг оролцуулж” гэсэн шаардлагыг тодорхой тавьсан нь цөөнхийн оролцоог хангах гэсэн өргөн агуулгатай.

УИХ түр хороог байгуулахдаа түүний ажиллах чадамж, хянан шалгах асуудлын агуулга, хүрээ, УИХ дахь улс төрийн хүчний тэнцвэрийг харгалзан бүрэлдэхүүний тоог тогтоохоор хуульчлах хэрэгтэй. “Парламент дахь бүх намууд парламент дахь суудлынхаа тоонд хувь тэнцүүлсэн байдлаар оролцдог эсхүл эрх барих ба бусад намуудын төлөөллийг тэнцүү байдлаар бүрдүүлдэг туршлага байх тул парламент дахь олонх цөөнхийн төлөөллийг хувь тэнцүүлэн түр хороог бүрдүүлэх санал”-ыг Эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг гаргаж байсан.¹¹¹ Иймд, үр хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн төлөөллийг хувь тэнцүүлэн эсхүл олонхын болон цөөнхийн төлөөллийг тэнцүү тоогоор оролцуулах бөгөөд цөөнхийн бүлэг бүрийн төлөөлөл, цөөнхийн гишүүдээс

¹⁰⁷ О.Мөнхсайхан, “Иргэний өргөдөл, мэдээлэлтэй холбоотой Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг оновчтой тодорхойлох боломж,” *Монгол Улсын хууль зүйн шинжлэх ухаан: өнөө ба ирээдүй, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл* дотор (МУИС-ийн Хууль зүйн сургууль, 2015), 64-81.

¹⁰⁸ Б.Чимид, “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх нь /Цаас үйлдвэрлэж мөнгө тараахаас цааш юу харагдана вэ?/, *Хууль дээдлэх ёс*, 2010, №2(29), 20, 22.

¹⁰⁹ *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар* (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг, 2017), 53.

¹¹⁰ *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах санал, түүний үндэслэл* (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг, 2019.03.05), 45.

¹¹¹ *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах санал, түүний үндэслэл* (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг, 2019.03.05), 45.

заавал багтаана. Түр хороонд орох гишүүнээ нам, эвслийн бүлэг өөрөө томилж, чөлөөлнө. Хэнийг уг түр хороонд оруулахаа тухайн цөөнх өөрөө шийднэ. Хэрэв хянан шалгах түр хороонд цөөнхөөс хэн орохыг цөөнх биш, УИХ дахь олонх шийдвэл гүйцэтгэх эрх мэдэлд тавих уг хяналт өөрөө үр нөлөөгүй болно. Мөн, цөөнхийн санаачилсан мөрдөн шалгах хорооны чиглэлтэй давхцуулж мөрдөн шалгах хороо байгуулахыг УИХ-д хориглох бөгөөд цөөнхийн санаачилсан хяналтын чиглэл, хязгаар дээр парламентын санаачилга гаргаж чиглэл, сэдэв нэмэх эрхгүй байхаар хуульчлах хэрэгтэй.

Эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсгийн саналд “хороо гишүүдийн олонхоор хүч түрэн мэдээллийг хэт нэг талыг барин цуглуулахгүйн тулд хорооны гишүүдийн ¼-ээр ямар мэдээллийг цуглуулахыг шийдвэрлэх, эсхүл гол улс төрийн хүчнүүд тэнцвэртэй байдлаар шийдвэрлэх боломжтой байдаг”¹¹² гэжээ. Хянан шалгах түр хороо байгуулсны дараа түр хорооны гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь хэнээс мэдүүлэг авах, ямар баримт авах вэ гэдэгтэй холбоотой тодорхой эрх эдлүүлэхгүйгээр цөөнхийн оролцоо бодитой хангагдахгүй. Хянан шалгах түр хороо дахь цөөнхийн гишүүд нь гэрчээс асуулт асуух, баримт бичгийг шинжлэн судлахад олонхын гишүүдтэй тэгш эрх эдлэх бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтны хадгалж буй нотлох баримтыг гаргуулах хүсэлт гаргах боломжтой байх хэрэгтэй. Түр хороо нотлох баримт цуглуулахаас татгалзсан, эсхүл нотлох баримтыг түр хороонд ирүүлээгүй, гаргаж өгөөгүй, мөн түүнчлэн гэрч, шинжээчтэй холбоотой зөрчилд шийтгэл оногдуулаагүй тохиолдолд түр хорооны нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хүсэлт гаргаж уг асуудлыг шийдвэрлүүлэх эрхтэй байхаар хуульчлах хэрэгтэй (ХБНГУ-ын Бундестагийн Хянан шалгах хорооны тухай хуулийн 17 (4)-тай адил агуулгаар).

Хянан шалгах түр хорооны дарга нь цөөнхийн гишүүн байхаар хуульчилбал гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналтыг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хяналт, тэнцлийг хангах боломжтой. Түр хорооны дарга нь хянан шалгалтыг удирдан зохион байгуулж, түр хорооны хуралдааныг даргална. Түр хорооны гишүүд цөөнхийн бүлгийн гишүүд, хэрэв цөөнхийн бүлэг байгуулах гишүүдийн тоо хүрэлцэхгүй бол цөөнхийн гишүүд дотроос түр хорооны даргыг сонгохоор заах нь чухал. Хянан шалгах түр хороог парламентын цөөнхийн гишүүнээр даргалуулдаг Унгарын туршлагыг Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсгийн тайлбарт тусгаж хэлэлцүүлсэн.¹¹³ Түр хорооны дэд дарга нь түр хорооны даргыг орлох бөгөөд түүнийг түр хорооны гишүүд дотроосоо сонгоно. Түр хорооны дарга, дэд дарга нь нэг нам, эвсэлд харьяалагдаж болохгүй. Мөн, хянан шалгах түр хорооны олонх, цөөнхийн тэнцвэртэй оролцоог хангахад илтгэгч гишүүнийг цөөнхөөс томилох, эсхүл олонхын болон цөөнхийн санал болгосон 2 илтгэгч гишүүн томилох хэрэгтэй.

Мөрдөн шалгах бүрэн эрх

Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 28.3-т “Хянан шалгах түр хороо нь холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй түр хороо дүгнэлт гаргаж, шаардлагатай бол тухайн асуудлыг эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлж болно. Түр хорооны дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй. Хорооны хэлэлцсэн баримтыг нотлох баримтад тооцох эсэхийг шүүх шийдвэрлэнэ” гэж түр хорооны бүрэн эрхийн тухай заалт туссан байсан. Гэвч, Төрийн байгуулалтын байнгын хороо болон нэгдсэн хуралдаан дээр энэ заалт дэмжигдээгүйгээс хасагдсан.¹¹⁴ Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг дээр хянан шалгах түр хорооны бүрэн эрхийн тухай энэ заалтыг дахин нэмж оруулах саналыг УИХ-ын нэр бүхий гишүүдээс гаргасны дагуу УИХ-ын дарга чиглэл өгч, улмаар уг заалтыг 2019.06.06-нд өргөн барьсан

¹¹² Мөн тэнд, 46.

¹¹³ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг, 2017), 54.

¹¹⁴ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 8 дугаар сарын 23-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл, 50; Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 6.

Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд байсан агуулгаар дахиад сэргээж оруулах саналыг гаргасан боловч 2019.09.09-нд Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаан дээр дэмжээгүй.¹¹⁵

Хянан шалгах түр хорооны бүрэн эрхийг Үндсэн хуульд тоочиж заагаагүй боловч тэдгээрийг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд туссан байсан агуулгаар нь ердийн хуульд тусгана хэмээн УИХ-ын гишүүд ойлгож байв. 2019 оны нэмэлт, өөрчлөлтөөр Үндсэн хуулийн 28.2-т “Байнгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Улсын Их Хурал тогтооно” гэж заасан байсныг “Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж байнгын төдийгүй түр зэрэг бусад хорооны талаар хуулиар зохицуулахаар өөрчлөн уг хэсгийн сүүлийн өгүүлбэр болгосон өөрчилсөн. Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт энэ талаар хэлэхдээ: “Энэ маань үндсэндээ органик хууль буюу Үндсэн хуульчилсан хуулиараа Улсын Их Хурлын тухай хууль болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульдаа үүнийг нарийвчлаад Байнгын хорооны эрх, үүргийг, түр хорооны эрх, үүргийг тодорхой заагаад өгчихье. Үүн дотроо тэр түр хороо, хянан шалгах түр хороо ямар эрхтэй байхыг нь тодорхой зааж өгье гэдэг байдлаар авч үлдэж байгаа юм.”¹¹⁶ Түүнчлэн, УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан “нотлох баримт гэнэ үү, гэр дуудах, тайлбар авах, сонсгох энэ янз бүрийн асуудал нь бол органик хуулиараа явж болох учраас хасаж болж байгаа юм гэж ингэж л ажлын хэсэг дээр яригдаад энэ асуудал орж ирсэн. Энэ арай нөгөө жирийн ердийн процедураар байгуулагддаг түр хорооноосоо энүүгээрээ ялгаатай” гэж хэлж байв.¹¹⁷

Хянан шалгах түр хороо нь өөрөө мөрдөн шалгах тодорхой бүрэн эрхүүдийг эдэлнэ. УИХ-ын 2020.01.09-ний 02-р тогтоолын 1.3.4-т энэ талаар тусгахдаа:

Хянан шалгах түр хороог хуулиар тусгайлан тогтоосон эрх хэмжээний хүрээнд мэргэжлийн хараат бус шинжээч томилох, гэрч, шинжээчээс мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах зэрэг арга хэрэгсэл ашиглан Засгийн газар, түүний байгууллага, албан тушаалтан хууль зөрчсөн эсэх, эрх мэдлээ урвуулан ашигласан эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан эсэх болон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар дүгнэлт гаргах, иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэх зорилгоор байгуулах, түр хорооноос гаргасан дүгнэлт шүүхэд үүрэг хүлээлгэхгүй байх зарчмыг хуульчлах;

Эндээс үзэхэд УИХ-аас байгуулах хянан шалгах түр хороо нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр хуульчилжээ: (1) мэргэжлийн хараат бус шинжээч томилох; (2) гэрчээр дуудан ирүүлэх; (3) гэрч, шинжээчээс мэдүүлэг авах; (4) нотлох баримт гаргуулах; (5) хуулиар тогтоосон бусад арга хэрэгсэл ашиглах. Бусад арга хэрэгсэл гэдэгт хянан шалгах түр хорооны чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бөгөөд ардчилсан улсын парламентуудад түгээмэл бусад арга хэрэгслийг багтаан ойлгоно. Жишээлбэл, газар дээр нь очиж шалгах, бичиг баримтын дүн шинжилгээ хийх зэргийг нэмж хуульчлах шаардлагатай.

Хянан шалгах түр хороо нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үед дурдагдсан болон олон улсын сайн туршлагаар хүлээн зөвшөөрөгдсөн бүрэн эрхийг л хэрэгжүүлнэ. Эдгээрээс бусдаар мөрдөн шалгах ажиллагааг түр хороо явуулахгүй. Ажлын дэд хэсгийн гишүүн О.Мөнхсайхан: хянан шалгах түр хороо “хүний биед үзлэг, нэгжлэг хийх, тагнаж чагнах гэсэн ийм ажлууд бол хийхгүй. ...Тэгээд энэ бол хуулиар тусгай яг органик

¹¹⁵ Монгол Улсын Их Хурлын 2019 ээлжит бус чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 9 дүгээр сарын 09-ний өдөр /Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл, 55.

¹¹⁶ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 32; Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 36.

¹¹⁷ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны 8 дугаар сарын 23-ны өдөр /Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл, 49-50.

зохицуулалтуудыг нь хийгээд нарийвчлаад ...эрх мэдлийг урвуулан ашиглахаас сэргийлэх тэр хашилт хаалт, хүрээ хязгаарыг нь тогтоогоод өгчих ийм боломж бол байж байгаа юм.”¹¹⁸

Нийтийн сонсгол

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг хянан шалгах түр хорооноос явуулах нийтийн сонсголын ач холбогдлыг ийнхүү бичжээ: “Парламентын мөрдөн шалгах эрхээ хэрэгжүүлэх замаар хийж буй сонсголыг quasi-judicial буюу хагас шүүхийн шинжтэй сонсгол гэж үздэг. Энэ төрлийн сонсголд гэрч нь сонсгол даргалагчийн удирдлагаар заавал үнэнийг өгүүлэх тангараг өргөдөг байна... Мөрдөн шалгах хяналт нь мэдээллийг олон талаас сонсох, засгийн газрын мэдээлэлтэй бие даасан шинжээчийн мэдээллийг харьцуулан үзэх боломж олгохоос гадна, сонсголоо нээлттэй хийснээр мэдээллийг олон нийтэд ил болгож, иргэд өөрсдийнхөөрөө дүгнэх боломж олгодог.”¹¹⁹ Мөн, хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны хэлбэр нь сонсгол гэж Эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг үзэж дараах байдлаар тайлбарлаж байсан.

Ихэвчлэн сонсгол хэлбэрээр хийгдэх бөгөөд сонсголын бусад төрлөөс ялгаатай нь холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн, хараат бус шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй байдаг онцлогтой. Учир нь Засгийн газар болон түүний харьяа байгууллагын олон нийтээс нуун далдалсан мэдээллийг нийтэд ил болгох замаар эрх мэдэл хоорондын хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд ингэснээр зүй зохистой хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох боломж үүснэ...

Сонсголын үеэр ямар албан тушаалтныг гэрч, шинжээч, экспертээр дуудаж сонсох, хянан шалгалтын үр дүнд ямар баримт мэдээллийг цуглуулж авах нь түр хорооны үйл ажиллагаа үр нөлөөтэй байх эсэхэд маш их нөлөөтэй. ...Хянан шалгаж буй асуудлын цар хүрээнээс хамаарч сонсголын үеэр гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүнийг асууж, хариулт авах жишиг нийтлэг байдаг.¹²⁰

Иймд, хянан шалгах түр хороо нь нийтийн сонсголын үеэр гэрч, шинжээчээр дуудаж мэдүүлэг, тайлбар сонсох, баримт, мэдээллийг цуглуулж авахаа шийдвэрлэх зэргээр ажиллах бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл Ерөнхий сайд, сайдыг асууж, хариулт авч болно.

Хянан шалгах түр хорооны тайлан

Хянан шалгах түр хорооны ажлын үр дүнд тайлан гаргаж цаасаар болон цахимаар хэвлэн нийтлэх бөгөөд УИХ-д танилцуулна. Тайланг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг “Парламентын мөрдөн шалгах үйл ажиллагаанаас гарах эрх зүйн актын хувьд ихэвчлэн дүгнэлт, тайлан, илтгэл” гарах бөгөөд тайланд дараахыг тусгахаар бичжээ:

- хорооны зорилго;
- хорооны үйл ажиллагааны журам, мөрдөн шалгахтай холбоотой баримтыг олж авах процедур, арга зүй;
- хорооны олж тогтоосон баримт нотолгоо болон хорооны үйлдсэн хууль зүйн баримт бичиг;

¹¹⁸ Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 14-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 82-84.

¹¹⁹ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг, 2017), 52-53.

¹²⁰ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах санал, түүний үндэслэл (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг, 2019.03.05), 46.

- нотолгооны танилцуулга;
- мөрдөн шалгахад тогтоосон асуудлын талаар хувь хүн эсвэл албан байгууллагын гаргасан тайлбар;
- мөрдөн шалгахтай холбоотой тогтоосон асуудал нь хорооны үйл ажиллагааны зорилгод хамаарсан тохиолдолд хорооноос авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ зэргийг тусгана.¹²¹

Эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг энэ талаар бичихдээ: “Түр хорооноос тайлан, дүгнэлт гарах бөгөөд түр хороо өөрийн мандат бүхий асуудлаар олж тодорхойлсон нөхцөл байдал, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний талаарх зөвлөмжүүдээс бүрдэнэ. Зөвлөмж нь хууль тогтоомжид оруулах өөрчлөлт, авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг дурдсан байж болно.”¹²² Мөн, УИХ-ын 2020.01.09-ний 02-р тогтоолын 1.3.4-т хянан шалгах түр хороо хянан шалгалтаа дуусгаад “нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар дүгнэлт гаргах”-аар заасан. Хянан шалгах түр хорооны тайланг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд улс төрийн хариуцлага (Ерөнхий сайдыг огцруулах санал хураах зэрэг) хүлээлгэх, хууль тогтоомжийн эсхүл төсвийн шинэчлэл хийх эсэхээ УИХ зохих журмын дагуу өөрөө шийдвэрлэнэ.

Хянан шалгах түр хороог үл хүндэтгэвэл хүлээлгэх шийтгэл

Хянан шалгах түр хороог үл хүндэтгэвэл хариуцлага тооцдог байхгүй бол парламентын хяналтын энэ механизм үр нөлөөгүй болно. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсгийн тайлбарт парламентыг үл хүндэтгэх дараах үйлдлийг хянан шалгах түр хорооны үйл ажиллагааны явцад гаргавал эрүүгийн эсхүл бусад хууль зүйн хариуцлага хүлээлгэх талаар бичиж, АНУ, Австрали, ХБНГУ, ОХУ-ын жишээ дээр тайлбарлажээ: парламент болон түүний хороодыг санаатайгаар хуурах, төөрөгдөлд оруулах; парламент болон түүний хороодод гэрчийн мэдүүлэг өгөх, баримт гаргаж өгөхөөс татгалзах; парламентын гишүүнд ямар нэг байдлаар нөлөөлөхийг оролдох, заналхийлэх гэх мэт болно.¹²³ Түүнчлэн, Эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг саналдаа ийнхүү тусгасан:

...хянан шалгах түр хороо нь шалгаж буй буюу өөрийн шалгахаар байгуулагдсан мандат бүхий асуудлаараа засгийн газрын мэдэлд байгаа мэдээллийг ямар нэг саадгүй гаргуулан авах, холбогдох албан тушаалтнаас үнэн зөв, бүрэн мэдүүлгийг бичгээр авах, аман асуулт хариулт хэлбэрээр сонсголын явцад сонсох эрх хэмжээтэй байдаг. Энэхүү баримт мэдээлэл гаргуулан авах эрх хэмжээний баталгаа нь холбогдох мэдээллийг гаргаж өгөхгүй байх, худал, бүрэн бус мэдээлэх зэрэгт парламентыг үл хүндэтгэсэн учир эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл болдог.¹²⁴

Мөн, Ажлын дэд хэсгийн гишүүн О.Мөнхсайхан хянан шалгах түр хороог үл хүндэтгэвэл хариуцлага зайлшгүй хүлээлгэдэг байх талаар чуулганы нэгдсэн хуралдаан дээр хэлсэн:

Энэ зөвхөн тэр нөгөө гүйцэтгэх эрх мэдэлд яг юу болсон бэ. Одоо нийгэм, эдийн засгийн маш том одоо төрийн өмчтэй холбоотой, хүний эрхтэй холбоотой ингээд асуудлууд яригдаад байдаг. Гэтэл цуураад ингээд дан байдлаар яриа явдаг байсан бол энэ хороо байгуулагдаж ажиллах нөхцөл бий болсноор шинжээч томилох, гэрч дуудах, нотлох баримт гаргуулах ийм боломжтой болно. Энийг нотлох баримтыг гаргаж өгөхгүй бол хуулийн

¹²¹ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг, 2017), 56-57.

¹²² Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах санал, түүний үндэслэл (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг, 2019.03.05), 47.

¹²³ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг, 2017), 55-56.

¹²⁴ Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах санал, түүний үндэслэл (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг, 2019.03.05), 46.

хариуцлага хүлээнэ. Хууль сануулж байж бас тайлбар авдаг. Ингээд бодитой мэдээллийг гаргаж тавина. Энэ дээр хэлэлцэнэ. Шаардлагатай хууль тогтоомжийг өөрчлөх боломжтой юу, үгүй юу гэдгийг бас Улсын Их Хурал дараа нь хэлэлцээд явах боломжтой. ...Олон улсын парламентын холбооноос хийсэн судалгаагаар бол 80 гаруй улсуудад ийм хянан шалгах түр хороо ажилладаг.¹²⁵

Иймд, нотлох баримт гаргаж өгөхөөс татгалзсан, гэрчээр дуудагдсан ч хүрэлцэн ирээгүй, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзсан, хуурамч нотлох баримт гаргаж өгсөн зэрэг зөрчилд зохих шийтгэл хүлээлгэхээр хуульчлах хэрэгтэй.

Зөрчлийн хууль болон зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд хянан шалгах түр хорооны ажиллагаанд саад учруулах зөрчлийг дараах байдлаар зааж Хянан шалгах түр хороо хянан шийдвэрлэхээр хуульчлах боломжтой: (1) Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны хуралдааны дэг, журам зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох; (2) Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, татгалзсан, гэрч мэдүүлэг өгөхөөс зайсхийсэн, татгалзсан, шаардсан мэдээлэл, нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй, гаргаж өгөөгүй бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох; (3) Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос томилсон шинжээч нь Хянан шалгах түр хорооны тухай хуульд заасны дагуу дүгнэлт гаргах хугацааг тохиролцох талаар хэлэлцэхээс зайлсхийсэн, тогтоосон хугацаанд дүгнэлт гаргаж өгөөгүй, дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, дүгнэлтийн талаар тайлбар, мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох. Мөн, Эрүүгийн хуулийн 21.1, 21.2, 21.3, 21.4 дүгээр зүйлүүдэд зохих өөрчлөлт оруулж хянан шалгах түр хорооны хянан шалгалтын явцад **нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах, худал мэдүүлэг өгөх, худал орчуулах, хэлмэрчлэх, шинжээч зориуд худал дүгнэлт гаргахыг гэмт хэрэгт тооцож ял шийтгэхээр зохицуулах хэрэгтэй.**

Хянан шалгах түр хороо ба эрүүгийн процесс

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах түр хороо ажиллаж байхад үүнтэй зэрэгцэн эрүүгийн, захиргааны зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж болох бөгөөд энэ явцад гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй илрэх нь тус хорооны үйл ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй. Парламентын мөрдөн шалгалт болон эрүүгийн процессын ялгааг Үндсэн хуулийн эх баригч Б.Чимид багш ийнхүү тайлбарлажээ:

ПХШ-ын цөөнгүй хэлбэрийн дотроос мөрдөн шалгалтын агуулга нь улс төр, хууль зүйн арга механизмыг хослуулан ашиглаж шинжин тогтоохоос илүү нааштай арга замгүй болсон ноцтой үр дагавартай, ихээхэн ээдрээтэй хэрэг явдлын учрыг олж, зангилааг тайлахад оршдог. Гэтэл түүнийг хэн нэг этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцааж тогтоох төдийд ойлгон, үгүйсгээд байна уу гэлтэй. Шүүх эрх мэдлийн байгууллага бол хэрэг, маргааны үйл баримтыг эрх зүйн ухамсрын үүднээс үнэлж, үйлдэл явдал хууль хэрэглэн шийдвэрлэдэг. Түүнээс биш хэргийг улс төрийн хэм хэмжээ, зүй ёсны үүднээс шалгаж тогтоодоггүй.¹²⁶

Хянан шалгах түр хороо нь гэмт хэрэг мөрдөн шалгах, яллах, шүүн таслах ажил руу хутгалдан орохгүй, тусдаа үйл ажиллагаа явуулна гэдгийг УИХ-ын гишүүд ойлгож хэлж байсан. Тухайлбал, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт “Хянан шалгах түр хороо байгуулах асуудал маань үндсэндээ шүүх эрх мэдэл уруу халдаад, төрийн

¹²⁵ Монгол Улсын Их Хурлын 2019 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 14-ний өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 82-84.

¹²⁶ Б.Чимид, “Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх нь /Цаас үйлдвэрлэж мөнгө тараахаас цааш юу харагдана вэ?/,” *Хууль дээдлэх ёс*, 2010, №2(29), 18.

өндөр эрх мэдэлтэн, албан тушаалтнуудыг шалгадаг, шүүдэг, ялладаг ийм зорилгоор байгуулах гэж байгаа юм шиг ийм ойлголтоор зарим хүмүүс ярьж байна. Тийм юм бол байхгүй ээ.” гэж тодорхой хэлсэн.¹²⁷ Хянан шалгах түр хороо нь шинжээч томилох, гэрч дуудах, тайлбар мэдүүлэг авах, нотлох баримт гаргуулах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлснээр “шүүхийн бие даасан байдал парламенттай хутгалдаад байх юм байхгүй” гэж Хууль зүй, дотоод хэргийн сайд, УИХ-ын гишүүн Ц.Нямдорж хэлж байв.¹²⁸

Хянан шалгах түр хороо тухайн асуудлыг эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлж болох ч УИХ-ын 2020.01.09-ний 02-р тогтоолын 1.3.4-т түр хорооноос гаргасан тайлан, дүгнэлт нь “шүүхэд үүрэг хүлээлгэхгүй байх зарчмыг хуульчлах”-аар заасан. Түр хорооны тайлан, дүгнэлтийг шүүх хянахгүй бөгөөд хорооны хэлэлцсэн үйл баримтыг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглах, нотлох баримтаар үнэлэх эсэхийг шүүх өөрөө шийдвэрлэнэ.¹²⁹ Ийм зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 47.1-т “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” гэж заасантай нийцнэ. Мөн, “Ерөнхий прокурор шаардлагатай гэж үзвэл хяналт шалгалтын үр дүнг ашиглаж болно.”¹³⁰

IV. ДҮГНЭЛТ

Парламентын зүгээс гүйцэтгэх эрх мэдэлд хяналт тавих олон хэлбэрүүд байдаг. Эдгээрээс хамгийн хүчтэй, үр нөлөөтэй нь мөрдөн шалгах чиг үүрэгтэй хянан шалгах хороо юм. Хянан шалгах хороо нь гүйцэтгэх эрх мэдэл, ялангуяа засгийн газрын үйл ажиллагаа зохих ёсоор хэрэгжиж буй эсэхийг үнэн, бодит мэдээллийн тусламжтайгаар тун нарийн нягт шалгаж хяналт тавихад зориулагдсан. 2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр гүйцэтгэх эрх мэдлийг бэхжүүлсний зэрэгцээ түүнд тавих хяналтыг сайжруулах заалтууд оруулсны нэг нь УИХ-ын хянан шалгах түр хороо юм. Хянан шалгах түр хороог Үндсэн хуулийн түвшинд зохицуулснаар Засгийн газар, түүний харьяа байгууллагад тавих УИХ-ын хяналтыг илүү үр нөлөөтэй болгох, гүйцэтгэх эрх мэдлийн хариуцлага, ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар бодит мэдээлэл олж авах иргэний эрхийг хангах ач тустай. Энэ өгүүлэл нь парламентын хянан шалгах хорооны талаарх олон улсын сайн туршлагыг судалсны зэрэгцээ 2019.11.14-нд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт дэх хянан шалгах түр хорооны үзэл баримтлалыг тайлбарласан. Энэ судалгааны үр дүнд Үндсэн хуулийн 28.2-т заасны дагуу байгуулах УИХ-ын хянан шалгах түр хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооход анхаарах зүйлсийг тодорхойлсныг нэгтгэн дүгнэж танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуулийн 28.2-оор хянан шалгах байнгын хороо бус, харин түр хороог байгуулахаар заасан нь Үндсэн хуулийн шинэ институтыг бий болгож, УИХ дахь олонхын үзэмжээр татан буулгах, өөрчлөхөөс сэргийлж хамгаалж буй хэрэг. УИХ-ын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй (олонх эсхүл цөөнхийн гишүүний аль нь ч байж болох) нь санал тавивал Засгийн газар, түүний байгууллага, албан тушаалтан хууль зөрчсөн эсэх, эрх мэдлээ урвуулан ашигласан эсэх, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан эсэх зэрэг нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг хянан шалгах түр хороог заавал байгуулж тодорхой хугацаанд ажиллуулна. Хянан шалгах асуудлыг санал гаргасан гишүүд тодорхойлох боловч энэ нь УИХ-ын эрх хэмжээнээс хальж болохгүй бөгөөд энэ талаарх маргааныг УИХ-ын гишүүний дөрөвний нэгээс доошгүйн гаргасан хүсэлтээр Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх боломжтой. Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнд УИХ дахь нам, эвслийн бүлгийн төлөөллийг хувь тэнцүүлэн эсхүл олонхын болон цөөнхийн төлөөллийг тэнцүү тоогоор оролцуулах бөгөөд түр хороонд орох гишүүнээ нам, эвслийн бүлэг өөрөө томилж, чөлөөлөх эрхтэй. Хянан шалгах түр хорооны дарга эсхүл илтгэгч

¹²⁷ Монгол Улсын Их Хурлын 2019 оны ээлжит бус чуулганы 8 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл, 32.

¹²⁸ Мөн тэнд, 36.

¹²⁹ *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгах санал, түүний үндэслэл* (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд саналын хувилбар боловсруулах үүрэг бүхий эрдэмтэн, судлаачдын дэд ажлын хэсэг, 2019.03.05), 47.

¹³⁰ *Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн тайлбар* (Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх ажлын хэсэг, 2017), 56.

гишүүн нь цөөнхийн гишүүн байхаар хуульчилбал гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналтыг илүү үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хяналт, тэнцлийг хангах боломжтой. Хянан шалгах түр хороо нь шинжээч томилох; гэрчээр дуудан ирүүлэх; гэрч, шинжээчээс мэдүүлэг авах; нотлох баримт гаргуулах; газар дээр нь очиж шалгах; бичиг баримтын дүн шинжилгээ хийх зэрэг мөрдөн шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, үүгээрээ бусад хороо, ажлын хэсгээс илүү эрх мэдэлтэй, онцлогтой. Мөрдөн шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэх баталгааг хангах үүднээс нотлох баримт гаргаж өгөхөөс татгалзсан, гэрчээр дуудагдсан ч хүрэлцэн ирээгүй, гэрчийн мэдүүлэг өгөхөөс татгалзсан, хуурамч нотлох баримт гаргаж өгсөн зэрэг зөрчилд зохих шийтгэл хүлээлгэхээр хуульчилна. Хянан шалгах түр хороо нь нийтийн сонсгол хийх замаар гэрч, шинжээчээр дуудаж мэдүүлэг, тайлбар сонсох, баримт, мэдээллийг цуглуулж авахаа шийдвэрлэх бөгөөд Ерөнхий сайд, сайдыг асууж, хариулт авч болно. Түр хорооны гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь ямар гэрчээс мэдүүлэг авах, хэнийг шинжээчээр томилох, ямар баримт авах вэ, хянан шалгах түр хорооны үйл ажиллагаанд саад уруулсан зөрчилд хариуцлага тооцох эсэхтэй холбоотой тодорхой эрх эдэлнэ. Хянан шалгах түр хорооны ажлын үр дүнд тайлан (дүгнэлт, зөвлөмжийг багтаасан) гаргаж хэвлэн нийтлэх бөгөөд УИХ-д танилцуулж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах түр хороо ажиллаж байхад үүнтэй зэрэгцэн эрүүгийн, захиргааны зэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж болох бөгөөд энэ явцад гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүй илрэх нь тус хорооны үйл ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй. Учир нь, хянан шалгах түр хороо нь гэмт хэрэг мөрдөн шалгах, яллах, шүүн таслах ажил руу хутгалдан орохгүй, тусдаа үйл ажиллагаа явуулна. Хянан шалгах түр хороо тухайн асуудлыг эрх бүхий байгууллагад шалгуулахаар шилжүүлж болох ч тайлан, дүгнэлт нь шүүхэд үүрэг хүлээлгэхгүй бөгөөд тэдгээр тайлан, дүгнэлтийг шүүх хянахгүй. Түр хорооны хэлэлцсэн үйл баримтыг ашиглах, нотлох баримтаар үнэлэх эсэхийг шүүх өөрөө шийдвэрлэх бөгөөд шаардлагатай гэж үзвэл Ерөнхий прокурор бас ашиглаж болно.





III.
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛ



3.1.ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРААС ИРҮҮЛСЭН САНАЛ

ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭЛЭЛ, ТАЙЛАГНАЛЫН СИСТЕМ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Нэг. УИХ-ын тухай хуулийн 39.1-д заасан хяналтын бүрэн эрхүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой Засгийн газрын мэдээлэл, тайлагналын систем, түүний зохион байгуулалт, хяналт, цаашид хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд тайлан, мэдээллийг тогтмол ирүүлэх, цаг үеийн асуудал болон Улсын Их Хурлын гишүүний асуулга, асуултын хариуг оновчтой, шуурхай ирүүлэх талаар Засгийн газраас авч буй арга хэмжээ, үр дүн, тулгамдсан асуудлууд:

1.1. Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн хэрэгжилтийн явцын талаар мэдээлэл цуглуулах, хяналт тавих, Улсын Их Хуралд тайлагнах үйл ажиллагааны талаар:

Улсын Их Хурлаар 2007 оны 10 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт Засгийн газрын гишүүнд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж тусгасан байсан.

Дээрх хуулийн зохицуулалт Улсын Их Хурлаар 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсон. Улмаар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 114 дүгээр зүйлийн 114.2.8-д “хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг холбогдох Байнгын хороо жилд 1 удаа” хэлэлцэнэ гэж хууль тогтоомжийн хэрэгжилтийг тусад нь танилцуулахаар шинэчлэн зохицуулсан.

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь хагас жил, бүтэн жилээр яамд, аймаг, нийслэл, Ерөнхий сайд, Шадар сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа агентлаг, байгууллагуудаас Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (цаашид “цахим сан” гэх)-аар дамжуулан авч нэгтгэн хэрэгжилтийн явцын тайланг Засгийн газрын хуралдаанд танилцуулан Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна.

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрт дараах баримт бичиг хамаарна:

Хууль тогтоомжид:

Монгол Улсын хууль;

Улсын Их Хурлын тогтоол;

Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол;

Тогтоол, шийдвэрт:

Ерөнхийлөгчийн зарлиг;

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр;

Засгийн газрын тогтоол;

Ерөнхий сайдын захирамж;

Засгийн газрын хуралдааны тэмдэглэл;

Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар;

Үүнээс, Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолыг хууль тогтоомж хэсэгт хамруулан авч үзэж, хэрэгжилтийг цахим сангаар дамжуулан нэгтгэн, хагас жил тутам Засгийн газар, Улсын Их Хуралд танилцуулан ажиллаж байна.

Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (www.unelgee.gov.mn)-д Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, 14 яам, Ерөнхий сайд, Шадар сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын харьяа агентлаг, байгууллагууд, 21 аймаг болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газар холбогдсон байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийг хүлээн авч бүртгэл хөтлөн, Засгийн газарт үүрэг чиглэл өгсөн эрх зүйн акт, шийдвэрийн зүйл, заалт бүрийг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаар дамжуулан хэрэгжилтийг нэгтгэн хариуцах төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага болон нутгийн захиргааны байгууллага (цаашид “Захиргааны байгууллага” гэх)-ыг цахим системд холбож, үүрэгжүүлэн ажилладаг. Захиргааны байгууллага нь хууль тогтоомжийг хяналтад авч, салбар, чиглэлээр ангилан хэрэгжилтийг холбогдох загварын дагуу гаргаж, Сайд, удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн хагас жилийн тайланг тухайн оны 7 дугаар сарын 1-ний дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор цахим санд тайлагнадаг. Хууль тогтоомжоор хэд хэдэн сайд, дарга, байгууллагад үүрэг өгсөн шийдвэрийн эхэнд нь бичигдсэн Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, засаг дарга, ажлын хэсгийн дарга (ахлагч) хэрэгжилтийг нэгтгэн мэдээлж байхаар журмаар зохицуулсан. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайд, Шадар сайдын ажлын алба болон яамд нь эрхлэх асуудлын хүрээнд хамаарах харьяа агентлаг, байгууллагын мэдээллийг нэгтгэн гаргадаг бол аймаг, нийслэл нь нутаг дэвсгэрийн хэмжээний нэгдсэн тайланг гаргах үүргийг хүлээдэг.

Хууль тогтоомжоор Засгийн газарт үүрэг, чиглэл болгосон шийдвэрийн зүйл, заалтын 2020 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцыг Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн, цахим санд бүртгэлтэй, хяналтад авсан нийт 92 хуулийн 461 заалт, Улсын Их Хурлын 87 тогтоолын 250 заалт, Улсын Их Хурлын Байнгын хорооны 87 тогтоолын 436 тогтоолын хүрээнд гарган нэгтгэж, хяналт-шинжилгээ хийх ажил энэ хугацаанд хийгдэж байна. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцын тайланг нэгтгэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулах бөгөөд Засгийн газрын хуралдаанаас гарсан шийдвэрийг захиргааны байгууллага мөрдөж ажиллах үүрэгтэй. Мөн хууль тогтоомжоор Засгийн газарт үүрэг, чиглэл болгосон эрх зүйн актын хэрэгжилтийн хагас, бүтэн жилийн тайланг Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна.

1.2. Хөгжлийн бодлогын баримт бичгүүд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлийн хэрэгжилтийг хянах, мэдээлэл цуглуулах, Улсын Их Хуралд тайлагнах үйл ажиллагааны талаар:

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах болон тайлагнах цаглаварыг нарийвчлан тогтоосон. Улмаар, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулиар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах журмыг Засгийн газар батлахаар заасны дагуу Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баталж, уг журамд дараах зохицуулалтыг тусгаад байна:

- Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд “Алсын хараа-2050”-ын хэрэгжилтийн явцад таван жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тайланг хянан үзэж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, тайланг Улсын Их Хуралд танилцуулна. (7.6.1.)

- Төрийн захиргааны төв байгууллага хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад таван жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тайланг хянан үзэж Засгийн газрын хуралдаанд танилцуулна. (7.6.2.)
- Төрийн захиргааны төв байгууллага Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийнхэрэгжилтэд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тайланг хянан үзэж Засгийн газрын хуралдаанд танилцуулна. (7.6.3.)
- Төрийн захиргааны төв байгууллага Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт-шинжилгээ, үнэлгээг жил тутамд хийж тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тайланг нэгтгэн, хянан үзэж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46.1 дэх хэсэгт заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. (7.6.4.)
- Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг яам болон холбогдох байгууллагаас авч хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар тайланг хянан үзэж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. (7.6.5.) гэж тус тус зохицуулсан.

1.3. Улсын Их Хурлын хяналтын бүрэн эрхүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр Улсын Их Хурал ба Засгийн газар (УИХ-ын Тамгын газар болон ЗГХЭГ-ын холбогдох чиг үүргийн нэгжүүд)-ын ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааны талаар:

Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж тухайн тайлант хугацаанд шинээр гарсан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл болгосон эрх зүйн актын жагсаалтыг Байнгын хороодын эрхлэх асуудлаар ангилан зүйл, заалт бүрээр гаргаж, өмнөх тайлант хугацаанд хэрэгжилт нь тогтмолжсон, хяналтаас хасах эрх зүйн актын жагсаалтын хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хагас жил тутам ирүүлдэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж ирүүлсэн жагсаалтын дагуу цахим сан (www.unelgee.gov.mn)-д эрх зүйн актыг бүртгэж, хариуцсан яам, агентлаг, байгууллага, аймаг, нийслэлийн Тамгын газрыг холбож, хэрэгжилт нь тогтмолжсон эрх зүйн актыг хүчингүй болох хүртэл дотоод хяналтандаа авч ажиллах чиглэлийг төрийн захиргааны байгууллагуудад өгдөг.

Төрийн захиргааны байгууллагууд хууль тогтоомжоор өгөгдсөн үүрэг, чиглэлийн хүрээнд салбар, орон нутгийн хэмжээнд хийж гүйцэтгэсэн ажлын талаарх тайлан мэдээллийг нэгтгэн удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, цахим сангаар дамжуулан тайлагнаж, нэгдсэн тайлан мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар Засгийн газрын хуралдаанд танилцуулан гарсан шийдвэрийг захиргааны байгууллагуудад хүргүүлэн, Улсын Их Хурлын Тамгын газарт хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцын тайланг хүргүүлэн ажиллаж байна.

1.4. Улсын Их Хурлын гишүүний асуулга, асуултын хариу өгөх ажлын талаар:

Улсын Их Хурлын тухай хуулийн 39.8-д “Асуултыг хүлээн авсан албан тушаалтан хариуг 14 хоногийн дотор гишүүнд бичгээр өгнө.” гэж 39.3-т “Асуулга хүлээж авсан албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр өгнө” гэж тус тус заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль эрх зүйн асуудал хариуцсан нэгж гишүүдийн асуулга, асуултын хариу өгөх ажлыг нэгтгэн зохион байгуулан ажиллаж байна.

Хоёр. Хууль тогтоомжийн тухай хуулийн 49, 50, 51, 52 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газрын түвшинд хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоо бүрдсэн эсэх, энэ чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн, тулгамдсан асуудлууд, цаашид энэ чиглэлээр хуулийн төсөлд тусгуулах санал:

2.1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой гарч буй эерэг, сөрөг нөлөөллийг тандан судлах, хэрэглэгч, сонирхогч болон олон нийтийн оролцоог хангах ажлын талаар:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1-д заасныг үндэслэн Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”, 6 дугаар хавсралтаар “Хууль тогтоомжийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг батлан мөрдөж байна. Энэхүү журмаар хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, төсөл боловсруулах, хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх, зардлын тооцоо хийх, хэрэгжилтийн хяналт-шинжилгээ хийх, үр дагаварт үнэлгээ хийх зэрэг хууль тогтоомжийн төсөл боловсруулахаас эхлээд батлагдсаны дараах үр дагаврыг үнэлэх зэрэг бүхий л шатны үйл ажиллагааг зохицуулж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно”, 49.8-д “Хууль тогтоомжийн зохицуулах харилцааны онцлог, асуудлаас хамааран хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийхдээ хууль тогтоомжийг бүтнээр нь, эсхүл зарим зүйл, заалтыг сонгож болно”, 49.3-т “Засгийн газраас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ” гэж тус тус заасны дагуу яамд эрхлэх асуудлын хүрээний хууль тогтоомжийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг хариуцаж байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21.4-т “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах журмыг Засгийн газар батална” гэж заасны дагуу Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг батлан мөрдүүлж байна.

Журмын 6.3-т хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачлалаар тооцохоор тусгасан:

- “бүрэн хэрэгжсэн”-холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);
- “хэрэгжих шатанд” - тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь /50-89 хүртэл хувь/;
- “хэрэгжилт хангалтгүй” - тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь /10-49 хүртэл хувь/;
- “хэрэгжээгүй” - тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг

хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь /0-9 хүртэл хувь/;

- "хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй".

Шинээр баталсан Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолоор Засгийн газарт үүрэг, чиглэл өгсөн зүйл, заалтын хэрэгжилтийг энэхүү журмаар тооцон ажиллаж байна.

2.2.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлэх ажлын талаар:

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д “Бүх шатны захиргааны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байна” (4.1.), “Тухайн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж байгууллагын чиг үүрэг, бүтэц, орон тооны хязгаарт нийцсэн үйл ажиллагаа явуулахад хүрэлцэхүйц бүрэлдэхүүнтэй байна” (4.5.) гэж тус тус заасан. Үүний дагуу яамдад 5-8 хүний бүрэлдэхүүнтэй хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж, агентлагт 1-4 хүний бүрэлдэхүүнтэй нэгж, зарим байгууллагад ажилтан, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2-3 хүний бүрэлдэхүүнтэй хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж ажиллаж байна. Эдгээр хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтнуудаас 1 ажилтан нь хууль тогтоомжийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг бодлогын баримт бичгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтай хавсран гүйцэтгэж байна. Мөн төрийн захиргааны байгууллагуудад эрхлэх асуудлын хүрээний бодлого төлөвлөлт, зохицуулалт, хэрэгжилтийн нэгж, ажилтнууд болон хууль эрх зүйн нэгж, ажилтнуудын гүйцэтгэж буй ажил үүрэг нь агуулгын хувьд хууль тогтоомжийн хяналт-шинжилгээ, үнэлгээний чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Гурав. Хууль тогтоомжийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг сайжруулах талаарх санал:

3.1. Улсын хэмжээний тайлан мэдээллийг нэгтгэх ажлын хүрээнд Засгийн газрын бүтцийн байгууллагын хүрээнд гаргаж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан мэдээлэлд Улсын Их Хурлаас томилогддог болон Улсын Их Хурлын харьяа байгууллага (Монголбанк, Үндэсний статистикийн хороо, Төрийн аудитын байгууллага, Төрийн албаны зөвлөл, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт)-ын мэдээллийг нэгтгэх ажлыг хийх шаардлагатай байна. Үүнд дараах 3 шийдлийн хувилбар байж болох юм.

- Засгийн газрын цахим санд Улсын Их Хурлын харьяа байгууллагуудыг холбох;
- Улсын Их Хурлын харьяа байгууллагуудад яамд, байгууллагууд тайлан мэдээллээ хүргүүлэх;
- Улсын Их Хурлын Тамгын газар Засгийн газрын болон харьяа байгууллагын мэдээллээ нэгтгэн авах цахим системийг хөгжүүлэх.

3.2. Хууль тогтоомжид хууль, Улсын Их Хурлын тогтоол, Байнгын хорооны тогтоолыг хамруулан хяналтад авч хэрэгжилтийг тайлагнадаг бөгөөд Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл, түр болон дэд хорооны тогтоол, хуралдааны тэмдэглэлээр Засгийн газарт холбогдох чиглэлийг өгсөн шийдвэрүүдийг хууль тогтоомжид хамруулах асуудлыг албан ёсоор холбогдох хууль журамд тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

3.3. Агуулгын хувьд төрийн захиргааны байгууллагууд эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой бүхий л судалгаа, тооцоолол, өөрчлөлтийн асуудлыг хууль санаачлагчид, хөндлөнгийн судалгааны байгууллага, эрдэмтэн судлаачид, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоо, иргэд, эрх ашиг нь хөндөгдөж буй талуудын оролцоотойгоор зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд гагцхүү хэлбэрийн хувьд энэхүү ажил нь харилцан адилгүй, нэр томьёоны ойлголтын хувьд зөрүүтэй зүйлүүд ажиглагдаж байна. Иймд:

- Хуулийн үр дагавар, үр нөлөөний үнэлгээний асуудлыг хуулийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээний асуудлаас ялгаж тодорхойлох;
- Хуулийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын цаглаварыг тодорхой болгох;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих чиглэлээрх Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хариуцах ажил үүргийн хуваарийг оновчтой тогтоох.

3.4.Цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, улс төрийн хувьд баримтлах зарчим, бодлого өөрчлөгдсөн ижил төрлийн асуудлаар гарч буй дараагийн шийдвэрт өмнөх шийдвэрээ хүчингүй болгох талаар тусгадаг байх асуудлыг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох,

3.5.Асуулга, асуултыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүлээн авсны дараа санал авахаар яамд холбогдох байгууллагад хүргүүлдэг тул хуульд заасан хугацааг “ажлын хоног” болгох саналтай байна.



3.2.УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН БАЙНГЫН ХОРООДЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ХЭЛТСЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТҮР ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БАЙГАА АСУУДАЛ, ЦААШИД ТҮР ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ САНАЛ

Улсын Их Хурлын түр хороодын үйл ажиллагаанд тулгамдаж байгаа асуудал:

- ✚ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт “Түр хороо нь ... Байнгын хорооны нийтлэг бүрэх эрхийг хэрэгжүүлнэ.” заасан боловч Байнгын хороо нь хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгахдаа ямар эрх хэмжээ эдлэх, байгууллага, албан тушаалтнаас хүссэн мэдээ, баримтаа хэрхэн гаргуулж авах талаар тодорхой зохицуулалт байхгүй учраас хяналт шалгалтын ажил үр дүнгүй, хэт ерөнхий байх зэрэг сөрөг үр дагавар гардаг тул үүнийг тодорхой процессжуулах нэн шаардлагатай байна.
- ✚ Түр хорооны асуудлыг харьяалах Байнгын хороо харицаж ажиллаж байгаа бөгөөд Улсын Их Хурлын Тамгын газрын шинэчлэгдсэн бүтэцтэй холбоотойгоор хүний нөөцийн хувьд хариуцан ажиллах боломжгүй юм. Иймд хяналт шалгалтын нэгж эсхүл бие даасан алба Түр хорооны асуудлыг хариуцан ажиллах боломжийг бүрдүүлэх.

Улсын Их Хурлын түр хороодын үйл ажиллагааг цаашид хяналтын үр нөлөөтэй арга хэлбэр болгох хүрээнд хуулийн төсөлд тусгуулах санал:

- ✚ Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор хойшлуулахгүйгээр байгуулна гэж заасан. Иймд Түр хорооны гишүүд нь Улсын Их Хурлын гишүүд байх бөгөөд тухайн асуудлаараа холбогдох албан тушаалтан, гэрчийг дуудан ирүүлэх, хянан шалгагч, шинжээч томилох, тэдгээрээс тайлбар, мэдүүлэг авах, нотлох баримт цуглуулах, мэдээлэл гаргуулах үйл ажиллагааг хийх ёстой. Улсын Их Хурлын гишүүд эдгээр ажлыг хийхэд цаг хугацаа, ажлын ачаалал зэргээс болон Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан бүрэн эрхэд хэрхэн нийцүүлэх талаар тодорхой тусгах шаардлагатай. Түүнчлэн хянан шалгах Түр хорооны гишүүнд Улсын Их Хурлын Тамгын газрын хяналт шалгалт хариуцсан нэгж туслалцаа үзүүлэх бол яг ямар чиг үүрэгтэй туслалцаа үзүүлэхийг тодорхой зааж, эрх хэмжээг нь тодорхойлох шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл дээр дурдсан гэрчийг дуудах, нотлох баримтыг бүрдүүлэх, шинжээч томилох асуудлыг уг нэгж хариуцан гүйцэтгэх боломжтой гэж үзвэл тухайн нэгжийн албан хаагчдын статус, эрх хэмжээг тодорхой хуульчлах шаардлагатай. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль тогтоомжийг хууль хяналтын байгууллагын алба хаагчид нэг мөр хэрэгжүүлдэггүй, хууль зөрчдөг гэсэн өргөдөл, гомдол Улсын Их Хуралд ихээр ирдэг тул уг хуулиудын хэрэгжилтийг шалгах ажлыг хэрхэн зохион байгуулах талаар тусгайлан оруулах;
- ✚ Улсын Их Хурлын хяналт шалгалт, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах хүрээнд Түр хороо байгуулагдсан тохиолдолд түр хорооны үйл ажиллагааг Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт, шалгалт, үнэлгээний газар дангаараа хариуцан ажиллах эрх зүйн зохицуулалтыг бий болгох, шаардлагатай бол түр хороо хариуцсан бие даасан ажлын албыг бий болгох;
- ✚ Түр хорооны ажиллах хугацаанд захиран зарцуулах төсвийг Байнгын хорооны эрх хэмжээтэй адил авч үзэж шийдвэрлэх;
- ✚ Түр хорооны гишүүдийн тоог Байнгын хорооны нийт гишүүдийн тооноос хэтрэхгүй байх, эсхүл дэд хорооны гишүүдтэй тэнцүү байх дээд тоог хязгаарлах;

Түр хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт орох бол анх байгуулагдсан тооноос хэтрэхгүй байх, хууль зүйн хувьд хэрхэн зохицуулах талаар тодорхой заах.

УЛСЫН ИХ ХУРЛААС ТОДОРХОЙ АСУУДЛЫГ ШАЛГАН СУДАЛЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЗОРИЛГООР БАЙГУУЛАГДСАН ТҮР ХОРООДЫН МЭДЭЭЛЭЛ

Санжаасүрэнгийн Зоригийн амь насыг хөнөөсөн хэргийг шийдвэрлэсэн асуудлаар Олон улсын парламентын холбооны удирдах зөвлөлөөс ирүүлсэн шийдвэрийг судалж, холбогдох санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий түр хороо					
	Түр хороо байгуулах шийдвэр	Байгуулсан огноо	Татан буугдсан огноо	Түр хорооноос гаргасан шийдвэр, хэрэгжүүлсэн ажил	Шийдвэрийн хэрэгжилт
1	Улсын Их Хурлын 2019 оны 32 дугаар тогтоол	2019.04.25	Татан буугдаагүй Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулиар түр хорооны 7 гишүүний 6-ийн бүрэн эрхийн хугацаа дууссан	Олон улсын парламентын холбооны удирдах зөвлөлөөс 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Санжаасүрэнгийн Зоригийн амь насыг хөнөөсөн хэргийг шийдвэрлэсэн асуудлаар гаргасан шийдвэртэй холбогдуулан зөвлөмж тус бүрээр санал боловсруулах	-С.Зоригийн хэргийн талаарх хэргийн материалтай Улсын Ерөнхий прокурорын газарт очиж танилцсан. -С.Зоригийн амь насыг бүрэлгэсэн гэсэн үндэслэлээр хорих ял эдэлж байгаа Б.Чимгээ, Т.Содномдаржаа нарын өмгөөлөгч нартай уулзсан. -Олон улсын парламентын холбооны гишүүдтэй уулзалт зохион байгуулсан. -Улсын Ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газрын дарга нартай уулзалт зохион байгуулсан.
Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо					
	Түр хороо байгуулах шийдвэр	Байгуулсан огноо	Татан буугдсан огноо	Түр хорооноос гаргасан шийдвэр, хэрэгжүүлсэн ажил	Шийдвэрийн хэрэгжилт
2	Улсын Их Хурлын 2020 оны 31, 49 дүгээр тогтоол	2020.05.13,	2020.10.29	“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай /Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 36 дугаар тогтоол/	-УОК болон холбогдох байгууллагууд тогтоолын хэргэжилтийг хангаж ажиллаж байна.
Цахим бодлогын түр хороо					
	Түр хороо байгуулах шийдвэр	Байгуулсан огноо	Татан буугдсан огноо	Түр хорооноос гаргасан шийдвэр, хэрэгжүүлсэн ажил	Шийдвэрийн хэрэгжилт
3	Улсын Их Хурлын 2018 оны	2018.05.24	2019.05.23	2020 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн УИХ-ын 10 дугаар	-Төрийн үйлчилгээний цахим шилжилтийг явуулахтай

	38 дугаар тогтоол, 2019 оны 50 дугаар тогтоол			тогтоолоор Инновац, цахим бодлогын байнгын хороо байгуууулагдсан	холбогдуулан 2019 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Чиглэл өгөх тухай” 05 дугаар тогтоол, -Цахим орчинд иргэдийн үнэн зөв, зохистой мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэхтэй холбогдуулан 2020 оны 01 дүгээр 24-ний өдөр “Чиглэл өгөх тухай” 01 дугаар тогтоол
--	---	--	--	--	--

**БАЙНГЫН БОЛОН ДЭД ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БАЙГУУЛАГДСАН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГТ ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ,
ЦААШИД БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ САНАЛ**

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан хяналт шалгалтын ажлын хэсэгт тулгамдаж байгаа асуудал:

- ✚ Хяналт шалгалтын ажлын хэсгээс ямар шийдвэр гарах нь тодорхойгүй;
- ✚ Ажлын хэсгийн талаар эрх зүйн зохицуулалт дутуу, ажлын хэсгийн гүйцэтгэх чиг үүрэг, эрх хэмжээний талаар зохицуулаагүй;
- ✚ Ажлын хэсгээс гаргасан шийдвэр нь Байнгын хороонд асуудал танилцуулсан хэлбэртэй явагддаг, үр дүн муутай байдаг;
- ✚ Ажлын хэсгийн танилцуулгыг хэлэлцээд Байнгын хорооноос заавал шийдвэр гардаг байх;
- ✚ Ажлын хэсгээс гаргасан танилцуулгатай холбоотойгоор Байнгын хороо, Улсын Их Хурлаас ямар нэгэн шийдвэр гардаггүй, гарсан ч хэрэгжилт нь хангалтгүй байдаг;
- ✚ Ажлын хэсэг батлагдсан чиг үүрэг, удирдамжид заагаагүй ажлыг хэрэгжүүлдэг;
- ✚ Хяналт шалгалтын ажлын хэсэг хэрхэн ажиллах тусгайлсан журам байхгүй;
- ✚ Хяналт шалгалтын ажлын хэсгийн удирдамжийг боловсруулахад УИХТГ-ын хяналт шалгалтын хэлтсээс санал авч, ажиллах удирдамжид заасны дагуу ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан ажиллах талаар зохицуулалт дутуу;
- ✚ Хяналт шалгалтын ажлын хэсэгт хөндлөнгийн эксперт, гадаадын шинжээч болон хараат бус хөндлөнгийн мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах, судалгаа шинжилгээ хийлгэх зардлын асуудал тодорхойгүй байдаг;
- ✚ Ажлын хэсгийг ажиллах боломжоор хангах талаар зохицуулалт байхгүй байгаа нь ажлын хэсгийг саналаа нэгтгэх дүгнэх боломж хязгаарлагдахаар байгааг анхаарах;
- ✚ Онцгой нөхцөлд хяналт шалгалтын ажлыг хэрхэн зохион байгуулах талаар тусгайлсан журам боловсруулах.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын хяналтыг хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох санал:

- ✚ Хяналт шалгалтын төрлийг тодорхой болгох;
- ✚ Хяналт шалгалтын нэр томьёо, чиг үүргийг тодорхойлох;
- ✚ Нийтийн сонсголын тухай хуулиас Улсын Их Хурлын хийх нийтийн сонсголын зохицуулалтыг авч, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд бие даасан зүйлээр оруулах;
- ✚ Улсын Их Хурлын даргын захирамж болон Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах, Тодорхой асуудлыг шалгах ажлын хэсэг байгуулах, ажлын хэсгийн чиг үүрэг, бүрэн эрхийн талаар бие даасан зүйл бий болгож, ажлын хэсэг ямар эрх зүйн баримт бичгийн хүрээнд ажиллах, ажлын хэсгээс газар дээр нь хэрхэн хяналт шалгалт хийх, үйл ажиллагаатай танилцах, албан тушаалтнуудаас мэдээлэл гаргуулж авах зэрэг зохицуулалтыг тусгах;

- ✚ Байнгын хорооны хуралдаанаар хяналт шалгалтын асуудлыг мэдээлэл сонсох хүрээнд хэлэлцүүлэх биш, гаргаж өгсөн мэдээллийн эх баримттай танилцах, буруу зөвийг нь нягтлах асуудлыг зохицуулалтыг тодорхой хуульчлах;
- ✚ Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн эрх хэмжээ, шалгалтын хүрээ хязгаар, бусад байгууллага албан тушаалтны эрх хэмжээ, үүрэг, хариуцлага, шалгалтын мөрөөр гаргах шийдвэр, түүний хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулах талаар хуулийн төсөлд тодорхой тусгах;
- ✚ Ажлын хэсгийн танилцуулгыг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Байнгын хорооноос шийдвэр гаргадаг байх зохицуулалтыг бий болгох. Байнгын хорооноос гарсан шийдвэрийн хэрэгжилтийг Байнгын хороонд эргэн мэдээлдэг байх зохицуулалтыг тодорхой болгох;
- ✚ Хяналт шалгалтын ажлын хэсгээс гарах шийдвэрийн төслийг ямар хэлбэртэй байх талаар тодорхой зохицуулалтыг хуульд тусгах;
- ✚ Ажлын хэсэг байгуулагдсан чиг үүрэг, удирдамжид заагаагүй, ажлын хэсэгт олгогдоогүй эрх хэмжээний хүрээнд ажил гүйцэтгэдэггүй байх зохицуулалтыг боловсронгуй болгох.

---o0o---

**БАЙНГЫН БОЛОН ДЭД ХОРООНЫ ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНД БАЙГУУЛАГДСАН
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН МЭДЭЭЛЭЛ** /Урьдчилсан байдлаар/

д/д	Байнгын хорооны нэр	Байнгын хорооноос байгуулагдсан ажлын хэсгийн мэдээлэл
1	Өргөдлийн байнгын хороо	<p>Туул голын бохирдлын асуудлаар ирүүлсэн өргөдлийн дагуу холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг судалж, шийдвэрийн төсөл боловсруулан Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг /2016-10-25-ны 02 тоот тогтоол/</p> <p>Арьс ширний үйлдвэрүүд стандартаас 2-5 дахин их бохир усыг Туул голд урсгаж байгаа талаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийн дагуу БХ-ноос Улсын Их Хурлын 2012 оны “Малчид үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоолын 5 дугаар заалтын биелэлтийг хангуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, санал дүгнэлт боловсруулж Байнгын хорооны хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг /2017-05-02-ны 04 тоот тогтоол/</p> <p>Түрээсийн орон сууцанд зорилтот бүлгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах журам”-ыг эргэн харж, иргэдэд мэдээлэл өгөх, өргөдөл, хүсэлт хүлээн авах, бүртгэх, гэрээ байгуулах зэргийг нэг цонхны үйлчилгээний зарчимд шилжүүлэх, орон сууц хүлээлцэх, түрээсийн орлого, түүнийг захиран зарцуулж байгаа байдал, ахмадын болон түрээсийн орон сууцанд хамрагдсан иргэд тухайн байрандаа амьдарч байгаа эсэхийг газар дээр нь очиж танилцах, хяналт тавих, санал дүгнэлт боловсруулан Байнгын хорооны хуралдаанд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг /2018-02-06-ны 02 тоот тогтоол/</p>
2	Төсвийн байнгын хороо	<p>“Оюу толгой” ХХК 2010-2012, 2013 оны 2 дугаар улирал хүртэл улсын төсвийн өмнө хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа байдал, Монгол Улсын Засгийн газартай байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ болон түүний хэрэгжилтийн байдалтай танилцаж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг</p> <p>Чиглэл өгөх тухай</p> <p>Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн 2013 оны зарцуулалтад Үндэсний аудитын газрын хийсэн аудитын тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан Засгийн газарт чиглэл өгсөн.</p> <p>Олон улсын зах зээлд гаргасан Засгийн газрын үнэт цаасны арилжаагаар төвлөрсөн хөрөнгийн зарцуулалт, эргэн төлөлт болон санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн сонголт, хэрэгжилтийн явц байдалтай танилцаж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий шалгалтын хамтарсан ажлын хэсэг</p> <p>Хөрөнгийн зах зээл дэх мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программ хангамжийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, Лондонгийн хөрөнгийн бирж групп болон Сангийн яамны хооронд байгуулсан “Стратеги түншлэлийн хамтын ажиллагааны гэрээ”-ний хэрэгжилтийн явц байдлыг шалгаж, Засгийн газарт чиглэл өгөх талаар санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг</p>
3	Инноваци, цахим бодлогын байнгын хороо	2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 02 тоот тогтоолоор “Эрүүл мэндийн салбар дахь цахим шилжилттэй холбоотой хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг байгуулсан
4	Нийгмийн бодлогын байнгын хороо	2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоол Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаатай танилцах, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үүрэг бүхий ажлын хэсэг
5	Эдийн засгийн байнгын хороо	<p>2015 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 08 дугаар тогтоол Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай УИХ-ын 41 дүгээр тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг.</p> <p>2019 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн 09 дугаар тогтоолоор Монголбанкнаас авч хэрэгжүүлж байгаа бодлогын арга хэмжээний хэрэгжилтийг шалгах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг.</p>

УЛСЫН ИХ ХУРЛААС НИЙТИЙН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ ЦААШИД БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, ҮР НӨЛӨӨГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР САНАЛ


Нийтийн сонсгол зохион байгуулахад оролцогчдын оролцоог хангах, чиг үүргийг тодорхой болгох хүрээнд:

✚ **Хууль тогтоогч:** Нийтийн сонсголын гол зорилго бол хууль тогтоогчдийг шийдвэр гаргахаас өмнө тухайн асуудлаар бүрэн дүүрэн мэдээллээр хангах явдал байдаг. Тодруулбал, Улсын Их Хурлын гишүүд ямар нэгэн асуудлаар шийдвэр гаргахаасаа өмнө мэдээллийг бүрэн дүүрэн авах үүднээс тухайн эрх ашиг нь хөндөгдөх этгээдийн төлөөллийг тэнцвэртэй оруулан мэдээллийг авах ёстой. Энэ нь шийдвэр нь үндэслэлтэй гарах суурь болж байдаг. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа Нийтийн сонсголын тухай хуульд тухайн Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр нийтийн сонсголыг хүчинтэйд тооцно гэсэн заалт байдаг хэдий ч амьдрал дээр хэрэгжихгүй буюу гишүүд сонсголд биечлэн суухгүй байна. Иймд Улсын Их Хурлын гишүүдийг сонсголыг дуустал бүрэн суулгадаг байх хөшүүргийг Нийтийн сонсголын хуульд оруулах нь нэн тэргүүний асуудал байгааг анхаарах. Ингэхдээ сонсголын ажиглагчаар оролцож байгаа хүмүүсийн эрх, үүргийг тодорхой болгох шаардлагатай. Өөрөөр хэлбэл гишүүдийн оролцоог ажиглагчаар оролцож байгаа хүмүүс бүртгэн сонсголын төгсгөлд тухайн сонсголыг хүчинтэй эсэх талаар дүгнэлтээ өгдөг байдлаар зохицуулвал гишүүдийн хариуцлага нэмэгдэх боломжтой гэж үзэж байна. Тодруулбал, Улсын Их Хурлын гишүүдийн ирцээс шалтгаалан тухайн сонсгол хүчингүй болох нь эдийн засгийн болон улс төрийн сөрөг үр дагавар дагуулах тул хариуцлагын сайн хөшүүрэг болох магадлалтай.

✚ **Иргэн, хуулийн этгээд:** Улсын Их Хурлаас гаргах гэж байгаа шийдвэр нь иргэн, хуулийн этгээдийн цаашдын үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлэх, үүнээс хэрхэн сэргийлэх талаар санаа бодлоо хууль тогтоогчдод хүргэхийн чухлыг болон сонсголын ач холбогдолыг олон нийтэд сурталчлан таниулах үр дүнтэй арга хэлбэрийг бий болгох шаардлагатай байна.

Нийтийн сонсголын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд:

- ✚ Нийтийн сонсголын тухай хуульд заасан Улсын Их Хурлын зохион байгуулах нийтийн сонсголын зохицуулалтыг Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд бие даасан бүлэг болгох оруулах;
- ✚ Нийтийн сонсголын төрөл тус бүрээр тухайлбал, Нийтийн сонсгол, Ерөнхий хяналтын сонсгол, Томилгооны сонсгол, Танилцах сонсгол, Төсвийн хяналтын сонсголын асуудлаар бие даасан зохицуулалтыг оруулах;
- ✚ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нийтийн сонсголотой холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох;
- ✚ Нийтийн сонсгол зохион байгуулах зардлыг ямар зардлаас гаргах, зохион байгуулалтыг хариуцан ажиллах асуудлыг тодорхой тусгах;
- ✚ Нийтийн сонсголыг нээлттэй зохион байгуулж, иргэдэд шууд дамжуулдаг байх боломжийг бүрдүүлэх;
- ✚ Тухайн асуудлаар мэргэжлийн хүмүүсийг нийтийн сонсгол оролцуулдаг боломжийг бүрдүүлэх;

 Нийтийн сонсголд оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулах хугацааг хангалттай болгох.

**НИЙТИЙН СОНСГОЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮР ДҮН**

/МУИХЧХДТХ-ИЙН 39.1.8/

	Байнгын хорооны нэр	Нийтийн сонсгол зохион байгуулсан эсэх ямар асуудлаар
1	Хууль зүйн байнгын хороо	3 удаа нийтийн сонсголыг зохион байгуулсан. <ul style="list-style-type: none">• Хар тамхи, мансууруулах бодисын хяналтын талаар 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ерөнхий хяналтын сонсгол.• Хууль зүйн байнгын хороо болон Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо хамтран "Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийллийн" талаар Ерөнхий хяналтын сонсголыг 2019 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан.• ХЭҮК-ын болон Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний сонгон шалгаруулалтад оролцогчдын томилгооны сонсголыг 2020 оны 06 дугаар сарын 11-ны өдөр зохион байгуулсан. Улсын онцгой комиссын заавар, зөвлөмжийн дагуу "Ковид-19" цар тахлын үед төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангах үүднээс уг томилгооны сонсголыг цахимаар явуулсан.
2	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	<ul style="list-style-type: none">▪ Агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэгтэй байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүнд төсөвлөгдсөн хөрөнгийн зарцуулалт, үр дүнг тодруулах зорилготой Ерөнхий хяналтын сонсголыг 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулсан.
3	Эдийн засгийн байнгын хороо	<ul style="list-style-type: none">▪ 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслөөр Хууль, тогтоомжийн төслийн сонсгол зохион байгуулсан.▪ 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Авто тээврийн хуулийн хэрэгжилтийн талаар Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулсан.▪ 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Ерөнхий хяналтын сонсгол зохион байгуулсан.



3.3.УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРААС ИРҮҮЛСЭН САНАЛ

УЛСЫН ИХ ХУРАЛ ХЯНАН ШАЛГАХ БҮРЭН ЭРХЭЭ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ХҮРЭЭНД ГҮЙЦЭТГЭЖ БҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ, ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

2021.01.29

Улаанбаатар хот

Улсын Их Хурлын даргын 2020 оны 44, 62 дугаар захирамжаар байгуулагдсан Улсын Их Хурлын хяналт шалгалтын анхдагч хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогтоос 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн УИХ-03/268 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан, мэдээлэл гаргуулах хүсэлтийн дагуу ажлын хэсгийн төлөвлөгөөнд дурдсан асуудал тухай бүрээр дараах мэдээллийг бэлтгэн хүргүүлж байна.

2.1.1.УИХ-ын гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад хандан асуулга, асуулт тавих үйл ажиллагаа, үр дүн (39.1.1, 39.1.2)

УИХ-ын гишүүн асуулга, асуулт тавих, хариуг сонсох, УИХ-аар хэлэлцэн шийдвэр гаргах, гарсан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавих үйл ажиллагааны зохион байгуулалт, үр дүн, практикт тулгарч буй асуудлууд, цаашид парламентын хяналтын үр нөлөөтэй, шуурхай арга хэрэгсэл болгон ашиглахад эрх зүй, зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах:

УИХ-ын гишүүн асуулга, асуулт тавих, хариуг сонсох, УИХ-аар хэлэлцэн шийдвэр гаргах, гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааны зохион байгуулалт, үр дүн, практикт тулгарч буй асуудлууд:

Улсын Их Хурлын гишүүнээс тавих асуулга, асуулт болон тэдгээртэй холбоотой харилцааг Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын 2014 оны 435 дугаар захирамжаар батлагдсан журмын хүрээнд зохицуулдаг.

Гишүүн асуулга, асуултын төслийг Хяналт шалгалтын хэлтэст ирүүлж, арга зүйн туслалцаа, зөвлөгөө авдаг бөгөөд төслийг “Улсын Их Хурлын гишүүний асуулга” гэсэн ягаан, “Улсын Их Хурлын гишүүний асуулт” гэсэн цайвар шар өнгийн хэвлэмэл хуудсан дээр тус тус 4 хувь хэвлэн гарын үсэг зуруулж, Тамгын газрын бичиг хэргээр дамжуулан хүргүүлдэг.

Асуулгын хариуг тухайн албан тушаалтан 30 хоногт, асуултын хариуг 14 хоногт багтаан ирүүлэх үүрэгтэй тул түүнд хяналт тавих зорилгоор асуулгын 1 хувийг Тамгын газрын тухайн асуудал хариуцсан референт авч нэгдсэн бүртгэлд оруулж хугацаандаа хариуг ирүүлэхэд хяналт тавьдаг.

Асуулга, асуултын хариуг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн даргын 2014 оны 435 дугаар захирамжид заасны дагуу тухайн албан тушаалтанд хариуг ирүүлэхийг албан бичгээр мэдэгдэх зохицуулалттай.

Асуулга, асуулт тавьсан гишүүн хариуг нэгдсэн, эсхүл Байнгын хорооны хуралдаанаар сонсох хүсэлтээ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу бичгээр ирүүлэх бөгөөд хэлэлцэх асуудлын дараалалд хариуцсан ажилтан бүртгэн оруулдаг. УИХ-ын даргын дэргэдэх Зөвлөлийн хурлаар хэлэлцэх товыг тогтоосны дараа хариуцсан газрын зүгээс хуралдаанд хэлэлцэх бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг хариуцаж гүйцэтгэдэг.

Цаашид парламентын хяналтын үр нөлөөтэй, шуурхай арга хэрэгсэл болгон ашиглахад эрх зүй, зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

1. УИХ-ын гишүүнээс тавьсан асуулга, асуултад холбогдох албан тушаалтны ирүүлсэн хариу шаардлага хангахгүй байна гэж Улсын Их Хурлын гишүүн үзсэн бол хариуг буцаах, сайжруулж авах харилцааг хуулиар зохицуулах;
2. УИХ-ын гишүүнээс тавьсан асуулга, асуултын хариуг холбогдох албан тушаалтан хуульд заасан хугацааг хоцроон ирүүлэх тохиолдол гарч байгаад зохицуулалт шаардлагатай байна.

УИХ-ын гишүүний асуулга асуулт, түүний хариуг мэдээллийн санд төвлөрүүлж, сэдэвчилсэн мэдээллийн сан үүсгэдэг эсэх талаар:

Улсын Их Хурлын гишүүнээс тавьсан асуулга асуулт, түүний хариуг тухай бүр www.parliament.mn цахим мэдээллийн санд байршуулан ажиллаж байна. Мөн Улсын Их Хурал дахь намын бүлэг, Улсын Их Хурлын гишүүний хүсэлтийн дагуу нийт асуулга, асуултаас тухайн гишүүнээр, эсхүл асуудлаар нь ангилан тухай бүр бэлтгэн өгдөг.

“Улсын Их Хурлын гишүүний асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн талаарх мэдээлэл” эмхэтгэлийг ээлжит чуулган бүрийн завсарлагааны хугацаанд гаргаж гишүүд болон холбогдох газруудад хүргүүлдэг. Хяналт шалгалтын хэлтсээс асуулга, асуултын мэдээллийн санг тавьсан асуудлаар нь сэдэвчилсэн лавлагаа, мэдээллийг гаргаж тус эмхэтгэлд хавсарган оруулахаар ажиллаж байна.

УИХ-ын гишүүн асуулга, асуултын сэдэв тодорхойлох, холбогдох байгууллага, албан тушаалтанд хандан тавих асуулга, асуултын төсөл боловсруулах, хариуг сонсох, УИХ-аас гаргах шийдвэрийн төсөл боловсруулахад Тамгын газраас үзүүлж буй мэргэшсэн ажил үйлчилгээ, түүний зохион байгуулалт, ЗГ болон Тамгын газрын хэлтэс, нэгжүүдийн ажлын уялдаа холбоо, зааг ялгаа:

УИХ-ын гишүүн асуулга, асуултын сэдвийг тухайн асуулга, асуулт тавьж буй гишүүн өөрөө тодорхойлдог. Асуулга, асуултын төслийг боловсруулан ХШҮГ-ын хариуцсан зөвлөхөөр хянуулан, албан ёсны дугаар бүхий хэвлэмэл хуудсыг авна.

Хариуцсан зөвлөх асуулга, асуултын төслийг хянахдаа тухайн асуулга, асуулт нь Улсын Их Хурлын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу боловсруулагдсан эсэх, агуулгын хувьд эрх бүхий албан тушаалтны эрхлэх асуудлын хүрээнд хамаарч буй эсэх талаар хянаж зөвлөгөө өгдөг.

Асуулга, асуултын хариу ирүүлэх хугацаанд хариуцсан зөвлөх, референт зохих хяналтыг тавьж ажилладаг. Асуулга, асуултын хариуг чуулганы болон Байнгын хорооны хуралдаанаар сонсох тохиолдолд холбогдох хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг хариуцан ажиллана.

УИХ-ын гишүүний асуулга, асуултын хариуг хэлэлцээд УИХ-аас тодорхой шийдвэр гаргах шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5, 39.9 дэх хэсэг болон Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.4-т тус тус зохицуулсан.

2016 оноос хойш Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаас гишүүний асуулгын хариуг хэлэлцээд шийдвэр гаргасан тохиолдол гараагүй байна.

ЕНБД-ын 2020 оны “Улсын Их Хурлын Тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг шинэчлэн батлах тухай” 560 дугаар захирамжийн дагуу Хяналт шалгалтын хэлтсийн чиг үүрэгт асуулга, асуултын хариуг хэлэлцэж, тодорхой шийдвэр гаргах тохиолдолд шийдвэрийн төслийг боловсруулахаар тусгасан.

Улсын Их Хурлын даргын зөвлөлийн хуралд Тамгын газрын Тэргүүн дэд дарга оролцож хариуцсан 2 газрын асуудлыг танилцуулж, холбогдох мэдээллийг өгч ажлын уялдааг хангаж ажиллаж байна.

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар асуулгын хариуг хэлэлцэх тов гарсан тохиолдолд ХШҮГ-аас нэгдсэн хуралдааны хуваарьт оруулах тухай саналаа Хууль, эрх зүйн газарт мэдэгдэж тусгуулдаг. Тухайн хуралдаанаар асуулгын хариуг хэлэлцэх бол ХШҮГ-ын Хяналт шалгалтын хэлтсээс хуралдаан удирдах дараалал, ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг гаргаж ХЭЗГ-ын Хуралдаан зохион байгуулах хэлтэст хүргүүлж хамтран ажилладаг.

Асуулгын хариуг танилцуулах Засгийн газрын гишүүний болон ажлын хэсгийн гишүүдийн нэр, хариуг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлдэг. Асуулгын хариуг хэлэлцэхэд оролцох ажлын хэсгийн гишүүдийг ирүүлсэн нэрсийн дагуу нэгдсэн хуралдаанд оролцуулах ажлыг Хяналт шалгалтын хэлтсийн ажилтнууд хариуцан гүйцэтгэдэг. УИХ-ын Тамгын газар, ЗГХЭГ-ын түвшинд энэ чиглэлээр ажлын уялдаа холбоо хангалттай явагдаж чадаж байгаа болно.

УИХ-ын гишүүний асуулга, асуултын мэдээллийн сан бүрдүүлэлт нэгдсэн статистик мэдээлэл:

Асуулга, асуултын мэдээллийн санг Хяналт шалгалтын хэлтэс, хариуцсан ажилтан дээр төвлөрч гардаг.

Асуулга 2002-2020 оны хугацаанд Улсын Их Хурлын нийт 729 гишүүнээс 496 асуулгыг 1552 асуудлаар тавьсан байна. Үүнээс Чуулганы нэгдсэн хуралдаанаар 158 асуулгын хариуг хэлэлцсэн.

Асуулт 2002-2020 оны хугацаанд Улсын Их Хурлын нийт 207 гишүүнээс 143 асуултыг 475 асуудлаар тавьсан байна. Үүнээс Байнгын хорооны хуралдаанаар 15 асуултын хариуг хэлэлцсэн статистик мэдээлэл байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав.

Х-ЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТЫН МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭЛТ, ХОЛБОГДОХ СТАТИСТИК МЭДЭЭГ
/чуул

Х ХУРЛЫН ГИШҮҮНЭЭС ТАВЬСАН АСУУЛГА

	2002 он		2003 он		НИЙТ	2004 он		2005 он		НИЙТ	2006 он		2007 он
	хавар	намар	хавар	намар		хавар	намар	хавар	намар		хавар	намар	хавар
Ирүүлсэн	14	7	4	6	31	-	5	3	17	27	25	13	21
Хэрэглэгчид	11	6	3	6	26	-	5	3	20	28	13	11	13
Үрээнд ийн тоо	39	17	10	8	74	-	5	9	63	77	28	15	32
Үүнээс:													
Бүтээгдсэн	4	2	-	1	7	-	2	1	8	11	10	11	12
Хэрэглэгчид	30	20	-	-	50	-	10	10	30	50	80	55	70
Хэрэглэгчид гоор/	50	30	-	-	80	-	30	20	50	100	290	169	205

	2008 он		2009 он		НИЙТ	2010 он		2011 он		НИЙТ	2012 он		2013 он
	хавар	намар	хавар	намар		хавар	намар	хавар	намар		хавар	намар	хавар
Ирүүлсэн	-	10	18	47	75	50	43	60	41	194	-	31	31
Хэрэглэгчид	-	9	16	35	60	33	21	30	24	108	-	21	21
Үрээнд длын	-	21	39	75	135	78	44	115	92	329	-	78	78
Үүнээс:													
Бүтээгдсэн	-	-	7	12	19	5	9	7	5	26	-	5	6
Хэрэглэгчид	-	-	65	99	164	42	74	77	66	259	-	42	51

гоор/													
	-	-	207	317	524	121	221	246	190	778	-	123	155

2014 он		2015 он		НИЙТ	2016 он		2017 он		НИЙТ	2018 он		2019 он		НИЙТ	2020 он
авар	намар	хавар	намар		хавар	намар	хавар	намар		хавар	намар	хавар	намар		хавар
17	32	32	41	122	-	16	9	16	41	30	26	16	8	50	-
13	15	17	21	66	-	15	9	15	39	19	15	14	8	37	-
48	37	55	66	206	-	45	24	73	142	91	77	67	34	178	-

Үүнээс:

4	2	3	5	14	-	6	4	7	17	3	1	-	-	4	-
19	11	31	31	92	-	47	68	78	193	29	8	-	-	37	-
60	27	67	85	239	-	149	169	210	528	81	31	-	-	112	-

Х ХУРЛЫН ГИШҮҮНЭЭС ТАВЬСАН АСУУЛТ

	2002 он		2003 он		НИЙТ	2004 он		2005 он		НИЙТ	2006 он		2007 он
	хавар	намар	хавар	намар		хавар	намар	хавар	намар		хавар	намар	хавар
	3	1	1	8	13	-	4	-	14	28	1	2	-
	3	1	1	4	9	-	4	-	4	8	1	2	-
рээнд длын	10	4	3	6	23	-	4	-	7	11	1	3	-

Үүнээс:

юоны	1	1	1	1	4	-	-	-	-	-	-	-	-
------	---	---	---	---	---	---	---	---	---	---	---	---	---

	2008 он		2009 он		НИЙТ	2010 он		2011 он		НИЙТ	2012 он		2013 он
	хавар	намар	хавар	намар		хавар	намар	хавар	намар		хавар	намар	хавар
	-	13	11	9	33	11	20	31	9	71	-	11	1
	-	13	10	7	23	9	14	20	6	49	-	11	1
рээнд длын	-	50	29	14	93	31	50	50	36	167	-	30	3

Үүнээс:

юоны	-	-	3	2	5	-	1	1	1	3	-	1	1
------	---	---	---	---	---	---	---	---	---	---	---	---	---

2014 он	2015 он		НИЙТ	2016 он		2017 он		НИЙТ	2018 он		2019 он		НИЙТ	2020 он
	намар	хавар		хавар	намар	хавар	намар		хавар	намар	хавар	намар		
	4	2	1	10	-	-	-	-	-	-	7	-	7	-

2	2	1	8	-	-	-	-	-			2	-	2	-
5	6	3	24	-	-	-	-	-	-	-	2	-	2	-

2.1.2.УИХ-д Ерөнхийлөгч, Засгийн газар болон УИХ-д ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудын тайлан, мэдээлэл, илтгэлийг сонсох, гаргасан шийдвэрийн биелэлтийг хянах, эргэн тайлагнах үйл ажиллагааны зохион байгуулалт, үр дүн (39.1.3)

УИХ-д Ерөнхийлөгч, Засгийн газар болон УИХ-д ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудын тайлан, мэдээлэл, илтгэлийг сонсох, УИХ-аас холбогдох байгууллага/албан тушаалтанд өгсөн үүрэг даалгаврын биелэлтэнд хяналт тавих, эргэн тайлагнах үйл ажиллагааг УИХ-ын Байнгын хороод, Тамгын газрын түвшинд хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрч байгаа талаарх танилцуулга, цаашид уг арга механизмыг парламентын хяналтын үр нөлөөтэй арга хэлбэр болгон ашиглахад тулгамдаж буй асуудлууд болон УИХ, Засгийн газрын түвшинд зайлшгүй бүрдүүлэх шаардлагатай нөхцөлүүдийг тодорхойлж эрх зүй, зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах:

УИХ-д Ерөнхийлөгч, Засгийн газар болон УИХ-д ажлаа хариуцан тайлагнадаг байгууллагуудын тайлан, мэдээлэл, илтгэлийг сонсох үйл ажиллагааны талаар:

1.Байнгын хорооны хуралдаанаар Засгийн газрын гишүүн болон бусад төрийн байгууллагын үйл ажиллагааны болон тодорхой сэдвээр мэдээлэл хийх ажлыг Байнгын хорооны ажлын алба хариуцдаг. Байнгын хорооны ажлын алба тайлан, мэдээллийг хүлээн авч хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж хэлэлцүүлдэг.

Хяналт шалгалтын хэлтсийн хувьд хяналт шалгалтын асуудал хариуцсан ажилтан хуралдаанд оролцож, статистик мэдээллийг хөтөлдөг. Хуралдаанаас шийдвэр гарах тохиолдолд шийдвэрийн төслийг боловсруулах, албажуулах ажиллагааг гүйцэтгэж байна.

2012-2016 оны парламентад Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн, 2016-2020 оны парламентад Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар нар АБГББХ-ны болон нэгдсэн хуралдаанд Гадаад харилцааны яамнаас хэрэгжүүлж байгаа ажлын тайланг танилцуулж байсан байна.

Тодорхой сэдвийн хүрээнд Байнгын хороо яам, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын ажлын талаар сайд, дарга нараас тайлан, мэдээлэл сонсож, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр үүрэг чиглэл өгч ажилладаг хэлбэр тогтмол явагдаж байна.

Цаашид Байнгын хорооны хуралдаанаар тайлан, илтгэл, мэдээллийг хэлэлцээд шийдвэр гарсан тохиолдолд тухайн шийдвэрийн хэрэгжилтийг Байнгын хорооны хуралдаанаар заавал хэлэлцдэг байх эрх зүйн зохицуулалтыг тусгах шаардлагатай болно. Ингэснээр Байнгын хорооны хуралдаанаар сонссон тайлан, илтгэл, мэдээллийг хэлэлцээд гарсан шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлэх, Улсын Их Хурлаас Засгийн газарт тавих хяналтын үйл ажиллагаа тодорхой түвшинд сайжрах боломжтой юм.

2.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлд Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын үйл ажиллагааны тайланг хэлэлцэхээр заасан.

Мөн Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолоор Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудын үйл ажиллагааны тайланг Улсын Их Хуралд ирүүлэхдээ “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж ирүүлэх үүрэг өгч, Хяналт шалгалтын хэлтэс хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон зохицуулалтыг баримталж ажиллаж байна.

яналт шалгалтын хэлтэс нь уг тогтоолын дагуу Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг 8 байгууллага жилийн ажлынхаа тайланг ирүүлэхдээ системчилсэн үнэлгээ хийж ирүүлсэн эсэхэд хяналт тавьж, танилцуулга бэлтгэн, холбогдох санал, дүгнэлтийг бэлтгэн Байнгын хороонд хүргүүлж мэдээллээр ханган ажилладаг.

Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагууд хуульд заасан хугацаанд буюу “Дараа оны нэгдүгээр улиралд” багтаан тайлангаа Улсын Их Хурлын харъяалах Байнгын хороонд ирүүлэх үүрэгтэй.

Тайлан ирүүлсэн статистик мэдээнээс үзвэл ихэнх тохиолдолд тухайн байгууллагууд нь үйл ажиллагааны тайлангаа дараа оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 04 дүгээр сарын 02-ны өдрийн хооронд ирүүлсэн байна.

Харин холбогдох Байнгын хороод тухайн тайланг 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 06 дугаар сарын 12-ны өдрийн хооронд хэлэлцэж, шаардлагатай тохиолдолд буюу 2016 оноос хойш 7 удаа Байнгын хорооны тогтоол, тэмдэглэлээр үүрэг, чиглэл өгсөн байна. Тогтоол, тэмдэглэлээр өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийн талаар тухайн Байнгын хорооны хуралдаанд тайлан тавьсан байгууллагаас эргэж танилцуулдаггүй байна.

Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудаас тухайн жилийн үйл ажиллагааны тайлан ирүүлэх, холбогдох Байнгын хороогоор хэлэлцэх үйл ажиллагаа тогтмолжсон хэдий ч Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолоор баталсан Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийж ирүүлэх үүргийн хэрэгжилт хангалтгүй байгаа болно. Тухайлбал, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл, Монголбанк зэрэг байгууллага тухайн жилийн үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээг хийж ирүүлдэггүй.

Дэлгэрэнгүй статистик мэдээллийг хүснэгтээр гаргав.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасны дагуу Ерөнхийлөгчийн тайланг сонсохтой холбоотой үйл ажиллагааг одоогоор ХШҮГ-аас хариуцан гүйцэтгээгүй болно.

**АЖЛАА ШУУД ХАРИУЦАН ТАЙЛАГНАДАГ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ ХЭЛЭЛЦЭГ
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

Байгууллагууд	Үндэсний аудитын газрын тайлан	Монгол банкны тайлан	Төрийн албаны зөвлөлийн тайлан	Үндэсний статистикийн хорооны тайлан	Санхүүгийн зохицуулах хорооны тайлан	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тайлан
айнгын хороо	ТБХ	ЭЗБХ	ТББХ	ЭЗБХ	ЭЗБХ	НББХ
Ирүүлсэн огноо	2016.03.31	-	2016.03.31	2016.03.30	2016.04.01	2016.03.30
Дүгнэн огноо	2016.05.19	-	-	-	-	2016.04.12
Ирүүлсэн огноо	2017.03.27	-	2017.05.19	2017.03.30	2017.03.30	2017.03.27
Дүгнэн огноо	-	-	2017.05.23	2017.06.07	2017.06.07	2017.04.19
Дээд үүрэг чиглэл үзэх	-	-	-	БХ-ны тогтоолоор	БХ-ны тогтоолоор	-
Ирүүлсэн огноо	2018.03.19	-	2018.03.30/ 2018.04.25 ¹³¹	2018.03.30	2018.03.30	2018.03.30
Дүгнэн огноо	2018.04.17	-	2018.05.01	2018.04.18	2018.05.02	2018.04.10
Дээд үүрэг чиглэл үзэх	-	-	Хуралдааны тэмдэглэлээр	БХ-ны тогтоолоор	БХ-ны тогтоолоор	Хуралдааны тэмдэглэлээр
Ирүүлсэн огноо	2019.03.29	-	2019.03.29/ 2019.04.05 ¹³²	2019.03.28	2019.04.03	2019.04.01
Дүгнэн огноо	2019.06.12	2019.06.12	2019.05.15	2019.06.12	-	-
Дээд үүрэг чиглэл үзэх	-	-	Хуралдааны тэмдэглэлээр	-	-	-
Ирүүлсэн огноо	2020.03.27	2020.07.08	2020.03.27	2020.03.18	2020.04.03	2020.03.31
Дүгнэн огноо	2020.05.12	-	-	2020.04.21	2020.04.15	-
Дээд үүрэг чиглэл үзэх	-	-	-	-	-	-

¹³¹Эзний тайлан ирүүлсэн огноо

¹³²Эзний тайлан ирүүлсэн огноо

Улсын Их Хурлаас холбогдох байгууллага, албан тушаалтанд өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, эргэн тайлагнах үйл ажиллагааны талаар:

Хяналт шалгалтын хэлтэс нь Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, тэмдэглэлээр Засгийн газар болон төрийн бусад байгууллагад үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийг тухай бүр мэдээллийн сангийн хяналтанд авч ажилладаг.

Өмнө мөрдөгдөж байсан /2007 онд баталсан/ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт “Засгийн газрын гишүүд хагас жил тутам хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлогын баримт бичгийн болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаарх тайланг холбогдох Байнгын хороонд ирүүлнэ” гэж заасан байсан.

Харин 2020 онд баталж одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар уг заалт хасагдсан тул хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, УИХ-д тайлагнахтай холбогдсон харилцаа тодорхойгүй болсон.

Харин Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 1 дүгээр хавсралтад заасны дагуу хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг Улсын Их Хуралд 4 дүгээр болон 9 дүгээр саруудад тус тус ирүүлэхээр заасан эрх зүйн орчинд энэ харилцаа явагдаж байна.

Энэ хүрээнд Засгийн газраас хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан мэдээллийг дээрх журмын дагуу үнэлэн Улсын Их Хурлын Тамгын газарт ирүүлэх бөгөөд Хяналт шалгалтын хэлтэс нь уг тайланд үндэслэн Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль тогтоомж тус бүрээр шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн холбогдох Байнгын хороодод хүргүүлж биелэлтийг тооцон ажиллаж байна. Байнгын хороодоос хяналтаас хасахаар ирүүлсэн хууль, тогтоомжийн хэсэг, заалтыг Тамгын газрын хяналтаас хасч мэдээллийг Засгийн газарт хүргүүлж байна.

Тулгамдаж буй асуудлууд: Засгийн газар болон төрийн бусад байгууллагад үүрэг, чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан, мэдээг ирүүлэх талаар хуульд нарийвчилсан зохицуулалт байхгүй, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмаар зохицуулж байгаас шалтгаалан дараах хүндрэлтэй асуудлууд үүсч байна.

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан мэдээг ЗГХЭГ-аас хагас жил тутам ирүүлдэг хэдий ч ихэвчлэн 2-6 сарын хугацаа хоцорч Байнгын хороодыг хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар үнэн зөв, бодитой мэдээллээр шуурхай хангах, тайлагнах үүрэг, мэдээллийн ач холбогдол зэрэг нь буурч байна. Тухайлбал, 2020 оны эхний хагас жилийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлан 2020 оны 9 дүгээр сард ирүүлэх байтал 12 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хурлын Тамгын газарт даруй 3 сар хоцорч ирсэн.
2. Засгийн газраас ирүүлсэн тайланд шинжилгээ хийхэд хяналтад авсан ихэнх хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг ирүүлдэггүй, өмнө ирүүлсэн мэдээг дахин давтан ирүүлэх, Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоолоор хугацаатай танилцуулахаар үүрэг болгосон тогтоолын хэрэгжилтийг тайлагнадаггүй зэрэг зөрчлүүд удаа дараа давтан гарч байна. Тухайлбал, 2020 оны эхний хагас жилийн байдлаар Хяналт шалгалтын хэлтсийн хяналтад авсан хуулийн 76.3 хувь, Улсын Их Хурлын тогтоолын 77.1 хувь, Байнгын хороодын тогтоолын 90.3 хувийн хэрэгжилтийн мэдээг ирүүлээгүй зөрчил гарлаа.
3. Зарим хууль тогтоомжийн хэсэг, заалтын хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байгаа шалтгаан нөхцөлийг тайлбарлан тодруулаагүйгээр үнэлэх, мэдээллийн санг шинэчлэхгүй байх, өмнө ирүүлсэн хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь хэмжээг

бууруулан үнэлж ирүүлэх, шинээр хяналтад авсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг ирүүлэхгүй байх, тайлангийн бичилт, боловсруулалт хангалтгүй байгаа зэргээс шалтгаалан Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсч байна.

4. Хяналт шалгалтын хэлтэс нь хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрээр Засгийн газрын гишүүдэд болон УИХ-д ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдлагад хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон дүрэм, журам, заавар батлан гаргах тусгайлан үүрэг, чиглэл өгсөн заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг хангуулан ажилладаг өнөөгийн энэ зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай байна.

Эрх зүй, зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг тайлагнах, өгсөн үүрэг, чиглэл, даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах, Байнгын хорооны хуралдаанаар эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг хэлэлцдэг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
2. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагууд үйл ажиллагааны тайландаа системчилсэн үнэлгээг батлагдсан аргачлалын дагуу хийж ирүүлсэн эсэх талаарх Тамгын газраас хийсэн танилцуулга, санал, дүгнэлтийг холбогдох Байнгын хороо хуралдаанаар сонсож, шийдвэрийн төсөлд тусгадаг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
3. Байнгын хорооны хуралдаанаар тайлан, илтгэл, мэдээллийг хэлэлцээд шийдвэр гарсан тохиолдолд тухайн шийдвэрийн хэрэгжилтийг Байнгын хорооны хуралдаанаар заавал хэлэлцдэг байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох;
Ингэснээр Байнгын хорооны хуралдаанаар тайлан, илтгэл, мэдээллийг хэлэлцээд гарсан шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэх, Улсын Их Хурлаас Засгийн газарт тавих хяналтын үйл ажиллагаа тодорхой түвшинд сайжрах боломжтой болох юм.
4. Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналтын үйл ажиллагааг сайжруулах хүрээнд Засгийн газрын гишүүний жилийн ажлын тайланг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар жил бүр заавал хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгдөг эрх зүйн зохицуулалтыг бий болгох;

УИХ-ын тухай хуулийн 39.1.3, 39.11-д заасан байгууллагуудаас тайлан, мэдээлэл гаргуулах үйл ажиллагааны үр дүн, мэдээллийн сан бүрдүүлэлт, тайлан мэдээлэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн талаарх танилцуулга, статистик мэдээллийг гаргаж ирүүлэх:

2016-2021 ОНД БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ

Хамрах хугацаа	Мэдээллийн тоо	Мэдээллийн хүрээ		Асуулт асууж, санал хэлсэн УИХ-ын гишүүд /давхардсан тоогоор/	Асуулт, саналын тоо /тоогоор/
		Хуульд заасан хугацаанд	Цаг үеийн асуудлаар		
2016 он	19	1	18	94	430
2017 он	43	12	31	205	798
2018 он	37	9	28	258	626
2019 он	24	6	18	152	376
2020 он	16	10	6	147	295
2021 он	1	-	1	5	15
Нийт дүн	140	38	102	861	2540

**УИХ-ЫН БАЙНГЫН, ДЭД, ТҮР ХОРООДЫН ХУРАЛДААНААР
СОНССОН МЭДЭЭЛЭЛ**

2016 ОНД БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ /2016.01.01-12.31/					
№	Байнгын хорооны нэр, мэдээлэл сонссон огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Асуулт, санал хэлсэн УИХ-ын гишүүд /давхардсан тоогоор/	Асуулт, саналын тоо
1.	БОХХААБХ 2016.09.08	ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн	Намрын ургац хураалтын талаарх мэдээлэл	6	25
2.	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.02	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж	Ашигт малтмалын лиценз олголт, газрын тосны хайгуулын зөвшөөрөл бүхий компаниудын хайгуулын болон олборлолтын үйл ажиллагааны явц, Тавантолгой болон стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр хийгдэж байгаа ажлын явц, Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн явц байдал, цаашдын чиг хандлагын талаар	5	22
3.	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.08	Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат	Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын хэрэгжилт, Хөшигийн хөндийн шинэ нисэх буудлын ажлын явц, байдал, тулгамдсан асуудлууд	9	52
4.	НББСШУБХ 2016.11.09	ХНХ-ын сайд Н.Номтойбаяр	Нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагааны талаар	4	11
5.	НББСШУБХ 2016.11.09	ХНХ-ын сайд Н.Номтойбаяр	Хүүхэд харах үйлчилгээний талаар	3	9
6.	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2016.11.15	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол	“Нийслэл хот болон томоохон суурин газрын агаарын бохирдлын тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр	4	20
7.	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2016.11.15	“Любрикон Монголиа” ХХК-ийн захирал Э.Эрдэнэбаатар, “МОНВАТТ” ХХК-ийн захирал Т.Пүрэвдорж, “Эко Ресурс” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Ш.Цогтбаатар	Агаарын бохирдол бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа зарим аж ахуйн нэгжийн үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний танилцуулгын талаар	3	10

8.	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.16	Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Б.Цогтгэрэл	Төмөр замын тээврийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, төмөр замын транзит тээврийн байдал, тулгамдсан асуудлуудын талаар	7	38
9.	ТББХ 2016.11.16	Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн	Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн дүнгийн талаар	2	4
10.	Хууль зүйн байнгын хороо 2016.11.16	Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж	Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаархи Хүний эрхийн үндэсний комиссын 15 дахь илтгэл	1	1
11.	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.22	Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн	Монголын хөрөнгийн зах зээлийн байдал, цаашдын чиг хандлагын талаар	7	34
12.	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.22	Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Нямаа	Төрийн банкны үйл ажиллагаа, хувьчлах бэлтгэл ажлын явц, байдлын талаар	5	14
13.	Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо 2016.11.23	ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулга	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн хэрэгжилт болон жижиг, дунд үйлдвэрийн салбарт хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүд, тулгамдсан бусад асуудлуудын талаар	5	33
14.	Эдийн засгийн байнгын хороо 2016.11.29	Эрчим хүчний сайд П.Ганхүү	Эрчим хүчний талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөрт эрчим хүчний чиглэлээр туссан зорилт, арга хэмжээний бэлтгэл ажлын явц байдал, тулгамдсан асуудлын талаар	7	45
15.	БОХХААБХ 2016.11.30	БОАЖ-ын сайд Д.Оюунхорол	Байнгын хорооны 2015 оны 05, 07 тоот тогтоолын биелэлтийн талаар	1	2
16.	Эдийн засгийн байнгын хороо 2016.12.20	Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр	Ипотекийн зээлийн хөтөлбөрийн хэрэгжилт, барилгын салбарын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлуудын талаар	3	20
17.	Эдийн засгийн байнгын хороо 2016.12.14	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын өр, зээлийг барагдуулж, ашигт ажиллагааны түвшинг дээшлүүлэх талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүн болон 2017	9	39

			онд хувьчлагдах объектуудын хувьчлалын бэлтгэл ажлын явц, байдал, тулгамдсан асуудлуудын талаар		
18.	Эдийн засгийн байнгын хороо 2016.12.27	Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан	Үндэсний хөгжлийн газрын үйл ажиллагаа, гадаадын хөрөнгө оруулалтын байдал, Концессын тухай хуулийн хэрэгжилтийн талаар	7	32
19.	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2016.12.27	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн	Хөдөө аж ахуйн “Халх гол” үндэсний бүтээн байгуулалтын бүс байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2016 оны 46 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	6	19
ДҮН-19				94	430

2017 ОНД БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ /2017.01.01-12.31/					
№	Байнгын хорооны нэр, мэдээлэл сонссон огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Асуулт асууж, санал хэлсэн УИХ-ын гишүүд /давхардсан тоогоор/	Асуулт, саналын тоо
1.	Эдийн засгийн байнгын хороо 2017.01.04	ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн	Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн хэрэгжилт, хүнс хөнгөн аж үйлдвэрийн хөгжлийн талаар	8	30
2.	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2017.01.10	Цөмийн энергийн комиссын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Г.Манлайжав	Цөмийн энергийн салбарын өнөөгийн байдлын талаар	4	17
3.	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2017.01.18	Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат	Төрийн ордны барилгын өнөөгийн байдлын дүгнэлт, чанар, аюулгүй байдлын шаардлагыг хангах зарим арга хэмжээний талаар	3	7
4.	Өргөдлийн байнгын хороо 2017.01.24	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын сайд Н.Номтойбаяр	“Ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлийг бууруулах арга зам” сэдэвт хэлэлцүүлэгт оролцогчдоос гаргасан саналын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар	7	27
5.	Төрийн байгуулалтын байнгын хороо 2017.01.31	МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн	Байнгын хорооны 2016 оны 07 тоот тогтоолын хэрэгжилтийн талаар	2	2

		дарга Б.Энхмандах			
6.	Эдийн засгийн байнгын хороо 2017.02.01	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол	Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал болон эдийн засгийг сэргээх хөтөлбөрт аялал жуулчлалын талаар тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын явц, тулгамдсан асуудлуудын талаар	8	24
7.	Өргөдлийн байнгын хороо 2017.02.01	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж	Өргөдлийн байнгын хорооноос “Туул голын бохирдлын асуудлаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2016 оны 03 дугаар тогтоолын биелэлт, явцын талаар	4	15
8.	АБГББХ 2017.02.01	Гадаад харилцааны сайд Ц.Мөнх- Оргил	Гадаад харилцааны яамны 2016 оны тайлан	Хаалттай хуралдаан	
9.	Төсвийн байнгын хороо 2017.02.01	ҮАГ-ын Нийцлийн аудитын газрын дарга Б.Алтанзул	Үндэсний аудитын газраас Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайлан	4	7
10.	Эдийн засгийн байнгын хороо 2017.02.07	Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоолын хэрэгжилт, 2017 оны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын явц байдлын талаар	9	31
11.	БОХХААБХ 2017.02.08	Барилга, хот байгуулалтын сайд Г.Мөнхбаяр	Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар	9	51
12.	НББСШУБХ 2017.02.08	Эрүүл мэндийн сайд А.Цогцэцэг	Эрүүл мэндийн салбарын өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор хийж байгаа ажлын явц байдлын талаар	7	22
13.	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2017.02.08	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Оюунхорол	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017.01.10-ны өдрийн 03-03 тоот зөвлөмжийн дагуу агаарын бохирдлыг бууруулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ болон хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний талаар	5	35
14.		Эрчим хүчний сайд П.Ганхүү	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны 2016.11.24-ний өдрийн 12/5391 албан тоотын 6, 7, 8 дахь заалтын биелэлтийн явц, үр дүнгийн талаар		

15.	АБГББХ 2017.02.08	Батлан хамгаалахын сайд Б.Бат- Эрдэнэ	Батлан хамгаалах яамны 2016 оны үйл ажиллагааны тайлан	Хаалттай хуралдаан	
16.	Өргөдлийн байнгын хороо 2017.04.12	Барилга, хот байгуулалтын дэд сайд Ш.Лхамсүрэн	Өргөдлийн байнгын хорооны 2016 оны 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар	12	31
17.	Эдийн засгийн байнгын хороо 2017.04.19	Монгол Улсын шадар сайд У.Хүрэлсүх	Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагаа, цаашдын чиглэлийн талаар	5	11
18.	Эдийн засгийн байнгын хороо 2017.04.19	Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд тусгаж байгаа төсөл, арга хэмжээ, Эдийн засгийн байнгын хорооны 2016.12.27-ны өдрийн хуралдаанаас өгсөн чиглэлийн биелэлтийн талаар	8	41
19.	БОХХААБХ 2017.04.19	ХХААХҮ-ийн сайд П.Сэргэлэн	Мал аж ахуйн салбарын хаваржилт, мал төллөлтийн явцын талаар	3	14
20.	БОХХААБХ 2017.04.19	Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин	Цаг агаарын 4, 5 дугаар сарын төлөв байдлын талаар	2	5
21.	НББСШУБХ 2017.04.19	ХНХ-ын сайд Н.Номтойбаяр	Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайлан	5	16
22.	Өргөдлийн байнгын хороо 2017.05.02	ХХААХҮийн сайд П.Сэргэлэн, Нийслэлийн ЗД- ын орлогч Ж. Батбаясгалан	УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоол, Өргөдлийн байнгын хорооны 2016 оны 03 дугаар тогтоолуудын хэрэгжилтийн талаар	3	10
23.	Эдийн засгийн байнгын хороо 2017.05.02	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор	“Эрдэнэт Үйлдвэр” ХХК-ийн талаар Улсын Их Хурлаас гаргасан 2017 оны 23 дугаар тогтоолын хэрэгжилт, тус үйлдвэрийн үйл ажиллагааны өнөөгийн байдал, 2017 онд хувьчлагдах объектуудын хувьчлалын бэлтгэл ажлын явц, Эдийн засгийн байнгын хорооны 2016.12.14-ний өдрийн хуралдаанаас өгсөн чиглэлийн биелэлтийн талаар	5	13
24.	БОХХААБХ 2017.05.16	БОАЖ-ын сайд Д.Оюунхорол	Байгаль орчны төлөв байдлын 2015-2016 оны тайлан	4	13
25.	ТББХ 2017.05.16	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон	Улсын Их Хурлын Тамгын газрын 2016 оны үйл ажиллагааны тайлан	4	13
26.	Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хороо 2017.05.16	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд П.Сэргэлэн	Монгол Улсын хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын өнөөгийн байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар	6	29

27.	Эдийн засгийн байнгын хороо 2017.05.17	“Эрдэнэс Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал Ц.Түмэнцогт	“Эрдэнэс-Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны байдал, цаашдын чиглэлийн талаар	6	31
28.	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо 2017.05.17	Үндэсний хөгжлийн газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Ж.Должинсүрэн	“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030”-ын хэрэгжилт, өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх зорилтын талаар	4	17
29.		ҮСХорооны Үндэсний тооцоо, шинжилгээ, судалгааны газрын дарга А.Дэмбэрэл	“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал- 2030”-ын биелэлт, дүгнэлт, цаашид авах арга хэмжээний талаар		
30.	ТББХ 2017.05.23	Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо	Төрийн албаны зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайлан	5	14
31.	Эдийн засгийн байнгын хороо 2017.05.24	Сангийн дэд сайд Х.Булгантуяа	Засгийн газрын гадаад, дотоод өрийн удирдлагын байдал, Засгийн газрын гадаад бондыг эргүүлэн төлөх, дахин санхүүжүүлэх чиглэлээр авч байгаа арга хэмжээний талаар	4	24
32.	Эдийн засгийн байнгын хороо 2017.06.07	СЗХ-ны дарга С.Даваасүрэн	Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны үйл ажиллагааны тайлан	7	36
33.	Эдийн засгийн байнгын хороо 2017.06.07	ҮСХ-ны дарга А.Ариунзаяа	Үндэсний статистикийн хорооны 2016 оны үйл ажиллагааны тайлан	3	16
34.	Хүний эрхийн дэд хороо 2017.10.17	ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж	Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 16 дахь илтгэл	8	31
35.	Хууль зүйн байнгын хороо 2017.10.17	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадорж	Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 16 дахь илтгэл /үргэлжлэл/	5	12
36.	Өргөдлийн байнгын хороо 2017.11.15	БОАЖ-ын дэд сайд Ц.Батбаяр, Нийслэлийн засаг даргын орлогч Ж.Батбаясгалан	Монгол Улсын Их Хурлын 2012 оны “Малчид, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 74 дүгээр тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих Өргөдлийн байнгын хорооны ажлын хэсгийн тайлан	5	16
37.	Өргөдлийн байнгын хороо 2017.12.06	Байгаль орчин, аялал жуулчлалын дэд сайд Ц.Батбаяр	Агаарын бохирдол, түүний хор хохирлыг бууруулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай Өргөдлийн байнгын хорооны 2017 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах талаар Монгол Улсын Засгийн	7	33

			газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар		
38.	Өргөдлийн байнгын хороо 2017.12.13	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаар “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2016 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	3	21
39.	НББСШУБХ 2017.12.19	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл	Эрүүл мэндийн даатгалын сан байгуулагдсанаас хойших үйл ажиллагааны болон санхүүгийн хэрэгжилтийн талаар, мөн тус сан Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудалд шилжихтэй холбоотой бэлтгэл ажлын талаар	3	9
40.	НББСШУБХ 2017.12.19	ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр	Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого батлах тухай УИХ-ын 2015 оны 53 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	0	0
41.	НББСШУБХ 2017.12.26	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа	Боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2017.07.05-ны өдрийн 25 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	7	29
42.	НББСШУБХ 2017.12.26	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа	Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2017.06.09-ний өдрийн 24 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар	6	29
43.	НББСШУБХ 2017.12.26	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа	Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2017.07.26-ны өдрийн 26 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар	5	16
ДҮН-43				205	798

2018 ОНД БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ /2018.01.01-12.31/					
№	Байнгын хорооны нэр, мэдээлэл сонссон огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Асуулт асууж, санал хэлсэн УИХ-ын гишүүд /давхардсан тоогоор/	Асуулт, саналын тоо
1.	БОХХААБХ 2018.01.10	ХХААХҮЯ-ны ТНБД-ын албан үүргийг түр хариуцагч бөгөөд Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Д.Энхбат	Мал, амьтны эрүүл мэндийн тухай болон Малын генетик нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний талаар	4	7
2.	БОХХААБХ 2018.01.10	ХХААХҮЯ-ны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Л. Чой-Иш	Мөн өвс тэжээлтэй холбогдуулан улсын төсөвт батлагдсан 45 тэрбумын гүйцэтгэлийн талаар	4	16
3.	Хууль зүйн байнгын хороо 2018.01.31	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Бямбадорж	Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 16 дахь илтгэл	5	14
4.	Өргөдлийн байнгын хороо 2018.02.06	БХБ-ын дэд сайд Ш.Лхамсүрэн, Нийслэлийн ЗД-ын Дэд бүтэц, гэр хорооллын хөгжлийн асуудал хариуцсан орлогч П.Баярхүү, ТОСК-ийн захирал Ж.Хичээнгүй	“Ахмадын орон сууц”, “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар	7	29
5.	НББСШУБХ 2018.04.10	ЭМДҮЗ-ийн дэд дарга Д.Дэмбэрэл	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайлан	4	4
6.	НББСШУБХ 2018.04.10	ХНХ-ын сайд С.Чинзориг	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайлан	8	8
7.	Төсвийн байнгын хороо 2018.04.17	Үндэсний аудитын газрын дарга Д.Хүрэлбаатар	Төрийн аудитын байгууллагын 2017 оны үйл ажиллагааны тайлан	12	15
8.	Эдийн засгийн байнгын хороо 2018.04.18	ҮСХ-ны дарга Л.Ариунзаяа	Үндэсний статистикийн хорооны 2017 оны үйл ажиллагааны тайлан	7	10
9.	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо 2018.04.24	Үндэсний статистикийн хорооны дарга А.Ариунзаяа	“Тогтвортой хөгжлийн зорилтуудын талаарх мэдээллийн мониторинг”	2	2

10.	Тогтвортой хөгжлийн зорилгын дэд хороо 2018.04.24	Үндэсний хөгжлийн газрын дарга Б.Баярсайхан	“Засгийн газрын гурван тулгуурт бодлого ба үндэсний хөгжлийн үзэл баримтлал-30, НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудын уялдаа”	3	3
11.	Өргөдлийн байнгын хороо 2018.04.25	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар	Өргөдлийн байнгын хорооны 2017 оны 02 тогтоолын хэрэгжилтийн талаар УУХҮ-ийн сайдын мэдээлэл	6	12
12.	Төрийн байгуулалтын байнгын хороо 2018.05.01	Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Цогоо	Төрийн албаны зөвлөлийн 2017 оны үйл ажиллагааны тайлан	4	21
13.	Эдийн засгийн байнгын хороо 2018.05.02	Санхүүгийн зохицуулах хорооны дарга С.Даваасүрэн	Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны үйл ажиллагааны тайлан	11	17
14.	БОХХААБХ 2018.05.02	БОАЖ-ын сайд Н.Цэрэнбат	Богдхан уулын дархан цаазат газарт хамаарах Туул голын эрэг дагуу аялал жуулчлал эрхлэх зориулалтаар эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл	6	41
15.	Төрийн байгуулалтын байнгын хороо 2018.05.09	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон	Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2017 оны үйл ажиллагааны тайлан	3	6
16.	Эдийн засгийн байнгын хороо 2018.05.09	Монгол Улсын шадар сайд Ө.Энхтүвшин	“Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2016 оны 34 дүгээр тогтоолын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт, үр дүнгийн талаарх мэдээлэл	4	10
17.	БОХХААБХ 2018.05.16	ХХААХҮ-ийн сайд Б.Батзориг	Монгол Улсын Их Хурлын 2017 оны 81, 82 дугаар тогтоолын биелэлтийн талаарх мэдээлэл	3	11
18.	БОХХААБХ 2018.05.16	ХХААХҮ-ийн сайд Б.Батзориг	Мах, сүүний анхдугаар аяны хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх мэдээлэл	3	9
19.	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2018.05.16	БОАЖ-ын сайд Н.Цэрэнбат	Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрний урсац бүрэлдэх эхийн хилийн заагийн солбилцол, Ойн сан бүхий газрын хилийн заагийн солбилцол, Усан сан бүхий газрын хамгаалалтын бүсийн солбилцлын талаарх мэдээлэл	4	12

20.	НББСШУБХ, БОХХААБХ 2018.05.30	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат	УИХ-ын “Агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2018 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн тайлан, УИХ-ын даргын 2017 оны 212 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн зөвлөмжийн дагуу МУ-ын ЗГ, Нийслэлийн ЗД-аас хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээлэл	16	39
21.	Эдийн засгийн байнгын хороо 2018.06.05	Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх чиглэлээр Монголбанкнаас 2017 онд зохион байгуулсан ажлын талаарх мэдээлэл	15	27
22.	НББСШУБХ 2018.06.26	ХНХ-ын сайд С.Чинзориг, БСШУС-ын дэд сайд Г.Ганбаяр, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл	Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 2018 оны хөрөнгө оруулалтын явц, гүйцэтгэлийн тухай мэдээлэл	4	5
23.	НББСШУБХ 2018.06.26	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл	Байнгын хорооны 2018.05.22- ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр хүргэгдсэн эрүүл мэндийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийн зарцуулалтыг шалгасан ажлын хэсгийн тайлангийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл	9	13
24.	Өргөдлийн байнгын хороо 2018.06.27	Нийслэлийн Засаг дарга С.Батболд, БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газрын дарга Ч.Батсансар	Туул голын эргийн дагуу Баянзүрхийн гүүрнээс яармагийн гүүр хүртэлх газар ашиглах, барилга барих эрхийн зөвшөөрөл олгосон асуудлаарх мэдээлэл	8	13
25.	Эдийн засгийн байнгын хороо 2018.10.17	Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан	Валютын ханшийн өсөлт, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээлэл	10	39
26.	Эдийн засгийн байнгын хороо 2018.10.17	Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар	Бензин, шатахууны үнийн өсөлт, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээлэл	6	19
27.	БОХХААБХ 2018.10.23	ХХААХҮ-ийн сайд Б.Батзориг	Мал тооллого, хадлан, тэжээл, ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэл ажил, хүнсний ногооны хангамжийн талаарх мэдээлэл	4	6
28.	БОХХААБХ 2018.10.23	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат	Агаарын бохирдлыг бууруулах талаар УИХ-ын болон Байнгын хороодын хамтран баталсан тогтоолын биелэлтийн талаарх мэдээлэл	8	30

29.	Өргөдлийн байнгын хороо 2018.10.24	БХБХ-ын дэд сайд Ш.Лхамсүрэн, Нийслэлийн гэр хорооллын дэд бүтцийн газрын дарга Ч.Батбилэг	Өргөдлийн байнгын хорооны 2018 оны 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	5	23
30.	Өргөдлийн байнгын хороо 2018.10.24	Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор Л.Одгэрэл	Үндэсний аудитын газраас 2018 онд “Цэвэр агаар сан”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан	9	35
31.	Эдийн засгийн байнгын хороо 2018.10.30	УУХҮЯ-ны ТНБД Г.Нандинжаргал	Алт олборлолтын явцын талаарх мэдээлэл	9	15
32.	Хүний эрхийн дэд хороо 2018.11.14	ХЭҮК-ын дарга Ж.Бямбадорж	Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын 17 дахь илтгэл	11	24
33.	Эдийн засгийн байнгын хороо 2018.11.13	Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан	Ипотекийн зээл олголтын байдал, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээлэл	11	14
34.	Өргөдлийн байнгын хороо 2018.12.05	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат	УИХ-ын 1998 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Тусгай хамгаалалттай бүс нутгийн үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл	4	8
35.	НББСШУБХ 2018.12.11	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Мөнгөнчимэг	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2017 оны 46 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	10	25
36.	НББСШУБХ 2018.12.18	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг	Хүүхдийн эрхийн тухай болон хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл	5	8
37.	НББСШУБХ 2018.12.25	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Мөнгөнчимэг, Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн	Агаарын бохирдлын улмаас хүн амын дунд тохиолдож байгаа өвчлөл, эрүүл мэндийн асуудал, эрүүл мэндийн байгууллагын ачаалал, нөхцөл байдал, үүнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл болон эрүүл мэндийн тухай, ЭМД-ын тухай, нийгмийн даатгалын тухай, нийгмийн	14	36

		халамжийн тухай хуулиудын холбогдох заалтууд УИХ-ын 2018.01.05-ны өдрийн агаарын бохирдлыг бууруулахтай холбогдуулан авах арга хэмжээний тухай 02 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл		
	ДҮН-37		258	626

2019 ОНД БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ /2019.01.01-12.31/					
№	Байнгын хорооны нэр, мэдээлэл сонссон огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Асуулт асууж, санал хэлсэн УИХ-ын гишүүд /тоогоор/	Асуулт, саналын тоо
1.	НББСШУБХ 2019.01.08	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг	Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газраас чиглэл өгөх тухай НББСШУБХ-ны 2018 оны 6 сарын 22-ны өдрийн 17 тоот тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	5	7
2.	НББСШУБХ 2019.01.08	ХНХ-ын сайд С.Чинзориг, БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа, ЭМ-ийн сайд Д.Сарангэрэл	2018 оны төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаарх мэдээлэл	2	7
3.	НББСШУБХ 2019.01.29	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” НББСШУБХ-ны 2018.05.22-ны өдрийн 14 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	2	5
4.	НББСШУБХ 2019.01.29	БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа	Соёл, урлагийн салбарын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай НББСШУБХ-ны 2018.10.16-ны өдрийн 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	4	8
5.	НББСШУБХ 2019.01.29	БСШУС-ын сайд Ц.Цогзолмаа	Монгол Улсын консерватори /хөгжмийн дээд боловсролын байгууллага/-ийн талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай НББСШУБХ-ны 2018.05.15-ны өдрийн 13 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	2	7
6.	НББСШУБХ 2019.01.29	Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл	Амьсгалын замын халдварт өвчин, Томуу, томуу төст өвчинтэй холбогдуулан ЗГ-аас авс	4	9

			хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх мэдээлэл		
7.	Өргөдлийн байнгын хороо 2019.04.16	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ТНБД Г.Өнөрбаяр	“Эхийн алдар” нэгдүгээр, хоёрдугаар зэргийн одонг олгох хууль эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлын талаар ирүүлсэн өргөдлийн дагуу хийсэн мэдээлэл	8	12
8.	БОХХААБХ 2019.05.01	ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан	Мал төллөлт болон хаваржилтийн талаарх мэдээлэл	4	4
9.	ХЗБХ 2019.05.08	ХЭҮК-ийн дарга Ж.Бямбадорж	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 18 дахь илтгэл	12	38
10.	Өргөдлийн байнгын хороо 2019.05.08	Барилга, хот байгуулалтын дэд сайд Б.Мөнхбаатар	Түрээсийн орон сууцны хөтөлбөр, журам, бүртгэлтэй холбоотой асуудлаар иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу хийсэн мэдээлэл	8	16
11.	ТББХ 2019.05.15	Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг	“Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны тайлан”	6	19
12.	НББСШУБХ 2019.05.21	Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан	Орон сууцжуулах хөтөлбөрт багш, эмч, төрийн жинхэнэ албан хаагчдыг хэрхэн хамруулах тухай	8	24
13.	ӨБХ, БОХХААБХ 2019.05.22, 28	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан	Туул голын ойр орчимд олгосон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл	11	33
14.	ӨБХ 2019.05.28	МХЕГ-ын дэд дарга Д.Энхсайхан	Аюултай хог хаягдлын асуудлаар холбогдох байгууллагын мэдээлэл	4	13
15.	БОХХААБХ 2019.05.28	Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ч.Улаан	Хүнсний аюулгүй байдал болон хүнсний гол нэрийн зарим бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн талаар авах арга хэмжээний талаарх танилцуулга	10	31
16.	ТББХ 2019.06.05	УИХ-ын ТГ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан	Улсын Их Хурлын Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны тайлан	1	3
17.	ТББХ 2019.06.11	ЗГХЭГ-ын дарга Л.Оюун-Эрдэнэ	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	2	3
18.	ЭЗБХ 2019.06.12	ҮСХ-ны дарга Л.Ариунзаяа	Үндэсний статистикийн хорооны 2018 оны үйл ажиллагааны тайлан	7	11
19.	ЭЗБХ 2019.06.12	Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан	Монголбанкны 2018 оны үйл ажиллагааны тайлан	14	27
20.	ТБХ 2019.06.12	Төрийн аудитын байгууллагын дарга Д.Занданбат	Төрийн аудитын байгууллагын 2018 оны үйл ажиллагааны тайлан	6	8

21.	Өргөдлийн байнгын хороо 2019.10.09	БОАЖ-ын сайд Н.Цэрэнбат	Өргөдлийн байнгын хорооны 2018 оны 05 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаарх мэдээлэл	3	10
22.	БОХХААБХ 2019.10.23	ХХААХҮ-ийн сайд Ч.Улаан	Агаарын бохирдлыг бууруулах талаар хэрэгжүүлж буй ажил, мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэл ажлын талаарх мэдээлэл	13	35
23.	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2019.10.30	Нийслэлийн Засаг даргын I орлогч Ж.Батбаясгалан, Орчны бохирдлыг бууруулах комиссын НБДарга Ц.Гантулга, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэд дарга Л.Зэндмаа	Сайжруулсан түлшний талаарх холбогдох албан тушаалтны мэдээлэл	6	18
24.	Өргөдлийн байнгын хороо 2019.12.10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ТНБД Г.Нандинжаргал	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн 1072 хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах асуудлаар хийсэн мэдээлэл	10	28
ДҮН-24				152	376

2020 ОНД БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ /2020.01.01-12.31/					
№	Байнгын хорооны нэр, мэдээлэл сонссон огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Асуулт, санал хэлсэн УИХ-ын гишүүд /давхардсан тоогоор/	Асуулт, саналын тоо
1.	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2020.02.19	Монгол Улсын Шадар сайд, УОК-ын дарга Ө.Энхтүвшин, Эрүүл мэндийн дэд сайд Л.Бямбасүрэн	Коронавирусын халдвар буюу Ковид-19 /COVID-19/-ийн өнөөгийн байдал, халдвараас урьдчилан сэргийлэх болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар	4	16
2.	АБГББХ 2020.02.19	Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар	Гадаад харилцааны яамны 2019 оны үйл ажиллагааны тайлан	3	8
3.	Эдийн засгийн байнгын хороо 2020.04.15	СЗХ-ны дарга Б.Баярсайхан	Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны үйл ажиллагааны тайлан	11	23
4.	Өргөдлийн байнгын хороо 2020.04.15	Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч О.Эрдэмбилэг	Монголбанкнаас гаргасан хэрэглээний болон ипотекийн зээлийн эргэн төлөлтийн хугацааг хойшлуулах шийдвэр арилжааны банкуудад хэрэгжихгүй байгаа талаар	12	28

5.	Эдийн засгийн байнгын хороо 2020.04.21	ҮСХ-ны дарга А.Ариунзаяа	Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагааны тайлан	8	13
6.	Төрийн байгуулалтын байнгын хороо 2020.05.12	УИХ-ын ТГ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан	Улсын Их Хурлын Тамгын газрын 2019 оны үйл ажиллагааны тайлан	3	7
7.	Төрийн байгуулалтын байнгын хороо 2020.05.12	МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн дарга Б.Энхмандах	МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайлан	1	2
8.	Төсвийн байнгын хороо 2020.05.12	Үндэсний аудитын газрын дарга Д.Занданбат	Төрийн аудитын байгууллагын 2019 оны үйл ажиллагааны тайлан	2	7
9.	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2020.08.26	Монгол Улсын Шадар сайд, УОК-ын дарга Я.Содбаатар	Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, эх орондоо ирэх хүсэлт гаргасан иргэдийг татан авах үйл ажиллагааны талаар	32	59
10.	Нийгмийн бодлогын байнгын хороо 2020.10.10	Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан	Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайлан	14	21
11.	Нийгмийн бодлогын байнгын хороо 2020.10.20	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд А.Ариунзаяа	Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны тайлан	8	11
12.	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2020.10.26	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Д.Сарангэрэл	Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр хийж байгаа ажлын мэдээлэл	6	10
13.	БОХХААБХ 2020.10.27	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайхан	Хөдөө аж ахуйн салбарт хамаарах эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн талаарх мэдээлэл	8	11
14.	/Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах түр хороо 2020.11.03	Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар	Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилт, биелэлтийн талаарх мэдээлэл	8	21
15.	Нийгмийн бодлогын байнгын хороо 2020.12.02	Хүний эрхийн үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт	11	20
16.	Нийгмийн бодлогын байнгын хороо	ХЗДХ-ийн сайд Х.Нямбаатар,	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль	16	38

	2020.12.09	ХНХ-ийн сайд А.Ариунзаяа	тогтоомжийн хэрэгжилтийн тайлан		
	ДҮН-16			147	295

2021 ОНД БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНД СОНССОН МЭДЭЭЛЭЛ <i>/2021 оны 1 дүгээр сарын байдлаар/</i>					
№	Байнгын хорооны нэр, мэдээлэл сонссон огноо	Мэдээлэл хийсэн байгууллага, албан тушаалтан	Мэдээллийн сэдэв	Асуулт, санал хэлсэн УИХ-ын гишүүд /давхардсан тоогоор/	Асуулт, саналын тоо
1.	Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороо 2021.01.20	БОАЖ-ын сайд, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга Д.Сарангэрэл	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2020 оны тайлан, 2021 оны төлөвлөгөө	5	15
	ДҮН-1			5	15

Хууль тогтоомжийн хэрэгжилт, УИХ-аас баталсан бодлогын баримт бичгүүд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, мөнгөний бодлого, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаар холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тайлан, мэдээлэл илтгэлийг мэдээллийн санд авч судалгаа-дүн шинжилгээний эх үүсвэр болгон ашигладаг эсэх /мэдээллийн цахим сан, түүний ашиглалт/;

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр: Хяналт шалгалтын хэлтэс нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газраас ирүүлсэн тайланд үндэслэн “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу зорилт, арга хэмжээ тус бүрийн биелэлт, хэрэгжилтийн явцыг тодорхойлж, хяналт шинжилгээний танилцуулга бэлтгэн Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлдэг.

Хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийх явцад Засгийн газраас уг хөтөлбөрийн тайланг ирүүлэхдээ дараах нийтлэг зөрчлүүдийг удаа дараа давтан гарч байдаг.

- хэрэгжүүлэхээр заасан зорилт, арга хэмжээний тайлагналт дутуу ирэх;
- хэрэгжүүлэхээр тусгагдсан ажлын зохион байгуулалт хангалтгүй, зарим зорилт, арга хэмжээний хувьд тодорхой үр дүнд хүрээгүй, үр дүнг тооцох суурь үзүүлэлт, хүрэх болон хүрсэн түвшин зэрэг нь тодорхойгүй байх;
- хэрэгжилт удаашралтай, үнэлгээ буурсан байгаа зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тайлагнахгүй байх, зорилт, арга хэмжээний хүрсэн үр дүнг тодорхой бус, ерөнхий байдлаар хэрэгжилтийн явцыг тоочих байдлаар нэгтгэн ирүүлдэг;
- хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар хариуцсан яам, төрийн захиргааны байгууллагуудад тодорхой чиглэл өгч гүйцэтгэлийг тогтмол хянах, бодлогын үр дүн, үр нөлөөг тооцож, хоорондын уялдааг хангаж ажиллах талаар дутагдалтай байдаг.

Нийгэм, эдийн засгийн хөгжүүлэх Үндсэн чиглэл: Тус хэлтэс нь жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн байдалд бүхэлд нь хяналт

шинжилгээ хийж, холбогдох саналт, дүгнэлтийг бэлтгэж, Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн биелэлтийн талаарх мэдээлэл лавлагааг гарган Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлдэг.

Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс жил бүр Нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд дүн шинжилгээ хийж, товч танилцуулга бэлтгэн Эдийн засгийн байнгын хороонд хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэх хуралдаанаас өмнө хүргүүлдэг. 2016-2020 онд Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд 4 удаа, төсөлд 4 удаа, нийт 8 удаа уг танилцуулгыг бэлтгэн Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлэн ажилласан.

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 2020 онд батлагдсанаар нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл бус Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг батлахаар болсон тул өргөн мэдүүлсэн тухай бүрт шинжилгээ хийж санал, дүгнэлт гарган хүргүүлж ажиллана.

Хууль тогтоомжийг боловсронгуй болгох Үндсэн чиглэл: Засгийн газраас Улсын Их Хуралд хууль тогтоомжийг боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн хүрээнд өргөн мэдүүлэхээр заасан хууль тогтоомжийн лавлагаа мэдээллийг он тус бүрээр, Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар ялган гаргаж, мэдээлэл, лавлагаагаар хангаж ажилладаг.

Цаашид хууль тогтоомжийн хэрэгжилт, УИХ-аас баталсан бодлогын баримт бичгүүд, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, мөнгөний бодлого, үндсэн чиглэлийн хэрэгжилтийн талаар Тамгын газрын холбогдох нэгжээс гүйцэтгэсэн тайлан, танилцуулгын талаар Байнгын хорооны хуралдаанд мэдээлж санал, дүгнэлт, зөвлөмжийг тухайн асуудлыг хэлэлцээд гарах шийдвэрийн төсөлд тусгадаг байх,

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Хууль тогтоомжийг боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцыг жил бүр хэлэлцэж, хэрэгжилтийг хангуулах талаар холбогдох субъектэд чиглэл өгч биелэлтийг тооцож ажилладаг эрх зүйн орчныг бүрдүүлэхийг санал болгож байна.

Тухайн жилийн төсөв: Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс нь төсвийн төсөл хэлэлцэх, төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэхэд холбогдох тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж, санал, дүгнэлт гаргадаг.

Улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн талаарх дэлгэрэнгүй судалгаа, танилцуулга бэлтгэн Төсвийн байнгын хороонд болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлдэг. Тухайн жилийн төсвийн төсөл нь төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөлөл, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлтэй хэрхэн уялдаж байгаа талаар шинжилгээ хийж санал, дүгнэлтдээ тусгадаг. Төсвийн орлого, зарлага, тэнцэл, санхүүжилтийн эх үүсвэр болон төсвийн өр төлбөр, тэдгээрийн талаар, судалгааг тогтмол гарган Төсвийн байнгын хороонд хүргүүлж мэдээллээр хангаж ажилладаг.

Түүнчлэн Байнгын хороодын эрхлэх асуудлын хүрээн дэх төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн төсөл, тодотгол болон төсвийн гүйцэтгэлд хийсэн тооцоо судалгаа, танилцуулгыг холбогдох Байнгын хороодод хүргүүлдэг.

2016-2020 онд Төсвийн хүрээний мэдэгдэлд 10, улсын төсвийн төсөлд 5, төсвийн тодотголд 4, төсвийн гүйцэтгэлд 5 удаа тус тус дүн шинжилгээ хийж, Монгол Улсын нэгдсэн төсвийн дэлгэрэнгүй танилцуулгыг 4 удаа бэлтгэн холбогдох Байнгын хороодод хүргүүлэн мэргэжлийн туслалцаа үзүүлж ажилласан.

Сангийн яамнаас Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг сар бүр хүлээн авч дүн шинжилгээ хийж, танилцуулгыг дотоод сүлжээ болон www.parliament.mn цахим хуудсанд байршуулж, төсвийн Ерөнхийлөн захирагчдын төсвийн гүйцэтгэлийг Байнгын хороодод хүргүүлэн Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангаж ажилладаг.

Монгол Улсын Төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тухай хуулиудаар Улсын Их Хурлын гишүүдэд зориулсан дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэж m-office.parliament.mn цахим хуудсанд байршуулж гарын авлага, мэдээллээр хангадаг. Тухайлбал, 2017-2018 оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн танилцуулга бүхий инфографикаар харуулсан мэдээллийг бэлтгэн газрын зурагт байршуулж, тайлбар, дүгнэлтийн хамт гарын авлага бэлтгэн гишүүдэд хүргэсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор хууль тогтоомжийн төслийн хувилбаруудад төсөвтэй холбоотой зардлын тооцоолол хийж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөө, орлого, зарлагын шинжилгээнд суурилан хуулийн хэрэгжилтийн үр дүнд төсөвт үзүүлэх нөлөөлөл буюу зардалтай холбоотой тооцооллыг хийж дүгнэлт боловсруулан хууль санаачлагчдад болон Байнгын хороонд хүргүүлж мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллаж байна.

Дээрх тооцоо судалгааг гүйцэтгэх явцад Сангийн яамнаас мэдээллийн эх үүсвэрийг ирүүлэхгүй байх, хугацаа хоцроох, заавал албан бичиг шаардах зэрэг хүнд суртал удаа дараа гаргаж хэлтсийн үйл ажиллагааг хэвийн явуулж Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр түргэн шуурхай хангах үйл ажиллагааг доголдуулдаг.

УИХ-аас хяналтын бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газраас хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээлэл, тайлан мэдээ гаргуулах байнгын механизмыг бүрдүүлэхийн тулд цаг хугацааны хоцрогдолгүй мэдээллийг тухай бүр хүлээн авах урсгалын зохион байгуулалтыг бэхжүүлэх, Засгийн газрын тоон мэдээллийн бааз суурьт нэвтрэх эрх, боломжоор хангагдах, бусад шаардлагатай мэдээллүүдийг тогтмол ирүүлэх болон өөрчлөлт гарах бүрт Тамгын газарт ирүүлдэг механизмыг бүрдүүлэх нь зүйтэй байна.

Дүн шинжилгээ хийсэн ажлын статистик

Д/д	Чиглэлүүд	2016	2017	2018	2019	2020	Дүн
1	Төсвийн хүрээний мэдэгдэл	1	4	2	2	1	10
2	Төсвийн төсөл	1	1	1	1	1	5
3	Төсвийн тодотгол	1	2	0	0	1	4
4	Төсвийн гүйцэтгэл	1	1	1	1	1	5
5	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл	0	1	1	1	1	4
6	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл хэрэгжилт	0	1	1	1	1	4
7	Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл	1	1	1	1	1	5
8	Өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөлд хавсаргасан зардлын тооцоонд хийсэн дүн шинжилгээ	1	5	4	2	3	15
9	Макро эдийн засгийн тойм	2	4	4	4	4	18
10	Гадаад худалдааны тойм	0	12	12	12	12	48
11	Монгол Улсын нэгдсэн төсвийн дэлгэрэнгүй танилцуулга	0	1	1	1	1	4

Төсвийн хэлэлцүүлгийн явцад тооцооллыг хэрхэн явуулсан талаар болон дэлгэрэнгүй тооцооллын мэдээллийг Тамгын газраас шаарддаг. Иймд Тамгын газрын төсвийн хяналтын нэгжийг Сангийн яам, Монголбанк, Үндэсний Аудитын газар болон Үндэсний статистикийн хороо зэрэг эдийн засгийн чиглэлийн байгууллагуудаас төсөв, санхүүгийн дэлгэрэнгүй задаргаа, тоон мэдээллүүд, динамик харьцуулалтуудыг тухай бүр авч танилцах, судалгаа шинжилгээнд ашиглах эрхийг олгох зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэл, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагуудаас дэлгэрэнгүй задаргаа бүхий тоон мэдээлэл, тэдгээрийн өөрчлөлтийн талаарх судалгааг тухай бүр цахим болон цаасан хэлбэрээр шуурхай авч гишүүдэд хүргэдэг байх тогтолцоог бий болговол холбогдох төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо сайжирна гэж үзэж байна.

Мөнгөний бодлого: Монголбанкнаас Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бүрт Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс Үндсэн чиглэлийн төсөлд дүн шинжилгээ хийж, макро эдийн засаг, олон улсын байгууллагуудын төсөөлөл зэрэгтэй харьцуулсан судалгаа хийж, төсвийн төсөлтэй хэрхэн уялдаж байгаа зэрэгт шинжилгээ хийж санал, дүгнэлт боловсруулж танилцуулгыг бэлтгэн Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлдэг. 2016-2020 онд жил бүр буюу нийт 5 удаа уг санал, танилцуулгыг боловсруулж хүргүүлэн ажилласан.

Холбогдох байгууллага, албан тушаалтны тайлан, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, УИХ-аас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хянах, эргэн тайлагнах үйл ажиллагааны зохион байгуулалт ба энэ хүрээнд УИХ болон ЗГ-ын түвшинд үүсгэсэн дундын мэдээллийн сан, мэдээлэл солилцох тогтолцоо /хэрэв холбогдох байгууллагуудын хяналт-шинжилгээний мэдээллийн санд нэвтрэх эрх авсан бол нэрлэх/;

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт шинжилгээ, үнэлгээний нэгдсэн мэдээллийн www.unelgee.gov.mn цахим санд нэвтрэх эрхийг Хяналт шалгалтын хэлтэс 1 ажилтанд эрх авч өгсөн. Гэвч уг мэдээллийн сан нь Улсын Их Хурал болон Засгийн газрын хооронд мэдээллийн урсгалыг бий болгох, мэдээлэл солилцох түвшинд хийгдээгүй, зөвхөн ЗГХЭГ-аас бусад аймаг, нийслэл, яам, агентлагын үйл ажиллагаа, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн мэдээллийг хүлээн авах үүрэг бүхий анхдагч мэдээллийн сан болно.

Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө, Улсын Их Хурлын ЕНБД-ын 2020 оны 658 дугаар захирамжаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх журам” зэрэгт Хуулийн хэрэгжилтийн нэгдсэн цахим сантай байх талаар заасан. ХШҮГ-аас 2020 онд уг цахим санг бий болгохоор Тамгын газрын төлөвлөгөөнд тусган холбогдох газар, нэгжтэй хамтран ажиллаж байна.

Уг мэдээллийн сан нь Улсын Их Хурлаас хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад хяналт тавих, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, зөвлөмжийг илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээх үүрэгтэй байх бөгөөд уг цахим санг Тамгын газар ажиллуулах болно.

Мэдээллийн цахим санг Хяналт шалгалтын хэлтэс нь дараах байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

- Цахим хуудсанд суурилсан программ, систем /portal website/ хэлбэрээр ажиллах бөгөөд байгууллагууд дараах зохицуулалт бүхий хэрэглэгчийн эрхээр хандана.
- Хэрэглэгчийн эрхийг нь байгууллагад, эсвэл тухайн албан тушаалтан /УИХ-ын гишүүн, ЕНБД, ХШҮГ-ын ажилтан гэх мэт/-д тусгайлан олгож болно.
- Хэрэглэгч өөрийн эрхээр орж зөвшөөрөгдсөн ангилал, төрөлд хамаарах мэдээллийг оруулна.
- Байгууллагуудын оруулсан мэдээлэл цахим санд шууд орж бусдад харагдахгүй "хүлээлгийн горим"-д орох бөгөөд санд орсон мэдээллийг ХШҮХ-ийн эрх бүхий

ажилтан хянаж системд нийтлэх эрхийг олгож баталгаажуулж болно. Мэдээлэл зөв ангилал, төрөлд орсон эсэхийг магадлах зорилгоор ийм шат дамжлагатай байж болох юм. Тухайлбал, олон нийтэд нээлттэй байх ангилалд орох мэдээллийг шалгаж баталгаажуулах шаардлагатай.

- Бусдын /бусад байгууллагын/ оруулсан мэдээллийг зөвхөн унших эрхтэй, устгах, засварлах эрхгүй байна.
- Мэдээллийн ангилал, төрөлд хэрэглэгч бүрийн эрхийг ялгаатай зааж өгөх боломжтой байна. /Өөрөөр хэлбэл байгууллагууд бусад байгууллагын мэдээлэл бүрийг үзэх боломжгүй, зөвхөн эрх бүхий байгууллага, хэрэглэгчид бүх мэдээллийг үзэх боломжтой байж болно. Эсвэл ангилал, төрөл тус бүрд аль аль хэрэглэгч үзэх боломжтой байхыг тусгайлан зааж өгч болно.
- Олон нийтэд нээлттэй байх мэдээллийн ангилал, төрлийг зааж өгөх бөгөөд түүнд хамаарах мэдээлэл нээлттэй байна. /Иргэд, олон нийтийн хэрэглэгчийн эрхийг тусгайлан үүсгэхгүй, системд хэрэглэгчийн тусгайлсан эрхээр нэвтрээгүй бол олон нийтэд нээлттэй мэдээллийг л үзэх боломжтой байна.

2.1.4.Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үйл ажиллагааны зохион байгуулалт, хүрсэн үр дүн (39.1.6)

Хууль тогтоомжийн тухай хуулийн 49, 50, 51, 52-р зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд УИХ, Тамгын газрын түвшинд хэрэгжүүлж буй ажлууд, цаашид эрх зүй, зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах

Хяналт шалгалтын хэлтсийн Хяналт шинжилгээ, үнэлгээний алба нь бүтэц, орон тооны хувьд 4 хүний бүрэлдэхүүнтэй Улсын Их Хурал, Байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, гүйцэтгэлийг хангах, дүн шинжилгээ хийх, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн байдалд болон Улсын Их Хурлаас Засгийн газар, холбогдох бусад байгууллагад өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавих, гаргасан санал, дүгнэлт, танилцуулга, зөвлөмжийг холбогдох Байнгын хороонд танилцуулах үндсэн чиг үүргийн хүрээнд 14 чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын талаар: Хууль тогтоомжийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн 2017 оноос хойш Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтэс нь дараах 5 хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээг гүйцэтгэсэн болно.

Хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийх ажил нь судалгааны арга зүй, аргачлалын хүрээнд мэдээлэл цуглуулах үйл явц болон боловсруулалтын үе шатанд багагүй хугацаа шаарддаг тул хийгдсэн хяналт шинжилгээний болон үр дагаврын үнэлгээний ажлуудын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй байдлаар тусгалаа.

1.2018 онд Хууль зүйн байнгын хорооны ажлын албатай хамтран НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд бүхэлд нь хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газраас 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан аргачлалын дагуу хийсэн.

Тайланг нь Хууль зүйн байнгын хорооны гишүүдэд болон Архидан согтуурахтай тэмцэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт тус тус хүргүүлсэн.

2000 онд батлагдсан Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, хэрэгжилтийн үр дагаварт нь үнэлгээ хийхдээ хуулийг мөрдөж

эхэлснээс хойших хугацаанд хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж, гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг үр дагаврыг судлан, хуулийн зорилгыг хангаж байгаа түвшинг тодорхойлох, үзэл баримтлалд тодорхойлсон үр дүнд хүрэх байдлыг тогтоох, хуулийг зохистой хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлоход чиглэгдсэн.

Энэхүү судалгааг гүйцэтгэхдээ холбогдох 100 орчим бичиг баримтад дүн шинжилгээ хийж, архидаг согтуурсаны улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн тоо өндөртэй нийслэлийн Баянгол, Баянзүрх, Налайх дүүрэг болон Төв аймгийг сонгож хуулийн хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий төрийн захиргааны 30 гаруй ажилтнуудтай фокус бүлгийн ярилцлага, 150 гаруй иргэдтэй хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, тандалтын судалгаа хийж дүгнэлт гаргасан.

Мөн хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээний тохирох хэмжүүрийг сонгохдоо төрийн захиргааны байгууллагуудаас гарах нийт 94 үзүүлэлт бүхий тоон мэдээлэлд тулгуурлан нийгэмд болон тухайн зорилтот бүлэгт үзүүлсэн эерэг, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг тооцсон болно.

2.2019 онд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ, тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад үр эөлөөний үнэлгээ хийсэн.

Хяналт шинжилгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсаргалтаар баталсан аргачлалын дагуу гүйцэтгэсэн.

Харин Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт мөрдөгдөж эхэлснээс хойших хугацаанд нийгэмд үзүүлсэн нөлөөллийн байдлыг тогтоох буюу үнэлэх үйл ажиллагааг олон улсад ашиглагддаг онол, арга зүйн хүрээнд Швейцарын Холбооны Улсын Тамгын газрын Үнэлгээний нэгжтэй хамтран гүйцэтгэж, үнэлгээний тайланг 2019 онд ШПТГ-ын Үнэлгээний нэгжийн холбогдох албан тушаалтнуудад тайлагнаж, тайланг БОХХААБХ-нд хүргүүлсэн.

Судалгааг гүйцэтгэхдээ ажлын хүрээг газар зүйн байршлын хувьд газрын нэгдмэл сангийн 2018 оны улсын нэгдсэн тайланд үндэслэн Өмнөговь, Хэнтий, Увс аймгуудыг болон хүн амын шилжилт хөдөлгөөн, төвлөрөл ихтэй нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх, Сүхбаатар, Налайх дүүргүүдийг тус тус сонгосон.

Дээрх хүрээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан баталсан хууль тогтоомж, эрх зүйн актууд, холбогдох төрийн захиргааны байгууллагуудын тайлан, мэдээлэл болон газар өмчлөх харилцаатай холбогдуулан хийсэн судалгааны ажлын тайлан зэрэг баримт бичгүүдийг судлах, газар өмчилсөн болон газар өмчлөөгүйгээр нь иргэдийг ангилан санал асуулга авах, иргэдийг болон төрийн байгууллагын албан тушаалтнуудыг оролцуулсан фокус бүлгийн ярилцлага зохион байгуулах зэрэг арга зүйг ашиглан мэдээлэл цуглуулсан.

Фокус бүлгийн ярилцлагын хүрээнд 3 аймаг, 5 дүүргийн хэмжээнд хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн албан хаагчид, газар өмчлөх эрх нь үүссэн хэдий ч газар өмчлөөгүй иргэд, газар өмчлөх хүсэлтээ өгсөн ч өмчлөөгүй иргэд болон газар өмчилж авсан иргэдийн төлөөлөлтэй уулзаж нээлттэй ярилцлага хэлбэрээр явуулсан.

3. 2019 онд ТББХ-ноос ирүүлсэн захиалгын дагуу “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030” батлах тухай Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийн байдалд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсаргалтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын хүрээнд уг тогтоолын хэрэгжилтийн байдлыг бүхэлд нь хамруулж, үнэлгээ хийж, үнэлгээний тайланг ТББХ-нд хүргүүлсэн.

Уг бодлогын баримт бичигт үнэлгээг хийхдээ Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болох үндсэн зорилгын хүрээнд 20 үндсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд нийт 4 бүлэг, 44 зорилтын хэрэгжилтийг 2030 он хүртэл III үе шаттай хэрэгжүүлэхээр баталсан.

“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030” бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд 2016-2020 онд хэрэгжүүлэх I үе шатны арга хэмжээний хэрэгжүүлэлтийн байдал нь үзэл баримтлалд дэвшүүлсэн үндсэн зорилгоо хэрэгжүүлж чадаж байгаа эсэхийг тодорхойлох байдлаар үнэлгээг гүйцэтгэсэн болно.

4.Монгол Улсын Сангийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 10/202 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Улсын Их Хурлын Тамгын газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон тайланд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, Сангийн яаманд хүргүүлсэн.

Энэхүү хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.2.2.12, 7.1, 7.2-т заасны дагуу “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн 2019 онд дэвшүүлсэн зорилтот түвшинг үйл ажиллагааны тайланд үндэслэн хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлж, цаашид анхаарах асуудал, дүгнэлт зөвлөмж гаргахад чиглэгдсэн.

5.2020 онд Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтийн байдалд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан аргачлалын дагуу хяналт шинжилгээ хийж, тайланг Улсын Их Хурлаас байгуулагдсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах Түр хороонд хүргүүлсэн.

Хуулийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийхдээ уг хууль батлагдсанаас хойших хугацаанд гарсан Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, бусад байгууллагын шийдвэрээр баталсан журам, жагсаалт зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн хяналт-шинжилгээний тохирох хэмжүүрийг сонгохдоо Засгийн газар болон төрийн бусад байгууллагуудаас гаргасан тоон мэдээлэл, хуулийн хэрэгжилтийн хүрээнд батлан гаргасан баримт бичиг, цахим мэдээллийн хүрээнд дүн шинжилгээ хийж, хуулийн хэрэгжилтийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулсан болно.

САНАЛ:

1. Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд Улсын Их Хурлаас хийх хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээг холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар хамтран хэрэгжүүлэхээр зохицуулсан. Тэгэхдээ Улсын Их Хурал болон Засгийн газрын хувьд ямар хуульд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх талаар тусгайлан нарийвчилж бус харин бүх хууль тогтоомжид хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр заасан.

Засгийн газар, УИХ-д ажлаа хариуцан тайлагнадаг бусад байгууллагууд өөрийн хамрах хүрээний хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж мэдээллээ УИХ-д ирүүлж байх хуулийн зохицуулалтыг бий болгох. Засгийн газраас хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний дүн, тайлан мэдээг тогтмол Улсын Их Хуралд ирүүлж байх сувгийг тодорхой болгох, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналтай байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар, УИХ-д ажлаа хариуцан тайлагнадаг бусад байгууллагуудаас ирүүлсэн хяналт шинжилгээний дүнд үндэслэн Улсын Их Хурлаас үр дагаврын үнэлгээ хийж, хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг сайжруулах талаар холбогдох Байнгын хорооны хяналтыг өндөржүүлэхэд хуулийн зохицуулалт чиглэгдсэн байх нь зүйтэй байгаа болно.

УИХ-ын хувьд шаардлагатай тохиолдолд тухайн хуульд хяналт шинжилгээ хийх, харин хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж дүнг холбогдох Байнгын хорооны хуралдаанд жилд 1 удаа танилцуулдаг одоогийн хуулийн зохицуулалтыг хадгалах саналтай байна.

2. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ болон үр дагаврын үнэлгээ хийж, санал дүгнэлт гаргах ажил нь олон шат дараалал, аргачлал бүхий цаг хугацаа шаардсан ажил юм. Тус ажлын хүрээнд хуулийн хэрэгжилтийг хариуцан ажилладаг байгууллагаас шаардлагатай мэдээллийг гаргуулан авах, тухайн тоо баримт, статистик мэдээлэл, баримт бичгийг судлах дүн шинжилгээ хийх, тэдгээрт үндэслэн тайлан бичих, санал зөвлөмж боловсруулах ажлууд хийгддэг. Зарим тохиолдолд фокус бүлгийн ярилцлага, анкетын санал асуулга авах, хариуцсан мэргэжлийн байгууллагуудтай уулзаж ярилцах, тандан судалгаа хийх шаардлага үүсдэг.

ЕНБД-ын 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 658 дугаар захирамжаар “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх журам”-ыг баталуулсан. Энэхүү журмын 3.4-т тухайн хууль тогтоомжид бүхэлд нь үнэлгээ хийх тохиолдолд 4-6 сар, тодорхой зүйл, хэсэг, заалтад үнэлгээ хийх тохиолдолд 2 хүртэл сарын хугацаанд хийхээр заасан. Гэвч зарим тохиолдолд үнэлгээг яаралтай, богино хугацаанд гүйцэтгэхээр үүрэг өгөх нь тухайн үнэлгээний тайлангийн мэдээллийн чанар, хүртээмж, үндэслэл хангалтгүй байх, үнэлгээний тайлангаас гарах зөвлөмжийн ач холбогдол буурах эрсдэл бий болдог.

Иймд Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Улсын Их Хурлаас үр дагаврын үнэлгээ хийх хууль тогтоомжийн хүрээ, хязгаарыг тогтоож өөрийн чадавхыг нэмэгдүүлэхэд чиглэсэн өөрчлөлтийг оруулах саналтай байна.

3. Хууль тогтоомжийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5-д “Улсын Их Хурал, Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний бүтцийн нэгж нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн эерэг, сөрөг үр дагаврын талаарх хяналт шинжилгээний үр дүнг хууль санаачлагчид тогтмол мэдээлнэ” гэж заасан байдаг. Гэвч Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал”-ын дагуу хуулийн хэрэгжилтийн эерэг, сөрөг үр дагаврыг гаргах боломжгүй байдаг.

Хяналт шинжилгээ, үнэлгээ нь ялгаатай ойлголт бөгөөд үнэлгээ нь тодорхой цаг хугацаанд нэг удаа хийж гүйцэтгэдэг бол хяналт шинжилгээ нь байнгын тасралтгүй

үйл ажиллагаа юм. Хяналт шинжилгээгээр цуглуулсан мэдээлэл нь үнэлгээний ажлын суурь үндэс болж, үнэлгээ хийх явцад ашиглагдана. Өөрөөр хэлбэл, хяналт шинжилгээ хийсний дараа үнэлгээ хийнэ гэсэн үг юм.

4. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын зохион байгуулалт шинэ тутам тул Тамгын газрын зүгээс Байнгын хороо, гишүүдэд хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, санал, дүгнэлт, зөвлөмжийн ач холбогдлыг танилцуулж шийдвэр гаргуулах, Байнгын хорооны хуралдаанаар үнэлгээний тайланг хэлэлцүүлэх зэрэг процедурны ажлын талаарх туршлага хангалтгүй байна.

Удаан хугацаанд хүч хөдөлмөр гарган хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын үр дүнд бий болсон санал дүгнэлт, зөвлөмжийг Байнгын хорооноос гарах шийдвэрт тусган хэрэгжилтийг хангах талаар холбогдох байгууллагад үүрэг, чиглэл өгөх зэргээр ач холбогдолыг нэмэгдүүлэх ажлыг Улсын Их Хурлын түвшинд сайтар төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байгаа болно.

5. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дагаварт үнэлгээ хийхэд төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангах, хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байгаа төрийн захиргааны байгууллага хууль тогтоомжийн хэрэгжилтийн мэдээг шаардлагатай үед тухай бүр гарган ирүүлэх зохицуулалтыг хуульд нэмж тусгах шаардлагатай.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилтийн бодит мэдээ мэдээллээр цаг алдалгүй хангагдах шаардлага байдаг. Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа байгууллага хооронд мэдээлэл солилцох тогтмол бүтэц бий болсноор албан бичиг явуулах, хариу ирүүлэх, нэмэлт мэдээлэл авах зэрэгт цаг алдалгүй түргэн шуурхай ажиллах, улмаар УИХ-ын гишүүдийг бодит мэдээ мэдээллээр шуурхай хангах нөхцөл бүрдэх юм.

6. Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлангийн нэгдсэн мэдээллийн санг бий болгох эрх зүйн зохицуулалтыг бий болгож, түүнийг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцан хөгжүүлж ажилладаг байх, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллага бүр мэдээллээ энэхүү санд оруулж харилцан ашигладаг нэгдсэн сан байхаар зохицуулалт хийх.

Засгийн газар болон бусад байгууллагаас хийгдсэн хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний дүн, тайлан, мөн үр дагаврын үнэлгээний тайланг Улсын Их Хуралд тогтмол ирүүлж байхыг үүрэгжүүлснээр УИХ-ын гишүүдийг хуулийн хэрэгжилтийн мэдээллээр тухай бүр, хурдан шуурхай ханган ажиллах боломжтой болно.

Түүнчлэн УИХ-ын чуулганы нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодод хийгдсэн тайлан, мэдээлэл, илтгэл, хяналт шалгалтын ажлын тайлан, хууль тогтоомжийн болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг нэг дор төвлөрүүлж, мэдээллийн урсгалыг сайжруулах боломж бий болох юм.

7. Улсын Их Хурал батлан гаргасан хуулийн хэрэгжилттэй танилцаж, хэрэгжилтийн үр дүнд үнэлгээ хийх, үр дүнгийн үнэлгээнд үндэслэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, цаашид хуулийн хэрэгжилтийг хангах, сайжруулах талаар бусад холбогдох арга хэмжээг авч ажилладаг тогтолцоог бүрүүлэх шаардлага чухал байгаа болно.
8. ОУПХ-ны гишүүн зарим орнуудад хяналт шалгалтын ажлыг бие даасан Байнгын хороонд хариуцуулан хэрэгжүүлж байгаа туршлагыг судалж бусад байнгын хорооны хяналт шалгалтын ажлын чиг үүргийг энэ байнгын хороонд хариуцуулах;

9. Улсын Их Хурлын Тамгын газрын хяналт шалгалтын ажлын эрх хэмжээг нэмэгдүүлж Байнгын хороодоос Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагад хийсэн хяналт шалгалтын ажлаар өгсөн үүргийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн шалгалт хийх, үр дүнг тооцож холбогдох Байнгын хороонд мэдээлдэг эрх зүйн зохицуулалтыг бий болгох.

Хууль, УИХ-ын бусад шийдвэрүүд болон бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх чиглэлээр Тамгын газрын ХШҮГ-аас хийсэн ажлын тайлан, статистик мэдээлэл

д/д	Хууль тогтоомжийн нэр	Огноо	Захиалагч	Төрөл	Хийгдсэн аргачлал	Тайланг хүргүүлсэн байдал
1	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль	2018	УИХ-ын Тамгын газар	Хуульд бүхэлд нь хяналт шинжилгээ болон үр дагаврын үнэлгээ хийсэн.	Засгийн газраас 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал”, 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэсэн.	Хууль зүйн байнгын хорооны гишүүд болон Архидан согтуурахтай тэмцэх тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн хэрэгжилттэй танилцах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт хүргүүлсэн.
2	Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль	2019	УИХ-ын Тамгын газар	Хуульд бүхэлд нь хяналт шинжилгээ хийсэн.	Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх аргачлал”	БОХХААБХ-нд хүргүүлсэн.
			ХШҮГ болон ШПТГ хамтран	Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад үнэлгээ хийсэн.	ШПТГ-т ашигладаг олон улсад түгээмэл ашиглагддаг аргачлал, арга зүйн дагуу гүйцэтгэсэн.	
3	Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030”	2019	ТББХороо	Хуульд бүхэлд нь үр дагаврын үнэлгээ	Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу гүйцэтгэсэн.	ТББХ-д хүргүүлсэн.

	бодлогын баримт бичиг					
4	“Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төслийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон тайланд	2020	Сангийн сайдаас ирүүлсэн албан бичгийн дагуу	Бүхэлд нь хяналт шинжилгээ	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хавсралтаар баталсан аргачлалын дагуу гүйцэтгэсэн.	Сангийн яаманд ЕНБД-ын албан бичгээр хүргүүлсэн.
5	Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль	2020	УИХ-ын Тамгын газрын санаачлагаар	Хуульд бүхэлд нь хяналт шинжилгээ	Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан аргачлалын дагуу	Улсын Их Хурлаас байгуулагдсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах түр хороонд

2.1.5.Байнгын, дэд хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт хийх үйл ажиллагаа, зохион байгуулалт, үр дүн (39.1.7)

Байнгын, дэд хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан хяналт шалгалтын ажлын хэсгүүдийн үйл ажиллагаа, үр дүн, практикт тулгамдаж буй асуудлууд, цаашид боловсронгуй болгох чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах:

Байнгын, дэд хорооны эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдсан хяналт шалгалтын ажлын хэсгүүдийн үйл ажиллагаа, үр дүн:

Улсын Их Хурлын тухай хуулийн 23, 24, 25, 29, 39 дүгээр зүйлийг үндэслэн Байнгын хорооны хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу хяналт шалгалтын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. 2008-2020 оны байдлаар Улсын Их Хурлын даргын захирамжаар болон Байнгын, дэд хорооны тогтоолоор хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий нийт 139 ажлын хэсэгт давхардсан тоогоор 845 гишүүн орж ажилласан байна.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд Тамгын газар нь Байнгын хорооны тогтоолын дагуу хяналт шалгалтын ажлын хэсгийг байгуулахад “Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийг боловсруулан Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулдаг. Ажлын хэсгийн ажиллах төлөвлөгөө, удирдамжийн төслийг боловсруулан

ажлын хэсгийн ахлагчаар батлуулж, төлөвлөгөө, удирдамжийн дагуу ажиллахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажилладаг. Мөн ажлын хэсгийн гишүүдээс гаргасан санал, хуралдаанаас гарах санал, дүгнэлтийг нэгтгэн Ажлын хэсгийн тайлан болон Байнгын хорооноос гарах шийдвэрийн төслийг боловсруулж, Байнгын хорооны хуралдаанд оруулж хэлэлцүүлэн “Чиглэл өгөх тухай” тогтоол болон зөвлөмжийг боловсруулж батлуулан, албажуулах, тогтоол болон зөвлөмжийг албан тоотоор холбогдох газруудад хүргүүлэх, хяналт тавьж ажиллах чиг үүргийг ханган ажиллаж байна.

Цаашид боловсронгуй болгох чиглэлээр эрх зүй, зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал:

- Байгууллагын үйл ажиллагаатай танилцах болон хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах ажлын хэсгийн үйл ажиллагааны зааг ялгаа, хүрээ хязгаар тодорхойгүй байдгаас зарим тохиолдолд Байнгын хорооны гишүүдийн зүгээс баталсан удирдамж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг явуулахгүй байх, өөр төрлийн мэдээ, мэдээлэл шаардах зэрэг асуудал үүсдэг.
- УИХ-ын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.16-т заасны дагуу төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулах тохиолдолд уг хяналт шалгалтыг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлнэ гэж заасан. Гэвч уг хяналт шалгалтыг ямар байгууллагаар гүйцэтгүүлэх, уг байгууллага ямар эрх үүрэгтэй оролцох, уг хяналт шалгалтын байгууллагын хяналт шалгалтын дүн, гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлаар хэрхэн хэлэлцэх гэх мэт нарийвчилсан зохицуулалтыг боловсронгуй болгох;
- Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Сангийн яамны санхүүгийн хяналтын нэгжээр хяналт шалгалт хийлгэж тэдний санал дүгнэлтийг Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлын хэсэг ашиглах нь хэр зохимжтой вэ? гэдгийг анхаарах шаардлагатай.
- Цаашид Хяналт шалгалтын тухай хуулиар Улсын Их хурлаас хийх хяналт шалгалтын ажилд Байнгын хороо, дэд, түр хороо, Тамгын газрын ажиллах чиглэлийг тодорхой болгож хуульчлах нь зүйтэй болно.
- Хяналт шалгалтын тухай хууль батлагдсан тохиолдолд хяналт шалгалтын ажлын хэсгийн хүрээнд Тамгын газар болон Байнгын хорооны асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагааг хэрхэн уялдуулах журмыг нарийвчлан боловсруулах шаардлагатай.



3.4.УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСЭЭС ИРҮҮЛСЭН САНАЛ

2021.02.01

Улаанбаатар хот

Улсын Их Хуралд 2013 онд өргөн мэдүүлсэн Төсвийн албаны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хуулийн төсөл санаачлагчид буцаан түүнд дурдсан төсвийн хяналт, шинжилгээний чиглэлээр тус хэлтсийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бүрдүүлэхэд Хяналт шалгалтын анхдагч хуулийн төсөлд нэг бүлэг болгон оруулах саналтай байна. Дараах зүйл, хэсэг, заалтыг тус бүлэгт оруулах саналтай байна:

1.Төсвийн хяналт, шинжилгээний хэлтэс нь улсын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, түүнтэй холбоотой бусад асуудлаар судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт, зөвлөмж гаргах хүрээнд дараах үүргийг гүйцэтгэнэ:

1.1.Улсын төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлд болон Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, төсөв мөнгөний бодлогын уялдааны талаар судалгаа, шинжилгээ хийж, зөвлөмж гаргах;

1.2.төсвөөс санхүүждэг, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсвийн хөрөнгийн зарцуулалт, санхүүд шалгалт хийж, түүний үр дүнд судалгаа, шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гаргах;

1.3.Засгийн газрын тусгай зориулалтын сан, төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэг, эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулж байгаа төсвийн хөрөнгө болон олон улсын байгууллага, гадаад орны Засгийн газар, байгууллага, иргэдээс Монгол Улсын Засгийн газар, төсвийн байгууллагад олгосон зээл, тусламж, хандивын ашиглалт, зарцуулалт, үр дүнд судалгаа, шинжилгээ хийж, зөвлөмж гаргах;

1.4.Улсын төсвийн хөрөнгө оруулалт, түүний үр дүнд судалгаа, шинжилгээ хийж, зөвлөмж гаргах;

1.5.Засгийн газрын жилийн эцсийн санхүүгийн тайланд судалгаа, шинжилгээ хийх;

1.6.Улсын төсвийн төслийн орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх талаар санал боловсруулж, Улсын Их Хуралд танилцуулах;

1.7.эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий улсын томоохон хөтөлбөр, арга хэмжээний дунд болон урт хугацааны санхүүгийн шаардлагад шинжилгээ хийх;

1.8.Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл батлагдсанаар улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн талаар судалгаа, шинжилгээ хийж зөвлөмж гаргах;

1.9.Байнгын хороо болон Улсын Их Хурлын гишүүдийн хүсэлтийн дагуу өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар судалгаа, шинжилгээ хийх;

1.10.сар, улирал, хагас жил, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах;

1.11.Монгол Улсын хөгжүүлэх жилийн төлөвлөгөө, мөнгөний бодлогын үндсэн чиглэл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг үнэлэх;

1.12.төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

1.13.төсвийн бодлого, эдийн засгийн хөгжлийн бодлоготой уялдаж байгаа эсэх асуудлаар судалгаа, шинжилгээ хийх.

2.Төсвийн хяналт, шинжилгээ хийх зорилгоор нэгжийн ажилтнууд холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнаас шаардлагатай бичиг баримт, мэдээ, мэдээлэл, албан ёсны статистик, тоон үзүүлэлтийг цаг тухай бүрт нь, албан бичиг шаардалгүйгээр гаргуулан авах эрхтэй.

3.Сангийн яам, Монголбанк, Үндэсний статистикийн хороо болон бусад холбогдох байгууллагууд Төсвийн нэгжийн шаардсан мэдээллийг цаг тухай бүр, аливаа хүндрэл учруулахгүйгээр гарган өгч байх үүрэгтэй.

БУСАД ОРНЫ ТӨСВИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ТӨСВИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭДЭГ ҮҮРГҮҮДИЙН ТАЛААР ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн нэгж нь макро-эдийн засгийн болон засаглалын хэтийн төлвөөс төсвийн бодлого (мөн татварын бодлого)-ын төслийг бэлтгэх, шийдвэр гаргахад ашигласан мэдээллийн чанар, найдвартай байдал, төсвийн бодлогын хэрэгжилт, үр дүнгийн тайлангийн чанар, үнэн зөв байдлыг үнэлдэг. Үүнд төсвийн бодлогын зорилтуудыг биелүүлэхэд учирч болзошгүй эрсдэлүүд, төсвийн бодлого нь бодлогын зорилт, төсвийн санхүүжилт, эдийн засгийн урт хугацааны тогтвортой байдал, Парламент болон Засгийн газраас тогтоосон тодорхой зорилтуудыг хэрэгжүүлэхэд үр дүнтэй байсан эсэх, макро эдийн засгийн тогтвортой байдал, түүний үр дүнтэй байдлыг үнэлэхийн зэрэгцээ төсвийн бодлоготой холбоотой бодлогын шинжилгээ, санал, үнэлгээ боловсруулдаг.

Төсвийн шинжилгээний нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Макро эдийн засгийн төлөвлөлттэй уялдуулан төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх, мөн төсвийн төслийг хэлэлцэх явцад гарсан аливаа өөрчлөлттэй холбоотой саналд дүн шинжилгээ хийх;
- Сар, хагас жил, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэлийн эцсийн үр дүнд дүн шинжилгээ хийх;
- Улсын төсвөөс орон нутагт хуваарилсан санхүүгийн тусламжийн зарцуулалтад дүн шинжилгээ хийх;
- Батлагдсан төсвийн орлого, зарлагын аливаа өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх;
- Төсвийн илүүдэл, алдагдал, өр төлбөрийн асуудалд дүн шинжилгээ хийх;
- Улсын төсөвт хийх нэмэлт өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх;
- “үндсэн чиглэл”-д тодорхойлсон зардлууд болон дунд хугацааны стратегийг судалж шинжлэх;
- Улсын төсвийн мөнгийг зарцуулах эрх бүхий байгууллагуудын дунд хугацааны стратегийг судалж шинжлэх;
- Улсын төсөвт тусгасан хөтөлбөр, үйл ажиллагааны зорилго, тэдгээрийн үр дагавар, оновчтой эсэх, санхүүжилтийн хэмжээнд дүн шинжилгээ хийх;
- Төсөв боловсруулах, батлах болон төсвийн гүйцэтгэлтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал гаргах;
- Төсвийн болон төрийн санхүүгийн удирдлагын асуудлаар эрх мэдлийн хүрээнд өөрийн санаачилгаар мэргэжлийн судалгаа шинжилгээ хийх;

Макро эдийн засгийн шинжилгээ ба татварын бодлогын нэгж нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Макро эдийн засгийг хөгжүүлэх жилийн төсөөллийг боловсруулах, Засгийн газрын төсөөлөл, түүний үндсэн үзүүлэлтүүд болон таамаглалыг үнэлэх;
- “Үндсэн чиглэл”-д тодорхойлогдсон мөнгө болон төсөв санхүүгийн бодлогын үндсэн чиглэл, дунд хугацааны стратегийг үнэлэх;
- Төлбөрийн тэнцэл, мөнгө, татвар, гаалийн бодлогуудад дүн шинжилгээ хийх;

- Макро эдийн засгийн хөгжлийн үндсэн чиглэлд судалгаа шинжилгээ хийх (ДНБ, экспорт импорт, инфляц, мөнгөний бодлого гэх мэт);
- Төсвийн үндсэн үзүүлэлтүүд болон аливаа зөрүү, хэлбэлзлийн шалтгаан нь улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн чадавхиас хэр хамаарч буйг судалж шинжлэх;
- Эрх мэдлийн хүрээнд өөрийн санаачилгаар макро эдийн засгийн асуудлууд болон төрийн санхүүгийн удирдлагын чиглэлээр мэргэжлийн судалгаа шинжилгээ хийх юм.

Зардлын тооцоо, хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх нэгж нь дараах ажил үүргийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төсвийн хуулийн төслийн үр дагавар, түүний эдийн засгийн үндэслэлд дүн шинжилгээ хийх;
- Улсын төсвөөс зээл авах, олгох тухай олон улсын гэрээ, хэлэлцээрүүдэд дүн шинжилгээ хийх;
- Хуулийн төслийг боловсруулахаас өмнө болон боловсруулах явцад, мөн хэлэлцэх үеэр парламентын гишүүдийг холбогдох зардлын тооцоогоор хангах;
- Эрх мэдлийн хүрээнд өөрийн санаачилгаар төрийн санхүүгийн удирдлага болон хуулийн төслийн санхүүгийн үр дагаврын асуудлаар мэргэжлийн судалгаа шинжилгээ хийх зэрэг болно.

Бусад нийтлэг чиг үүргүүдээс:

- Санхүү, төсөв, макро эдийн засгийн асуудал, мөн төрийн санхүүгийн удирдлагын асуудалтай холбоотой дүн шинжилгээ болон судалгаа шинжилгээний мэдээллээр Парламентыг хангах;
- улсын макро эдийн засгийн өсөлтийн жилийн төсөөллийг бэлтгэх, Засгийн газрын төсөөлөл, мөн түүний үндсэн үзүүлэлтүүд болон таамаглалыг үнэлэх;
- макро эдийн засгийн төлөвлөлттэй уялдуулан төсвийн төсөлд дүн шинжилгээ хийх, мөн төсвийн төслийг хэлэлцэх явцад гарсан аливаа өөрчлөлттэй холбоотой саналд дүн шинжилгээ хийх;
- сар, хагас жил, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэл болон гүйцэтгэлийн эцсийн үр дүнд дүн шинжилгээ хийх;
- Төсвийн төсөлд дүн шинжилгээ хийж, төсвийн төслийг хэлэлцэх явцад гарсан аливаа өөрчлөлттэй холбоотой саналд дүн шинжилгээ хийх;
- төсвийн орлого, зарлагын тооцоог хянаж шалгах;
- парламентад танилцуулсан бүх аудитын тайланд шалгалт хийх;
- Парламентад танилцуулсан төсөвтэй холбоотой бүхий л асуудлуудыг хянаж шалган, хяналт, шалгалтын үр дүнг Парламентад танилцуулах
- Парламентад зөвлөмж гаргах;
- төсвийн болон эдийн засгийн бодлоготой холбоотой мэдээлэлд шинжилгээ хийх;
- Парламентад төсвийн мөчлөг, төсвийн бодлого болон хуулийн төслийн зардлын тооцооны бие даасан, хараат бус дүн шинжилгээгээр хангах
- парламентын хяналтыг хэрэгжүүлэхдээ үйл ажиллагааны тайланг хянан, жилийн төсөв болон жилийн төлөвлөгөөг батлах;
- Санхүү төсөв болон мөнгөний бодлогын үндсэн чиглэл, дунд хугацааны стратегийг үнэлэх;
- улсын өр төлбөрийн асуудал болон төсвийн алдагдал, илүүдэл, төлбөрийн тэнцлийн байдал, мөн татвар, мөнгө, гаалийн бодлогод дүн шинжилгээ хийх;
- хуулийн төслийн үр дагавар болон түүний санхүү, эдийн засгийн үндэслэлд дүн шинжилгээ хийх;
- улсын төсвөөс зээл авах, олгох тухай олон улсын гэрээ, хэлэлцээрүүдэд дүн шинжилгээ хийх;
- Улсын төсвөөс нутаг дэвсгэрийн нэгжийн төсөвт хуваарилсан санхүүгийн тусламжийн зарцуулалтад дүн шинжилгээ хийх;
- Батлагдсан төсвийн орлого, зарлагын аливаа өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх;
- Төсвийн илүүдэл, алдагдал, өр төлбөрийн асуудалд дүн шинжилгээ хийх

- Улсын төсөвт хийх нэмэлт өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх;
- Улсын төсөвт тусгасан хөтөлбөр, үйл ажиллагааны зорилго, тэдгээрийн үр дагавар, оновчтой эсэх, санхүүжилтийн хэмжээнд дүн шинжилгээ хийх;
- Төсөв боловсруулах, батлах болон төсвийн гүйцэтгэлтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал гаргах;
- Халамжийн зардлын зарцуулалтыг хянаж, халамжийн чиг хандлагын талаар тайлан гаргах;
- Төсвийн хүрээний зааварт зааснаар төсвийн дүрэм журмын хэрэгжилтийг хянах;
- Макро эдийн засгийн урьдчилсан таамаглалын үнэлгээ хийх;
- Төсвийн тэнцлийг сайжруулах талаар санал боловсруулах, хэрэгжүүлэх үүргээ Засгийн газар биелүүлсэн эсэхэд үнэлгээ хийх;
- Төсвийн бодлого нь дунд хугацааны зорилтуудын дагуу хэрэгждэг эсэхт хяналт шинжилгээ хийх;
- төсвийн бодлого нь дунд хугацааны зорилтуудад нийцэхгүй байвал засаж залруулах санал боловсруулах;
- Засгийн газрын авсан арга хэмжээнүүд нь төсвийн тэнцлийг засаж залруулахад хангалттай эсэхийг үнэлэх;
- Үндэсний аудитын газар нь Сангийн яамны тогтвортой байдлын дүн шинжилгээ болон яамдын бодлогын хувилбарууд, таамаглал, төсөөлөлд чанарын шинжилгээ хийх;
- бие даасан олон талт үнэлгээний аргачлалд тулгуурлан чанарын болон тоон шинжилгээний аль алиныг нь хамтад нь, түүнчлэн боломжит эрсдлийн үнэлгээг хослуулан хийж дүн шинжилгээ боловсруулах.

Эх сурвалж: Парламентын төсвийн албаны тухай хуулиудаас.





IV
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗУРАГТ ТАНИЛЦУУЛГА





МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

/ОНЦЛОХ АСУУДЛУУД/

УЛААНБААТАР ХОТ

2021 ОН

ҮНДЭСЛЭЛ ШААРДЛАГА



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ

Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг тогтоохдоо Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтад "хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах," гэж заасан.



"Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог..." байгуулах замаар хууль тогтоомжийн биелэлтийг хангах эрх зүйн үндсийг тогтоосон.

"төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах," гэж заасан.

ПРАКТИК ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА



ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА



Олон Улсын Парламентын холбоо (IPU)-ноос гаргасан судалгааны тайлан, зөвлөмж болон АНУ, ХБНГУ, ИХ Британи, Итали, Канад, Өмнөд Африк, Польш, Швед, Энэтхэг, Япон зэрэг улсуудын туршлага, бие даасан хуультай ОХУ, Босни-Херцеговени улсуудын хуулийн зохицуулалтыг харьцуулан судалсан.

2017 онд ОУПХ, НҮБХХ-өөс хамтран дэлхийн 150 орны парламент, парламентын гишүүд болон парламентын хяналтын харилцаанд оролцогчдын дунд суурь судалгаа хийж "Дэлхийн парламентын тайлан-2017: Парламентын хяналт" сэдэвт судалгааны тайлан, дүгнэлт, зөвлөмж гаргасан. Олон улсын экспертүүдийн зүгээс парламентын хяналтыг үр нөлөөтэй явуулах зохицуулалтын үндсэн зарчмуудыг тодорхойлсон.

ХУУЛИЙН ТӨСЛИЙН БҮТЭЦ



УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО



Үндсэн хууль, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хангуулах;



Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, баталгааг хангах;



нийтийн эрх ашгийг хөндсөн тодорхой асуудлаар иргэдийн мэдэх эрх болон өөрсдийн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөллийн байгууллагаараа уламжлан төрийн үйл хэрэгт шууд оролцох эрхийг хангах;



Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн улсын төсөв, төсвийн гүйцэтгэлийг батлахдаа Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7-д нийцэж байгаа эсэхийг хянах;

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО



төсөв, төрийн санхүүгийн удирдлагын хяналтын байнгын тогтолцоо бүрдүүлэх, тэдгээрийн үр нөлөөг сайжруулах;



хууль хэрэгжүүлэх явцад төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд гарч буй алдаа дутагдал, тулгамдсан асуудлыг тогтоох, Улсын Их Хурлын хяналтын явцад төрийн байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагаанд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах замаар төрийн удирдлагын тогтолцооны үр нөлөөг дээшлүүлэх;



хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлан шинжилж, хууль тогтоомжийн хэрэгжилт, үр нөлөөг сайжруулах, боловсронгуй болгох.



УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

Байнгын, дад болон хянан шалгах түр хороо нь хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

шаардлагатай бол тухайн асуудлаар дагнан мэргэшсэн судлаач, мэргэжлийн холбоо болон төрийн бус байгууллагыг оролцуулна.

Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Тамгын газар мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.



Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл **хараат бус хянан шалгах чиг үүрэгтэй байгууллагад** түшиглэн явуулна. Улсын Их Хурал тэдгээр байгууллагыг хууль тогтоомжид заасан чиг үүргийнх нь хүрээнд Улсын Их Хурлын хяналт шалгалтад оролцуулахдаа тухайн байгууллагын хараат бус байдалд хөндлөнгөөс нөлөөлж үл болно.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН


Улсын Их Хурлаас хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь саад учруулах, шаардлагатай тоон үзүүлэлт, статистик мэдээлэл, тооцоо судалгаа, баримт бичгийг нуун дарагдуулахыг хориглоно.

Улсын Их Хурлын Тамгын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, эрхлэн хөтөлнө. Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журмыг Улсын Их Хурлын даргын захирамжаар батална.



Тамгын газар холбогдох төрийн бусад байгууллагын цахим систем болон цахим хэлбэрээр бүрдүүлсэн мэдээллийн сангаас шаардлагатай мэдээллийг нэн даруй гаргуулан авах эрхтэй.

тогтмол мэдээллийг Улсын Их Хурлын Тамгын газар /цаашид "Тамгын газар" гэх/ болон холбогдох байгууллагын хамтарсан шийдвэрийн дагуу төвлөрүүлнэ.



ОНЦЛОГ ЗОХИЦУУЛАЛТУУД

ТАЙЛАН

03

- ✓ Урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн тайланг хэлэлцэхдээ бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг нэгдмэл, цогц, уялдаа холбоотой тайлагнах тогтолцоо бүрдүүлэх
- ✓ Улсын Их Хуралд ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргах нарийвчилсан дэгийг зохицуулах

ТӨСВИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ

04

- ✓ төсвийн төлөвлөлтийн хяналт;
- ✓ төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх шатны хяналт;
- ✓ хэлэлцүүлгийн шатны хяналт;
- ✓ төсвийн гүйцэтгэлийн хяналт шалгалт;
- ✓ төсвийн гадуурх санхүүжилтэд хяналт тавих харилцааг нэмж тусгах чиглэл өгсөн

ХЯНАЛТЫН СОНСГОЛ

05

- хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол;
- төсвийн хяналтын сонсгол;
- томилгооны сонсгол;
- ерөнхий хяналтын сонсгол.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО



Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор уг хороог заавал байгуулна.

ХЯНАН ШАЛГАХ /МӨРДӨН ШАЛГАХ/ ТҮР ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлыг мөрдөн шалгах арга хэрэгслээр хянан шалгаж, дүнг Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.

6 сар хүртэл хугацаагаар байгуулах бөгөөд шаардлагатай бол мөн хугацаагаар нэг удаа сунгаж болно.



тогтоолын төсөлд хянан шалгах түр хорооны мөрдөн шалгалтын сэдэв, хүрээ хязгаар, тухайн асуудлаар хянан шалгах түр хороо байгуулах болсон үндэслэлийг тодорхой тусгана.

Хянан шалгах түр хорооноос шүүх болон эрх бүхий бусад байгууллагын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, хөндлөнгөөс оролцох, заавар өгөхийг хориглоно.

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН



ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО НЬ БАЙНГЫН ХОРООНЫ НИЙТЛЭГ БҮРЭН ЭРХЭЭС ГАДНА ДАРААХ БҮРЭН ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ:

CONTROLLING



- нотлох баримт цуглуулах
- нотлох баримтыг нийтийн сонсголоор сонсох
- төрийн байгууллагаас нотлох баримт гаргуулж авах
- нотлох баримт гаргаж өгөх тухай хүсэлт гаргах
- нотлох баримт гаргаж өгөхийг хүн, хуулийн этгээдээс шаардах
- гэрчээр дуудах, гэрчээс мэдүүлэг авах, асуулт тавих
- шинжээч томилох, тайлбар, мэдүүлэг авах
- хянан шалгагч томилох
- тайлан, шаардлагатай бол тогтоолын төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах
- хуульд заасан бүсэд

ТҮР ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН, ТАЙЛАН, САНАЛ, ДҮГНЭЛТ, ЗАРДАЛ

Түр хорооны тайлан, санал, дүгнэлт нь шүүхэд үүрэг хүлээлгэхгүй бөгөөд түр хорооны цуглуулсан нотлох баримтыг шүүн таслах ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд үнэлэх эсэхийг шүүх шийднэ.

Санал
дүгнэлт



Зардал

Тайлан

Lorem ips
хянан шалгах
ажиллагааны
агуулга,
цуглуулсан
нотлох
баримт,
тогтоогдсон
үйл баримт,
хянан
шалгалтын
дүгнэлтийг
багтаана um
dolor sit amet,
nibh est. A

Түр хорооны мөрдөн шалгах үйл ажиллагаатай холбогдон гарах аливаа зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ

ХУУЛЬ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

Оногдуулсан үүргийг хугацаанд нь биелүүлээгүй, эсхүл зохих ёсоор биелүүлээгүй нь Улсын Их Хурлын хянан шалгалтыг тасалдуулсан бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 37.9-д заасан парламентыг үл хүндэтгэх үйлдэл гэж үзэн Төрийн албаны тухай, эсхүл Зөрчлийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Холбогдох албан тушаалтан энэ хуульд заасан нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр түр хороонд ирүүлээгүй, гаргаж өгөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулна.

Гэрч мэдүүлэг өгөхөөс хууль бусаар татгалзсан, зайлсхийсэн бол Зөрчлийн тухай, худал мэдүүлэг өгсөн бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага оногдуулна.

Шинжээч тогтоосон хугацаанд дүгнэлт гаргаж өгөөгүй, мэдүүлэг өгөхөөс хууль бусаар татгалзсан, зайлсхийсэн бол Зөрчлийн тухай, худал мэдүүлэг өгсөн, санаатайгаар худал дүгнэлт гаргасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага оногдуулна.

Хянан шалгагч мэдүүлэг өгөхөөс хууль бусаар татгалзсан, зайлсхийсэн бол Зөрчлийн тухай, худал мэдүүлэг өгсөн, санаатайгаар худал дүгнэлт гаргасан бол Эрүүгийн хуульд заасан хариуцлага оногдуулна.

Гэрч, шинжээч хуралдааны дэг зөрчсөн, эсхүл хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдаагүй бол хуралдаан даргалагч тэдэнд сануулга өгч, дахин зөрчил гаргасан бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.



ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ